

Танилцуулга

ИЛ БОЛСОН

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд
хийгдсэн шалгалтын талаар**Ажлын хэсгийн зохион байгуулалт**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг, ажлын дэд хэсгээс Монгол Улсын Хөгжлийн банкинд татан төвлөрүүлсэн нийт санхүүжилтийн эх үүсвэр, төслүүдийн сонгон шалгаруулалт, төслийн санхүүжилтийн зарцуулалт болон хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, цаашид учирч болзошгүй эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол банк, Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн төлөөлөл, ажлын дэд хэсэгт Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Монгол банкны төлөөлөл бүхий нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Ажлын хэсгийн гишүүд банкны санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, банкны үйл ажиллагаа, мөрдөгдөж буй болон шинээр гаргасан хууль, эрх зүйн баримт бичигт дүгнэлт өгөх багуудад хуваарилагдан ажиллаж дараах тайлан, дүгнэлтийг танилцуулж байна.

**Нэг. Монгол Улсын Хөгжлийн банкны гадаад, дотоод зах зээлээс
татан төвлөрүүлсэн эх үүсвэрүүдийн талаар**

Монгол Улсын Хөгжлийн банк нь Засгийн газрын 2010 оны 07 сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоол болон Монгол Улсын Их хурлаас 2011 оны 02 сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн дагуу 2011 оны 03 сарын 25-ны өдөр байгуулагдаж үйл ажиллагаагаа 05 сараас эхэлсэн байна. Монгол Улсын Хөгжлийн банк нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд Засгийн газрын шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг. Банкны хувь нийлүүлэгч нь Монгол Улсын Засгийн газар.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.1-р зүйлд УИХ нь Банкны өөрийн хөрөнгөнд оруулах Засгийн газрын хувь хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох, батлах болон Засгийн газраас гаргах зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох бүрэн эрхтэй гэж заасан. Арилжааны банкуудын даган мөрдөж буй Банкны тухай хууль болон Монголбанкнаас баталж гаргасан дүрэм, журам нь Банкинд хамаарахгүй. Банкны бодлого нь хөрөнгө оруулалт, зээлийн болон зах зээлийн найдвартай байдлыг хангах, мөн бизнесийн ирээдүйн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Монгол Улсын Хөгжлийн Банкны нийт хөрөнгө 2015 оны жилийн эцсийн байдлаар 6 их наяд 70 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны эцэстэй харьцуулахад 10.3 хувиар өсчээ. Тус банкны зээлийн эх үүсвэрийг Чингис бонд -1.5 тэрбум ам.доллар, Дунд хугацааны евро бонд -580.0 сая ам.доллар, Самурай бонд -24.3 тэрбум иен, Коммерц банкны эх үүсвэр 13.1 сая евро, Хятадын хөгжлийн банкны зээл -212 сая

ам.доллар, Кредит свисс банкны зээл -300 сая ам.доллар, Внешэконом банкны зээл -20.0 сая ам.доллар болон өөрийн хөрөнгө зэрэг хөрөнгүүд бүрдүүлж байна. Энэхүү эх үүсвэрүүдээр санхүүжүүлсэн зээлийн хэмжээ 2015 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 4,909.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс эргэн төлөгдөх нийт зээлийн багц 55 хувь, төслийн орлогоос эргэн төлөгдөх зээлүүд нийт багцын 45 хувийг тус тус бүрдүүлж байна.

1.1 ГАДААД ЗАХ ЗЭЭЛЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРҮҮД:

I. Дунд хугацааны евро өрийн бичиг (ДХЕӨБХ)-ийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 85, 232, 287, 322 дугаар тогтоолууд, Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид МУХБ гэнэ)-ны Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ гэнэ)-ийн 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар тогтоолуудын хүрээнд МУХБ нь 2011 оны 11 дүгээр сард 600 сая ам.долларын дүн бүхий Дунд хугацааны евро өрийн бичгийн хөтөлбөрийг байгуулсан ба 2011 оны 12 дугаар сард 1 жилийн хугацаатай 20 сая ам.долларын өрийн бичгийг хаалттай хэлбэрээр, 2012 оны 3 дугаар сард 5 жилийн хугацаатай 5.75 хувийн хүүтэй 580 сая ам.долларын үнэт цаасыг олон улсын зах зээлд амжилттайгаар арилжаалсан.

Дунд хугацааны евро өрийн бичгийн хөтөлбөр		
Хөтөлбөр байгуулсан огноо	2011.11.30	
Зээлжих зэрэглэл	B1(тогтвортой) / BB-(тогтвортой) / T+(тогтвортой)	
Баталгаа гаргагч	Монгол Улсын Засгийн газар	
Зорилго	Шинэ төмөр зам, дэд бүтэц, зам, барилга	
Дүн	20 сая ам.доллар	580 сая ам.доллар
Төрөл	Хаалттай	Нээлттэй
Хугацаа	1 жил	5 жил
Хүлээн авсан огноо	2011.12.09	2012.03.21
Хүү/купон	6.00%	5.75%
Эргэн төлөлт	2012.12.09-ний өдөр төлсөн	2017.03.21-ний өдөр төлнө

Дунд хугацааны евро өрийн бичгийн хүрээнд 2011 оны 12 дугаар сард гаргасан 20 сая ам.долларын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сард эргэн төлсөн бөгөөд 2012 оны 3 дугаар сард 580 сая ам.долларын үнэт цаасны эх үүсвэрийг хүлээн авч эргэн төлөлтийг 2017 оны 3 дугаар сард төлөх хуваарьтай байна.

II. Самурай бондын тухай

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 417 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкны 30 тэрбум иений үнэт цаасыг 10

жил хүртэлх хугацаатай, хаалттай хэлбэрээр Япон улсын зах зээл дээр Японы Олон Улсын хамтын ажиллагааны банкны баталгаатайгаар арилжаалахыг МУХБ-ны ТУЗ-д зөвшөөрсөн. Түүнчлэн, уг бондын үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайдад, хууль зүйн дүгнэлт гаргахыг Хууль зүйн сайдад тус тус зөвшөөрсөн.

Монгол Улсын Засгийн газрын 417 дугаар тогтоолыг үндэслэн МУХБ-ны ТУЗ-ийн 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 75 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкны 30 тэрбум иений үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, 1.52 хувийн хүүтэй, хаалттай хэлбэрээр Япон улсын зах зээл дээр гаргахыг зөвшөөрч, холбогдох байгууллагуудтай байгуулах гэрээ, баримт бичиг болон холбогдон гаргах баталгааны шимтгэл болон үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталсан.

Үүний хүрээнд 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 75 дугаар тогтоолын Хавсралт 1-д заасанчлан дараах гэрээ бичиг баримтуудыг байгуулсан. Үүнд:

Гэрээний нэр	Огноо	Оролцогч талууд	Тайлбар
Баталгааны гэрээ (Indemnity Agreement)	2013.12.18	МУХБ, СЯ, ЯОУХАБ	ЯОУХАБ-ны баталгааны нөхцөл, МУХБ, СЯ-ны үүрэг, хариуцлага, уг баталгааны төлбөр, баталгаа хэрэгжсэн тохиолдолд ЯОУХАБ-ны зардлыг хэрхэн эргэн төлөх тухай харилцааг зохицуулна.
Бонд худалдан авах гэрээ (Bond Purchase Agreement)	2013.12.16	МУХБ, СЯ, Банкууд	МУХБ-ны бонд гаргах, хөрөнгө оруулагчдын бонд худалдан авах эрх үүрэг, хариуцлагын талаарх харилцааг зохицуулна.
Үнэт цаасны мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллага (ҮЦБ)-тай хийх гэрээ (Agreement with Commissioned Company for Bondholders)	2013.12.18	МУХБ, СЯ, ЯОУХАБ, ҮЦБ	МУХБ, бондын хөрөнгө оруулагчдын хоорондын харилцаа, эрх үүргийг хамгаалах тухай харилцааг зохицуулна.
Агентын гэрээ (Agency Agreement)	2013.12.16	МУХБ, СЯ, ҮЦБ	МУХБ-ны бонд гаргах агент, төлбөрийн агентын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулах, эдгээр үүргийг ХОТБ давхар гүйцэтгэнэ.
Хөрөнгө оруулалтын банкуудтай байгуулах гэрээ (Mandate Letter)	2013.12.16	МУХБ, Банкууд	Банкуудын үйлчилгээний төлбөр, бонд гаргах үйл ажиллагааны зардлын хуваарилалт, бондын арилжааны хязгаарлалтын тухай харилцааг зохицуулна.
Банкууд, агентын зардлын тухай гэрээнүүд (Expense Side)	2013.12.16 2013.12.18	МУХБ, Банкууд,	Банкууд, агент байгууллагын үйлчилгээний төлбөрийн тухай харилцааг Япон улсын

Letter, Letter Agreement)		ҮЦБ	хууль зүйн журмын хүрээнд зохицуулна.
Гарын үсгийн баталгааны сертификат (Incumbency Certificate)	2013.12.16	МУХБ	Холбогдох шийдвэрийн дагуу олгогдсон эрхийн дагуу үнэт цаас гаргахтай холбоотой байгуулах хууль зүйн гэрээ, баримт бичгүүдэд зурах гарын үсгийг баталгаажуулна.
Хаалтын сертификат (Closing Certificate)	2013.12.25	МУХБ	Гэрээ байгуулагдсан өдөр болон санхүүгийн төлбөр тооцоо хийгдсэн өдөр хооронд холбогдох гэрээний аливаа заалтыг зөрчөөгүй болохыг баталгаажуулна.
Хууль зүйн итгэмжлэл (Power of Attorney)	2013.12.16	МУХБ	Япон Улсын хууль, эрх зүйн шаардлагын дагуу үнэт цаас гаргагчийг төлөөлөх хууль зүйн бүрэн эрхт төлөөлөгчийг томилно.

МУХБ-ны ТУЗ-ийн 2013 оны 75 дугаар тогтоолд заасанчлан 30 тэрбум иений үнэт цаасыг дараах нөхцөлтэйгээр Японы хөрөнгийн зах зээлд арилжаалсан.

Үнэт цаас гаргагч	Монгол Улсын Хөгжлийн банк
Баталгаа гаргагч	Монгол Улсын Засгийн газар, Японы Олон Улсын хамтын ажиллагааны банк
Бондын төрөл	Хаалттай
Нийт дүн	30 тэрбум иен
Хугацаа	10 жил
Купон хүү	Жилийн 1.52% (тогтмол)
Хүүгийн төлбөр	6 сар тутам
Үндсэн төлбөр	Хугацааны эцэст
Зуучлагч санхүүгийн байгууллагууд	Дайва Секюритиз Ко Лтд. Номура Секюритиз Ко Лтд.
Хуулийн зөвлөх байгууллага	Шимизаки олон улсын хуулийн байгууллага

Самурай бондын эх үүсвэр болох 30 тэрбум иенээс холбогдох зардал, шимтгэлүүд болох 5.75 тэрбум иенийн төлбөр хасагдсан дүнгээр 24,250,214,308.00 (хорин дөрвөн тэрбум хоёр зуун тавин сая хоёр зуун арван дөрвөн мянга гурван зуун найм) иен 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны Монголбанк дахь 3330536 тоот иенийн харилцах дансанд Япон улсын Мизухо банкнаас шилжин орсон байна.

Гэрээний дагуу уг эх үүсвэрийн үлдэгдлийг зөвхөн дараах Баталгааны гэрээний Хавсралт Г – Зарцуулалтын тайлангийн дагуу ашиглах боломжтой юм.

1	2	3	4	5	6	7	8	
							Зээлийн хугацаа	
МУХБ-ны зээлдэгч	Товч утга	Санхүүжилтийн дүн (үндсэн валютаар)	Санхүүжилтийн огноо	Албан ханш	Санхүүжилтийн дүн (иенээр) – /Багана 3 х Багана 5/	Байгаль орчны салбар	Эхлэх	Дуусах
Төрийн банк	Моргажийн 6 хувийн зээлийн хөтөлбөр	MNT 50,000,000,000	2013/01/17	15.70	3,184,713,376	С	2012/06/15	2015/03/17
Төрийн банк	Моргажийн 6 хувийн зээлийн хөтөлбөр	MNT 30,000,000,000	2013/01/17	15.70	1,910,828,025	С	2013/01/17	2017/03/17
ЖДҮХ сан	ЖДҮ-ийн хөгжүүлэх сангийн зээл	MNT 36,347,469,600	2013/09/27	16.69	2,177,799,257	С	2012/07/17	2017/07/17
Пи Ай Эм Эм ХХК	Яармагийн гүүрний орчмын орон сууцны хороолол барих төсөл	MNT 6,000,000,000	2013/11/14	17.43	344,234,079	С	2013/08/27	2016/08/27
ТОСК ТӨҮГ	Буян-Ухаа орон сууцны хороолол барих төсөл	MNT 60,000,000,000	2013/12/13	16.14	3,717,472,119	С	2013/10/02	2022/09/30
Баземент ХХК	Хөтөлийн цементийн үйлдвэрийн төсөл	USD 61,265,000	2012/10/19	0.013	4,712,682,308	С	2012/10/19	2017/10/19
Эрэл ХХК	БУК-ын төсөл	USD 14,000,000	2013/08/20	0.010	1,400,000,000	С	2013/08/19	2021/08/19
Голомт банк	Ноос ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн шинэчлэл	MNT 269,030,318,200	2013/08/15	16.02	16,793,403,134	С	2013/08/15	2017/12/01
Нийт шаардлагатай хангасан зарцуулалтын дүн (иен)							34,241,142,298	

III. Коммерц банкны эх үүсвэрийн тухай

“Эрэл” ХХК нь ХБНГУ-ын “EBAWE Anlagentechnik GmbH” компаниас нийт 17,350,000 еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг худалдан авах гэрээг 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. МУХБ нь ХБНГУ-ын Коммерц банкт тус гэрээний үнийн дүнгийн 70 хувь буюу 12,145,000 еврогийн төлбөрийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 2014 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Зээлийн ерөнхий гэрээ болон Зээлийн тусгай гэрээг тус тус байгуулсан байна.

Зээлдүүлэгч	Коммерц банк	
Зээлдэгч	Монгол Улсын Хөгжлийн банк	
Зээлийн төрөл	Дамжуулан зээл	
Зээлийн хугацаа	5 жил	
Зээлийн хэмжээ	Нийт 13,115,000 евро	
	12,145,000 евро (зээлийн гэрээний 70%)	970,000 евро (Санхүүжилттэй холбоотой бусад зардал)
Валют	Евро	
Зээлийн хүү	6М Еврибор + 1.90%	
Хүүгийн төлбөр	6 сар тутам	
Үндсэн төлбөр	6 сар тутам	
Комметмент хүү	0.70% (жилийн)	

Удирдлагын шимтгэл	0.90% (нэг удаа төлөгдөх)
Эрх зүйн зохицуулалт	ХБНГУ-ын хууль

Тус гэрээний 2.2.2-т "ХБНГУ-ын *EBAWE Anlagentechnik GmbH* компани тоног төхөөрөмжийг ачуулан, "Худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу Хавсралт 4а-д заасан баримт бичгийн эх хувийг ХБНГУ-ын Коммерц банкинд хүргүүлнэ. ХБНГУ-ын Коммерц банк нь уг баримт бичгүүдийн эх хувийг мэдэгдлийн хамт Банкнд ирүүлэх бөгөөд Банк баримт бичгийг үүрэг гүйцэтгэгчээр нягтлан шалгуулна. Үүрэг гүйцэтгэгч нь Банкнд төлбөр төлөхийг даалгаснаар Банк төлбөр төлөх зөвшөөрлийг ХБНГУ-ын Коммерц банкинд илгээнэ." гэж заасны дагуу Коммерц банкны 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн нийт 11,277,500 еврогийн зээлийг "Эрэл" ХХК-д олгоод байна. Одоогийн байдлаар үүрэг хүлээсэн нийт дүнгээс 867,500 еврогийн зээлийг олгоогүй байна. Тус эх үүсвэрийн даатгалын төлбөрт 902,123.50 еврог шилжүүлсэн.

IV. Хамтарсан зээл (Credit Suisse, SMBC, Эксим банкууд)-ийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 117, 372 дугаар тогтоолууд, МУХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Кредит Свисс банкттай 300 сая хүртэлх ам.долларын хамтарсан зээлийн гэрээг Сангийн яамны баталгаатайгаар байгуулахыг зөвшөөрсөн.

Хамтарсан зээлийн санхүүжилтийн ерөнхий нөхцөл бүхий саналыг Кредит Свисс банкнаас 2014 оны I улиралд МУХБ-нд ирүүлсэн бөгөөд удаа дараагийн хэлэлцээрийн дүнд 2014 оны II улиралд дараах ерөнхий нөхцөлүүдийг тохиролцож, 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдөр зээлийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Нөхцөл	Транч А (5 жил)	Транч Б (3 жил)
Баталгаа гаргагч	МУЗГ-ын нэрийн өмнөөс Сангийн яам	
Нийт дүн	200 сая ам. доллар	
Хэмжээ нэмэгдүүлэх боломж	100 сая ам. доллар	
Хугацаа	5 жил	3 жил
Хүү	6 сарын Лайбор + маржин	6 сарын Лайбор + маржин
Маржин (жил бүр)	4.375%	4.250%
Хүүгийн эргэн төлөлт	6 сар тутам	6 сар тутам
Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	2 жил 6 сар	
Үндсэн төлбөрийн эргэн төлөлт	Хагас жил тутам үндсэн дүнгийн 10%, 10%, 15%, 15%, 25%, 25%-нар	
Үүргээ эс биелүүлсэн тохиолдолд төлөх хүү (жил бүр)	2%	
Хөтөлбөрийн агентын төлбөр (жил бүр ам.доллар)	25,000 ам. доллар	
Урьдчилгаа төлбөр (нэг удаа, нийт дүнгийн%)	2.25%	2.25%

Нийт 300 сая ам.долларын санхүүжилтийн 30 сая ам.доллар нь 3 жилийн хугацаатай бөгөөд үлдсэн 270 сая ам.доллар нь 5 жилийн хугацаатай болно. Тус хамтарсан санхүүжилтэд олон улсын санхүүгийн байгууллагууд дараах хэлбэрээр оролцсон. Үүнд:

	Транч А (5 жил)	Транч Б (3 жил)
Кредит Свисс Банк	185 сая ам. доллар	
Хятадын Эксим Банк	85 сая ам.доллар	
Сумитомо Мицуби Банк		25 сая ам. доллар
Тайваны Эксим Банк		5 сая ам. доллар
Нийт	270 сая ам.доллар	30 сая ам.доллар

Санхүүжилтийн эхний хэсэг болох 185 сая ам.долларыг 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр, үлдэгдэл 115 сая ам.долларыг 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр тус тус хүлээн авсан. Мөн 5 жилийн хугацаатай хэсэг нь эхний 24 сардаа үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, 30 дахь сараас эхлэн хагас жил тутамд шат дараалалтайгаар үндсэн дүнгийн 10%, 10%, 15%, 15%, 25%, 25% гэсэн хувиар төлбөр төлөгдөх бол 3 жилийн хугацаатай хэсэг нь хугацааны эцэст буюу 36 сарын дараа бүтэн дүнгээр төлөгдөх болно.

Гэрээний дагуу уг эх үүсвэрийг эрчим хүч, үйлдвэрлэл, дэд бүтэц, уул уурхайн салбаруудад зарцуулахаар тусгасан байна.

V. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээлийн тухай

МУХБ болон БНХАУ-ын Хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд талууд хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсад хэрэгжиж буй БНХАУ-ын оролцоотой төслийн санхүүжилт дээр хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 116 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 40 дүгээр тогтоолуудын хүрээнд Авто зам, орон сууц барих болон хоёр талын тохиролцсон бусад төслийг санхүүжүүлэх зориулалтаар БНХАУ-ын Хөгжлийн банкттай 8 жилийн хугацаатай 162 сая ам.долларын зээлийн хөтөлбөрийн гэрээг дараах ерөнхий нөхцөлтэйгээр байгуулсан.

БНХАУ-ын Хөгжлийн банкны 162 сая ам.долларын зээл	
Хөтөлбөр байгуулсан өдөр	2014.08.21
Зээлжих зэрэглэл	B2/сөрөг
Баталгаа гаргагч	Монгол Улсын Засгийн газар
Зорилго	БНХАУ-ын гүйцэтгэгчтэй төсөл хөтөлбөрүүд

19

НУУЦ

ИЛ БОЛСОН

Дүн	162,000,000 ам.доллар
Хугацаа	8 жил
Хүлээн авсан огноо	2014.09.02
Хүү/Купон	6%
Эргэн төлөлтийн огноо	2022.09.02

Уг гэрээний хүрээнд дараах улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй БНХАУ-ын гүйцэтгэгч бүхий авто зам болон эрчим хүчний салбарын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр тохиролцсон.

(ам.доллар)

№	Төсөл хөтөлбөр	Санхүүжилтийн дүн
1	Авто замын төслүүд (нийт 10 төсөл)	72,100,000
2	ДЦС-3 станцын өргөтгөлийн төсөл	14,000,000
3	Амгалангийн дулааны станц барих төсөл	75,900,000
НИЙТ ДҮН		162,000,000

Дээрх төсөл хөтөлбөрүүдийн урьдчилгаа санхүүжилтэд зориулан санхүүжилтийн эхний хэсэг болох 112 сая ам.долларыг 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хүлээн авсан ба одоогоор нийт 155,310,000 ам.долларын санхүүжилтийг дараах байдлаар хүлээн аваад байна.

(ам.доллар)

№	Санхүүжилт хүлээн авсан огноо	Дүн	Албан ханш
1	2014-09-04	112,000,000	1,819.24
2	2015-01-06	12,950,000	1,892.91
3	2015-05-29	7,590,000	1,914.13
4	2015-11-17	17,410,000	1,991.59
5	2016-03-11	5,360,000	2,048.18
НИЙТ ДҮН		155,310,000	-

Зээлийн хөтөлбөрийн гэрээний дагуу үлдэгдэл 6,690,000 ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг Амгалангийн дулааны станц барих төсөлд санхүүжүүлэхээр байна.

VI. ОХУ-ын Гадаад эдийн засгийн үйл ажиллагаа, хөгжлийн банк (Внешэкономбанк)-аас бүрдүүлсэн эх үүсвэрийн тухай

МУХБ болон ОХУ-ын Внешэкономбанкны хамтын ажиллагаа нь 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр “Харилцан ойлголцлын санамж бичиг”, 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр “Үүргийн бичиг” байгуулснаар эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 99, 119, 2014 оны 202 дугаар тогтоолууд болон МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, 100МВт-ын турбингенератор шинээр суурилуулахад шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын Внешэкономбанкттай 74.1 сая хүртэл ам.долларын зээлийн гэрээ байгуулахыг МУХБ-нд зөвшөөрсөн билээ. Үүний хүрээнд Внешэкономбанкттай удаа дараа хэлэлцсэний дүнд тус банкнаас ОХУ-ын Экспортын даатгалын агентлагийн шимтгэлтэй хамт нийт 62.1 сая ам.долларыг зээлдүүлэх боломжтойг мэдэгдсэн бөгөөд эхний ээлжинд 20.0 сая ам долларын зээлийн шугамыг Монгол Улсын Засгийн Газрын баталгаагүйгээр нээх боломжтой болсон ба МУХБ нь Внешэкономбанкттай 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдөр дараах үндсэн нөхцөл бүхий зээлийн гэрээг амжилттай байгуулсан.

Зээлдүүлэгч	Внешэкономбанк
Зээлдэгч	Монгол Улсын Хөгжлийн банк
Зориулалт	ДЦС IV-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, 100МВт-ын турбингенератор шинээр суурилуулах
Гэрээ байгуулсан огноо	2015.06.15
Хүлээн авсан огноо	2015.06.30
Хугацаа	8 жил
Хэмжээ	20 сая хүртэлх ам.доллар
Дуусах огноо	2023.06.15
Купон	3.2%
Эрх зүйн зорхицуулалт	ОХУ-ын хууль

VII Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банкнаас бүрдүүлсэн эх үүсвэрийн тухай

МУХБ болон Олон Улсын Хөрөнгө оруулалтын банкны хамтын ажиллагаа нь 2014 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр “Стратегийн түншлэлийн гэрээ” байгуулсанаар эхэлсэн ба тус гэрээний хүрээнд хамтран төсөл хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор нийт 20.0 сая хүртэлх еврогийн зээлийн шугамыг МУХБ-нд нээх боломжтойг тус банкнаас 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр мэдэгдсэн.

НУУЦ

ИЛ БОЛСОН

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 319 дүгээр тогтоолоор 20 сая хүртэлх еврогийн зээлийн шугамыг ОУХОБ-нд нээх зөвшөөрлийг МУХБ-нд олгосон ба МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 66 дугаар тогтоолоор зээлийн шугам нээх гэрээг байгуулахыг зөвшөөрсөн.

Үүний хүрээнд ОУХОБ-тай 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр дараах ерөнхий нөхцөл бүхий зээлийн гэрээг байгуулсан.

Зээлдүүлэгч	Олон Улсын Хөрөнгө оруулалтын банк
Зээлдэгч	Монгол Улсын Хөгжлийн банк
Огноо	2015.09.14
Хүлээн авсан өдөр	2015.09.16
Хугацаа	7 жил
Хэмжээ	20 сая хүртэлх евро
Дуусах огноо	2022.09.14
Купон	EURIBOR3m+6%
Эрх зүйн зорхицуулалт	Английн хууль

Тус санхүүгийн эх үүсвэрийг Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр суурилуулах T-120/130-130-8MO маркийн турбогенераторыг худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийн дахин санхүүжүүлэлт, “Эрэл” ХХК-ны Байшин үйлдвэрлэх комбинатын төсөл болон “Тайж” группын Мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөлд тус тус олгосон. Боловсруулах үйлдвэрт 9 сая ам.доллар, мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөлд 4.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

VIII. ВТБ Банкны зээлийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 93 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоол, 11 дүгээр сарын 25-ны өдрийн 98 дугаар тогтоол, 2016 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 31 дүгээр тогтоолуудын хүрээнд ОХУ-аас авах газрын тосны бүтээгдэхүүний импортод шаардагдах гадаад валютын урсгалыг тэнцвэржүүлэх зорилгоор 300,000,000 ам.долларын зээлийн шугамын санхүүжилтийг Сангийн яамны баталгаатайгаар ОХУ-ын ВТБ Банкаас авч ажиллахыг МУХБ-нд зөвшөөрсөн.

НУУЦ

ИЛ БОЛСОН

Үүний хүрээнд МУХБ нь ВТБ банктай 2015 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр дараах үндсэн нөхцөл бүхий санхүүжилтийн гэрээг эцэслэн гарын үсэг зурж баталгаажуулсан.

Зээлдүүлэгч	ВТБ банк	
Зээлдэгч	Монгол Улсын Хөгжлийн банк	
Транчийн хугацаа	6 сар	9 сар
Баталгаа гаргагч	Монгол Улсын Засгийн газар	
Дүн	300 сая ам.доллар	
Хугацаа	36 сар	
Хүү	3 сарын ЛАЙБОР+5.75%	3 сарын ЛАЙБОР+5.75%
Урьдчилгаа төлбөр	1%	
Хүүгийн эргэн төлөлт	3 сар тутам	
Үүргээ биелүүлээгүй тохиолдолд төлөх хүү	2%	
Транчийн дүн	20 сая ам.доллараас багагүй	
Урьдчилсан Эксиарын даатгал (транч бүрт)	1.1%	

Энэхүү зээлийн шугам нь 36 сарын хугацаатай бөгөөд зээлийн шугамыг бүтэн дүнгээр эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр 6 болон 9 сарын хугацаатайгаар ашиглах хоёр бүтэцтэй буюу 6 сар болон 9 сар тутамд ашигласан дүнгээ хүүгийн хамт эргүүлэн төлж, буцаан зээлдэж авах хэлбэрээр нийт 36 сар үргэлжлэх нөхцөлтэй. Энэхүү зээлийн шугам нь газрын тос импортлогч дөрвөн аж ахуйн нэгж (Петровис, Магнай Трейд, Шунхлай, Сод Монгол)-ийн хэрэгцээгээр хязгаарлагдах юм.

Зээлийн шугамын эхний зэлжийн санхүүжилт болох 65,430,000 ам.долларыг 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан болно. Тус санхүүжилтийн зээлийн эргэн төлөлтийг энэ ондоо багтаж буцаан төлөх бөгөөд ирэх онд Засгийн газрын баталгааны хэмжээнд үлдэгдэл санхүүжилтийн дүнгээр тусгуулсаны дүнд үлдэгдэл эх үүсвэрийг хүлээн авах боломжтой байна.

IX. Каргилл санхүүгийн байгууллагын зээлийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоол, МУХБ-ны 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 17 дугаар тогтоолоор Каргилл санхүүгийн үйлчилгээний олон улсын байгууллагаас 75 сая ам.долларын худалдааны зээлийн санхүүжилт авахыг зөвшөөрсөн.

23

НУУЦ

ИЛ БОЛСОН

Улмаар 2015 оны 12 дугаар сараас эхлэн тус байгууллагатай хамтран ажиллаж, гэрээний нөхцөлүүдийг харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах нөхцөлийн дагуу гэрээг 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр амжилттайгаар эцэслэсэн.

Хөтөлбөрийн төрөл:	Худалдааны зориулалттай Зээлийн гэрээ
Зээлдэгч:	МУХБ
Зээлийн зориулалт:	Хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүд
Зээлдүүлэгч:	Каргилл олон улсын санхүүгийн байгууллага, АНУ
Төлбөр:	Акредитив нөхцөл бүхий Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Зээлдүүлэгчийн хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр/өдрөөр төлнө./
Аккредитив гаргах банк:	МУХБ
Зээлийн хэмжээ:	75 сая хүртэлх ам.доллар (Транчаар хувааж авах боломжтой).
Төлбөрийн нөхцөл:	Зарцуулалт эхэлсэн өдрөөс хойш 720 өдрийн дараа буюу эргэн төлөлтийн доорх хуваарийн дагуу Зээлийн үндсэн төлбөрийг төлөх:
	Зарцуулалт эхэлсэн өдрөөс хойш 540 өдрийн дараа (Эхний хэсэгчилсэн төлбөр) 18.75 сая ам.доллар;
	Зарцуулалт эхэлсэн өдрөөс хойш 720 өдрийн дараа (Дараагийн хэсэгчилсэн төлбөр) 56.25 сая ам.долларыг тус тус төлөх.
Хүүгийн хугацаа:	(a) Зээл олгосон өдрөөс эхлэн 6 сарын дараа
	(b) Сүүлийн хүүгийн төлбөр төлөгдсөнөөс 6 сарын дараа Хүүгийн төлбөр төлөх өдөр нь зээлийн хугацаанаас давж болохгүй, мөн амралтын өдөр таарах юм бол өмнөх ажлын өдөр төлөгдөнө.
Хүү*:	365 өдрийн суурь дээр тооцсон зээлийн хүү 9.5%, Зээлийн үлдэгдэл дүнгээс тооцно. (Эхний хүүгийн түвшин)
Баримт бичиг:	1. Худалдааны зориулалт бүхий зээлийн гэрээ
	2. Эх үүсвэрийн ашиглалтыг баталгаажуулсан баримт бичиг
	3. Зээлдүүлэгчийн хүлээн зөвшөөрсөн хэлбэр бүхий Аккредитивын баримт бичиг
Хууль:	Энэхүү баримт бичиг нь Нью Йорк муж улсын хуульд захирагдана; Баримт бичигт тэмдэглэсэнээс бусад тохиолдолд.
	АНУ-ын орлогын албан татвараас бусад буюу тус Зээл эсхүл Аккредитивтэй холбогдох одоо болон ирээдүйд үүсэх аливаа албан

Татвар:	татвар, Зээлдэгчийн оршин суугаа улсын ЗГ/ эсхүл албан татвар/эсхүл бусад эрх бүхий зохицуулалтыг Зээлдэгч нь дангаараа хариуцна.
Хориг арга хэмжээ:	ЕХ/АНУ/НҮБ/Швейцарь/Канадын тавьсан хориг арга хэмжээ болон холбогдох журмыг дагаж мөрдөх
Нөхцөлүүд:	МУХБ нь МУ-ын ЗГ-ын тогтоол шийдвэр болон МУ-ын холбогдох хууль журмын дагуу Зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан байна.

Тус гэрээний дагуу 75 сая ам.долларын эх үүсвэрийг 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр МУХБ нь өөрийн дансандаа хүлээн авсан одоогоор төслүүдэд санхүүжүүлж эхлээгүй байна.

Х. БНХАУ-ын Экспорт-Импорт банкны зээлийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 236 дугаар тогтоолоор Нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулах зорилтын хүрээнд 7 дугаар хорооллын "Г" хэсэгт баригдах орон сууцны хорооллын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 188,230,395.30 хүртэлх ам.долларын зээлийг БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас авч "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газарт (ТОКС ТӨҮГ) дамжуулан зээлдүүлэхийг МУХБ-нд зөвшөөрсөн.

ТОКС ТӨҮГ-аас 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр болон 2015 оны 8 дугаар сарын 12-ны өдрүүдэд МУХБ-нд БНХАУ-ын Эксим банкнаас авах дамжуулан зээлийг шийдвэрлэж өгөх хүсэлтийн дагуу МУХБ нь БНХАУ-ын Эксим банкинд 2015 оны 8 дугаар сард Г-1 хэсгийн барилга угсралтын ажилд 42,836,932.60 ам.доллар, Г-2 хэсгийн барилга угсралтын ажилд 86,138,566.14 ам.доллар, Г-3 хэсгийн барилга угсралтын ажилд 92,472,025.14 ам.долларын санхүүжилтийг тус тус олгох тухай зээлийн хүсэлтийг хүргүүлсэн.

Улмаар МУХБ-ны хүсэлтийн дагуу БНХАУ-ын Эксим банкны Үнэлгээний хороо хуралдаж, 2015 оны 12 дугаар сарын 29-ний өдөр ТОКС ТӨҮГ-аас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн Г-1 болон Г-2 хэсэгт МУХБ-аар дамжуулан нийт гэрээний дүнгийн 85 хувь буюу 109,629,173.93 ам.долларын (Г-1 хэсэгт 36,411,392.71, Г-2 хэсэгт 73,217,781.22 ам.доллар) санхүүжилтийг олгох тухай шийдвэр гарсан ба тус улсын Экспортын даатгалын корпораци буюу Синошурэ (Sinosure)-ийн даатгалтайгаар дараах ерөнхий нөхцөлийн дагуу МУХБ-нд санхүүжилт олгох боломжтой талаар мэдэгсэн.

Зээлдүүлэгч	БНХАУ-ын Экспорт-Импортын банк
Зээлдэгч	Монгол Улсын Хөгжлийн банк
Зээлийн төрөл	Дамжуулан зээл
Хугацаа	5 хүртэлх жил

НУУЦ

ИЛ БОЛСОН

Дүн	нийт 109,629,173.93 ам.доллар	
	36,411,392.71	73,217,781.22
Валют	ам.доллар	
Зээлийнжилийн хүү	6 сарын ЛАЙБОР* +3.80%	
Удирдлагын шимтгэл	0.50%(нэг удаа төлөгдөх)	
Даатгалын зардал**	3.06%(нэг удаа төлөгдөх)	
Коммитмент шимтгэл	0.80%(жилийн)	
Эрх зүйн зорхицуулалт	Англи хууль	

Монгол Улсад зохион байгуулагдсан Ази-Европын дээд хэмжээний чуулга уулзалтын хүрээнд хийгдсэн БНХАУ-ын Засгийн газрын тэргүүний айлчлалтай холбоотойгоор МУХБ болон БНХАУ-ын Эксим банк нь 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдөр тус зээлийн хөтөлбөрийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Уг гэрээ нь БНХАУ-ын Эксим банк болон МУХБ хоорондын харилцааг зохицуулах бөгөөд гэрээний дагуу санхүүжилтийг зөвхөн ТОСК ТӨҮГ-ын Орон сууцны 7-р хороолол төслийг санхүүжүүлэхэд ашиглахаар тооцсон байна.

1.2 ДОТООД ЗАХ ЗЭЭЛЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРҮҮД:

I.Чингис бондын эх үүсвэрийг байршуулах тухай

Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам (хуучнаар) болон Хөгжлийн банкны хооронд 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 01/12/3/88 тоот "Санхүүгийн зуучлалын гэрээ"-ний хүрээнд Хөгжлийн банк нь Чингис бондын хөрөнгөөс Хүснэгт 1-т харуулсаны дагуу нийт 2,021.25 тэрбум төгрөг болон 269.89 сая ам.долларыг тус тус хүлээн авсан байна.

Хүснэгт 1

Огноо	Ханш	Төгрөг	Ам.доллар
5/6/2013	1,432.81	0.00	84,740,000.00
5/10/2013	1,436.87	52,705,236,479.56	1,939,041.00
5/28/2013	1,441.93	253,999,999,694.35	0.00
7/16/2013	1,461.23	0.00	73,210,000.00
8/9/2013	1,570.32	390,870,000,036.00	0.00
10/2/2013	1,650.04	411,619,999,774.76	0.00
11/21/2013	1,746.01	431,570,499,999.60	0.00

26

НУУЦ

ИЛ БОЛСОН

11/27/2013	1,746.59	0.00	110,000,000.00
3/17/2014	1,764.80	355,060,000,005.79	0.00
4/8/2014	1,778.05	125,424,885,500.73	0.00
Нийт	1,643.14	2,021,250,621,490.79	269,889,041.00

Тухай үед Чингис бондын эх үүсвэрийг Хөгжлийн банканд ам.доллараар байршуулаагүй нь Чингис бондын эргэн төлөлтийг хийхэд хүүгийн зөрүүгээр МУ-ын Засгийн газар ханшийн алдагдал хүлээхээр байна. Хөгжлийн банк нь Чингис бондын эх үүсвэрийг гэрээний дагуу Засгийн газарт 2,021.2 тэрбум төгрөг, 269.9 сая ам.долларыг хүлээлгэн өгнө. Засгийн газар Чингис бондыг гадаад талдаа 2018 онд 500.0 сая ам.доллар, 2022 онд 1,000.0 сая ам.доллараар эргүүлэн төлөх бөгөөд ХБ-наас гэрээний дагуу хүлээн авах төлбөрийг 2016 оны 9 дүгээр сарын 4-ний Монголбанкны ам.долларын албан ханш 2,207.7 төгрөгөөр тооцон үзэхэд нийт 694.5 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний алдагдал хүлээхээр байна.

II. МИАТ бонд

Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 137 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ын 19 дүгээр тогтоолуудын дагуу АНУ-ын "Боинг" компаниас худалдан авах "Боинг"-767-300 ER загварын агаарын хөлгийн төлбөрт "МИАТ ТӨХК"-иас төлөх шаардлагатай 114,450,000\$-ын санхүүжилтийг тус компани нь АНУ-ын EXIM банкнаас урт хугацаатай зээл авах хүртэл Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор дотоодын зах зээлд үнэт цаас гаргахаар тогтсон. Үүний дагуу 2013 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Хөгжлийн банк болон Худалдаа Хөгжлийн банкны хооронд 78,550,000 ам.долларын үнэт цаас арилжаалах гэрээг байгуулсан.

Хөгжлийн банк гаргасан үнэт цаасыг АНУ-ын Экзим банкны урт хугацаатай зээл орж ирсэний дагуу буцаан худалдаж авсан байна.

III. Эрдэнэс МГЛ вексел

Засгийн газрын 2013 оны 239, 299 дүгээр тогтоолуудаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд "Говийн зам" ХХК-ийн барьсан авто зам, "Энержи ресурс" ХХК-ийн Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар барьсан дэд бүтцийг төрийн өмчид худалдан авч "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн мэдэлд шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт даалгасан ба ба энэ хүрээнд "Эрдэнэс Монгол" ХХК болон МУХБ-ны хооронд 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 3-ЭМГЛ-ХО-2014-05 дугаартай зээлийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан байна.

Уг дагуу 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр МУХБ-аас олгох зээлийн төлбөрийг гүйцэтгэхэд векселийг дамжуулан бичих, векселийн төлбөрийг хийхээр


МУХБ, Худалдаа Хөгжлийн банк, “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн хооронд векселээр хийх төлбөр тооцооны харилцааг зохицуулах тухай 3-ЭМГЛ-ХО-2014-07 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээнд векселийн нийт дүн 177,419,298,891.30 төгрөг, 1 ширхэг, векселийн хямдруулалтын хүүгийн хувь жилийн 4%, хямдруулан худалдах үнэ 170,595,479,703.17 төгрөг. Худалдаа, хөгжлийн банк нь хямдруулан авсан төлбөрийг “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн дансанд шилжүүлж, хүлээн авсан вексельд дамжуулан бичилт хийн Монголбанканд хямдруулан худалдахаар заасан байна.

Векселийн эргэн төлөлтийн хугацаа 2015 оны 2 дугаар сарын 12-нд байсан ч МУХБ-аас өөрийн хөрөнгөөс эргэн төлөгдөх шийдвэрийг ТУЗ-ын 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 42 дугаар тогтоолын дагуу банкны өөрийн хөрөнгөөр шийдвэрлэхээр тогтоосон байна. Энэхүү шийдвэр гарах хүртэл векселийн алданги төлбөр 1.9 тэрбум төгрөг байна.

Тухайн зээл олгох шийдвэр, эх үүсвэрийг векселээр хийх шийдвэрүүдийн нөлөөгөөр үүссэн векселийн алданги төлбөрийг “Эрдэнэс МГЛ” ХХК-тай байгуулсан зээлийн нэмэлт гэрээнд тусгуулан, улсын төсвөөс эргэн төлөлтийг хийх байдлаар тусгасан байна.

IV. АСЕМ үнэт цаас

Засгийн газрын 2015 оны 344 дүгээр тогтоолыг үндэслэн Ази, Европын дээд түвшний 11 дэх уулзалтын үеэр бусад улс орнуудын төрийн тэргүүнүүд, өндөр хэмжээний зочид төлөөлөгчдийг хүлээн авч байршуулах зочид буудлуудад олгох хөнгөлттэй зээлийг санхүүжүүлэх болон АСЕМ Вилла цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд шаардах нийт 275 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ХБ-наас дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлэхийг ХБ-ны ТУЗ-ийн 71 дүгээр тогтоолоор баталсан байна.



Эх үүсвэрийн эргэн төлөлт

Үнэт цаасны эх үүсвэрийн үндсэн төлбөр хугацааны эцэст хийгдэх ба үнэт цаасны хүүгийн төлбөрийг үнэт цаас гаргаснаас хойш хагас жил тутам төлнө.

V. Банк хоорондын эх үүсвэр

1. Үнэт цаас

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 15 дугаар, 2014 оны 293 дугаар тогтоолуудын дагуу Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээр богино(нэг жил хүртэлх) хугацаатай ЗГ-ын үнэт цаас худалдаж авахыг зөвшөөрсөн.

Тогтоолын дагуу Засгийн газрын үнэт цаасыг худалдан авахаар Сангийн яам болон МУХБ хооронд 115 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй 11 ширхэг үнэт цаасыг 1 жилийн хугацаатай, 5.5 хувийн хүүтэй 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр худалдан авсан байна.

МУХБ болон Улаанбаатар банкны хооронд 2014 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг байгуулж дараах 2 төрлийн нийт 35,000,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГ-ын үнэт цаасыг нийт 40,094,645,017 төгрөгөөр Хөгжлийн банканд худалдсан байна.

а. 1ш, нэгжийн нэрлэсэн үнэ-25,000,000,000 төгрөг, жилийн 11.50 хувь хүүтэй ЗГ-ын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сарын 21-нд 3 жилийн хугацаатай УБ хотын банк худалдан авсан.

б. 10ш, нэгжийн нэрлэсэн үнэ-1,000,000,000 төгрөг, нийт 10,000,000,000 төгрөгийг жилийн 7.8 хувийн хөвөгч хүүтэй ЗГ-ын үнэт цаасыг 2010 оны 07 дугаар сарын 19-нд 5 жилийн хугацаатай УБ хотын банк худалдан авсан.

МУХБ нь 2016 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн АПУХ-ны эчнээ хурлын 16/02/015 дугаартай шийдвэрээр Худалдаа Хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хадгаламжийн хэмжээг бууруулах үүднээс ХХБ-ны эзэмшиж буй Сангийн яамнаас 2016 оны 2 дугаар сарын 26-ны өдөр "Кью Эс Си" ХХК-д бичсэн 130.0 тэрбум төгрөгийн 13 ширхэг шилжих векселийг хуримтлагдсан хүүгийн хамтаар худалдан авах 2/608 тоот гэрээг, 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн АПУХ-ны эчнээ хурлын 16/02/013 дугаартай шийдвэрээр Улаанбаатар хотын банкинд байршуулсан мөнгөн хадгаламжийн хэмжээг бууруулах үүднээс ХХБ-ны эзэмшиж буй Сангийн яамнаас 2016 оны 2 дугаар сарын 26-ны өдөр "Кью Эс Си" ХХК-д бичсэн 53.6 тэрбум төгрөгийн 5 ширхэг шилжих векселийг хуримтлагдсан хүүгийн хамтаар худалдан авах 16/07-2/537 тоот гэрээг байгуулсан байна.

2. Хадгаламж

Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-16 тоот "Журам батлах тухай" тушаалаар Актив, пассивын удирдлагын хорооны үйл ажиллагаа, арилжааны үйл ажиллагаа, арилжааны банкуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам, аргачлалыг тооцох журмыг тус

29

НУУЦ

ИЛ БОЛСОН

тус баталсан. Дээрх журмуудын хүрээнд 2015 оны хагас жил болон жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад байршуулсан хадгаламж, харилцахын хязгаарлалтын тайлан дараах байдалтай байна.

Арилжааны банкуудад байршуулсан харилцах, хадгаламжийн 2015 оны хязгаарлалтын тайлан

6/30/2015

12/31/2015

№	Арилжааны банк	Хязгаарлалтын дүн /2015.06.15 -07.15/	Нийт Харилцах, Хадгаламж		Хэтэрсэн дүн/нэмэх боломжит дүн/ Харилцах, хадгаламж	Хязгаарлалтын дүн /2015.12.20-01.20/	Нийт Харилцах, Хадгаламж		Хэтэрсэн дүн/нэмэх боломжит дүн/ Харилцах, хадгаламж
			Хувь	Дүн			Хувь	Дүн	
1	Улаанбаатар Хотын банк	72,965.0	23.7%	259,421.80	(186,456.8)	83,722.80	31.2%	243,071.10	(159,348.3)
2	Капитал банк	45,285.3	5.5%	60,523.90	(15,238.6)		1.96%	15,283.00	(15,283.0)
3	Чингис Хаан банк	-	0.8%	8,800.00	(8,800.0)	-	1.90%	14,790.30	(14,790.3)
4	Капитрон банк	-	0.5%	5,000.00	(5,000.0)	7,357.50	0.38%	3,000.00	4,357.50
5	Богд	2,384.4	0.09%	1,000.00	1,384.40	1,506.30	0.00%	-	1,506.30
6	Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк	10,073.1	0.69%	7,530.00	2,543.10	9,957.90	1.96%	15,296.40	(5,338.5)
7	Төрийн банк	122,856.0	10.7%	117,722.10	5,133.90	128,952.30	13.9%	108,452.00	20,500.30
8	Хас банк	115,672.2	4.99%	54,546.50	61,125.70	95,977.50	0.0%	17.1	95,960.40
9	Худалдаа Хөгжлийн банк	498,857.8	36.8%	403,247.70	95,610.10	385,346.60	43.9%	342,896.10	42,450.50
10	Голомт	215,051.0	9.4%	103,342.40	111,708.60	196,481.70	4.02%	31,373.00	165,108.70
11	ХААН	416,429.0	6.6%	72,673.50	343,755.50	279,707.09	0.73%	5,667.30	274,039.80
Нийт дүн /сая төгрөг/		1,499,573.8	100 %	1,093,807.90	405,765.90	1,189,009.76	100%	779,846.30	409,163.50

Арилжааны банкны санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, мөнгөн хадгаламж байршуулах, хэмжээ тогтоох аргачлалын дагуу тооцон гаргасан банкуудад байршуулах боломжит хадгаламжийн хязгаарлалтын хэмжээг сар бүр Эрсдэлийн удирдлагын газраас гаргаж Актив, пассивын удирдлагын газар болон Актив, пассивын удирдлагын хороонд хүргүүлдэг байна.

Дээрх хүснэгтээс харахад 2015 оны хагас жил болон жилийн эцсийн байдлаар МУХБ-ны нийт харилцах, хадгаламжийн дийлэнх хувийг Худалдаа Хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкуудад байршуулсан, эрсдэлийн хязгаарлалтын дүнгээс Улаанбаатар хотын банкинд байршуулсан харилцах, хадгаламж хагас жилийн байдлаар 186.4 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн байршуулсныг АПУГ болон

АПУХорооноос хадгаламжаа бууруулах, журмын хүрээнд арга хэмжээ аваагүй нь жилийн эцсийн байдлаар хязгаарлалтын дүнгээс 159.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн байгаагаас харагдаж байна. Дээрх тайлангаас бусад банкуудад харилцах, хадгаламжийг нэмэх боломжтой байтал Улаанбаатар хотын банк, Капитал, Чингис хаан банкинд харилцах, хадгаламжийн хэмжээг хэтрүүлэн байршуулсан байгаа нь банкны эрсдлийн түвшинг нэмэгдүүлж байна.

2016 оны хагас жилийн байдлаар арилжааны банкуудад байршуулсан нийт харилцах, хадгаламж 706.8 тэрбум төгрөг/бусад валютыг хөрвүүлэн тооцсон/-ийн 242.1 тэрбум төгрөг Улаанбаатар хотын банкинд, 366.2 тэрбум төгрөг Худалдаа Хөгжлийн банкинд, нийт харилцах, хадгаламжийн 608.3 тэрбум төгрөгийг тус хоёр банкинд байршуулсан байна. Банкуудад харилцах, хадгаламж байршуулах хязгаарлалтын дүнгээс Улаанбаатар хотын банк 149.8 тэрбум, Худалдаа Хөгжлийн банк 8.5 тэрбум төгрөг, Чингис хаан банк 5.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн байршуулсан байна.

МУХБ-аас арилжааны банкуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журмын 4 дэх хэсгийн Актив, пассивын удирдлагын хороо эсвэл Актив, пассивын удирдлагын газрын захирлын шийдвэрийг үндэслэн эх үүсвэрийн чөлөөт үлдэгдлийг хадгалуулах тухай саналыг бичгээр эсвэл цахим шуудангаар авах, хүргүүлэх үйл ажиллагааг одоог хүртэл авч хэрэгжүүлээгүй, мөн харилцах, хадгаламжийн эрсдэлийн хязгаарлалтын дүнгээс хэтрүүлэн байршуулсан банкуудаас харилцах, хадгаламжаа эргүүлэн татах талаар АПУГ-ын захирлын шийдвэр, АПУХорооны шийдвэр гараагүй байгаа нь Гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-16 тоот журмыг зөрчсөн, банкны хөрөнгө эрсдэлтэй хэлбэрээр арилжааны банкуудад байршиж байна.

Эх үүсвэрийн зарцуулалт:

Эх үүсвэрүүдийн зарцуулалтын талаар мэдээллийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүдээр ангилан харуулж байна.

Тус хүснэгтэд Чингис бондын эх үүсвэр нийт 2,611.6 тэрбум төгрөг төгрөг/ханш: 2016 оны 8 дугаар сарын 16-ны байдлаар/-с улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдэд 1,819.2 тэрбум төгрөг, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдэд 637.1 тэрбум төгрөг нийт 2,456.4 тэрбум төгрөгийн зээлүүдийг олгосон бөгөөд эх үүсвэрийн үлдэгдэл 155.2 тэрбум төгрөг байна.

580 сая ам.долларын евро бондын эх үүсвэр нийт 1,268 тэрбум төгрөгөөс олгосон зээлийн нийт дүн 1,275 тэрбум төгрөг, БНХАУ-ын Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэр нийт 339.7 тэрбум төгрөгөөс олгосон зээлийн нийт дүн 362.8 тэрбум төгрөг, Кредит Свисс банкны хамтарсан зээлийн эх үүсвэр нийт 656.2 тэрбум төгрөг төгрөгөөс олгосон зээлийн нийт дүн 790.2 тэрбум төгрөг эх үүсвэрүүдээс олгосон зээлийн нийт дүн нь эх үүсвэрүүдийн дүнгээс нийт (164.2) тэрбум төгрөгөөр хэтрүүлэн олгосон байдлаар бүртгэсэн байна.

Самурай бондын эх үүсвэр, Олон Улсын Хөрөнгө оруулалтын банкны зээл, ВЭБбанкны зээл, Коммерз банкны зээл, ВТБанкны зээл, Каргилийн зээл, дотоод

39
НУУЦ

ИЛ БОЛСОН

үнэт цаас, банк хоорондын эх үүсвэр, өөрийн хөрөнгийн эх үүсвэрүүд нийт 1,865.5 тэрбум төгрөгөөс олгосон зээлийн нийт дүн 1,101.7 тэрбум төгрөг, эх үүсвэрийн үлдэгдэл нийт 763.8 тэрбум төгрөг байна.

		Эх үүсвэрийн зарцуулалт	Төгрөг	Ам.доллар	Евро	Иен	Нийт төгрөг
Чингис бонд	Чингис бондын эх үүсвэр		2,021,250,621,490.79	269,889,041.00	-	-	2,611,600,511,993.37
Чингис бонд	Нийт олгосон зээл		1,569,999,972,234.14	405,218,816.81	-	-	2,456,367,507,746.70
	Төсвөөс		1,328,030,980,522.18	224,555,823.08	-	-	1,819,219,896,809.61
	Төслөөс		241,968,991,711.96	180,662,993.73	-	-	637,147,610,937.09
	Эх үүсвэрийн үлдэгдэл		451,250,649,256.65	(135,329,775.81)	-	-	155,233,004,246.67
ДХЕӨБХ 580 сая ам.доллар	ДХЕӨБХ 580 сая ам.долларын бондын эх үүсвэр			580,000,000.00	-	-	1,268,680,400,000.00
ДХЕӨБХ 580 сая ам.доллар	Нийт олгосон зээл		184,189,227,957.68	499,014,826.47	-	-	1,275,724,279,081.23
	Төсвөөс		604,800,000.00	176,767,625.29	-	-	387,262,768,206.45
	Төслөөс		183,584,427,957.68	322,247,201.18	-	-	888,461,510,874.79
	Эх үүсвэрийн үлдэгдэл		(184,189,227,957.68)	80,985,173.53	-	-	(7,043,879,081.23)
Самурай бонд	Самурай бондын эх үүсвэр					24,250,214,308.00	524,289,633,338.96
Самурай бонд	Нийт олгосон зээл		317,111,996,661.71	58,392,830.79	-	-	444,839,306,866.85
	Төсвөөс		-	58,392,830.79	-	-	127,727,310,205.14
	Төслөөс		317,111,996,661.71	-	-	-	317,111,996,661.71
	Эх үүсвэрийн үлдэгдэл		(317,111,996,661.71)	(58,392,830.79)	-	24,250,214,308.00	79,450,326,472.11
БНХАУ-н Хөгжлийн банкны зээл	БНХАУ-н Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэр			155,310,000.00	-	-	339,721,987,800.00
БНХАУ-н Хөгжлийн банкны зээл	Нийт олгосон зээл		-	165,901,127.08	-	-	362,888,807,358.86
	Төсвөөс		-	165,901,127.08	-	-	362,888,807,358.86
	Төслөөс		-	-	-	-	-
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	(10,591,127.08)	-	-	(23,166,819,558.86)
Кредит Свисс банкны хамтарсан зээл	Кредит Свисс банкны хамтарсан зээлийн эх үүсвэр			300,000,000.00	-	-	656,214,000,000.00
Кредит Свисс банкны хамтарсан зээл	Нийт олгосон зээл		436,024,693,730.58	161,910,525.78	-	-	790,184,539,612.95
	Төсвөөс		10,749,999,997.00	51,310,541.80	-	-	122,985,652,921.20
	Төслөөс		425,274,693,733.58	110,599,983.98	-	-	667,198,886,691.75
	Эх үүсвэрийн үлдэгдэл		(436,024,693,730.58)	138,089,474.22	-	-	(133,970,539,612.95)
ОУХОБанкны зээл	ОУХОБанкны зээлийн эх үүсвэр				20,000,000.00	-	48,856,800,000.00
ОУХОБанкны зээл	Нийт олгосон зээл		4,500,000,000.00	9,000,000.00	-	-	24,186,420,000.00
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		4,500,000,000.00	9,000,000.00	-	-	24,186,420,000.00
	Эх үүсвэрийн үлдэгдэл		(4,500,000,000.00)	(9,000,000.00)	20,000,000.00	-	24,670,380,000.00
ВЭБанкны зээл	ВЭБанкны зээлийн эх үүсвэр			19,999,999.39	-	-	43,747,598,665.70
ВЭБанкны зээл	Нийт олгосон зээл		-	-	-	-	-
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		-	-	-	-	-
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	19,999,999.39	-	-	43,747,598,665.70
Коммерц банкны зээл	Коммерц банкны эх үүсвэр				12,179,623.50	-	29,752,871,470.74
Коммерц банкны зээл	Нийт олгосон зээл		-	-	12,179,623.50	-	29,752,871,470.74
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		-	-	12,179,623.50	-	29,752,871,470.74
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	-	-	-	-
ВТБанкны зээл	ВТБанкны зээлийн эх үүсвэр			65,430,000.00	-	-	143,120,273,400.00
ВТБанкны зээл	Нийт олгосон зээл		-	-	-	-	-
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		-	-	-	-	-
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	65,430,000.00	-	-	143,120,273,400.00
Каргиллийн зээл	Каргиллийн эх үүсвэр			75,000,000.00	-	-	164,053,500,000.00
Каргиллийн зээл	Нийт олгосон зээл		-	-	-	-	-
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		-	-	-	-	-
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	75,000,000.00	-	-	164,053,500,000.00
Дотоодын үнэт цаас	Дотоодод гаргасан үнэт цаасны эх үүсвэр		233,425,387,969.00		-	-	233,425,387,969.00
Дотоодын үнэт цаас	Нийт олгосон зээл		233,425,387,969.00	-	-	-	233,425,387,969.00
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		233,425,387,969.00	-	-	-	233,425,387,969.00
	Эх үүсвэрийн үлдэгдэл		-	-	-	-	-
Банк хооронд	Банк хоорондын эх үүсвэр		14,000,000,000.00	119,660,000.00	43,600,000.00	-	382,249,714,800.00
Банк хооронд	Нийт олгосон зээл		-	71,299,999.99	-	-	155,960,193,978.13
	Төсвөөс		-	-	-	-	-
	Төслөөс		-	71,299,999.99	-	-	155,960,193,978.13
	Эх үүсвэрийн үлдэгдэл		14,000,000,000.00	48,360,000.01	43,600,000.00	-	226,289,520,821.87
Өөрийн хөрөнгө	Өөрийн хөрөнгө		296,069,885,975.06		-	-	296,069,885,975.06
Өөрийн хөрөнгө	Нийт олгосон зээл		171,321,922,712.47	19,312,569.50	-	-	213,565,850,985.38
	Төсвөөс		171,180,948,040.17	-	-	-	171,180,948,040.17
	Төслөөс		140,974,672.30	19,312,569.50	-	-	42,384,902,945.21
	Эх үүсвэрийн үлдэгдэл		124,747,963,262.59	(19,312,569.50)	-	-	82,504,034,989.68

Эх үүсвэр, зээлийн эргэн төлөлтийн хуваарь:

Монгол улсын Хөгжлийн банкны олон улсын зах зээлээс босгосон бонд, зээлийн эх үүсвэр болон дотоод зах зээлээс босгосон үнэт цаас, бондын эх үүсвэрүүдийн эргэн төлөлтийн хуваарийг он тус бүрээр доорх хүснэгтэд харууллаа. Зарим эх үүсвэрийн хувьд гэрээний үүргийн дагуу Монгол улсын зээлжих зэрэглэл буурахад хүүгийн түвшинд өөрчлөлт орох гэрээний үүргийг ханган ажилладаг тул 2016 оны 9 дүгээр сарын 3-ны байдлаар нэгтгэн харуулж байна. Эх үүсвэрүүдийн эргэн төлөлт 2017 онд 1,644.0 тэрбум төгрөг, 2018 онд 1,497.4 тэрбум төгрөг, 2022 онд 1,863.3 тэрбум төгрөг буюу хамгийн өндөр төлөлттэй жилүүд байхаар харагдаж байна. Одоогийн байдлаар эх үүсвэрүүдийн эргэн төлөлт 2016-2023 онуудаар тооцон гаргахад нийт 6,736.2 тэрбум төгрөг байхаар байна.

Валют	Байгууллага	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	НИЙТ
MNT	MOF	14,079,253,424.66	-	-	-	-	-	-	-	-	14,079,253,424.66
	Chinggis Bond	48,426,133,014.99	96,852,266,029.97	465,180,295,578.42	78,734,577,008.17	78,734,577,008.17	78,734,577,008.17	1,721,879,536,170.17	-	-	2,568,541,961,818.05
	ASEM 125	2,515,068,493.15	5,000,000,000.00	5,000,000,000.00	4,990,684,931.51	5,009,863,013.70	64,989,041,095.89	66,309,589,041.10	-	-	153,814,246,575.34
	ASEM 150	2,173,337,095.71	4,335,903,737.94	102,619,627,049.40	10,347,344,109.59	-	-	-	-	-	119,476,211,992.64
Нийт MNT	67,193,792,028.50	106,188,169,767.91	572,799,922,627.82	94,072,606,049.26	83,744,440,021.86	143,723,618,104.06	1,788,189,125,211.27	-	-	2,855,911,673,810.69	
USD	CDB	4,327,956.67	34,815,325.00	33,262,225.00	31,709,125.00	30,156,025.00	28,602,925.00	27,049,825.00	-	-	189,923,406.67
	CS	8,266,050.00	99,786,468.00	91,811,664.00	140,592,240.00	-	-	-	-	-	340,456,422.00
	VEB	2,756,199.91	2,954,999.91	2,885,199.91	2,809,099.91	2,737,899.91	2,664,199.92	2,591,199.92	1,268,199.99	-	89,054,794.52
	Cargill	3,513,698.63	25,777,397.26	59,763,698.63	-	-	-	-	-	-	67,396,575.89
	VTB	67,396,575.89	-	-	-	-	-	-	-	-	67,396,575.89
	DBM	16,675,000.00	596,675,000.00	-	-	-	-	-	-	-	613,350,000.00
	Chinggis Bond	6,466,136.59	12,932,273.18	271,002,653.41	-	-	-	-	-	-	290,401,063.18
Нийт USD	109,401,617.69	772,941,463.34	458,725,440.95	175,110,464.91	32,893,924.91	31,267,124.92	29,641,024.92	1,268,199.99	-	1,611,249,261.63	
EUR	Commerz	1,312,070.24	2,588,014.37	2,542,053.20	2,494,356.44	1,229,661.56	-	-	-	-	10,166,155.81
	ИБ	610,000.00	3,013,760.33	4,631,476.67	4,409,983.67	4,190,612.00	3,969,422.33	3,746,564.00	-	-	24,571,819.00
Нийт EUR	1,922,070.24	5,601,774.70	7,173,529.87	6,904,340.11	5,420,273.56	3,969,422.33	3,746,564.00	-	-	34,737,974.81	
JPY	Samurai	228,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	30,456,000,000.00	-	33,420,000,000.00
Нийт JPY		228,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	456,000,000.00	30,456,000,000.00	-	33,420,000,000.00
НИЙТ ДН төгрөгөөр		290,458,309,250.61	1,644,048,947,747.83	1,497,417,314,075.48	461,502,224,595.70	168,845,371,240.35	222,479,612,056.79	1,863,269,640,377.59	588,157,760,526.09	-	6,736,179,179,870.44

Хөгжлийн банкнаас олгосон зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүд, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдэд олгосон зээлүүдээр тус тус доорх хүснэгтэд харууллаа. Нийт зээлүүдийн эргэн төлөлт 2017 онд 1,654.4 тэрбум төгрөг, 2022 онд 1,664.7 тэрбум төгрөг буюу хамгийн өндөр төлөлттэй жилүүд байхаар байна. 2016 оны 8 дугаар сарын 16-ны байдлаар нийт олгосон зээлүүд 2016-2024 онуудад нийт 5,558.6 тэрбум төгрөг байхаар байна.

Хөгжлийн банкнаас олгосон зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарь он тус бүрээр

2016 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн ханш: USD 2,187.38
EUR 2,442.87

Валют	Зээлийн ангилал	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
MNT	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл	36,984,240,679	1,190,268,337	1,084,693,255	200,886,701,035	170,595,479,703		1,099,825,345,551			1,510,566,728,559
	Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл	38,595,821,347	251,533,510,455	197,163,348,748	121,935,807,751	292,327,486,261	245,951,002,047	72,151,851,852			1,219,658,828,460
Нийт MNT		75,580,062,025	252,723,778,792	198,248,042,003	322,822,508,786	462,922,965,964	245,951,002,047	1,171,977,197,402	-	-	2,730,225,557,019
USD	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл	2,512,000	389,828,877					216,277,071	68,310,000		676,927,948
	Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл	36,975,654	250,996,923	106,805,413		61,265,000	87,479,774	9,000,000		50,000,000	602,522,764
Нийт USD		39,487,654	640,825,800	106,805,413	-	61,265,000	87,479,774	225,277,071	68,310,000	50,000,000	1,279,450,712
EUR	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл										
	Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээл				12,179,624						12,179,624
Нийт EUR		-	-	-	12,179,624	-	-	-	-	-	12,179,624
Нийт ДҮН /төгрөгөөр/		161,954,566,741.18	1,654,453,317,150.23	431,872,066,487.41	352,575,745,645.30	596,932,801,664.46	437,302,510,777.24	1,664,743,756,988.29	149,419,927,800.00	109,369,000,000.00	5,558,623,693,254.11

АПУГазрын эх үүсвэрийн дүгнэлтийг үндэслэхгүйгээр Зээлийн хорооны шийдвэр гардаг ба АПУГазраас эх үүсвэр бүрийг ангилан, хүүгийн түвшин, зээлийн эргэн төлөлтийн хугацааг тогтоосон дүгнэлтийг Зээлийн хороонд хүргүүлсэний дагуу түүнд тохирох төслийг санхүүжүүлэх шаардлагатай байна.

Мөн өдөр тутам гаргадаг дотоодын банкуудад байршуулсан хадгаламж болоод эх үүсвэрүүдийн тайлангаас харахад тухайн банкны активын 13 хувьтай тэнцэх хэмжээний хадгаламжийг нэг банкинд байршуулж байгаа нь хадгаламжийн төвлөрөл их байгааг харуулж байна. Энэхүү хадгаламжийн төвлөрөл нь Хөгжлийн банкнийг эрсдэлд оруулаад зогсохгүй төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлөхөөр байна.

МУХБ-ны гадаад болон дотоодоос босгосон эх үүсвэрүүдийн хүү, эргэн төлөлтийн хуваарь нь хоорондоо харилцан адилгүй байдаг. Гэтэл 580 сая ам.долларын евро бонд, БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл, Кредит Свисс банкны хамтарсан зээлийн эх үүсвэрээс олгосон зээлийн нийт дүн нь хэтэрсэн байгаа нь Зээлийн хорооноос төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ эх үүсвэрийн хүү, хугацаа зэрэгтэй уялдуулан санхүүжүүлдэггүй болохыг харуулж байна. 2017 оны эхний улиралд багтаан МУХБ-аас Дунд хугацааны евро өрийн бичиг болох 580 сая ам.долларын эх үүсвэрийн эргэн төлөлтийг хийхээр байтал 2016 оны бизнес төлөвлөгөөний эхний хагас жилийн гүйцэтгэлээр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээлийн эргэн төлөлт 3 хувь, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн зээлийн эргэн төлөлт 62 хувь буюу нийт 123.7 тэрбум төгрөгөөр зээлийн эргэн төлөлт тасалдаад байна.

МУХБ-ны эх үүсвэрүүдийн болон төслүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг харьцуулан харахад ойрын 3 жилийн хугацаанд эх үүсвэрүүдийн эргэн төлөлт нийт 3,431.8 тэрбум төгрөг байхад зээлийн эргэн төлөлт нийт 2,248.3 тэрбум төгрөг байгаа (зээлийн эргэн төлөгдөх чадвараас хамаарах) нь эх үүсвэрүүдийн эргэн төлөлтийг хийхэд саад учруулахаар байна.

Өөрөөр хэлбэл, эх үүсвэрүүдийн эргэн төлөлтийн хүү, хугацааг үндэслэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж буй зээлийн суурь хүү, эргэн төлөлтийн хугацааг тооцоолоогүй нь дээрх асуудлыг бий болгож байна.

Сангийн сайдын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 7-1/4437 албан тоотор Монгол Улсын Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагаа, зохистой засаглал, харилцагч, ажиллагсадын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусч, шинээр байгуулагдах Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэх хүртэл хугацаанд шинээр зээл олголт, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт гаргахгүй, үнэт цаас худалдах, худалдан авах шийдвэр гаргахгүй, аливаа өр төлбөр үүсгэх, их хэмжээний гэрээ хэлцлэл хийхгүй, банкинд бүтцийн өөрчлөлт буюу томилгоо, халаа, сэлгээг хийхгүй, хэвийн үйл ажиллагааг хангахаас бусад аливаа шийдвэр гаргахгүй байх чиглэл, даалгаврыг хүргүүлсэн.

Дээрх байдлыг зөрчин дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

1. Худалдаа Хөгжлийн банкны эзэмшиж байсан нийт 130.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын шилжих векселийг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр худалдан авч, 61.75 сая ам.долларын 3 сар хүртэл хугацаатай хадгаламж, 12.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.
2. Улаанбаатар банкны эзэмшиж байсан нийт 53.6 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын шилжих векселийг 2016 оны 7 дугаар сарын 7-ны өдөр худалдан авч, 3.0 тэрбум төгрөгийн ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн зээл олгосон.
3. Богд банкинд 2016 оны 7 дугаар сарын 5-ны байдлаар 2 сая еврогийн 3 сараас доош хугацаатай хадгаламж байршуулсан.
4. Голомт банкинд 3.2 тэрбум төгрөгийн зээл, 5.0 тэрбум төгрөгийн 3 сар хүртэл хугацаат хадгаламж байршуулсан.
5. Төрийн банкинд 24.7 тэрбум төгрөгийн 3 сар хүртэл хугацаат хадгаламж, 18.0 тэрбум төгрөгийн ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн зээл олгосон.
6. Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд 1.0 тэрбум төгрөгийн 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж байршуулсан.
7. Хас банкинд 0.9 тэрбум төгрөгийн зээл олгосон.
8. Чингис хаан банкинд 3.0 тэрбум төгрөгийн 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж, 250.0 мянган ам.долларын 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж байршуулсан байна.

Дээрх хугацаанд нийт 2 сая евро, 215.8 тэрбум төгрөг, 62 сая ам.долларын зээл(зээл, хадгаламж, үнэт цаас)-ийг олгосон байна.

Хоёр. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалт, санхүүжилт холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуурыг хангасан байдал

Шалгалт хийхдээ Хөгжлийн банкны 2011-2016 оны худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг, тухайн онуудад бараа, ажил, үйлчилгээ худалдан

авахаар хийсэн гэрээ, гүйцэтгэх захирлын тушаал, ТУЗ-ын тогтоол зэрэгт үндэслэн тухайн онуудад худалдан авалт хийхдээ 2012, 2013 онд батлагдсан "Монгол Улсын Хөгжлийн банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ыг мөрдсөн эсэхийг хянан үзлээ.

Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль 2011 оны 2 дугаар сард УИХ-аар батлагдсан бөгөөд түүнийг дагалдан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд "Монгол Улсын хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж 3.6 заалтыг нэмэлтээр оруулж баталсан байдаг.

Дээрх хуулийн заалтаас шалтгаалан тус банк нь өөрийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмыг дараах байдлаар батлан хэрэгжүүлсэн байна. Үүнд:

"Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам" /ЖББ, үнэлгээний зааврын хамт/-ыг 2012 оны 5 дугаар сарын 30-ны ТУЗ-ын 24 дүгээр тогтоолоор батласан бөгөөд журмыг 2013 оны 5 дугаар сард хүчингүй болгосон байна.

2013 оны 9 сарын 25-ны өдрийн А-127 тоот гүйцэтгэх захиралын тушаалаар "Монгол улсын Хөгжлийн банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам" гэж баталсан байна. Энэхүү журам нь 2015-2016 онуудад 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Журмын хэрэгжилт :

2011-2016 онд Хөгжлийн банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан архивын баримтад тулгуурлан "Монгол улсын Хөгжлийн банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам" /цаашид "журам" гэх/-ын дагуу үзэхэд дараах байдалтай байна.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт нь нээлттэй болон үнийн харьцуулалт, шууд гэрээгээр хийгдсэн байна. Тухайлбал: 2014 онд 638 сая төгрөгийн өртөг бүхий 4 жийп автомашин худалдан авахдаа нээлттэй тендер шалгаруулалтын журмыг ашиглаж зохион байгуулсан бол бусад худалдан авалтын хувьд журмын 5.1-д заасан харьцуулалтын босго үнийг баримталсан байна.

Үнийн харьцуулалт хийхдээ урилгыг банкны вэб сайтад байршуулдаг бөгөөд худалдан авах бараа, ажил үйлчилгээнд тавигдах техникийн тодорхойлолт болон үнийн санал авах баримт бичиг боловсруулдаггүй нь журмын 8, 14 дүгээр зүйлийг зөрчсөн, албан ёсоор мөрдөгдөх үнийн санал авах баримт бичиг нь батлагдаагүй байна. Тендерийн нээлтийн цаг нь тодорхойгүй, 4 цагаас 4 өдрийн дараа хийсэн нь журмын 21.1 дүгээр зүйлийг зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн материалд харьцуулалтын аргаар хийсэн тендерийн урилга, нээлтийн тэмдэглэл, тендер хүлээн авсан бүртгэл, үнэлгээний хорооны тэмдэглэл, оролцогчдын ирүүлсэн материал, үнэлгээний

хорооны дүгнэлт, гүйцэтгэх захиралын зардал батлах тушаал зэргийг хавсаргасан байна.

Тус банкны байгуулсан гэрээний хувьд нэгдсэн загваргүй, зарим гэрээ нь үнийн дүн байхгүй, огноогүй, нэгдсэн дугаарлалтгүй зэрэг зөрчилтэй байна. Тухайлбал: "Анун" ХХК-аас тасалгааны тавилга, хэрэгсэл худалдан авах 2011, 2013 оны гэрээнүүд нь үнийн дүнгүй байна. Үүнээс үзэхэд одоог хүртэл тавилга хэрэгсэл авах тендер шалгаруулалт огт зарлагдаагүй, дээрх гэрээний дагуу худалдан авдаг байна.

2011 оны худалдан авах ажиллагааны баримтаас үзэхэд 1 удаа үнийн харьцуулалт хийж 838,486,550 төгрөгөөр банкны програм хангамж худалдан авсан байна. Тухайн онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийт гэрээний дүн 1,167,540,546 төгрөг байх бөгөөд үүнээс 329,053,996 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ хугацаанд банкны худалдан авах ажиллагааг зохицуулах журам байгаагүй тул журам зөрчсөн гэж шууд дүгнэх боломжгүй байдалд орж байна.

2012 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийт гэрээний дүн 307,766,912 төгрөг байна. Үүнээс үнийн харьцуулалт хийж Оракл програм хангамж, лицензийн хамт 136,254,398 төгрөгөөр авсан байна. 2012 оны 5 сард бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам батлагдсан хэдий ч бүтээгдэхүүний даатгалт үйлчилгээ, харуул хамгаалалт болон аудитын үйлчилгээ авахад нийт 197,780,000 төгрөгийн гэрээ хийсэн нь журам батлагдсан хугацаанд хамаарахгүй байна.

2013 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийт гэрээний дүн 4,447,856,145 төгрөг байна. Үүнээс үнийн харьцуулалт хийж 1 ширхэг суудлын, 1 ширхэг ниссан навара, 2 ширхэг тоёота прадо маркийн автомашинуудыг 3 удаа үнийн харьцуулалт хийж 233,200,000 төгрөгөөр худалдан авсан байна. Журамаа зөрчин худалдан авсан гэрээний дүнгийн ихэнх хувийг "Блүүмберг ТВ"-тэй 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан 1,835,200 ам доллар буюу тухайн үеийн ханшаар хөрвүүлвэл 3,115,252,000 төгрөгийн гэрээ эзэлж байна. ТУЗ-ийн 2012 оны 5 сард баталсан "Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам" нь 2013 оны 4 сард ТУЗ-ын 13 тоот тогтоолоор хүчингүй болсон бөгөөд мөн оны 9 сарын 25-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр журамгүй байжээ.

2014 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийт гэрээний дүн 2,147,085,583 төгрөг байх бөгөөд үүнээс 638,000,000 төгрөгөөр тоёота ландкузер 200 маркийн автомашин 4 ширхэгийг нээлттэй тендер шалгаруулалт зарлан "Таван богд" ХХК-аас худалдан авсан байна. Мөн 605,900,000 төгрөг нь "Макс импекс" ХХК-д төлсөн ажлын байрны түрээсийн зардал байх бөгөөд үүнийг хасаад нийт 599,144,583 төгрөгийн гэрээ байгуулахдаа журмын дагуу тендер шалгаруулалт зарлаагүй байна. Тухайлбал: Цагаан Чингис брэндийн шинэ жилийн идэвхижүүлэлтийн ажил, Альфа мюзик хөтөлбөрийн 9 удаагийн шоу арга хэмжээ зохион байгуулах гэх мэт 3 ажилд "Анар-Од" ХХК-тай нийт 76,200,000 төгрөгийн дүнтэй гэрээ, "Ай Си Эйч" ХХК-тай 62,300,000 төгрөгийн өртөг бүрий "цуврал нэвтрүүлэг хийлгэх, телевизүүдээр цацах" гэрээ, "Монголын шилдэг нийтлэлчдийн клуб" ТББ-тай 60,000,000 төгрөгийн өртөг бүхий "Монгол Улсын Хөгжлийн банкны

олон нийттэй харилцах бодлогод мэргэжлийн зөвлөгөө өгч хяналт тавих” гэрээг тус тус шууд хийсэн байна.

2015 онд худалдан авсан нийт гэрээний дүн 29,320,271,145 төгрөг байх бөгөөд үүнээс 27,598,081,637 төгрөгийн өртөг бүхий Худалдаа хөгжлийн банкнаас худалдан авах ажлын байрны гэрээ ихэнх хувийг эзлэж байна. Тухайн оны худалдан авах ажиллагааны материалаас харахад өндөр үнийн дүн бүхий гэрээнүүд нь гадаадын байгууллагуудтай хийгдсэн байх бөгөөд эдгээр нь гүйцэтгэх захиралын 2015 оны 3 сард бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журамд “...зэрэглэл тогтоолгох, хууль зүйн үйлчилгээ, гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтран төсөл санхүүжүүлэхэд мэргэжлийн экспертизийн зөвлөх сонгох...” зэргийг харьцуулалтын аргаар үнийн санал авч сонгохоор өөрчлөлт оруулсны дагуу хийгдсэн гэрээ байна. Тухайлбал: Зээлжих зэрэглэл тогтоолгох зорилгоор “PWC adviser” ХХК-тай 116,322,570 төгрөгийн, “Стандарт энд Пүүрс” ХХК-тай 84,978 ам доллар буюу 167,699,834 төгрөгийн, “Мүүдийз инвесторс сервис” ХХК-тай 85,000 ам доллар буюу 169,618,350 төгрөгийн гэрээг тус тус хийсэн байна. Хуулийн зөвлөгөө авахаар “Майер Браун” ХХК-тай 268,176,090 /ТУЗ-ийн 30-р тогтоолоор/ болон 64,609,350 төгрөгийн өртөг бүхий гэрээг тус тус байгуулсан байна.

2016 онд худалдан авсан нийт гэрээний дүн 1,365,980,208 төгрөг бөгөөд үүний 1,186,308,250 төгрөгийн гэрээ нь банкыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах ажилд зориулан 6 сард байгуулсан гэрээнүүд ихэнх хувийг эзэлж байх бөгөөд эдгээрийн зарим нь үнийн саналыг харьцуулсан боловч ихэнх нь дотоод журамаа мөрдөлгүй шууд гэрээ хийсэн байна.

Тус банк нь өөрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зориулж журам баталсан хэдий ч ихэнх худалдан авалтуудыг ТУЗ-аас баталсан нийт төсөвт өртөгийг үндэслэл болгожгүй төсөвт өртгийг хэд хэд хуваан тендер шалгаруулалт зохион байгуулдаг хандлага байх ба журамд үүнийг хязгаарласан заалт байхгүй байна.

Дотоодод мөрдөж байгаа журам нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтуудыг авсан хэдий ч үр ашигтай байх, ил тод байх зарчмыг хангасан заалтуудыг орхигдуулж худалдан авах ажиллагааг ил тод бус байдлаар үнийн харьцуулалт болон шууд худалдан авалтын хэлбэрээр явуулж байна.

Гурав. Төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, тэдгээрийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүн, зээлийн эргэн төлөлтийн явц

3.1 Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагаатай холбоотой бусад бодлого, тэдгээрийн хэрэгжилт

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт “Хөгжлийн банкны зээлийн бодлого”-ыг зээлийн найдвартай эргэн төлөгдөх зарчимд тулгуурлан жил бүр тодорхойлж батлах гэж заасан бөгөөд Монгол Улсын

Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 13 дугаар тушаалаар “Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлого”-ыг баталсан байна. Үүнээс хойш жил бүр тодорхойлж баталсан зүйл байхгүй. “Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлого”-ын 10 дахь хэсгийн 10.1-д **“Банк нь зээл болон түүнтэй адилтган тооцох актив хөрөнгийн ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг нөхөх зорилгоор зээлийн эрсдэлийн сан байгуулна. Актив хөрөнгийн ангилал, активын эрсдэлийн сан байгуулах аргачлал, түүнд харгалзан үзэх хүчин зүйлсийг ТУЗ-өөс батлах “Активын ангилалын журам”- аар нарийвчлан заах ба энэ нь НББОУС, СТОУС-д нийцсэн байна”** гэж заасан байна.

Активын ангиллын журам нь банкны активын чанарыг тодорхойлох, активын эрсдэлийн түвшинг тодорхойлох, болзошгүй эрсдэлийг нөхөх, хяналтын зорилго бүхий журам бөгөөд банкны дотоод үйл ажиллагааг зохицуулсан, зөвхөн дотоодод ашиглагдах журам биш юм. Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын 2012 оны А-22 дугаар тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам” баталж, 2015 оны А-26 дугаар тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-днэмэлт өөрчлөлт оруулсан байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2011 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлого”-ын 10 дахь хэсгийн 10.1 дэх заалтыг зөрчсөн байна.

“Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлого”-ын 10 дахь хэсгийн 10.1-ийн дагуу тус банкны ТУЗ-өөс “Активын ангилалын журам”-ыг баталж, банкны үйл ажиллагаанд мөрдүүлээгүй, дээрх журмыг Гүйцэтгэх захирал баталж, журамд өөрчлөлт оруулж, болзошгүй эрсдэлийг нөхөх эрсдэлийн санг зардлаар байгуулах хувь хэмжээ, зээлийн чанарын ангилалыг өөрчилж байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн чанар, ашигт ажиллагаа, эрсдэлийн бодит байдлыг тодорхойлох, хяналт тавих боломжийг бууруулж байна гэж үзлээ. Гүйцэтгэх захирлын 2012 оны А-22 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-аар Хөгжлийн банкны активыг эргэн төлөгдөх хугацаа болон зээлдэгчийн санхүүгийн тайланд үндэслэн ангилж, эрсдэлээс хамгаалах санг зардлаар байгуулах зохицуулалттай байсныг 2015 оны А-26 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулснаар актив тус бүрд байгуулах эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ болон алдагдлын хэмжээг харьцангуй багаар тайланд тусгаж, өөрийн хөрөнгө болон эрсдэл даах чадварыг өндөр түвшинд харагдуулж байна.

Тус банкны “Зээлийн бодлого”-д дараах зохистой харьцааг тусгасан байна. Үүнд:

9.1-д “Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг шаардлагатай тохиолдолд дотоод удирдлагадаа хэрэгжүүлж болно.”

9.2-д “Банкны санхүүгийн хяналтын тогтолцоо, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээ, удирдлагын заавар хүчин төгөлдөр болсоноор банк нь энэ бодлогод өөрчлөлт орсон эсэхээс үл хамааран энэхүү зааврыг мөрдөнө.”

9.3-д “Энэхүү бодлогын 9.2 дах заалтад заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээ, удирдлагын үйл ажиллагаа нь тогтворжих хүртэл банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 12%, 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 6%-аар тогтооно.”

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон Монголбанкны Нягтлан бодох бүртгэлийн багц материал шинэчлэн батлагдсан, мөн тус банкны “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-д дансны гүйлгээний зааврыг тусгаагүй байх тул “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-оо СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Монголбанкны Нягтлан бодох бүртгэлийн багц материалд нийцүүлэн боловсруулж, батлах шаардлагатай байна. “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Дансны жагсаалт”, “Санхүүгийн тайлангийн маягт, загвар”, “Санхүүгийн тайлан, тодруулга бэлдэх аргачлал” зэргийг боловсруулан Сангийн яамаар хянуулсаны үндсэн дээр Хөгжлийн банкны ТУЗ-аар батлуулах нь зүйтэй.

ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын алба

Дотоод аудитын алба нь шалгалт хамрах хугацаанд зээлийн үйл ажиллагааг шалгах, зээлийн эрсдэлийг үнэлэх, илрүүлэх, бууруулах талаар маш хангалтгүй ажилласан ба цаашид уг албаны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

Эрсдэлийн удирдлагын хороо(ЭУХ)

Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын 2013 оны А-133 дугаар тушаалаар батлагдсан “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-аар ЭУХ-ны ээлжит хурлыг сар бүр хийхээр журамласан боловч 2013 онд 2 удаа, 2014 онд 4 удаа, 2015 онд 6 удаа, 2016 онд нэг удаа хуралдсан байна. Энэ журманд заасан хэлэлцэх асуудлыг бүрэн хамарч үйл ажиллагаа явуулаагүй ба зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах, бууруулах талаар Эрсдэлийн удирдлагын хороо маш хангалтгүй ажиллажээ.

Зээлийн хороо

Шалгалт хамрах хугацааны Зээлийн хорооны хурлаар хэлэлцсэн асуудал нь бүхэлдээ зээл олгох, зээлийн гэрээний нөхцөл өөрчлөх шийдвэр гаргах байсан ба Зээлийн хороо олгосон зээлийн ашиглалтыг хэлэлцэх, зээлийн эрсдэлийг илрүүлэх, бууруулах, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр маш хангалтгүй ажиллажээ.

Зээлийн бүтэц

Шалгах өдрийн байдлаар нийт 5.56 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд шалгалтаар зээлийн багцыг түүврийн аргаар шалгав.

Зээлийн өрийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар нь харуулбал:

№	Эдийн засгийн салбар/төсөл, хөтөлбөрийн зориулалт/-ын ангилал	Зээлийн багц /тэрбум төгрөгөөр/	Нийт багцад эзлэх хувийн жин
Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээл		2,991.3	53.8%
1	Авто зам	1,281.5	23.0%
	Орон нутаг	1,143.9	20.6%

Улаанбаатар		137.6	2.4%
2	Гудамж төсөл	134.0	2.4%
Инженерийн дэд бүтэц		344.1	6.2%
3	Орон сууцны хорооллын дэд бүтэц	215.5	3.9%
	Гэр хорооллын дэд бүтэц	128.7	2.3%
4	Төмөр зам	480.8	8.6%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		406.5	7.3%
5	Тавантолгойн цахилгаан станц	32.4	0.6%
	Эгийн голын усан цахилгаан станц	17.5	0.3%
	ДЦС-3, ДЦС-4 хүчин чадал нэмэгдүүлэх	207.1	3.7%
	Амгалан дулааны станц	149.4	2.7%
6	6%-ийн орон сууцны зээлийн санхүүжилт	127.7	2.3%
7	Уул уурхай	6.1	0.1%
8	Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор	9.7	0.2%
9	Улсын төсвөөс шилжин ирсэн төслүүд (2015, 2016 оны Төсвийн тухай хуулийн дагуу санхүүжүүлж буй)	200.9	3.6%
Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн төсөл /Төслийн орлогоос эргэн төлөгдөх/		1,502.0	27.0%
1	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	21.5	0.4%
2	Уул уурхай	607.0	10.9%
	Үүнээс: "Эрдэнэс таван толгой" ХК	437.5	7.9%
3	Тээврийн үйл ажиллагаа /МИАТ ТӨХК, онгоц худалдан авах/	33.1	0.6%
4	Барилга	325.7	5.9%
	Үүнээс: "ТОСК" ТӨҮГ-ын 1000 айл хөтөлбөр, Шинэ Яармаг болон Буянт-Ухаа хороолол	301.7	5.4%
5	Боловсруулах үйлдвэрлэл	514.7	9.2%
	"Хөх цавын цемент" төсөл /"МАК цемент" ХХК/	119.7	2.2%
	"Монцемент" төсөл /"Монполимет" ХХК/	142.2	2.6%
	"Байшин үйлдвэрлэх комбинат" төсөл /"Эрэл" ХХК/	80.1	1.4%
	"Арматурын үйлдвэр" төсөл /"Бэрэн групп" ХХК/	38.7	0.7%
	"Хөтөлийн цементийн үйлдвэрийг өргөтгөх төсөл" /"Хөтөл" ХХК/	134.0	2.3%
Арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлж буй төсөл хөтөлбөр		1,068.3	19.2%
1	АСЕМ Вилла цогцолбор хотхон	125.0	8.0%
2	ХАА, Хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төсөл	218.7	3.9%
3	Ноолуурын салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалттай олгож буй дамжуулан зээл	54.1	1.0%
4	Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 888 төсөл	245.3	4.4%
5	Үйлдвэрлэлийн чиглэлийн экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл	120.0	2.2%
6	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл	23.1	0.4%
7	Жижиг, дунд үйлдвэрийн 70.0 тэрбум төгрөгийн дамжуулан зээл	68.7	1.2%
8	Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл	75.3	1.4%

9	АСЕМ -Зочид буудлуудад олгох санхүүжилт	108.4	1.9%
10	Хөдөө аж ахуй	29.7	0.5%
	Мах хөтөлбөр	11.8	0.2%
	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөр	13.4	0.2%
	Мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөл	4.5	0.1
	Нийт	5 561,6	100,00%

Нийт зээлийн багцын 53.8 хувийг улсын төсвөөс эргэн төлөгдөх зээл, 27.0 хувийг Хөгжлийн банкны шууд санхүүжүүлсэн, төслийн орлогоор эргэн төлөгдөх зээл, 19.2 хувийг арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлсэн, төслийн орлогоор эргэн төлөгдөх зээл тус тус эзэлж байна.

Зээлийн ангилал, багцын чанар:

Зээлийн өрийн үлдэгдлийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу хугацааны ангилал хийхэд/чанарын болон харгалзах хүчин зүйлийн ангилал хийгээгүй/ **нийт 1.1 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдлийг ангилж, зээлийн эрсдэлийн санг 352.4 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах тохируулга хийв.** /Хавсралт 1/

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 2,991.3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн эргэн төлөлт 2016 оны 3, 5 дугаар саруудаас эхлэн зөрчигдсөн буюу төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан огт төлөгдөөгүй. Хүүгийн хугацааны зөрчлөөр эдгээр зээлүүд ангилагдаж, зээлийн эрсдэлийн сан байгуулагдахаар байгаа боловч Хөгжлийн банкнаас МУ-ын ЗГ-т төлөх 2,611.4 тэрбум төгрөгийн Чингис бондын эх үүсвэрийн 82.5 тэрбум төгрөгийн хүүгийн өглөгийг пассив талд хуримтлуулан тооцсон байгааг харгалзан ангилаагүй болно. /эх үүсвэрийн хүү, зээлийн хүү хоёрын зөрүү жилийн 1.0 хувь/

Мөн Чингис бондын эх үүсвэрээр олгогдсон Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл төлөгдөхгүй тохиолдолд үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг эргэн төлөх үүргээс эдгээр зээлийн үндсэн болон зээлийн хүүгийн төлбөрийн нийт хэмжээгээр чөлөөлөгдөж, банкинд эрсдэл үүсэхгүй байхаар Сангийн яамтай байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-нд зохицуулагдсан байна. **Харин Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 123.1 сая ам.долларын зээлийн эргэн төлөлт Улсын төсөвт суухгүй /төсөл хэрэгжээгүй, төслийн хэрэгжилт хангалтгүй гэх мэт шалтгаанаар/ бол эрсдэл үүсэхээр байгааг анхааруулж байна.**

Арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг төслийн дэд зээлүүдийн чанараас үл хамааран тухайн арилжааны банк хариуцахаар гэрээ байгуулсан бөгөөд шалгах өдрийн байдлаар арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлт зөрчилгүй байв.

Арилжааны банкуудаар дамжин олгогдсон дэд зээлүүдэд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 475/182 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зөвхөн зээлийн хугацааны ангилал хийж үзэхэд /зээлүүдэд чанарын үнэлгээ хийгээгүй/ 79.2 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлд ангилагдахаар байгаа

бөгөөд банкуудад нийт 52.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлээс хамгаалах санг зардлаар байгуулахаар байна. Өөрөөр хэлбэл МУ-ын ХБ-наас дээрх зээлүүдийг шууд санхүүжүүлсэн бол тус банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 52.0 тэрбум төгрөгөөр буурах байжээ.

Цаашид зээл, үнэт цаас төлөгдөх, авлага барагдахад болон хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлсэнээр учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг оновчтой тодорхойлохуйц “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг боловсруулан, Сангийн яамаар хянуулсаны үндсэн дээр Хөгжлийн банкны ТУЗ-аар батлуулах шаардлагатай байна.

Зээлийн үнэ цэнийн бууралтыг хэрхэн тооцож, бүртгэхийг “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар” боловсруулахдаа дэлгэрэнгүй оруулж өгөх, тухайн зээлд зээлийн эрсдэлийн сан байгуулахдаа зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцсон зээлийн эрсдэлийн сан, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцсон зээлийн эрсдэлийн сан хоёрын аль ихээр нь байгуулахаар журамлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл зээлийн үнэ цэнийн бууралтын бүртгэлийг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-аар зохицуулсан гажуудлыг засах шаардлагатай.

Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй, Хөгжлийн банк шууд санхүүжүүлсэн зээлүүд.

Шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдийг ерөнхийд нь нэгтгэвэл төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн сонгон шалгаруулалт тодорхойгүй, зээл олголт холбогдох хууль, журамд нийцэхгүй, зээлийн эрсдэлийн судалгаа, төсөв төсөөлөл хангалтгүй, зээлийн зарцуулалт болон төслийн гүйцэтгэлтэй холбоотой хяналт сул, ирээдүйд орох мөнгөн урсгал болон борлуулалтын төлөвлөгөө хэт өөдрөгөөр хийгдсэн, ханшийн эрсдэлийн судалгаа дутуу, барьцаа хөрөнгийн борлогдох, хөрвөх чадвар сул, үнэлгээ өндөр, тоног төхөөрөмжийн бичиг баримтжуулалт дутуу, зээлийн эргэн төлөгдөх эх үүсвэр хангалтгүй, зээлийн эргэн төлөлтийн хуваарь олон удаа хойшлогдон, хугацаа сунгагддаг, зээлдэгчийн санхүүгийн чадварыг үнэлэхдээ холбоотой этгээдүүдийн болон зээлдэгчийн бусад банк санхүүгийн байгууллага дахь зээлийн өр төлбөрийг тооцоолдоггүй зэрэг нийтлэг зөрчлүүд ажиглагдаж байна.

Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүдийн судалгаа хангалтгүй, эрсдэлийн тооцоололгүй байгаагаас төсөл амжилттай хэрэгжих нөхцөлүүд хангагдаагүй байхад олгосон зээлүүдийн эргэн төлөлтөд хүндрэл, хоцролт үүсч, зээлдэгч төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөр байна. Улсын Их Хурал болон Засгийн Газрын холбогдох тогтоолын хүрээнд зээл олгогдож байгаа хэдий ч МУХБ-ны тухай хуулийн 10.1 дэх заалтын шаардлагыг хангахгүй зээлүүдийг олгохгүй байх, бүх нөхцөлийг бүрдүүлсний дараа олгох тал дээр Хөгжлийн банкны ТУЗ, Зээлийн хороо, Эрсдэлийн хороо хангалтгүй ажиллаж, зохих дүгнэлтүүдийг бодитоор хийхгүй байна. Түүнчлэн зээл олголтын явц, зээлүүдийн хуулийн дүгнэлтүүд бодит бус байна.

Төслийн орлогоос эргэн төлөгдөх Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн зээлүүдийн төслийн үр дүнд үүссэн хөрөнгийг үндсэн барьцаа болгож байгаа нь амжилтгүй төслүүдийн эрсдэлийг улам ихэсгэж байгаагаас гадна зээлдэгчийн хариуцлагыг бууруулж байгаа сул тал ажиглагдаж байна.

Шалгасан зээлүүдээс “Монлаа” ХХК болон “Бэрэн” ХХК-д олгосон зээлүүд төлбөрийн чадварын эрсдэлд орсон тул банк “Монлаа” ХХК-д олгосон зээлд үнэ цэнийн бууралт тооцон холбогдох эрсдэлийн санг байгуулсан байна. Харин “Бэрэн” ХХК-д олгосон зээлд нэмж 34.9 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг зардлаар байгуулах шаардлагатай байна. “Пи Ай Эм Эм” ХХК-д олгосон зээл хугацааны ангилалаар эргэлзээтэй ангилалд шилжихээр байна. Түүнчлэн “Пи Ай Эм Эм” ХХК, “Эрэл” ХХК болон “МАК Цемент” ХХК-д олгосон зээлээр санхүүжигдэж байгаа төслүүд санхүүжилтийн дутагдалд орсон тул зогссон байдалтай байна. “Хөтөл” ХХК болон Амгалангийн дулааны станцын төслүүд амжилттай хэрэгжиж дууссан боловч борлуулалт болон орлого муу байгаагаас эргэн төлөлтийн хүндрэлд орсон байна. “Эрдэнэс таван толгой” ХК болон Амгалангийн дулааны станцын зээлүүдийг Засгийн газраар төлүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд Улсын төсөвт суугаагүй байна. Түүнчлэн, “ТОСК” ТӨҮГ-т олгосон зээлүүд Засгийн газрын тогтоол шийдвэрээс хамаарч хоцролт, хүндрэлтэй байдалд орсон байна. Геологийн Төв лаборатори, “МИАТ” ТӨҮГ-ын зээлүүдийн олголт холбогдох хууль журамд нийцээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Авто замын төсөл /орон нутаг/. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол, 2011 оны 15 дугаар тогтоолын дагуу МУ-ын ЗГ-ын 2012 оны 47 дугаар тогтоолын хавсралтад багтсан 2012 онд замын барилгын ажил болон хяналтын зөвлөхийн ажлыг санхүүжүүлэх 87.94 тэрбум төгрөгөөс Хөгжлийн банк өөрийн эх үүсвэрээр 40.38 сая ам.доллар, МУ-ын ЗГ-ын 2012 оны 110 дугаар тогтоолын хавсралтад багтсан замын барилгын ажлын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх 308.47 тэрбум төгрөгөөс Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээр 72.0 сая ам.доллар, 2013 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад багтсан замын барилгын ажлаас 10.8 сая ам.долларыг тус тус санхүүжүүлэн, нийт дүнгээр **123.1 сая ам.долларыг** өөрийн эх үүсвэр /Чингис бондын бус эх үүсвэр/-ээс санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн замыг ЗГ-ын 124 дүгээр тогтоолын хавсралтад заасан төсөвт өртгийн дагуу Зам, тээврийн яам гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, авто замын барилгын ажил гүйцэтгэх ажлын гэрээг Хөгжлийн банктай 3 талт хийсэн байна. Тус гэрээнд захиалагч тал барилгын ажлын гүйцэтгэлийг хянаад, ХБ-нд гүйцэтгэлийн санхүүжилтийн дүнг илгээснээр гэрээний дагуу мөнгийг шилжүүлдэг байна. Мөн авто замын барилгын ажлыг санхүүжүүлэх талаар ХБ шийдвэр гаргахдаа АПУХорооны дүгнэлтгүй, зээлийн хорооны хурлын шийдвэр гарсан нь ХБ-ны зээлийн бодлогын 7.2 дахь заалтыг зөрчиж байна. Үүнд банк тайлбар гаргахдаа “...ЗГ-ын тогтоолоор Чингис бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх тул АПУХ-ны дүгнэлт шаардлагагүй” гэв.

Харин Хөгжлийн банк өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн 123.1 сая ам.долларыг Чингис бондын эх үүсвэрт шилжүүлэхгүй тохиолдолд хэдийгээр улсын төсвөөс эргэн төлөгдөх гэрээтэй ч 2015, 2016 онуудад зээлийн үндсэн төлбөрийг улсын төсөвт суулгаж өгөөгүй нь өнөөдрийн байдлаар хамгийн эрсдэлгүй зээл бус хамгийн эрсдэлтэй зээл болон хувирсан байна. Чингис бондын эх үүсвэрт шилжүүлсэний дараа улсын төсвөөс эргэн төлөгдөх боломжгүй болсон тохиолдолд ЭЗХЯ, СЯ, Хөгжлийн банкны хооронд 2013 оны 4 сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний дагуу Үнэт цаасны арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг эргэн төлөх үүргээс эдгээр зээлийн үндсэн болон зээлийн хүүгийн төлбөрийн нийт хэмжээгээр чөлөөлөгдөж, банкинд эрсдэл үүсэхгүй юм.

Улсын төсвөөс шилжин ирсэн төслүүд. УИХ-ын 2015 оны төсвийн тухай хууль болон 2015 оны төсвийн тодотгол, МУ-ын ЗГ-ын 2015 оны 73 дугаар тогтоол, 2016 оны 53 дугаар тогтоол, МУ-ын ХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 34 тоот тогтоол, 2016 оны 15, 54 тоот тогтоол, ЗХХ-ын 2015/50, 2016/07, 2016/69 тоот шийдвэрээр яам бүртэй тусад нь “Төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөлийг тохиролцох гэрээ” байгуулсан.

Тус шууд шилжин ирсэн төслүүд Хөгжлийн банкны тухай хуулийн 8.3.2, 10.1.1 дэх заалтыг зөрчсөн. /“Зөвхөн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэсэн байх;” болон “Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах” гэж заасантай/ Мөн “Төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөлийг тохиролцох гэрээ”-ний 3.2.6 дахь заалтад санхүүжилтийн үндсэн хүү бондын эх үүсвэрийн хүүн дээр нэмэх нь үйл ажиллагааны зардал 0.0 хувь гэсэн буюу ХБ-нд маржин хүү байхгүй байгаа нь Хөгжлийн банкны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт буюу **“Хөгжлийн банк нь ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд байна”** гэж заасныг зөрчсөн байна. Мөн Хөгжлийн банкны “Зээлийн бодлого”-ын 5.1, “Зээлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Гудамж төсөл. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол, 2011 оны 15 дугаар тогтоолын дагуу МУ-ын ЗГ-ын 2013 оны 46, 71, 81 дүгээр тогтоол, МУ-ын ЗГ-ын 2012 оны 244 дүгээр тогтоолын дагуу “Гудамж төсөл”-ийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 200.0 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх эрх олгосон байна. “Гудамж төсөл”-ийн хүрээнд Хөгжлийн банкнаас дараах 7 дэд төслийн хүрээнд зээл олгосон байна:

д/д	Дэд төслийн нэр	Зээлийн тоо	Олгосон зээлийн дүн /тэрбум төгрөг/
1	Гудамж төслийн нэгж	3	15.1
2	Уулзвар шинэчлэлт	20	30.5
3	Автозамын барилгын ажил	47	51.9
4	Орон нутгийн зам, гудамж	9	25.3
5	Хурдны зам	5	7.2
6	Гэр хорооллын дэд бүтэц	4	2.5
7	Зураг төслийн бүтэц	30	1.6
Нийт		118	134.0

ЭЗХСайдын 2013 оны 29 тоот тушаалаар “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг баталсан. Энэ журмыг “Гудамж төсөл”-д мөрдлөг болгож, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна.

д/д	Төсөл хөтөлбөрийн нэр	Дансны дугаар	Гүйцэтгэгч компани	ЗХХ-ын бусад нөхцөл	Үндсэн гэрээний дүн, дугаар, огноо
1	3, 4-р хорооллын эцсийн уулзвар	3600000481	"Паблицроуд" ХХК	Зураг төслийг гүйцэтгэж дууссаны дараагаар төсөвт өртгийг баталгаажуулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	MNT 1,356,847,700.00
					C-ГТ-Б2013-151-1
					2013.10.21
2	Цэцэг төвийн урд уулзвар	3600000899	"Экспресс зам" ХХК	Төсөвт өртөг албан ёсоор баталгаажсаны дараа "Ажил гүйцэтгэх гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулах	MNT 2,249,533,583.00
					C-A3-Б2014-71-1
					2015.07.06
3	Ахуйн үйлчилгээний зам барилгын ажил	3600000912	"Наранбулагхан" ХХК	Бусад нөхцөлгүй	MNT 1,356,847,700.00
					C-ГТ-Б2014-80-1
					2015.07.06
4	Архангай аймгийн төв дэх 1.51 км авто замын барилгын ажил	3600000936	"Авто зам" ХХК, "Архангай Азза" ХХК, "Саруул харгуй" ХХК	Тус ажлын барилгын ажлын зураг төсөл, төсөвт өртөг эцсийн байдлаар батлагдсаны дараа ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ЗХХ-д дахин танилцуулах.	MNT 5,054,046,643.24
					C-ГТ-Б2014-115-1
					2015.07.24
5	Архангай аймгийн төв дэх 3.63 км авто замын барилгын ажил	3600000935	"ОДНД" ХХК	Тус ажлын барилгын ажлын зураг төсөл, төсөвт өртөг эцсийн байдлаар батлагдсаны дараа ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ЗХХ-д дахин танилцуулах.	MNT 5,089,700,000.00
					C-ГТ-Б2014-116-1
					2015.07.24
6	Архангай аймгийн төв дэх 6,25 км авто замын барилгын ажил	3600000937	"Готик голд" ХХК	Тус ажлын барилгын ажлын зураг төсөл, төсөвт өртөг эцсийн байдлаар батлагдсаны дараа ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ЗХХ-д дахин танилцуулах.	MNT 8,056,200,000.00
					C-ГТ-Б2014-117-1
					2015.07.24

Дээрх хүснэгтэд дурдсан гудамж төслийн уулзвар шинэчлэлтийн ажлууд авто замын барилгын ажлын зураг төсөл хийгдэж дууссаны дараа барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн дүгнэлтийг авалгүй гүйцэтгэх ажлыг эхлүүлсэн байна. ЗХХ-аар "Зураг төслийг гүйцэтгэж дууссаны дараагаар төсөвт өртгийг баталгаажуулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах" талаар тусган гүйцэтгэгч болон захиалагч нарын хооронд урьдчилсан гэрээ байгуулан замын ажлыг эхлүүлсэн байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт буюу "Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд авто зам, замын байгууламжийн ажил эхлэхийг хориглоно", Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт буюу "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдлийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт буюу "10.1.2.төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх" зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт.

- Таван толгой цахилгаан станц(ТТЦС): МУ-ын ЗГ-ын 2013 оны 71, 80, 261, 375 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 07 дугаар тогтоол, ЗХХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 29, 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн шийдвэрээр төслийг санхүүжүүлсэн байна. Засгийн газрын 80 дугаар тогтоолоор ТТЦС барих төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 50.0 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг ЗГҮЦ-ыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс ХБ-аар дамжуулан санхүүжүүлэхийг ХБ-ны ТУЗ-д зөвшөөрсөн байна. Уг зээлийн нөхцөл нь давуу эрхийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй **мезанин** зээл юм. Станц ашиглалтанд орсоноор ХБ нь зээлийг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх эрхтэй бөгөөд хувьцаа нь буцаан худалдан авах нөхцөлтэй. Зээлийг судлах үйл явцад ХБ нь төслийг шинжлэн судлахдаа АПУХорооны дүгнэлтийг аваагүй байна. 2015, 2016 оны Улсын төсөвт зээлийн үндсэн төлбөрийг суулгаж өгөөгүй байна.

- Эгийн голын усан цахилгаан станц (ЭГУЦС): МУ-ын ЗГ-ын 2013 оны 80 дугаар тогтоол, 2013 оны 375 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 14 дүгээр тогтоол, 2015 оны 18, 34 дүгээр тогтоол, ЗХХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 29, 2014 оны 01 дүгээр сарын 15, 2014 оны 02 дугаар сарын 25, 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрээр ЭГУЦС-ын төслийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

МУ-ын ЗГ-ын тогтоол нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийг үндэслэл болгож гаргасан бөгөөд **энэ нь Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1 дэх "УИХ-аас баталсан төсөл, хөтөлбөрийн жагсаалтад багтсан байх" заалт, 8.3.5 дахь "зээл нь барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн бусад арга хэрэгслээр хангагдсан байх" заалтыг зөрчсөн. Банк МУ-ын Засгийн газрын тогтоолыг энэ заалтад нийцэж байна гэж үзсэн.**

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.1 дэх заалт буюу "Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр сонгон санхүүжүүлэх асуудлыг тухай бүр ЗГ-ын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад бичгээр танилцуулах", мөн 2.2 дахь заалт буюу "ЗГ-ын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрээр МУ-ын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх" гэж заасныг үндэслэн гаргажээ. ЗГ-ын 2013 оны 375, 80 дугаар тогтоолд Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөлд зарцуулахаар шийдвэрлэсэн 50.0 (тавин) сая ам.долларын эх үүсвэрийн үлдэгдлээс ижил нөхцөлийн дагуу санхүүжүүлэхийг шийдвэрлэсэн бөгөөд ЭЗХСайдын 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн а/100 албан тоотоор хуваарилсан хөрөнгөөс 34.0 сая ам.долларыг ЭГУЦС-ын төсөлд зарцуулахаар шийдвэрлэснийг хүргүүлсэн байна. **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж нь хууль, тогтоол шиг заавал хэрэгжүүлэх үүрэг бүхий эрх зүйн акт биш бөгөөд 2013-2014 оны хооронд шийдвэрлэсэн 15 удаагийн нийт 5,110,944.74 ам.долларын олгосон зээл нь Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж байна.** Шалгах өдрийн байдлаар 2016 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс хойш бодогдсон зээлийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс төлөөгүй ба 160 хоногийн хугацаа хэтрэлттэй байна.

Засгийн газрын 2013 оны 375 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төсөлд давуу эрхтэй хувьцаанд хөрвөх нөхцөлтэй мезанин зээл олговол зээлийн хуримтлагдсан хүүгийн хамт хөрвүүлнэ. Улсын төсвөөс эргэн төлөгдөх боломжгүй болсон тохиолдолд ХБ нь ЭЗХЯ, СЯ, Хөгжлийн банкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний дагуу үнэт цаасны арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг энэхүү зээл болон зээлийн хүүгийн нийт хэмжээгээр эргэн төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

Төсвөөс эргэн төлөгдөх “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн үйл ажиллагааны зардлыг хэтрүүлсэн байдал баримтаар харагдаж байна. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 4 дүгээр хавсралтад заасан “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын үндсэн цалингийн жишиг”-т заасан дүнг ЭГУЦС-ын төслийн нэгжийн 2013 он (2 сар), 2014 он, 2015 оны цалингийн зардалд нийт 2,969,600.0 мянган төгрөгийг олгосон байна. (2016 оныг оруулбал 4,435,200.0) Сар бүрийн цалингийн задаргаанаас харахад Төслийн нэгжийн нийт 30 ажилтны жишиг цалинг суурь цалин гэж үзэн, өсгөх коэффициент /100%/ нэрийн дор бодон үндсэн цалинг 100 хувиар нэмэгдүүлэн бодсон байна. **Зөвхөн цалингийн зардлын хувьд 1,484,800.0 мянган төгрөгийг (2016 оныг оруулбал 2,217,600.0 мянган төгрөг) давхар тооцон санхүүжүүлсэн байна.**

Мэргэжлийн төсөвчин, инженер оролцуулан тухайн ажлын төсөв, гүйцэтгэлийг газар дээр нь шалгах шаардлагатай гэж үзэж байна.

- Дулааны цахилгаан станц 4 хүчин чадал нэмэх: МУ-ын ЗГ-ын 2012 оны 94 дүгээр тогтоол, МУХБ-ны Зээлийн хорооны 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн шийдвэр, МУХБ-ны ТУЗ-ийн 2012 оны 52 тоот тогтоолын дагуу Улсын төсвөөс эргэн төлөгдөхөөр 70.0 сая ам.долларын зээлийг ДЦС 4-ийн хүчин чадлыг өргөтгөх зориулалтаар олгосон. МУ-ын ЗГ-ын 2012 оны 119 тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 78 тоот тогтоолын дагуу зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсаны улмаас үлдэх 10.3 сая ам.долларын санхүүжилтийг Хөгжлийн банкны төслийн зээлээр олгосон байна. Улсын комисс 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдөр төслөөр хийгдсэн ажлыг хүлээн авсан.

- Дулааны цахилгаан станц 3-д 50 МВт-ын турбин суурилуулах: МУ-ын ЗГ-ын 2013 оны 142 тоот тогтоол, МУХБ-ны Зээлийн хорооны 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн шийдвэр, МУХБ-ны ТУЗ-ийн 2013 оны 27 тоот тогтоолын дагуу Улсын төсвөөс эргэн төлөгдөхөөр 35.0 сая ам.долларын зээлийг ДЦС 3-д 50 МВт-ын турбин суурилуулах зориулалтаар олгосон. МУ-ын ЗГ-ын 2013 оны 238 тоот тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2013 оны 78 тоот тогтоолын дагуу зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, зээлийн хугацааг 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасан байна. Улсын комисс 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр төслөөр хийгдсэн ажлыг хүлээн авсан. 2016 он гарснаас хойш 2 удаагийн 1.31 сая ам.долларын зээлийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс төлөөгүй байна.

- Амгалан дулааны цахилгаан станцын төсөл: МУ-ын ЗГ-ын 2013 оны 155, 55 дугаар тогтоол, 2014 оны 166 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2016 оны 44 дүгээр тогтоол, 2015 оны 24 дүгээр тогтоол, 2014 оны 81, 53 дугаар тогтоол, ЗХХ-ын 2013 оны 5 дугаар сарын 08, 2014 оны 7 дугаар сарын 22, 2014 оны 11 дүгээр сарын 27,

2015 оны 2 дугаар сарын 12, 2016 оны 02 дугаар сарын 05, 2016 оны 3 дугаар сарын 01, 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн шийдвэрүүдээр Амгалан дулааны цахилгаан станц барих төслийн 75.9 сая ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэсэн. ХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 53 дугаар тогтоолоор Самурай бондын эх үүсвэрээс 25.0 сая ам.долларын гүүрэн зээлийг БНХАУ-ын "Машин инженерийн корпораци" ТӨХК-д олгосон байна.

УИХ-аас Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар хавсралтад Амгалан дулааны станц /348МВт/ төслийн санхүүжих дүнг 39.45 тэрбум төгрөгөөр суулгаж өгсөн байна.

Дээрх бүгдээс дүгнэхэд МУ-ын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох хүртэлх хугацаанд 3 удаагийн 45.54 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг олгосон нь **Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1 дэх заалтыг зөрчсөн байна.** Тус цахилгаан станцыг 2016 оны 7 дугаар сард Улсын комисс хүлээн авсан бөгөөд 2016 он гарсаар 4 удаагийн нийт 3,762,199.45 ам.долларын зээлийн хүүгийн төлөлт Улсын төсвөөс хийгдээгүй байна. /224 хоног хугацаа хэтэрсэн.

Уул уурхайн төсөл /Улсын төсвөөс эргэн төлөгдөх/.

- Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл: МУ-ын ЗГ-ын 2014 оны 74, 104 дүгээр тогтоол, ЗХХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн шийдвэрээр 991,856,100.00 төгрөгийн төслийн зээлийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Үүнээс 585,468,337.00 төгрөгийг олгоод байна. Уг зээлийн хорооны хурлын шийдвэрт ХБ-ны Гүйцэтгэх захирал оролцоогүй бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ЗХ-ны шийдвэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, хугацааг сунгасан байна. Зээлийн гэрээнд тус төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал болон гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний төлбөрийг санхүүжүүлэх нөхцөлтэй байсан. Гэвч төслийн нэгжийн ТУХ-ны зүгээс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, шалгах өдрийн байдлаар зөвхөн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна. УИХ-ын баталсан Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар хавсралтад "Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2015 онд Хөгжлийн банкнаас санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тодотгосон жагсаалт"-д тус зээлийн эхний санхүүжүүлсэн дүн буюу 493.2 сая төгрөгийг суулгаж, 46.2 сая болон 40.5 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас баталгаажуулаагүйн улмаас төсөвт суугаагүй үлдсэн байна.

МУ-ын ЗГ-ын "Төслийн нэгж байгуулах тухай" 2014 оны 74 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Найдалааг Төслийн нэгжийн захирлаар томилсон нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчихөөр байсан тул МУ-ын ЗГ-ын 2014 оны 231 дүгээр тогтоолоор Б.Найдалааг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсөн байна.

- Оюутолгой болон бусад стратегийн ач холбогдол бүхий төслийн санхүүжилт: МУ-ын ЗГ-ын 2014 оны 274 тоот тогтоол, ХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 75 тоот тогтоол, ЗХ-ны 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн шийдвэрээр "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д Оюутолгой төслийн санхүүжилтийн үр ашигтай байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон

олон нийтийн харилцааны зөвлөх үйлчилгээнд шаардагдах 10.0 сая хүртэлх ам.долларын зээлийг баталсан. МУ-ын ЗГ-ын 2016 оны 44 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Уг зээлийн шийдвэрийг ЗГ-аас гаргахдаа УИХ-ын ямар нэг хууль тогтоомжийг үндэслээгүй бөгөөд Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт буюу *"Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана"* гэснийг үндэслэл болгон тогтоол гаргасан байна.

Арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлсэн зээлүүдийн олголт, эрсдэлийг тодорхойлох.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн дэд зээлдэгчдийн зээлийн мэдээлэл, эргэн төлөлтийн хуваарь болон зээлийн эргэн төлөлтийн тайланг авч үзэхэд арилжааны банкуудаар олгогдсон нийт 92 дэд зээлдэгчийн 87.8 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл эргэн төлөлтийн доголдолтой байна. Дээрх зээлүүдэд **Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 475/182 тоот тушаалаар батлагдсан "Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"**-ын дагуу зөвхөн зээлийн хугацааны ангилал хийж үзэхэд /зээлүүдэд чанарын үнэлгээ хийгээгүй/ 79.2 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлд ангилагдахаар байгаа бөгөөд банкуудад нийт 52.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлээс хамгаалах санг зардлаар байгуулахаар байна. нийт 52.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлээс хамгаалах санг зардлаар байгуулахаар байна. Өөрөөр хэлбэл МУ-ын ХБ-наас дээрх зээлүүдийг шууд санхүүжүүлсэн бол тус банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 52.0 тэрбум төгрөгөөр буурах байжээ.

Дээрх банкуудтай хийсэн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд дэд зээлдэгчийн эргэн төлөлтөөс хамаарахгүйгээр банкууд зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх үүрэг хүлээсэн бөгөөд эргэн төлөлтийн хувьд Монгол Улсын Хөгжлийн банкинд шууд учрах эрсдэл харьцангуй бага түвшинд байна гэж үзлээ. Харин зээлийн гэрээнээс үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банкны зээлдэгч нь арилжааны банк, зээлийн барьцаа нь зээлдэгч банкнаас бичсэн өрийн бичиг байгаа бөгөөд зээлдэгч банк төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд дээрх векселийг мөнгөжүүлэх асуудал тодорхой бус, эргэн төлөгдөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

МУХБ-ны тухай хуулийн 8.3.5-д зааснаар банкнаас олгосон зээл нь барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн бусад арга хэрэгслээр хангагдсан байх шаардлагатай байна. МУХБ-ны арилжааны банкуудтай байгуулсан гэрээний 2.1.11-д зааснаар зээлийн эргэн төлөх баталгаа болгож, зээлдэгч нь энгийн векселийг Хөгжлийн банкинд тухай бүр бичиж өгөх үүрэгтэй байна. Векселийн тухай хуулийн 15.1-д зааснаар вексель нь батлан даагчтай байна гэж заасан ба МУХБ-ны арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлсэн хөтөлбөрүүдэд бичсэн вексель нь батлан даагч байхгүй учир Векселийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн дагуу хүчингүй болох эрсдэлтэй байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны “Дамжуулан зээлдүүлэх” гэрээний Ерөнхий зүйлийн 1.2 дахь хэсэгт “... Зээлдэгч нь төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журмын шаардлагыг хангасан байна” гэж заасан байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны 2013 оноос 2016 оны хоорондох хугацаанд банкуудтай хийсэн “Дамжуулан зээлдүүлэх” гэрээнээс үзэхэд тус гэрээний 3.1.1-д заасан зээлдэгчийн **зээл авахдаа хангах шаардлагыг хангахгүй байсан нийт 9 банкинд 128.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна**. Үүнээс, Банкны тухай хуулийн 17 дахь хэсгийн 17.1-д заасан шаардлагыг хангаагүй 6 банкинд нийт 67.5 тэрбум төгрөгийн, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй 5 банкинд нийт 61.1 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

МУХБ-ны тухай хуулийн 8.2-т “зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивын болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн Зээлийн хороо гаргана” гэж заасан. “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл”, “Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яамны ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарууд” хөтөлбөрүүд **АПУГ-ын дүгнэлтгүй байхад Зээлийн хороо зээл олгох шийдвэр гаргасан байна**.

“Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-нд барьцааны талаар тусгайлан заагаагүй байгаа нь МУХБ-ны тухай хуулийн 10.1.5-тай нийцээгүй байна. “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 4 дэх хэсэгт “дэд зээл эргэн төлөгдөх эсэхээс үл хамааран зээлдэгч нь дэд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг хийнэ” гэсэн байгаа боловч төлбөрийг хийхгүй тохиолдолд хэрхэн төлбөрийг төлүүлэх талаар тусгаагүй байна.

УИХ-ын тогтоолоор дэд зээлдэгч тус бүрээр төсөл хөтөлбөрийг жагсаалтыг батлаагүй, Засгийн газар жагсаалтыг гарган Хөгжлийн банкинд үүрэг өгч хэрэгжүүлсэн байна.

МУХБ-ны тухай хуулийн 8.1, 10.1-т зааснаар Хөгжлийн банк нь үр ашигтай томоохон төсөл хөтөлбөрүүдэд зээл олгохоор байна. Хөгжлийн банкны 100.0 тэрбум төгрөг хүртэлх эх үүсвэртэй “Ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрүүдэд түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээл”-ийн хөтөлбөр нь дээрх заалтуудад нийцэхгүй байна.

Доорх хүснэгтэд хөтөлбөр тус бүрээрх дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэв:

Д /д	Хөтөлбөрийн нэр	ЗГ, УИХ-ын тогтоол	МУХБ-ны тогтоолууд, шийдвэрүүд	МУХБ-ны хуульд заасан шаардлагад нийцсэн эсэх /8-10 дугаар зүйл/	Эргэн төлөлт	Арилжааны банк, тоо, дүн, арилжааны банкаар дамжуулах үндэслэл
						Эх үүсвэрийн баталсан нийт дүн /олгосон дүн /
1	АСЕМ Вилла	УИХ-ын тогтоол байхгүй. ЗГ-ын тогтоол- 2015.8.17 №331 дугаар- Хөрөнгө шийдвэрлэх тухай 2015.8.24 №344 дугаар- Үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай.	ТУЗ-ын тогтоол 2015.9.8-71 2015.9.8- 72 2016.2.29- 19 Зээлийн хорооны шийдвэр- 2015/76 2016/21	8.3.5 заалтыг зөрчсөн. Вексель өөрөө батлан даалт шаарддаг төлбөр тооцооны үнэт цаас тул үүргийн гүйцэтгэлийг хангах арга болж чадахгүй. /МУХБ-ны Хуулийн дүгнэлтээс/ 8.1 заалтыг зөрчсөн, УИХ –ын тогтоол байхгүй буюу томоохон төслийн жагсаалтад багтаагүй. 8.3.3 заалтын шаардлага хангаагүй. 9.1 заалтыг хангаагүй Засгийн газрын баталгаа байхгүй.	ХХБ- хэвийн	ЗГ тогтоол №331- арилжааны банкаар дамжуулах шийдвэртэй. ХХБ-125 тэрбум Эх үүсвэр- 125 тэрбум Эх үүсвэр- Дотоодын зах зээлд 6 жил хүртэлх хугацаатай 4 хувийн хүүтэй хаалттай хэлбэрээр гаргах бонд- Хөгжлийн банк
		<p>Нэмэлт тайлбар: Барьцаа хөрөнгө АСЕМ виллагийн дутуу гүйцэтгэлтэй барилгууд- 90,276 мян төгрөг.</p> <p>Дүгнэлт: МУХБ-ны 8.1, 10.1, 9.1, 8.3.5 заалтуудын шаардлагыг хангаагүй.</p>				
2	Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтад оролцох төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлын дамжуулан зээл	УИХ-ын тогтоол байхгүй. ЗГ-ын тогтоол- 2015.8.17 №331 дугаар- Хөрөнгө шийдвэрлэх тухай 2015.8.24 №344 дугаар- Үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	ТУЗ-ын тогтоол 2015.9.8- 71 2015.11.10- 87 дугаар 2016.5.6-40 дугаар 2016.2.29- 19 дугаар Зээлийн хорооны шийдвэр- 2015/75 2015/90 2016/46	8.3.5 заалтыг зөрчсөн. Вексель өөрөө батлан даалт шаарддаг төлбөр тооцооны үнэт цаас тул үүргийн гүйцэтгэлийг хангах арга болж чадахгүй. 8.1 заалтыг зөрчсөн, УИХ-ын тогтоол байхгүй. Томоохон төслийн жагсаалтад багтаагүй. 8.3.3, 9.1 заалтын шаардлагууд хангагдаагүй.	Хэвийн	ЗГ-ын 2015.6.2-ны бдрийн 226 дугаар тогтоолоор арилжааны банкаар дамжуулан зээл олгохыг зөвшөөрсөн. Банк- 5 Баталсан-150 тэрбум, Олгосон- 108.4 тэрбум. Эх үүсвэр- Дотоодын зах зээлд 6 жил хүртэлх хугацаатай 4 хувийн хүүтэй хаалттай хэлбэрээр гаргах бонд- Хөгжлийн банк
		<p>Нэмэлт тайлбар: АСЕМ-ийн зочдыг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам.-2015.8.26 229 дугаар</p> <p>Нэмэлт өөрчлөлт- 2015.8.28, 241 дугаар. Тус журмын 4.5-т зааснаар Хөгжлийн банк шаардлага хангасан зочид буудлуудад санхүүжилт олгох зөвшөөрлийг тухай бүр Сангийн яамнаас авч, арилжааны банкаар дамжуулан зээл олгоно гэж заасан боловч Хөгжлийн банк арилжааны банкаар дамжуулан зээл олгохдоо тухай бүр зөвшөөрөл аваагүй байна.</p> <p>Хөнгөлөлттэй зээл олгох зочид буудлын жагсаалтыг ямар байгууллага гаргах асуудал дээр эргэлзээтэй, тодорхой үндэслэл байхгүй. Бодит байдал дээр Сангийн яам, Гадаад хэргийн яамдууд зээл олгох зочид буудлуудын жагсаалтыг гаргасан байна.</p> <p>Дүгнэлт: МУХБ-ны 8.1, 10.1, 9.1, 8.3.5 заалтуудын шаардлагыг хангаагүй.</p>				

3	Мах хөтөлбөр	<p>УИХ-ын тогтоол 2015.12.03 №108 дугаар-малчдын амьжиргааны түвшинг сайжруулах, махны зах зээл, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Мах хөтөлбөрийг боловсруулж ажлыг ЗГ-т даалгасугай.</p> <p>ЗГ-ын тогтоол 2015.12.14 өдөр, 492 дугаар-хөтөлбөр батлах тухай</p> <p>ЗГ-ын тогтоол 2015.8.3-321 дугаар- зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн яам, МБ, МУХБ-д даалгасан.</p>	<p>ТУЗ тогтоол 2016.2.4 өдөр-16 дугаар. 100 хүртэлх тэрбум төгрөгийн зээлийг АПУГ-ын тодорхойлсон эх үүсвэрээр шийдвэрлэх. ТУЗ-ийн тогтоолд зээлийн зориулалт нь эргэлтийн хөрөнгө гэж заасан байна.</p>	<p>8.1 заалтыг зөрчсөн, Мах хөтөлбөр нь эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой.</p> <p>9.1 хангаагүй-Засгийн газрын баталгаа байхгүй.</p> <p>8.3.5 хангагдаагүй-барьцаанд вексель бүртгэсэн.</p>	Хэвийн	<p>Арилжааны банк- 4, тэрбум, Арилжааны банкаар дамжуулах үндэслэл- ЗГ тогтоол 492 Мах хөтөлбөрийн 3.2.2-т заасан</p> <p>Баталсан-100, Олгосон- 11.8</p> <p>Эх үүсвэр- Кредит-Свисс хамтарсан зээлийн эх үүсвэр</p>
<p>Нэмэлт тайлбар: 100 тэрбум төгрөг нь экспортын зориулалттай мах бэлтгэхэд зориулагдах буюу эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхэд зарцуулагдана. МУХБ-ны Кредит-Свисс банкны хамтарсан зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн.</p> <p>Дүгнэлт: МУХБ-ны 8.1, 9.1, 8.3.5, 10.1 заалтуудын шаардлага хангаагүй.</p>						
4	Ноолуур хөтөлбөр	<p>УИХ-ын тогтоол 2015.2.18- 41 тоот- Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай.</p> <p>ЗГ-ын тогтоол 2015.4.20-149 тоот- Ноолуурын үйлдвэрийн дэмжих, экспортын нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай.</p>	<p>2015.5.28-ны өдрийн ТУЗ-ийн тогтоол 39. Зээлийн хорооны хурлын шийдвэр-2015.5.25-2015/61</p>	<p>Ноолуур хөтөлбөр нь УИХ-ын эдийн засгийн хүндрэлээс гарах хөтөлбөрийн 10.9-д багтсан боловч ноолуурын үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхэд зориулсан.</p> <p>МУХБ-ны 8.3.5 заалтын шаардлагыг хангаагүй буюу вексель нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга болж чадахгүй байна.</p> <p>9.1 буюу Засгийн газраас баталгаа гаргуулж аваагүй.</p>	Хэвийн	<p>Арилжааны банк- 7, Арилжааны банкаар дамжуулах үндэслэл- 171 тогтоолоор арилжааны банкуудаар дамжуулан зээл олгох ажлыг зохион байгуулахыг МУХБ-д даалгасан.</p> <p>Баталсан эх үүсвэр-100 тэрбум. Олгосон-56.2 тэрбум</p> <p>Эх үүсвэр- ЗГ-ын 126,141 тоот тогтоолоор олгогдсон зээлийн чөлөөт үлдэгдэл.</p>
<p>Дүгнэлт:МУХБ-ны тухай хуулийн 8.1, 10.1, 8.3.5, 9.1 заалтын шаардлагыг хангаагүй.</p>						
5	Голомт банкаар дамжуулан олгогдсон 5-н салбарын зээл	<p>Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж /2012.12.03/ - Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай.</p> <p>2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 126 тоот тогтоол- Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай /68.8 сая/</p> <p>2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 141 тогтоол- Үйлдвэрлэлийг дэмжих тухай / үлдсэн 4-н салбарт/.</p>	<p>2013.8.15 48 тоот тогтоол-ҮХААЯ-ны төслүүдийн санхүүжилтэд зориулж Голомт банкаар дамжуулан зээл олгох, Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зөвшөөрөл олгох тухай.</p> <p>2013.8.13-ны өдрийн</p>	<p>Энэ хөтөлбөрийн хүрээнд ноолуурын компаниудын эргэлтийн хөрөнгө /ноос нөөцөлж авах/ санхүүжүүлэх зорилгоор олгогдсон тул МУХБ-ны тухай хуулийн 8.1 дүгээр заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Мөн 9.1 заалтыг хангаагүй буюу Засгийн газраас баталгаа гаргуулаагүй.</p> <p>8.2-т зааснаар Актив-Пассивын Газрын дүгнэлт гаргуулж</p>	Хэвийн	<p>Арилжааны банк- 1, Арилжааны банкаар дамжуулах үндэслэл- ЗГ-ын 2014.5.26-ны 165 тогтоолоор арилжааны банкуудаар дамжуулан зээл олгохыг Хөгжлийн банкинд зөвшөөрсөн.</p> <p>Баталсан эх үүсвэр-269 тэрбум. Олгосон- 214.3 тэрбум</p> <p>Эх үүсвэр- Чингис бонд</p>

		зээлийн хорооны шийдвэр.	аваагүй.			
<p>Нэмэлт тайлбар: Ноолуурын зээлийн хөтөлбөрийн хүрээнд Капитал банкинд олгох нийт гурван зээлд МУХБ-ны Эрсдэлийн удирдлагын дүгнэлтэд тус банкаар дамжуулан зээл олгоход эрсдэлтэй гэж дүгнэсэн хэдий ч Капитал банкинд зээл олгогдсон байна. Капитал банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ 2015 оны 6 дугаар сарын байдлаар 12%-иас бага буюу 11.58% байгаа. Монголбанкнаас тус банкны зээл олголтыг хязгаарлах мэдэгдэл хүргүүлсэн, актив хөрөнгөд эзлэх зээлийн багц 64.2% байгаа гэж заасан байна.</p> <p>2013.12.2-2013.12.13-ны өдрүүдэд энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг МУХБ-наас ажлын хэсэг байгуулан шалгасан. ЗГ-ын 126.141 тогтоолуудын дараах заалтыг зөрчсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Зээлийг салбарын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулж олгоогүй, • Зээлийн хэмжээ тоног төхөөрөмжийн санхүүжилтийн гуравны нэгээс давсан. <p>Ноолуур 68.8 сая доллар хүртэл, Сүү- 27.7, Хүлэмж- 17.4, Ноос- 45, Оёдол- 13.5 сая доллар. Нийт 4-н салбарт- 103.6 сая ам.доллар хүртэл.</p> <p>2014.6.18-ны 198 тогтоолоор дээр заасан эх үүсвэрээс 30 тэрбум төгрөгийг арьс ширний хөтөлбөрт зориулахаар болсон.</p> <p>Дүгнэлт: МУХБ-ны тухай хуулийн 8.1, 8.2, 9.1, 10.1 заалтуудын шаардлагыг хангаагүй.</p>						
6	Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл	УИХ-ын тогтоол 2012.12.28 өдөр, №74, Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай,	2014.7.23- 49 тоот ТУЗ-ийн тогтоол.	8.2 заалтыг зөрчсөн. АПУГ-ын дүгнэлт байхгүй.	Хэвийн	Арилжааны банк-9 ,
		2013.3.30-ны өдрийн 111 дугаар ЗГ-ын тогтоол- Үнэт цаас гаргаж, арилжаалахыг зөвшөөрөх тухай.	2015.4.23- 28 тоот тогтоол	9.1 зөрчсөн- ЗГ баталгаа байхгүй.		Арилжааны банкаар дамжуулах үндэслэл- 2014.6.18-ны 198 тогтоолоор 30 тэрбум төгрөгт нь арилжааны банкаар дамжуулан зээл олгохыг зөвшөөрсөн. 2014.7.4-ны өдрийн 217 тогтоолоор үлдсэн 110.4 тэрбумыг арилжааны банкаар дамжуулан зээл олгохыг зөвшөөрсөн.
		2015.5.28- 38 тоот тогтоол,	8.3.5-д заасан шаардлагыг хангаагүй.			Баталсан эх үүсвэр-140.1 тэрбум.
		Зээлийн хорооны шийдвэр- 2014.7.22-ны өдөр.				Олгосон- 85.6 тэрбум
						Эх үүсвэр- Үйлдвэржилтийн бонд, Чингис бонд
<p>Нэмэлт тайлбар: МУХБ-ны АПУГ-ын дүгнэлт байхгүй.</p> <p>Дүгнэлт: МУХБ-ны тухай хуулийн 8.2, 9.1, 8.3.5 заалтуудыг хангаагүй.</p>						

3.2 Анхаарал татсан зээлүүд:

Улсын төсвөөс эргэн төлөгдөх "Тавантолгой-Гашуунсухайтын авто замын төсөл /Эрдэнэс МГЛ ХХК/"

Анх МУ-ын ЗГ-ын 2010 оны 83 дугаартай тогтоолоор нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, говийн бүсийн эко системийг хамгаалах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаахудагийн нүүрсний орд газраас Гашуунсухайтын боомт хүртэлх хатуу хучилттай 245 км авто замыг өөрийн хөрөнгөөр барихыг "Говийн зам" ХХК-д зөвшөөрсөн, "Говийн зам" ХХК-тай "Барих ашиглах шилжүүлэх" нөхцөл бүхий гэрээ байгуулан, гэрээнд уг хуулийн этгээд нь

замыг ашиглалтад хүлээн авснаас хойш 10 жилийн хугацаанд эзэмшиж ашиглах, засвар арчлалтыг хариуцах, хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх зорилгоор хүнд даацын тээврийн хэрэгслээс зам ашиглалтын төлбөр авч байх нөхцлүүдийг тусгасан буюу энэ орлогоороо зээлийг төлж дуусгах байсан.

Гэвч, ЗГ-ын 2013 оны 299 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд "Говийн зам" ХХК-ийн барьсан автозам, "Энержи ресурс" ХХК-ийн Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар барьсан дэд бүтцийг төрийн өмчид худалдан авч "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн мэдэлд шилжүүлэх арга хэмжээ авах шийдвэр гаргасан бол ЗГ-ын 2015 оны 449 дугаар тогтоолоор уг дэд бүтцийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн мэдэлд шилжүүлсэнтэй холбоотойгоор тус компанид МУХБ-наас олгосон 170.6 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт шаардагдах үлдэгдэл хөрөнгийг 2019-2020 оны улсын төсөвт тусгаж эргэн төлөх арга хэмжээ авахыг Сангийн сайдад үүрэг болгосон, үүнтэй уялдуулан зээлийн хугацааг сунгахыг МУХБ-ны ТУЗ-д зөвшөөрсөн. Анх авто зам ашиглуулсны орлогоос "Эрдэнэс Монгол" ХХК зээлийг төлөх байсан боловч орлого нь зээл, хүү төлөхөд хангалтгүй байсан тул ийм шийдвэрт хүрсэн. **Зээлийн гэрээнд "Эрдэнэс МГЛ" ХХК 2019 он хүртэл авто зам ашиглуулсны орлогоос зээлийн хүү төлөхөөр тусгагдсан боловч шалгах өдрийг хүртэлх хугацаанд зээлийн хүү огт төлөгдөөгүй байна.**

Уг төсөл хэрэгжиж дууссаны дараа МУХБ зээл олгосон бөгөөд вексель бичиж өгөх замаар санхүүжүүлсэн. МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгээс Монголбанкны Ерөнхийлөгчид ирүүлсэн 2014 оны ХЭГ/234 дугаартай албан бичигт "Эрдэнэс МГЛ ХХК-д шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг эхний ээлжинд МУХБ-наас вексель гарган банкуудад арилжаалах, улмаар нэг жилийн дотор ЗГ-ын урт хугацаатай бондод хөрвүүлэн дахин санхүүжүүлэх арга хэмжээг авахаар төлөвлөж байна. Иймд ЗГ-ын 299 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, МУ-ын нүүрсний зах зээлд үүссэн хүндрэл бэрхшээлийг шуурхай даван туулах зорилгоор МУХБ-наас гаргах векселийг банкуудад мөнгөжүүлэх, дахин санхүүжүүлэх арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлж, бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ үү" гэсний дагуу Худалдаа, хөгжлийн банкинд шилжүүлсэн МУХБ-ны векселийг Векселийн тухай хуулийн дагуу Монголбанк мөнгөжүүлжээ.

Векселийн хугацаа дуусах үед Монголбанкнаас МУХБ-нд векселийн төлбөрийг хугацаандаа төлөх, хугацаа хэтэрвэл хуулийн дагуу алданги төлөхийг удаа дараа албан бичгээр анхааруулсан боловч төлөлт хийхгүй явсаар 1.9 тэрбум төгрөгийн алданги хүлээж, банкныг хохироосон. Энэ хохирлыг МУХБ-ны удирдлагуудаар төлүүлэх нь зүйтэй. /МУХБ-ны ТУЗ уг хохирлыг "Эрдэнэс МГЛ" ХХК-иар төлүүлэх шийдвэр гаргасан./

Улсын төсвөөс эргэн төлөгдөх "Шинэ төмөр зам" төсөл

Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын барилгын ажил, суурь судалгааны ажлууд болон төслийн зөвлөх үйлчилгээнүүдийг санхүүжүүлсэн зээл бөгөөд захиалагч ЗТЯам, Сангийн яам, МУХБ-ны хооронд байгуулсан 3 талт гэрээний дагуу Зам, тээврийн яам уг төслийн гүйцэтгэл, аливаа зардалд хяналт тавьж, дараагийн санхүүжилт олгох бичиг ирүүлснээр МУХБ санхүүжүүлсэн байна. Зам тээврийн яам тухайн санхүүжилтээр хийсэн ажлын гүйцэтгэлийг 100.0 хувь, нийт төслийн гүйцэтгэл 51 хувь гэж дүгнэжээ.

Зам, тээврийн яамны гэрээгээрх эрх үүрэгт "Төслийн хүрээнд хэрэгжих ажлууд чанартай, хугацаандаа бэлэн болоход бүх талын хяналт удирдлагаар хангана", "Төслийн хэрэгжилт төлөвлөсөн цаг хугацаандаа, чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж, улсын төсвөөс эргэн төлөгдөх санхүүжилтийн үр ашигтай зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагчийн хувиар бүрэн хариуцлага хүлээнэ", "Төсөл хэрэгжүүлэгчийн ирүүлсэн төслийн гүйцэтгэлийг магадлан, шаардлага хангасан гэвэл нэхэмжлэлийн үнийг баталгаажуулж зохих олголтыг хийлгэх хүсэлтийг Хөгжлийн банкинд хүргүүлнэ", "Санхүүжилтийг энэхүү гэрээний зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх, хөрөнгийн үр дүнтэй зарцуулалтыг хангах бүхий л арга хэмжээг авна" гэжээ.

Гэвч, мэргэжлийн төсөвчин, инженер оролцуулан тухайн ажлын төсөв, гүйцэтгэлийг Зам тээврийн яам дээр шалгах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь захиалагчаас банкинд ирүүлсэн зарим баримт бичгээс харахад хуулийн зөвлөх үйлчилгээнд 3.2 сая ам доллар, техникийн зөвлөх үйлчилгээнд 3.0 сая, санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 1.6 сая, ХААН банкны зээл, хүүгийн төлбөрт 6.5 сая ам доллар, "Монголын төмөр зам" ТӨХК-ий энэ төслийн нэгжийн санхүүжилт сард дунджаар 120 сая төгрөг гэх мэт өндөр дүнтэй зардлууд, зээлийн зориулалтад нийцэхгүй Хятад улсад оюутан сургасан 112.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Бэрэн ХХК

Арилжааны банкуудад хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй. 308 хоногийн үндсэн болон 400 хоногийн хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлттэй. Эргэн төлөлтийн хуваарийг нэг удаа өөрчилсөн.

Эрэл ХХК

Еврогоор олгогдсон 2 зээл нь 44 хоногийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлттэй. Ам.доллараар олгогдсон зээл нь 247 хоногийн хүүгийн хугацаа хэтрэлттэй. Эргэн төлөгдөх хугацаа сунгагдсан. ХААН банкин дахьзээл нь муу, Хас банкин дахь зээл нь хугацаа хэтэрсэн ангилалтай. Төсөл бүрэн дуусаагүй 90 хувийн явцтай, төслөө дуусгахад нэмэлт санхүүжилт шаардлагатай.

Эрдэнэс таван толгой ХХК

Зээлийн олголт хууль журамд нийцээгүй. /ТЭЗҮ, төслийн төсөв байхгүй/ Зээлийн зориулалтыг буруугаар ашигласан. Эргэн төлөлт 135 хоногийн үндсэн болон хүүгийн хоцролттой. Эргэн төлөлтийн хуваарь 2 зээл тус бүрт 4 удаа өөрчлөгдөн, сунгагдсан. Сангийн яамны баталгаатай боловч Сангийн яам баталгааг мөнгөжүүлэхийн оронд төрийн институт хоорондын өглөг, авлага байдлаар шийдэж байгаа. Зээлийн зарцуулалтыг хянах ажил хийгдээгүй. Зээлдэгч зээлийг эргэн төлөхгүй тул Сангийн яамаар төлүүлэх хүсэлт тавьсан боловч Сангийн яам зээлдэгч компаний хувьцаагаар төлүүлэх тухай судалж байгаа.

Хөтөл ХХК

Төсөл амжилттай хэрэгжсэн боловч Улсын комисс хүлээж аваагүй байгаа. Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкуудад өндөр дүнтэй зээлийн өрийн үлдэгдэлтэй. Санхүүгийн хүндрэл, ханшийн тэгшитгэлээс ихээхэн хэмжээний алдагдал хүлээсэн, үйлдвэр бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байгаа,

эргэлтийн хөрөнгө байхгүй байгаа зэргээс шалтгаалан зээлийн хугацааг 2 удаа сунгасан байна. 121 хоногийн хүүгийн хугацаа хэтрэлттэй бөгөөд банк зээлийн үнэ цэнийн бууралт тооцон хангалттай хэмжээний буюу 34.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан.

МАК ХХК

Хөгжлийн банк 87.5 сая долларын зээл олгох шийдвэр гаргасан боловч нөхцөлүүд нь одоог хүртэл хангагдаагүй. Гэсэн ч 3 удаагийн олголтоор 109 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийн олголт хийгдсэн. 3 зээл тус бүр үндсэн болон хүүгийн 238 хүртэлх хоногийн хоцролттой. Төсөл хэрэгжилт 97 хувийн явцтай байгаа. Арилжааны банкуудад өндөр дүнтэй, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй. Гадаадын банкинд өндөр дүнтэй зээлтэй. Төслийн үр дүнд үүссэн хөрөнгийг Хөгжлийн банк дангаар эзэмшиж чадахгүй, гадны банкт хамтран барьцаалах боломжтой.

МИАТ

Худалдах, худалдан авах гэрээгүйгээр онгоц худалдан авах санхүүжилт олгосон. Төслийн үр дүнд үүсэн хөрөнгийг барьцаалаагүй, барьцаалах боломжгүй. ЗГ-ын баталгаатай. Зээлүүд бүгд хугацаа сунгагдсан /1-2 удаа/. Сүүлийн 2 зээл нь гадаадын банкны зээлийн төлбөрийг төлөхөд зарцуулагдсан.

Мон лаа ХХК

Зээлийн хүүгийн 616 хоногийн хугацаа хэтрэлттэй. Зээлийн үндсэн төлөлтийн хугацааг хойшлуулсан ч 251 хоногийн хоцрогдолтой. Зээлийн зарцуулалтын хяналт хангалтгүй. Төслийн хэрэгжилт хугацаа хоцорсон, 70 хувьтай явж байгаа, цаашид үргэлжлүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй. Арилжааны банкуудын зээл нь эргэлзээтэй ангилалд шилжсэн. Газар дээрх шалгалтын үеэр үйл ажиллагаа явуулахгүй байсан.

Монполимет ХХК

Зээл олгоход ТУЗ-ийн үндэслэсэн гэх Зээлийн хорооны дүгнэлт байхгүй. 2 зээл нь хугацаа сунгагдсан. Эргэн төлөлтийг хойшлуулсан.

Пи Ай Эм Эм ХХК

Зээлийн хүүгийн 265 хоногийн хугацаа хэтрэлттэй. Үндсэн төлбөрийн 144 болон 52 хоногийн хугацаа хэтрэлттэй. Төслийн гүйцэтгэл хугацаа хоцорсон, төлөвлөгдсөн 5 блок барилгын 2 нь дууссан. Үлдсэн 3 блок нь дуусгахад санхүүгийн эх үүсвэр байхгүй.

Кью Эс Си ХХК

МУ-ын ЗГ-ын тогтоол байхгүй, Концессийн гэрээг үндэслэн зээл олгосон. Зээлийн эх үүсвэр нь ХХБ-ны хадгаламж болон Хөгжлийн банкны арилжааны банкуудаас эргүүлэн татсан хадгаламж. Хугацаа сунгагдсан тул шинэ эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацааны зөрчилгүй. Төсөл амжилттай хэрэгжиж, Улсын комисс хүлээн авсан ч ТЭЗҮ болон зээлийн шийдвэр дээрх төмөр замын урт тохирохгүй байна.

ТОСК ХХК

Нийт 8 зээлийн 6 нь 13-261 хоногийн хүүгийн, 64 хүртлэх хоногийн үндсэн төлбөрийн хоцрогдолтой. Барьцааны гэрчилгээний зарим нь биетээр байгаагүй, УБЕГ-тай амаар байгуулсан тохиролцооны үндсэн дээр гэрчилгээг цаасаар хадгалдаггүй гэсэн тайлбартай. Улсын комисс хүлээн авсан орон сууцыг Засгийн газар түрээсийн хөтөлбөрт хамруулах асуудал яригдаж байгаа. Буянт-Ухаа 2 болон Шинэ Яармаг орон сууцны хорооллын гүйцэтгэл 50-60 хувьтай байгаа. Орон сууцны борлуулалтын орлогоор зээл төлөгдөх хуваарьтай боловч төлөлт хийгдэхгүй байгаа.

Амгалан дулааны станц

Эргэн төлөх үүргийг Эрчим хүчний яам, Сангийн яам хүлээсэн боловч Улсын төсөвт суугаагүй бөгөөд 2017 оны төсөвт суулгахаар төлөвлөгдөж байгаа. 169 хоногийн хүүгийн хугацаа хоцролттой.

Bloomberg компанитай хийсэн хэлцлийн талаар:

Монгол улсын нэр хүндийг өсгөх, хөрөнгө оруулалтын орчинг таниулах, хөрөнгө оруулагчдын хандлагыг эерэг болгоход чиглэсэн “Inside Mongolia” зар сурталчилгааны компани ажлыг Сингапур дахь Блүүмберг телевизтэй хамтран зохион байгуулсан байна. Энэ ажлын хүрээнд Европ, Ази, Хойт Америк болон Австрали тивүүдийн Блүүмбергийн телевизийн сувгуудаар хөрөнгө оруулагч нарт зориулж Монгол Улсын эдийн засгийн өсөлт, улсын төрийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын орчин, олон улсын харилцаа, эрдэс баялгийн талаар баримтлах бодлого гэсэн агуулгын хүрээнд сурталчилгааны болон богино хэмжээний баримтат киног мэргэжлийн түвшинд бэлтгэж дэлхий даяар 4900 гаруй удаа цацсанаар тайлагнасан байна. Мөн түүнчлэн олон улсад нэр хүнд бүхий www.bloomberg.com, www.businessweek.com зэрэг цахим хуудсуудаар сурталчилгааны ажлыг давхар зохион байгуулсан байна.

Блүүмберг телевизтэй 2013 оны 10 сарын 21-ний өдөр сурталчилгааны 1,835,200 ам.долларын гэрээг байгуулсанаас “Inside Mongolia” хөтөлбөрийн төлбөрийг татвар орсон дүнгээр 816,000 ам.долларын тооцоо үүсгэж татварыг хассан дүнгээр 2013-2014 онд нийт 652,800 ам.доллар шилжүүлсэн байна.

Зээлийн хүү

Шалгах өдрийн байдлаар зээлийн хүү төлөх хуваарь зөрчигдсөн **23 зээлийн 146.3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг орлогоос буцааж**, тэнцлийн гадуур бүртгэх тохируулга хийв. /Хавсралт 2/

Гүйцэтгэх захирлын 2012 оны А-56 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын дөрөв дэх хэсгийн 2.3-д “Хэвийн зээлийн хүүгийн авлагыг тэнцлийн дотуур хуримтлуулан тооцно. Хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн зээлийн хүүгийн авлагыг тэнцлийн дотуур хуримтлуулахыг зогсооно” гэж заасан байна. Гэвч хугацаандаа зээл, хүүгийн төлбөр хийгдэхгүй байгаа зээлүүдийн хүүг тэнцэлд хуримтлуулсаар байна.

Хөгжлийн банкны “Зээлийн үйл ажиллагааны журам”-ын 5.3 дахь хэсэгт “Зээлийн үндсэн хүүг тооцох аргачлал: Үндсэн зээлийн үлдэгдэл * Жилийн хүү/360

хоног * Ашигласан хоног” мөн “Нэмэгдүүлсэн хүүг тооцох аргачлал: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүн * Жилийн хүүгийн 20хувь * Хугацаа хэтэрсэн хоног/360 хоног” гэж заасан байгаа нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-236 тоот тушаалаар баталсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.2-т заасантай зөрчилдөж байна. /365 хоног≠360 хоног/ Хэдийгээр Төвбанк /Монголбанк/-ны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2¹ дэхь заалт буюу “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасан хэдий ч Хөгжлийн банк нь Арилжааны банкуудад дамжуулан зээл олгож байгаа учир тус банкны дотоод дүрэм, журам, заавар, аргачлалыг Монголбанкнаас гаргасан арилжааны банкуудын үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журамтай нийцүүлэх нь зүйтэй.

Зээлийн гэрээний нөхцөл өөрчилсөн байдал

Эдийн засаг болон төсвийн хүндрэлээс шалтгаалан улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүд, Хөгжлийн банк шууд санхүүжүүлсэн зээлүүдийн хугацааг сунгах, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах гэрээний нөхцөл өөрчлөлт маш их хийгдсэн байна. Харин арилжааны банкуудаар дамжуулан хэрэгжүүлсэн төсөл буюу арилжааны банкинд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр ямар ч зөрчилгүй байна.

Шалгах өдрийн байдлаарх Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2,991.3 тэрбум төгрөгийн зээлийн 34.7 хувь буюу 1,037.2 тэрбум төгрөгийн зээл /93 зээл/-ийн хугацааг сунгасан байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээлүүдийн зээлийн хүүгийн төлбөр 2016 оны эхнээс огт төлөгдөхгүй байгаа бөгөөд энэ төрлийн зээлийн хугацаа сунгалт цаашдаа ч үргэлжлэхээр байна.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүдийн үндсэн төлбөр 2016 оны үлдсэн саруудад 42.5 тэрбум төгрөгөөр, 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 706.3 тэрбум төгрөгөөр төлөгдөх хуваарьтай байна. Мөн Хөгжлийн банк шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн чанаргүйд ангилагдсан зээлүүдийн үндсэн төлбөр 2016 оны үлдсэн саруудад 368.5 тэрбум төгрөгөөр, 2017 оны эхний улиралд 42.9 тэрбум төгрөгөөр төлөгдөх хуваарьтай байна. **Шалгах өдрөөс буюу 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс 2017 оны эхний улирлыг дуустал хугацаанд эргэн төлөгдөх ёстой дээрх 1,160.2 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт төлөгдөхгүй байх магадлал маш өндөр байна.** Гэтэл Хөгжлийн банк 2017 оны 3 дугаар сард 580.0 сая ам.долларын ДХЕӨБ /Дунд хугацааны евро өрийн бичиг/-ийг бүрэн төлөх ёстой. Өөрөөр хэлбэл, зээл эргэн төлөгдөхгүй эрсдэлд орсон нь ДХЕӨБ-ийг төлж чадахгүйд хүргэхээр байна.

Дөрөв. Санхүүгийн өнөөгийн байдал, цаашид учирч болзошгүй эрсдэл

4.1 Активын чанар

Хөгжлийн банкны активын бүтэц

Хөгжлийн банк нь тайлант өдөр буюу 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 16.5 сая төгрөгийн бэлэн мөнгө, 2.3 тэрбум төгрөгийн Монголбанкинд байршуулсан хөрөнгө, 528.4 тэрбум төгрөгийн гадаад дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, 380.9 тэрбум төгрөгийн үнэт цаас, 5.5 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл, 452.9 тэрбум төгрөгийн бусад хөрөнгө, 29.3

тэрбум төгрөгийн биет болон биет бус хөрөнгөтэй, нийт 6.9 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй байна.

Тус банкны активын бүтцийг авч үзвэл нийт активын 79.6 хувь буюу дийлэнхи нь зээл, 5.6 хувийг үнэт цаас, 7.7 хувийг гадаад дотоодын арилжааны банкуудад байршуулсан харилцах, хадгаламж, 6.6 хувийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна. Тайлант өдрийн байдлаар нийт активын 92.9 хувийг орлого олдог актив эзэлж байна.

Хөгжлийн банкны нийт 528.4 тэрбум төгрөгийн **гадаад, дотоодын арилжааны банкуудад байршуулсан хөрөнгийн** 99.8 хувь нь буюу 527.3 тэрбум төгрөг нь дотоодын арилжааны банкуудад байршуулсан хадгаламж бол үлдсэн 1.1 тэрбум төгрөг нь гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах дансны үлдэгдэл байна. Харилцах дансны үлдэгдэлийн 117.7 сая төгрөг нь гадаадын арилжааны банкуудад байршуулсан харилцах дансны үлдэгдэл, 939.4 сая төгрөг нь дотоодын арилжааны банкуудад байршуулсан харилцах дансны үлдэгдэл байна.

Монгол улсын Хөгжлийн банкны актив шалгах өдрийн байдлаар 6,345.1 тэрбум төгрөг, нийт пассивын хэмжээ 6,664.7 тэрбум төгрөгт хүрсний 24.8 хувийг зээлийн эх үүсвэр, 72.5 хувийг олон улсын санхүүгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэр бүрдүүлж байна. Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 254.8 тэрбум, тухайн жилийн ашиг, алдагдал (41.2) тэрбум төгрөгт хүрсэн нь хагас жилийн төлөвлөгөөнд (7.2) тэрбум гэж төсөөлсөнөөс даруй 5 дахин өсөөд байна. Банкны ашгийн хэмжээ буурахад нөлөөлсөн хүчин зүйл нь хүүгийн бус орлого, зардал төлөвлөгөөнөөс 31.5 тэрбум төгрөгөөр өсөхөд валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал 67.3 тэрбум төгрөгт хүрсэн бол 2016 оны 08 дугаар сарын 19-ний байдлаар 193.1 тэрбум төгрөг болж нэмэгдээд байна. Банкны нээлттэй позицид багтдаг иен, ам.доллар болон евро гэсэн 3 голлох валют 197.2 тэрбум төгрөгийн ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээгээд байна. Үүний дийлэнх буюу 81.1 хувийг иен дээр хүлээж буй ханшийн тэгшитгэлийн алдагдал бүрдүүлж байна. ОУ-ын валютын зах зээл дээр хамгийн их хэлбэлздэг валют болох Японы иений эх үүсвэрээр бүрдүүлж тухайн эх үүсвэрийг ханшийн судалгаагүйгээр өөр валютад хөрөнгө оруулан, ханшийн эрсдэлээс хамгаалах ямар ч оролдлого хийгээгүй байгаа нь банкыг алдагдалд оруулах ноцтой үйл ажиллагаа болсон байна.

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (CAR) 10.9 хувьд хүрч 2016 оны бизнес төлөвлөгөөнд тусгаснаас 1.1 нэгж хувиар доогуур гарсан байна. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт буурахад зээлийн багцын хэмжээ өссөнтэй холбоотойгоор эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ өөрчлөгдсөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлохын тулд Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож ажилладаг. Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу Монгол улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд олон улсын зах зээлээс ихээхэн хэмжээний эх үүсвэрийг татан төвлөрүүлэх шаардлага тулгараад байна.

Тиймээс Хөгжлийн банкны нийт активын хэмжээ цаашид нэмэгдэх дээрх нөхцөлд банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, улмаар учирч болох эрсдлийг бууруулахын тулд Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээг

нэмэгдүүлэх(Дүрмийн сан+ тухайн жилийн ашиг/алдагдал) зайлшгүй шаардлага тулгараад байна.

Зарим эх үүсвэрийн гэрээгээр МУХБ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тодорхой түвшнээс дээш байлгах үүрэг хүлээсэн байдаг бөгөөд хэрэв гэрээний үүргээ биелүүлэх болбол МУХБ, Засгийн газар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байна.

МУХБ-ны тухай хуулийн 24 дүгээр зүйлээр зээл, зээлтэй адилтгах актив болон зээлийн баталгаа, үнэт цаасны хэмжээг нэмэгдүүлэх болбол өөрийн хөрөнгийн хэмжээнээс хамаарахаар байна.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон зээл ба урьдчилгаа төлбөр нь нийгмийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой, төслийн өөрийн мөнгөн урсгалаар зээлийг эргүүлэн төлөх боломжгүй төслүүд юм. Эдгээр төслүүдэд орон нутаг болон нийслэлийн зам, дулааны цахилгаан станцын өргөтгөл болон сайжруулалт, шинэ төмөр зам барих, арилжааны банкуудаар дамжин санхүүжигдэж байгаа бага дунд орлоготой өрхийг орон сууцжуулах ипотекийн санхүүжилт зэрэг орж байна.

Байгууллагаас эргэн төлөгдөх зээл ба урьдчилгаа нь зээлдэгч байгууллагын төслийн ирээдүйн мөнгөн урсгалаас төлөгдөх бөгөөд барьцаагаар баталгаажсан. Байгууллагаас эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд агаарын тээвэр, уул уурхай, төмөр зам, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэржүүлэлтийн салбарыг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийн зээл хамрагдаж байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар Сангийн яамнаас авахаар санхүүгийн тайланд тусгасан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хооронд 2012 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан, гурвалсан 77/03/1-35 дугаар “Төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцлийг тохиролцох гэрээ”-ний дагуу төлөх авлага болох 8.2 тэрбум төгрөгийн тооцоо нийлсэн акт байхгүй байна. Шалгалтын үеийн буюу 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар уг авлага 12.4 тэрбум төгрөг болж өсөөд байна. Дээр дурдсан гэрээг улс орны эдийн засаг, санхүү, төсвийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан 2016 оны 3 дугаар улиралд багтаан шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

Хөгжлийн банкны нийт активын 5.6 хувийг эзэлж буй 380.9 тэрбум төгрөгийн **үнэт цаасны** 88.4 хувийг 336.6 тэрбум төгрөгийн арилжааны буюу Засгийн газрын үнэт цаас эзэлж байгаа бол үлдсэн 11.6 хувийг 44.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үнэт цаас эзэлж байна.

Тайлант өдрийн байдлаар 44.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үнэт цаас байгаагаас 39.3 тэрбум төгрөг нь “МИК Холдинг” ХК-д, үлдсэн 4.9 тэрбум төгрөг нь Хөгжлийн банкны охин компани болох “Үндэсний экспортын даатгал” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт байна.

Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1 дэх зүйлийн дагуу Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 407 дугаар тогтоол, Хөгжлийн банкны 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн 93 дугаар тогтоолоор “Үндэсний экспортын

даатгал” ХХК-ийг үүсгэн байгуулж, тус бүр нь 50 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2 сая ширхэг хувьцаатай буюу нийт 100.0 тэрбум төгрөгийн дүрмийн сантай байхаар шийдвэр гарсан.

Хөгжлийн банкны ТУЗ-ийн дээрх тогтоолын хүрээнд Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-160 дугаар тушаалаар Хөгжлийн банкнаас тус компанид 5 тэрбум төгрөгийн (үүний 4.96 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 38 сая төгрөгийг автомашинаар) хөрөнгө оруулалт хийн 100.0 хувийн хөрөнгө оруулалттай өөрийн охин компани болгосон. Тус компанийг үүсгэн байгуулах ажлын хүрээнд Сангийн яам Дэлхийн банкнаас 10 сая ам.долларын техникийн туслалцаа авах, үүний 9 сая ам.долларыг дүрмийн санд оруулахаар төлөвлөгдөж байсан ч Дэлхийн банк экспортын даатгалыг дэмжих ажлыг хүрээнд дээрх техникийн туслалцааг “Хөдөө аж ахуйн давхар даатгалын компани”-д үзүүлэхээр болсон тул “Үндэсний экспортын даатгал” ХХК-ийн үүсгэн байгуулагдах ажил зогссон байна. Одоогоор Хөгжлийн банк тус охин компанийн дансанд байршуулсан 4.96 тэрбум төгрөгөө буцаан татаж өөрийн дансанд байршуулсан бөгөөд ТУЗ-өөс холбогдох шийдвэр гарахыг хүлээж байна.

Засгийн газар тухайн үед уг компанийг Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 11.4-т “Үйлдвэржилтийг дэмжсэн санхүүгийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бизнес эрхлэгчдэд учирдаг эрсдэлийг багасгах, санхүүжилтийн өртгийг бууруулах зорилгоор **хувийн хэвшилтэй хамтран экспортын даатгалын компани, тоног төхөөрөмжийн лизингийн компани байгуулах**” гэж заасныг үндэслэн байгуулсан нь хуульд нийцэхгүй шийдвэр болсон байна. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дахь заалтад “хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөл, түүний үндэслэлийг Засгийн газрын хариуцах гишүүн, хэрэв хэд хэдэн гишүүн хариуцах бол тэдгээр нь хянан үзээд бэлтгэл хангагдсан гэж үзвэл хуралдаанд оруулахыг зөвшөөрнө. Төсөл нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлигт нийцсэн, гүйцэд боловсрогдсон, зохих тооцоо, холбогдох яамны виз /санал/-ээр нотлогдсон байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна. 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар Монгол Улсын Хөгжлийн банкны урт хугацаат хөрөнгө оруулалтад 4,961,03,168.00 төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байсаар байна. Шинээр байгуулсан хуулийн этгээдийн санхүүгийн тайланд мөн бүртгэлтэй байна. Эдгээр хоёр хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэлийг цэгцлэх, татан буулгах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулах, Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийн агуулгад нийцүүлэн, хувийн хэвшилтэй хамтарсан хуулийн этгээд байгуулах эсэхийг шийдвэрлэх, өмнөх Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 18 дугаар зүйлийн 18.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2, Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУЗ-ийн 2015 оны 08 сарын 04-ний өдрийн 60 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны харьяанд “Бүтээн байгуулалтын лизингийн санхүүжилт” хязгаарлагдмал хариуцлагатай охин компани байгуулах тухай Гүйцэтгэх удирдлагын саналыг дэмжиж Сангийн сайдаар дамжуулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлага /Н.Мөнхбат/-д даалгасан байна.

“МИК Холдинг” ХК. Засгийн Газрын 2013 оны “Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх тухай” 12 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн банкны “МИК ОССК” ХХК-ийн хувьцааг эзэмших тухай ТУЗ-ийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор 10.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэснээр 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хөгжлийн банк нь “МИК ОССК” ХХК-ийн тус бүр нь 4000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2.5 сая ширхэг хувьцаа худалдан авч, тус компанийн 14.88 хувийг эзэмшсэн.

“МИК ОССК” ХХК нь 2015 оны 12 дугаар сард өөрчлөн байгуулагдаж, нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2015 оны 107 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын А-163 дугаар тушаалыг үндэслэн 5.5 тэрбум төгрөгийн 462,294 ширхэг хувьцааг нэмж худалдан авч, 2016 оны эхний хагас жилийн байдлаар “МИК Холдинг” ХК-ийн нийт хувьцааны 14.88 хувийг буюу нийт 3,081,955 ширхэг хувьцааг эзэмшиж байна.

Хөгжлийн банкны хөндлөнгийн хараат бус аудитор болох “PwC-Аудит” ХХК-ийн хянан баталгаажуулсан санхүүгийн загвараар хийгдсэн үнэлгээгээр хөрөнгө оруулалтын үнэ цэнэ 2014 оны эцэст 1.2 тэрбум төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн. 2014 оны ногдол ашгийн төлбөрийг МИК хувьцаагаар хийж, Хөгжлийн банкинд 540 сая төгрөгийн үнэ бүхий 119,661 ширхэг хувьцааг олгосон бол 2015 оны ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хийж, Хөгжлийн банкинд 743.3 сая төгрөгийн ногдол ашиг олгосон.

“МИК Холдинг” ХК-д оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнэ 2015 оны жилийн эцсийн байдлаар 27.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өссөн дүнг нийт хөрөнгө оруулалттай (15.5 тэрбум төгрөг) харьцуулахад хөрөнгө оруулалтын өгөөж 78.4 хувьд хүрч, 16.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар “МИК Холдинг” ХК нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 12,000 төгрөг байхаар зарласан бол Хөгжлийн банкны аудитор “PwC-Аудит” ХХК нэгж хувьцааны зах зээлийн бодит үнийг 9000 төгрөгөөр тооцон нийт хөрөнгө оруулалтын дүн 27.7 тэрбум төгрөг болгон залруулсан.

Харин 2016 оны эхний хагас жилийн байдлаар Хөгжлийн банкны аудитор солигдсон бөгөөд “Deloitte Онч Аудит” ХК нь “МИК Холдинг” ХК-ийн нэгж хувьцааны үнийг хөрөнгийн биржийн тухайн өдрийн хаалтын ханшаар буюу 12,750 төгрөгөөр тооцон нийт хөрөнгө оруулалтын дүнг 39.3 тэрбум төгрөг болгосноор тус хөрөнгө оруулалт нь 11.5 тэрбум төгрөгийн үнэ цэнийн өсөлттэй тайлагнагджээ.

Хөгжлийн банкны нийт активын 6.6 хувийг эзэлж буй 452.9 тэрбум төгрөгийн **бусад хөрөнгийн** 70.7 хувь буюу 320.7 тэрбум төгрөг нь хүүгийн авлага бөгөөд үлдсэн 132.6 тэрбум төгрөг нь бусад авлага, татварын тооцоо байна.

Хүүгийн авлагын 97.3 хувь нь буюу 311.9 тэрбум төгрөг нь зээлийн хүүгийн авлага, 4.2 тэрбум төгрөг нь Засгийн газрын үнэт цаасны хүүгийн авлага, 4.1 тэрбум төгрөг нь банкуудад байршуулсан харилцах, хадгаламжийн хүүгийн авлага байна. Зээлийн хүүгийн авлагаас 8.2 тэрбум төгрөг нь тэнцлийн гадуур гаргасан хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Тайлант өдрийн байдлаар тус банкинд 11.2 тэрбум төгрөгийн Сангийн яамнаас авах авлага байгаа нь ЖДҮ-д зориулан олгосон зээлд гэрээний дагуу тооцох ханшийн тэгшитгэлийн зөрүүтэй холбоотой. Түүнчлэн 82.4 тэрбум төгрөгийн урьдчилж төлсөн татвар бүртгэлтэй байгаа нь Сангийн яамны баталгаагаар

“Эрдэнэс таван толгой” ХК-д олгосон 50 сая ам.долларын зээлийн төлбөрийг хаахдаа Хөгжлийн банкинд 90.3 тэрбум төгрөгийн татварыг урьдчилж төлүүлсэнтэй холбоотой бөгөөд уг дүнгээс 2015 оны татвар суутгагдан тайлант өдрийн байдлаар 82.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн санхүүгийн болон татварын тайлангийн зөрүүнээс үүссэн 37.6 тэрбум төгрөгийн хойшлуулсан татварын хөрөнгө бүртгэлтэй байна.

Тайлант өдрийн байдлаар Хөгжлийн банкинд цэвэр дүнгээрээ 28.7 тэрбум төгрөгийн биет, 549 сая төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд: 27.3 тэрбум төгрөгийн барилга байгууламж, 489 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 295.6 сая төгрөгийн эд хогшил, 984.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1.0 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй байна. Дээрх хөрөнгүүдэд 1.2 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсон байна.

Тэнцлийн гадуур бүртгэлтэй хөрөнгө

Хөгжлийн банкинд тайлант өдрийн байдлаар 356.4 тэрбум төгрөгийн хүлээж болзошгүй үүрэг, 3.3 их наяд төгрөгийн зээлийн барьцаа, бусдаас авсан баталгаа батлан даалт, 8.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн орлогын буцаалт тус тус бүртгэлтэй байна.

Хүлээж болзошгүй үүргийн 200.1 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц 91.5 сая ам.долларын баталгаа, 154.2 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц 70.5 сая ам.долларын вексэлийн баталгаа, 2.1 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц еврогийн харилцагчийн өмнөөс гаргасан батлан даалт тус тус бүртгэлтэй байна.

Хөгжлийн банкнаас гаргасан 91.5 сая ам.долларын баталгааны 83.8 сая ам.долларын баталгаа нь “Шинэ Яармаг төсөл”-тэй холбоотой БНХАУ-ын Эксим банкинд гаргасан баталгаа бөгөөд одоог хүртэл хэрэгжээгүй бөгөөд баталгааны нөхцөл өөрчлөгдөн зээлдэгчээр БНХАУ-ын Эксим банкны оронд Голомт банкинд баталгаа гаргуулах хүсэлт ирүүлэн судлагдаж байна. Баталгааны үлдсэн 7.6 сая ам.доллар нь China Machinery Engineering Corporation-д гаргасан баталгаа байна.

Тайлант өдрийн байдлаар тус банкинд 1.06 их наяд төгрөгтэй тэнцэхүйц дотоодын банкуудаар олгосон зээлийн барьцаа хөрөнгүүд байна. Үүний 230.1 тэрбум төгрөгийг Голомт банкинд олгосон зээлийн барьцаа хөрөнгө, 198.6 тэрбум төгрөгийг Худалдаа хөгжлийн банкинд олгосон Асем Вилла зээлийн барьцаа хөрөнгө болон бусад дэд хөтөлбөрүүдийн хүрээнд дотоодын арилжааны банкуудад олгосон зээлийн барьцаа хөрөнгүүд бүртгэлтэй байна.

4.2. Төлбөр гүйцэтгэх чадварын эрсдэл

Монгол Улсын Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны тайлангаас үзэхэд 3 сараас нэг жил хүртэл болон 5-аас дээш жилийн хугацаанд нийт эргэн төлөгдөх татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн активын дүнгээс өндөр байгаа бөгөөд дээрх хугацаанд эргэн төлөгдөх актив нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн **55.7 хувиас 87.2 хувийг бүрдүүлж байгаа нь богино болон урт хугацаанд төлбөрийн чадварын эрсдэлд орж болзошгүй байгааг харуулж байна.** Монгол Улсын Хөгжлийн банкинд нийт 8.6 их наяд төгрөгийн санхүүгийн өр төлбөр бүртгэлтэй байгаагаас 3.3 их наяд төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгө богино буюу 1 жилийн хугацаанд, 2.6 их наяд төгрөг дунд

буюу 1-5 жилийн хугацаанд, 2.6 их наяд төгрөг урт буюу 5-аас дээш жилийн хугацаанд эргэн төлөгдөх буюу нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 38.8 хувь нь богино хугацаанд, 30.2 хувь нь урт хугацаанд эргэн төлөгдөх хуваарьтай байна.

Дүн тэрбум төгрөгөөр	3 сар хүртэлхи хугацаатай	3-6 сарын хугацаатай	6 сараас 1 жилийн хугацаатай	1-5 жилийн хугацаатай	5 дээш жилийн хугацаатай	НИЙТ
Санхүүгийн хөрөнгө						
Бэлэн мөнгө харилцах данс	1.38	-	-	-	-	1.38
Мөнгөн хадгаламж	534.80	-	-	-	-	534.80
Богино хугацаат хөрөнгө оруулалт	134.86	10.83	210.97	-	39.29	395.95
Зээл	53.15	412.96	1,681.56	2,837.34	1,548.77	6,533.77
Нийт санхүүгийн хөрөнгө	724.19	423.79	1,892.53	2,837.34	1,588.06	7,465.91
Санхүүгийн өр төлбөр						
Зээлийн баталгаа	(164.62)	-	-	-	-	(164.62)
Төлөгдөөгүй зээлийн үүрэг	(48.95)	(385.71)	(663.46)	-	-	(1,098.13)
Банк хоорондын эх үүсвэр	(103.58)	(155.05)	-	-	-	(258.63)
Зээлийн эх үүсвэр	(41.91)	(151.19)	(130.72)	(1,186.18)	(113.94)	(1,623.93)
Бонд	(39.12)	(6.43)	(1,314.21)	(170.43)	(727.32)	(2,257.52)
Засгийн газрын санхүүжилтийн эх үүсвэр	(14.09)	(62.57)	(62.57)	(1,317.38)	(1,761.25)	(3,217.85)
Чингис бондын эх үүсвэр	-	(62.57)	(62.57)	(1,317.38)	(1,761.25)	(3,203.77)
Нийт санхүүгийн өр төлбөр	(414.63)	(760.95)	(2,170.96)	(2,674.00)	(2,602.51)	(8,623.05)
Цэвэр санхүүгийн хөрөнгө/өр төлбөр	309.57	(337.17)	(278.44)	163.34	(1,014.45)	(1,157.14)
Нийт хуримтлагдсан дүн	309.57	(27.60)	(306.04)	(142.70)	(1,157.14)	(1,157.14)

Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2015 оны 106, 2016 оны 09 дүгээр тогтоолоор арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн доод хэмжээг **500.0 тэрбум төгрөг болон түүнтэй тэнцэх валютаар тогтоосон бөгөөд 2016 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар банкууд дахь мөнгөн хадгаламж нийт 534.8 тэрбум төгрөг байна.** Тус банкнаас шалгалтын ажлын хэсэгт гаргаж өгсөн тайлан мэдээнээс үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банк хадгаламж татах нэмэлт зөвшөөрөлгүй Чингис хаан банкинд 8.8 тэрбум төгрөг, 2.5 сая ам.доллар, 1.0 сая евро, Богд банкинд 2.0 сая еврогийн хадгаламж тус тус байршуулсан нь Монгол Улсын Хөгжлийн банкны эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж байна гэж үзлээ.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 6 сараас 1 жилийн хугацаатай эргэн төлөгдөх санхүүгийн өр төлбөрийн 60.3 хувийг буюу 1.3 их наяд төгрөгийг гадаад зах зээлд гаргасан ДХЕӨБ /580.0 сая ам.доллар/, Самурай бонд /30.0 тэрбум иен/-ийн эргэн төлөлт бүрдүүлж байгаа бол 5-аас дээш жилийн хугацаатай эргэн төлөгдөх татан төвлөрүүлсэн хөрөнгийн 67.7 хувийг буюу 1.7 их наяд төгрөгийг Чингис бондын эргэн төлөлт эзлэж байна. Монгол Улсын Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө болон бондын эргэн төлөгдөх хугацааг хүснэгтээр харуулав.

Дүн тэрбум төгрөг	3 сар хүртэлхи хугацаатай	3-6 сарын хугацаатай	6 сараас 1 жилийн хугацаатай	1-5 жилийн хугацаатай	5 дээш жилийн хугацаатай	НИИТ
Чингис бонд	-	62.57	62.57	1,317.38	1,761.25	3,203.77
ДХЕӨБ /580.0 сая ам.доллар/	36.47	-	1,305.17	-	-	1,341.64
Самурай бонд /30.0 тэрбум иен/	-	4.38	4.38	35.08	598.82	642.67
АСЕМ үнэт цаас	2.65	2.05	4.66	135.36	128.50	273.21
БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл	9.47	-	38.50	277.44	90.03	415.44
Кредит Свисс банкны хамтарсан зээл	18.39	-	77.15	649.52	-	745.06
ОУХОБанкны зээл /20 сая евро/	1.33	-	1.31	38.83	12.58	54.05
ВЭБ банкны зээл /20 сая ам.доллар/	2.73	3.29	3.24	24.55	11.33	45.15
ВТБанкны зээл	2.30	145.05	-	-	-	147.35
Каргиллийн зээл	7.69	-	7.69	179.43	-	194.80
Коммерц банкны зээл	-	2.85	2.82	16.41	-	22.09
Нийт	81.03	220.19	1,507.50	2,674.00	2,602.51	7,085.22
Бонд	36.47	4.38	1,309.55	35.08	598.82	1,984.31
Зээл	41.91	151.19	130.72	1,186.18	113.94	1,623.93
Чингис бонд	-	62.57	62.57	1,317.38	1,761.25	3,203.77

4.3. Ашигт ажиллагааг үнэлэх

МУХБ-ны аудитлагдсан санхүүгийн тайлангуудаас үзэхэд 2011, 2012 онуудад алдагдалтай ажилласан байна. Татварын дараах нийт ашиг 2013, 2014 онуудад 26.9 тэрбумаас 101.4 тэрбум төгрөг хүртэл 3.5 дахин өссөн байна. 2014 оны ашигт ажиллагаанд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь хүүгийн орлого болон гадаад валютын

НУУЦ

67

ИЛ БОЛСОН

ханшийн тэгшитгэлийн ашиг байна. 2015 онд татварын дараах ашиг 33.3 тэрбум төгрөг болж, 3 дахин буурсан байна.

/мян.төгрөг/

Үзүүлэлт	2011.12.31	2012.12.31	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.06.30
Хүүгийн орлого	253,433	12,878,274	130,357,281	332,739,994	408,829,111	206,423,564
Хүүгийн зардал	120,503	13,695,488	89,057,610	216,855,476	279,101,330	155,406,629
Хүүгийн цэвэр орлого	132,930	(817,214)	41,299,671	115,884,518	129,727,781	51,016,935
Хүүгийн бус орлого	3,758	(5,767,295)	4,615,801	50,721,141	(30,184,394)	(67,006,022)
Арилжааны цэвэр орлого/зардал	826	4,060	2,000,002	(2,148,945)	(1,047,423)	(282,457)
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого/зардал	2,932	(5,771,355)	1,913,579	51,715,248	(31,389,937)	(67,327,216)
Бусад орлого			702,220	1,154,839	2,252,966	603,651
Үйл ажиллагааны зардал	783,797	1,673,358	4,524,730	7,814,892	11,832,327	4,633,878
Үйл ажиллагааны орлого/зардлын дүн	(780,038)	(7,440,653)	91,070	42,906,249	(42,016,722)	(71,639,901)
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	(647,108)	(8,257,868)	41,390,741	158,790,767	87,711,059	(20,622,965)
Болзошгүй эрсдэл, хасагдуулгын зардал			6,224,791	24,668,226	46,454,176	34,172,411
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	(647,108)	(8,257,868)	35,165,950	134,122,540	41,256,882	(54,795,377)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого			57		538,832	743,367
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	14	29,960	69,159	129,135	177,420	30,314
Үйл ажиллагааны ашиг	(647,122)	(8,287,828)	35,096,846	133,993,405	41,618,294	(54,082,323)
Орлогын татварын зардал	(44,932)	(2,581,866)	8,209,257	32,536,552	8,331,533	(12,841,703)

НУУЦ 68

ИЛ БОЛСОН

Цэвэр ашиг/алдагдал	(602,190)	(5,705,962)	26,887,588	101,456,852	33,286,761	(41,240,620)
---------------------	-----------	-------------	------------	-------------	------------	--------------

Хүүгийн орлогыг задлаж авч үзвэл 2011-2015 онуудад өссөн үзүүлэлттэй байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар хүүгийн нийт орлогын 81 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.

Үзүүлэлт	2011.12.31	2012.12.31	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.06.30
Хүүгийн орлого	253,433	12,878,272	130,357,280	332,739,994	408,829,111	206,423,564
Зээлийн хүүгийн орлого		7,542,600	93,244,567	192,043,806	290,191,743	166,468,819
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого		59	76,578	616,371	2,050,417	157,974
Үнэт цаасны хүүгийн орлого				4,246,457	10,876,710	3,720,753
Бусад хүүгийн орлого	253433	5,335,613	37,036,135	135,833,360	105,710,241	36,076,018

Хүүгийн зардлын хувьд 2016 оны эхний хагас жилийн байдлаар хүүгийн зардлын 41.4 хувийг Засгийн газрын санхүүжилтийн хүүгийн зардал, 30 хувийг бонд, репо буюу үнэт цаасны хүүгийн зардал, 22 хувийг зээлийн хүүгийн зардал, 6.5 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна.

Хүүгийн зардал	2011.12.31	2012.12.31	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.08.16
Хадгаламжийн хүүгийн зардал			569,775	6,088,469	14,262,547	10,146,551
Зээлийн хүүгийн зардал				10,902,782	52,047,378	33,897,171
Үнэт цаасны хүүгийн зардал /бонд, репо/	120,503	13,695,488	57,319,682	84,727,005	90,467,816	46,885,400
Бусад хүүгийн зардал /ЗГ санхүүжилт/			31,168,153	115,137,219	122,323,588	64,477,507
НИЙТ	120,503	13,695,488	89,057,610	216,855,475	279,101,329	155,406,629

МУХБ-ны ашигт ажиллагааны үзүүлэлтийн биелэлтийг дүгнэвэл 2013, 2014 онуудад төлөвлөгөөг давж биелүүлсэн бол 2015 онд төлөвлөсөн үзүүлэлтэд хүрээгүй байна. 2016 оны эхний хагас жилд татварын дараах алдагдлыг 7.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн боловч алдагдал нь 41.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2016 оны эхний хагас жилд ашгийн хэмжээ буурахад цэвэр хүүгийн орлого төлөвлөгөөнд хүрээгүй буюу 17.2 тэрбум төгрөгөөр бага, ханшийн тэгшитгэлийн алдагдал 44.9 тэрбум төгрөгөөр их байгаа нь нөлөөлжээ. Дотоодын зах зээлд ам.доллар, иенийн ханш тасралтгүй чангарч байгаа нь ашгийг бууруулж, улмаар ашигт ажиллагааны үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Банкны актив, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтүүд 2015 оноос хойш бууралттай байна:

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016.06.30
ROA				
/активын өгөөж/	1.31%	2.32%	0.58%	-0.65%
ROE				
/өөрийн хөрөнгийн өгөөж/	18.69%	41.15%	11.58%	-16.34%

Энэ оны эхний хагас жилийн байдлаар алдагдалтай ажиллахад дараах хүчин зүйлс гол нөлөө үзүүлсэн байна:

1. Иенийн ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй алдагдал /30 сая иенийн “Самурай” бонд/;
2. Үйл ажиллагааны зардлын өсөлт;
3. Болзошгүй эрсдэл, хасагдуулгын зардлын өсөлт.

Шалгалт хийх өдрийн байдлаар буюу 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдөр ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй алдагдал нь 155.3 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс 132 тэрбум нь иенийн ханшийн тэгшитгэлийн алдагдал байна. Шалгалтаар 352.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан нэмж байгуулах, зээлийн хүүгийн авлагыг 146.3 тэрбум төгрөгөөр бууруулах тохируулга хийгдсэн нь ашигт ажиллагааны үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, банкны алдагдал 498.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт 615.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байна.

4.4. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл

Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн бүтцийг шалгах өдрийн байдлаар харуулав. Үүнд:

№	Үзүүлэлт	Дүн /сая төгрөгөөр/
1	Өөрийн хөрөнгө /2+3+4+5/	179,125.11
2	Дүрмийн сан	245,336.29
3	Хөрөнгө оруулалтын үнэлгээний нэмэгдэл	17,446.84
4	Өнгөрсөн жилийн ашиг / (алдагдал)	33,286.76
5	Тухайн жилийн ашиг / (алдагдал)	(116,944.77)

Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2012 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Эрсдэлийн удирдлагын бодлого” нь өнөөдрийн үйл ажиллагаандаа мөрдөж буй

өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт юм. Журмын 9.1 дэх заалтад “Банк нь Монголбанкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг шаардлагатай тохиолдолд дотоод удирдлагадаа хэрэгжүүлж болно” гэж заасан байна. Мөн 9.3 дахь заалтад “Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 12 хувь, 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 6 хувиар тогтооно” гэж заасан байна. Хэдийгээр **өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон боловч хэрхэн тооцох аргачлал, зохистой хэмжээнд хүрэхгүй тохиолдолд авах арга хэмжээг журмаар зохицуулаагүй байна.**

Шалгах өдрийн байдлаар Хөгжлийн банк нь PWC хөндлөнгийн аудитын байгууллагаас зөвлөсний дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцож байна. МУ-ын ЗГ-ын 2013 оны 238 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 200.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний төгрөгт хүргэх, хөрөнгийн хэмжээг 2013 оны Улсын төсвөөс боломжит хэмжээгээр нэмэгдүүлж, цаашид шаардлагатай эх үүсвэрийг улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг даалгасан байна. Мөн Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014, 2015 оны хурлаар хуримтлагдсан ашгийг хуваарилахгүйгээр дүрмийн санг нэмэгдүүлсэн байна.

Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байдал		
Огноо	Дүн	ЗГ-ын тогтоолын дугаар
2011.05.05	16,700,000,000.00	Сангийн сайдын 283 тогтоол
2011.12.24	33,000,000,000.00	ЗГ-ын 2011/09/30-ны өдрийн 285 дугаар тогтоол
2012.12.28	23,600,000,000.00	Төсөвт суусан /2012/11/09-ны өдрийн 1/581 тоот албан тоотын дагуу/
2013.07.24	10,000,000,000.00	ЗГ-ын 2013/07/06-ны өдрийн 238 дугаар тогтоол
2013.08.22	5,000,000,000.00	
2013.09.03	35,000,000,000.00	
2014.06.30	20,579,436,211.21	МУХБ-ны 2014/01/22-ны өдрийн ТУЗ-ын 4 дүгээр тогтоол
2015.06.30	101,456,852,036.80	МУХБ-ны 2015/06/16-ны өдрийн ТУЗ-ын 45 дүгээр тогтоол
Нийт	245,336,288,248.01	

Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газраас 7 хоног тутам зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцон гаргадаг бөгөөд шалгах өдрийн байдлаар (2016.08.12) дараах байдалтай байна:

III. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА	2016.08.12	
	PwC	Монголбанк
I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	6.73%	-0.12%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	7.40%	0.35%

Авах арга хэмжээ:

- Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журам, тооцох аргачлалыг ТУЗ-өөр яаралтай батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөх
- МУЗГ-ын 2013 оны 238 дугаар тогтоолын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 200.0 сая ам.доллартой тэнцэх төгрөгт хүргэх
- Хөгжлийн банкны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь заалтыг хэрэгжүүлэх

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцох болон бусад шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн тооцох талаар журамдаа тусгаагүй байна. Тухайлбал, эрсдэлээр жигнэсэн активыг тооцох хувь хэмжээг журмаар зохицуулаагүй байгаа бөгөөд эрсдэлийн тайланд зарим активын тооцох хувийн жин Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журамд заасан хувийн жингээс өөр байгаа нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бодитойгоор тооцохгүй байна гэж дүгнэж байна. Иймд **“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулан баталж ажиллах зайлшгүй шаардлагатай байна.**

Шалгах өдрийн тайлан тэнцэлд нийт зээлийг хугацаагаар ангилал бууруулж, зээлийн эрсдэлийн санг зардлаар 352.4 тэрбум төгрөгөөр, хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын 146.3 тэрбум төгрөгийг тэнцлийн гадуур гаргаж, нийт өөрийн хөрөнгийг 498.7 тэрбум төгрөгөөр бууруулах тохируулга хийхэд **Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө алдагдаж -319.6 тэрбум төгрөгт хүрэхээр байна.**

4.5. Зах зээлийн эрсдэл

Тус банк нь ТУЗ-ийн 2012 оны 04 тоот тогтоолоор “Эрсдэлийн удирдлагын бодлого”-оо баталж, мөрдлөг болгон ажиллаж байна.

ТУЗ нь банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагуудыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмуудыг баталж мөрдүүлэх, Дотоод аудитын алба нь банкны эрсдэлийн удирдлага, хяналт, банкны засаглал, зохион байгуулалтын зохицол, үр дүнтэй байдалд хяналт тавих, ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж ажиллах, АПУХороо болон Зээлийн хороо нь ТУЗ-с тогтоосон хязгаарын хүрээнд банкны эрсдэлийг удирдах, хянах, ЭУГ-ын оролцоотойгоор эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бодлого зарчмуудыг мөрдөн ажиллах, Санхүүгийн эрсдэлийн хэлтэс нь банкны өдөр тутмын үйл ажиллагаа болон бодлого, журмын хэрэгжилтийг хянаж шалган Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнаж ажиллах, ЭУГ нь банкны хэмжээнд эрсдэлийн бодлого, журам, зохицуулалтуудын хэрэгжилтэд бие даасан хяналтын үүргийг гүйцэтгэх гэж тус тус зааж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Банкны эрсдэлийн удирдлагын асуудлуудыг дараах хороод авч хэлэлцдэг байна:

- Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)
- Актив, пассивын удирдлагын хороо (АПУХ)
- Зээлийн хороо
- Аудитын хороо

Мөн Эрсдэлийн удирдлагын газар нь банкны зээлийн эрсдэлийн бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, эрсдэлтэй зээлийн багцад хяналт тавих, зээлийн хөрөнгийг алдагдлаас хамгаалах, нийт зээлийн багц болон эрсдэлтэй зээлийн багцын тайлан мэдээ мэдээллийг боловсруулж удирдлагыг тайлан мэдээллээр ханган ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын газрын бүтцийг авч үзэхэд Зээлийн эрсдэлийн хэлтэс /5 орон тоотой/, Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтэс /5 орон тоотой/, Санхүүгийн эрсдэлийн хэлтэс /5 орон тоотой/ гэсэн үндсэн 3 нэгжид хуваагдан ажиллаж байна.

Зээлийн эрсдэлийн хэлтэс нь зээлийн бодлого, зээлийн рейтинг, зээлийн эрсдэлийн судалгаа, муу зээл, аюулгүй байдал, даатгал, эрсдэлийн зүгээс зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулж байна. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх, төлбөрийн чадварын эрсдэл, хүүгийн эрсдэл, гадаад валютын эрсдэл зэрэг чиглэлийг хамарч үйл ажиллагаагаа явуулж байна.

Шалгалт хамрах хугацаанд эрсдэлийн удирдлагын чиглэлээр дараах журмуудынтөслийг боловсруулан удирдлагад танилцуулан, холбогдох байгууллага, газруудаас санал аван ажилласан байна: Үүнд:

1. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам
2. Эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлт оруулах
3. Эрсдэлийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах
4. Зээлийн үйл ажиллагааны журам

Харин тайлан, судалгааны ажлын хувьд дараахь ажлуудыг хийсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн эрсдэлийн тайланг долоо хоног бүр боловсруулан удирдлагад танилцуулж хэвшсэн байна. Мэдээний тоймд дараах эрсдэлийн хүчин зүйлсийг авч үзэж хэвшсэн байна. Үүнд:
 - a. Ханшийн эрсдэл
 - b. Хөрвөх чадварын эрсдэл
 - c. Хүүгийн эрсдэл
 - d. Тэнцлийн ерөнхий шинжилгээ
 - e. Гадаад валютын позицгийн танилцуулга
 - f. Актив пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан
2. Зээлийн эрсдэлийн өдөр тутмын тайлан;
3. 7 хоног тутмын зээлийн эрсдэлийн тайлан;
4. Дамжуулан зээлийн эрсдэлийн үнэлгээ, холбогдох арга хэмжээний санал зөвлөмж;
5. Зээлийн багцын эрсдэлийг тооцох, зээлийн эрсдэлийг удирдахад ашиглах зорилгоор “Винтэж шинжилгээ”-ний аргачлалын тухай судалгаа;
6. Грэйп бүртгэлийн програм дах зээлийн дансны мэдээлэл, зээлтэй холбоотой тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахаас гадна шаардлагатай тайлангийн загвар;
7. Эдийн засгийн судалгааг арилжааны банкуудын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлүүдийн хүрээнд судалж хийсэн үнэлгээ;

Хүүгийн эрсдэл

Актив, пассивын удирдлагын газар нь зээл, хадгаламжийн жигнэсэн дундаж хүүг тооцон, судалгаа гаргаж, энэ талаархи мэдээллийг улирал тутамд удирдлагад танилцуулан ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын газраас “Хүүд мэдрэмтгийг актив, пассивын шинжилгээ”-г 7 хоног бүр хийдэг. **Хүүгийн эрсдэлийн** хувьд тус

банкны эрсдэлийн нэгж нь хүүд мэдрэмжтэй актив, пассивын зөрүү, хүүгийн GAP, нийт активт орлого авчирдаггүй актив, хүүгийн цэвэр орлогын шинжилгээ, банкны ашиг болон алдагдлын хугарлын цэг зэргийг тооцоолж, банкны удирдлагад танилцуулж байна.

Тус банкны 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн тайлангаас үзэхэд хүүд мэдрэмжтэй актив +баталгаа батлан даалт (6.36 их наяд төгрөг+198.9 тэрбум төгрөг), пассивын (6.45 тэрбум төгрөг) зөрүү 106.8 тэрбум төгрөг буюу эерэг GAP-тай бөгөөд зөрүү нь өөрийн хөрөнгийн 55.7 хувийг эзэлж байна. Харин богино хугацаатай /6-12 сар/ актив, пассивийн GAP авч үзэхэд $GAP=XMA-XMP=-305.9$ тэрбум төгрөгийн сөрөг үзүүлэлттэй байна.

Банк сөрөг GAP-тай байгаа үед хүү өсөх нь цэвэр хүүгийн харьцааг багасгана. Учир нь хувьсах хүүтэй эх үүсвэрийн зардал нь хувьсах хүүтэй активын орлогоос их болно гэсэн үг. Харин хүү буурах нь цэвэр хүүгийн харьцааг нэмэгдүүлнэ.

Цэвэр хүүгийн харьцааг 2016 оны 08 дугаар сарын 16-ны байдлаар тооцвол:

$ЦХХ=(Хүүгийнорлого-Хүүгийнзардал)/Орлого \text{ олдог актив} = (262,419.72-198,242.68)/6,359,324.7 = 0.01009 \text{ } 1.09\%$ Тус банк активийн 1 төгрөг тутамд 1.001 мөнгөний орлого олж байна.

Шалгах өдрийн байдлаар жигнэсэн дундаж хүүг (ЖДХ) авч үзвэл зээл 6.57 хувь, үнэт цаас 5.71 хувь, банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 10.52 хувь, эх үүсвэр 4.71 хувь, гадаадын эх үүсвэр 4.82 хувийн тус тус жигнэсэн дундаж хүүтэй байна. Активын нэрлэсэн жигнэсэн дундаж хүү нь 7.0 хувь, пассивын жигнэсэн дундаж хүү нь 4.8 хувь, хүүгийн зөрүү 2.16 хувь буюу банкны системийн дундажтай харьцуулахад харьцангуй бага байна. Мөн үнэт цаасны дундаж хүү 5.71 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон Бодлогын хүү 10.5-15.0 хувиас харьцангуй бага байгаа нь ашигт ажиллагаанд муугаар нөлөөлж байна.

Ханшийн эрсдэл

Тус банкны тэнцлийн 24.1 хувь буюу 1.65 их наяд төгрөгийг гадаад валютаарх актив, тэнцлийн 29.3 хувь буюу 2.01 их наяд төгрөгийг гадаад валютаарх пассив эзэлж байна.

Гадаад валютын актив, пассив, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа нэгж валютын хувьд -318.19 хувь /иен/, -49.8 хувь /америк доллар/, -69.62 хувь /евро/, нийт валютын хувьд -437.61 хувьтай байна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассивын ханшийн тэгшитгэлээр нийт 155.3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Үүний 132.1 тэрбум төгрөгийн алдагдал иений ханшаас шалтгаалсан байна.

Гадаад валютын тэнцлээс харахад төгрөгийн ханш цаашид сулравал ханшийн тэгшитгэлээр алдагдал хүлээсээр байхаар байна. **Монголбанкны “Урт хугацаат своп хэлцлийн журам” нь банкуудын 5-аас дээш жилийн хугацаатай гадаадаас татсан эх үүсвэрт своп хэлцэл хийж, ханшийн эрсдэлээс сэргийлэхэд зориулагдсан. Уг журмыг судалж, гаднаас татсан эх үүсвэрийн алдагдалыг бууруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна.**

Гадаад валютын арилжаа

Хөгжлийн банкны гадаад валютын арилжаатай холбоотой үйл ажиллагаа нь тус банкны “Арилжааны үйл ажиллагааны журам”-ын хүрээнд зохицуулагддаг байна.

Шалгалт хамрах хугацаанд буюу 2014 онд тус банк Худалдаа, хөгжлийн банкттай 3 сарын хугацаатай 22.6 сая ам.доллар, еврогийн своп арилжаа хийж 8.1 тэрбум төгрөгтэй тэнцэх алдагдал хүлээсэн байна.

4.6. Хөндлөнгийн хяналтын байгууллагаас өгсөн аудитын дүгнэлтүүд, дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа

Үндэсний Аудитын газар нь Хөгжлийн банкны 2011, 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр “УБ Аудит корпораци” ХХК сонгож гурвалсан гэрээг байгуулсан ба уг аудитын компани нь тус байгууллагын санхүүгийн тайланд стандарт буюу “зөрчилгүй” дүгнэлт өгсөн байсан.

Шалгалтын явцад тус байгууллагаас санхүүгийн 2011, 2012 оны тайлангуудын цаасаар гаргуулан авч аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад баланс дахь үзүүлэлтүүд нь зөрүүтэй байсан.

Мөн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хөгжлийн банкны ТУЗ-ийн шийдвэрээр ОУ-ын аудитын байгууллага болох “Деллоит Онч Аудит” ХХК аудит хийлгүүлэхэд дахин өөрчлөлт орсон байна.

2013 оноос эхлэн ОУ-ын PwC Аудит ХХК аудитын үйлчилгээ үзүүлж эхэлснээр 2013 оны эхний үлдэгдэлд (2012 оны жилийн эцсийн тайлангийн дүн) дахин залруулга хийгдэж, өөрчлөлтийг оруулсан байна.

/2011-2012 онуудад арилжааны банкууд санхүүгийн цахим e-balance програмд шивдэггүй байсан тул эцсийн байдлаар харах боломжгүй байна./

Хөгжлийн банкны тухай хуулийн 18.1.1.-д “Хөгжлийн банкны стратегийг тодорхойлох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах” гэж заасан байтал үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлаагүй байна. Харин ажилтны ур чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдөн ажиллаж байна. Мөн Хөгжлийн банкны тухай хуулийн 18.5-д: “Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хуралд оролцогчдын саналын баримт бичгийн баталгаажуулсан хувийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хувь нийлүүлэгчид хүргүүлнэ.” гэж заасан байтал ТУЗ-ийн хурлын шийдвэр, тэмдэглэлийг ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаагүй байна.

Хурлын шийдвэрүүдийн албажуулалт бүрэн бус, хурлын тэмдэглэл дээр гарын үсгийн бүрдэл дутуу байхад тогтоол гарсан, мөн огт албажуулаагүй тохиолдол байна.

Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2013 оны 04 сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Ажилтнуудад зээл олгох журам”-ыг баталсан байна. Уг журамын 6-р зүйл. Өргөдөл гаргагчид тавигдах шаардлагын 6.1.1-д “Тус банкинд 18 сар ажилласан байх”, 6.1.4-д “Цалингийн зээл хүсэгч Банкинд 6-аас доошгүй сар

ажилласан байна.” гэж заасан ба цалингийн зээлийн өргөдлийг Хяналт, захиргааны газрын захирал, орон сууцны өргөдлийг удирдах хороогоор шийдвэрлэж арилжааны банкинд шилжүүлнэ гэж заасан байтал журмын заалтыг хангаагүй хамрагдсан дараах ажилтнууд байна.

Д/д	Ажилтны нэр	Албан тушаал	Ажилласан байдал	Авсан дүн
1	Э. Хишигбаатар	МТХ-ийн ахлах мэргэжилтэн	4сар	61,780,000
2	Б. Цолмон	Зээлийн газрын ахлах мэргэжилэн	2сар	40,000,000
3	Г.Одонтуул	Зээлийн газрын захирал	1сар	150,000,000

Төрийн банктэй хамтран ажиллах гэрээг байгуулснаар нийт 40 албан хаагч 478,031,164.25 /дөрвөн зуун далан найман сая гучин нэгэн мянга нэг зуун жаран дөрвөн төгрөг хорин таван мөнгө/ цалингийн зээлд, Монгол Улсын Хөгжлийн банк-Төрийн банк, Монгол Улсын Хөгжлийн банк-Худалдаа хөгжлийн банк хооронд хамтран ажиллах гэрээг байгуулснаар 13 ажилтан 980,530,000 төгрөгийн орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.

МУХБ-ны тухай хуулийн 18.1.10 “Төлөөлөн удирдах зөвлөл нь Хөгжлийн банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүү, үйл ажиллагааны талаархи хууль тогтоомж, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах” гэсэн заалт хангалтгүй хэрэгжсэн ба Хөгжлийн банк нь хөндлөнгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүрт хангуулж ажиллаагүй, дотооддоо дүгнээгүй, 2015 оноос хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа хийж эхлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн хангах асуудлыг хэлэлцүүлээгүй байна. Үйл ажиллагаа хэрэгжүүлж эхлэснээс хойш нийт 9 удаа хөндлөнгийн аудитад хамрагдсан бөгөөд 2014 онд Үндэсний аудитын нийцлийн аудит, 2011-2015 онуудад хөндлөнгийн төлбөртэй аудит хийлгэж, дараах төлбөрийг олгожээ.

Аудитын төлбөр жил тус бүрээр

Нэр төрөл	2011 он	2012 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
	Улаанбаатар аудит ХХК	Улаанбаатар аудит ХХК	Деллоитт Онч Аудит ХХК	PWC ХХК	PWC ХХК	PWC ХХК
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
Үйлчилгээний хэлс	20,000,000	20,000,000	46,200,000	144,203,400	278,719,870	278,719,870
Бусад зардал	-	-	-	8,011,300	8,011,300	8,011,300
Ханш хэлбэлзэл	-	-	-	12,229,016	-	2,353,628
Дүн	20,000,000	20,000,000	46,200,000	164,443,716	286,731,170	289,084,798

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан “хоёр жилд нэгээс доошгүй удаа” аудит хийх заалтыг хагас жил тутамд гэж шийдвэрлэн аудит хийлгэж буй нь үр дүн багатай зардал, цаашид аудитын зардлыг бууруулах нь зүйтэй гэж дүгнэхэд хүргэлээ. Дээрх 9 аудитаар нийт 77 зөвлөмж, албан шаардлага өгсөн бөгөөд 87,3 хувийн биелэлттэй байна.

Хамрагдсан огноо	Гүйцэтгэсэн байгууллага	Аудитаар өгсөн зөвлөмж /асуудал бүрээр/	
2011.12.31	УБ Аудит Корпораци ХХК	3	100%
2012.12.31	УБ Аудит Корпораци ХХК	11	96,4%
2012.12.31	Деллоитт Онч Аудит ХХК	20	92,1%
2013.06.31, 2013.12.31	PWC Аудит ХХК /жилд 2 удаа/	4	87,5%
2014.06.31, 2014.12.31	PWC Аудит ХХК /жилд 2 удаа/	10	82%
2014 он, 6 сар	Үндэсний аудитын газар /Гүйцэтгэлийн аудит/	13	83,3%
2015.06.31, 2015.12.31	PWC Аудит ХХК /жилд 2 удаа/	16	70%
2011-2015	9 удаа аудит хийгдсэн	77	87,3%
2016.06.31, 2016.12.31	Деллоитт Онч Аудит ХХК /жилд 2 удаа/	Хугацаа болоогүй хийгдэж байна.	

Гүйцэтгэх захирлын 2016 оны 9 дүгээр сарын 15/???) ны өдөр А-115 тоот тушаалаар “Нууцыг хамгаалах журам”-ыг баталсан ба уг журмын 2.4.1, 2.4.2, 2.4.3-т “Нууцын зэрэглэл, танилцах эрхтэй албан тушаалтан, нууцлах хугацаа зэргийг гүйцэтгэх удирдлагын хороогоор батлуулна” гэсэн боловч одоог хүртэл батлуулаагүй, нууцын ажилтныг томилоогүй, ажилтнууд нууцын төслийг өөрийн компьютер дээр бичдэг байна.

МУХБ-ны дүрмийн 10.7-д “Гүйцэтгэх удирдлага нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан багийн гишүүдийн ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална” гэж заасан боловч удирдлагын багийн үйл ажиллагааны журам буюу гүйцэтгэх удирдлагын ажлын харилцан уялдаа холбоо, хорооны гишүүдийн чиг үүрэг, хариуцлага, хорооны санал хураах, хурлын дэг зэрэг харилцааг зохицуулсан журам батлагдаагүй байна.

Хөгжлийн банкны “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг 2012 онд ТУЗ-ын 04 дүгээр тогтоолоор батлуулсан ба уг баримт бичигийн 5.2.2.6-д “Эрсдлийн удирдлагын хороо нь хурлын бэлтгэлийг хангах дүрэм болон хурлын

тэмдэглэлийг хөтлөх зааврыг батална”, 5.2.2.2-д “Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлыг улиралд 2-оос доошгүй удаа хуралдуулна”, Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмын 4.2-д “ЭУХ-ны ээлжит хурлыг сар бүрийн сүүлийн долоо хоногт хуралдуулна” гэж тус тус заасан боловч хурлын бэлтгэлийг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх дүрэм, заавар батлагдаагүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны хуралдсан байдал/ он тус бүрээр/

Д/д	Он	Хурлын давтамж
1	2013	2
2	2014	4
3	2015	5
4	2016	1

Хөгжлийн банкны “**Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам**”-ын 2.1-д “дарга, гишүүдээс, саналын эрхгүй нарийн бичигтэй байна.”, 2.2-д “эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнийг гүйцэтгэх удирдлага томилж чөлөөлнө.” гэж заасан ч тус хорооны гишүүд аль газрын ямар албан тушаалтан байх нь тодорхойгүй, нарийн бичгийг томилж чөлөөлсөн тушаал гараагүй байна.

АПУБодлогын 4.2.3.5-д “АПУХ нь хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх болон хурал явуулах дүрэм, журмыг боловсруулж батална”, АПУХ нь АПУБодлогын 4.2.4.1-д дурдсан 7 төрлийн тайланг гүйцэтгэх удирдлагад гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд АПУБодлогын 4.2.4.2-д “дээрхи тайлангуудыг нэгдсэн байдлаар бэлтгэн **улирал** бүр ТУЗ-д танилцуулна” гэж заасан боловч хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх болон хурал явуулах дүрэм, журмыг боловсруулж батлуулаагүй, хурлын шийдвэрийг дугаарлахдаа 2013 оны 5-р сарын 3-ны, 5-р сарын 10-ны шийдвэрүүдийг давхар 12 гэж дугаарлаж, 2013 оны 1-р сарын 21, 12-р сарын 10-ны өдрийн шийдвэрийг алгасаж 20, 22 гэж дугаарласан, тайлангуудыг нэгдсэн байдлаар бэлтгэн улирал бүр ТУЗ-д танилцуулж ажиллаагүй, хурлын тэмдэглэлийг албажуулж, архивлаагүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор дотоод аудиторoor 1 хүн томилон ажиллуулах шийдвэр гаргасан боловч 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл 1 жил 6 сар дотоод аудитын ажил хийгдээгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 84 дүгээр “Дотоод аудитын албаны түр дүрэм батлах тухай” тогтоолоор “Дотоод аудитын албаны түр дүрэм”, 85 дугаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн Дэд хороодын үйл ажиллагааны түр журам батлах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Дотоод аудитын дэд хорооны түр журам” батласан байна.

Хөгжлийн банкны дотоод хяналтын тогтолцоо доголдолтой, үйл ажиллагаа нь хэвийн бус, шаардлага хангахгүй байгаагаас дотоод үйл ажиллагаанаас гадна, гаднын харилцагчтай явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт дутагдах, ашиггүй ажиллах (2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаарх байгууллагын алдагдлын хэмжээ 41.2 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь өмнөх оны жилийн эцсийнхээс 74.5 тэрбум төгрөгөөр өссөн) байгууллагын үнэ цэнэ буурах эрсдэлтэй байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 26.1.-д “Хөгжлийн банк нь хянан шалгагчтай байх бөгөөд хянан шалгагч нь энэ хууль болон гэрээний дагуу тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ” гэж заасан боловч хууль, дүрэмд заасны дагуу Хянан шалгагчийг томилон ажиллуулаагүй байна.

4.7. Хөгжлийн банкны урсгал болон хөрөнгийн зардал, өглөг авлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны зардлыг ТУЗ-өөр хэлэлцэн баталж ирсэн байна. 2011-2016 оны эхний хагас жилд нийт 30.7 тэрбум төгрөгийн урсгал, 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардал гарсан байна.

	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт дүн
Боловсон хүчинтэй холбоотой зардал	429.2	1,004.1	2,648.1	4,505.4	5,784.6	3,184.3	17,555.7
Үүнээс цалин хөлс	373.8	821.6	2,067.9	3,448.4	4,700.9	2,749.8	14,162.4
Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал	362.7	1,282.5	2,647.7	3,309.5	2,671.1	2,553.3	12,826.8
Үүнээс, мэргэжлийн үйлчилгээ	17.6	661.2	990.9	720.2	1,082.7	343.4	3,816.0
Олон нийтэд мэдээлэл хүргэх зардал	32.2	7.9	793.1	1,248.9	623.3	974.5	3,679.9
Түрээсийн зардал	64.1		251.7	604.6	788.8	260.2	1,969.4
Харилцаа холбооны зардал	10.1	56.7	97.1	108.5	154.1	85.4	511.9
Бичиг хэргийн зардал	10.7	13.0	25.0	55.1	61.9	26.1	191.8
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	17.4	29.9	68.6	129.1	93.8	32.9	371.7
Нийт зардлын дүн	809.3	2,316.5	5,364.4	7,944.0	8,549.5	5,770.5	30,754.2
Хөрөнгийн зардал	1,053.3	117.3	605.2	1,011.9	106.1	3.0	2,896.8

Урсгал зардлын дүнд боловсон хүчний холбогдолтой зардал буюу ажилтнуудын цалин хөлс, шимтгэлийн болон албан томилолтын зардал 43.3-69.2 хувийг, үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал 31.9-55.36 хувийг эзэлж байна.

Цалингийн зардал 2011 онд 373.8 сая төгрөг байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар 4,700.9 сая төгрөг болж өссөн нь ажилтнуудын тоо 38-116 болж өссөнтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлын дийлэнх хувийг мэргэжлийн үйлчилгээ олон нийтэд мэдээлэл хүргэх зардал, түрээсийн зардлууд эзэлж байна. Мэргэжлийн үйлчилгээний зардалд 2015 онд хамгийн их буюу 1.1 тэрбум төгрөг зарцуулсан нь Банкны зээлжих зэрэглэлийг тогтоолгох зорилгоор 2015 оны эхний хагас жилд PWC компанид 103.3, “Стандард энд Пүүрс” компанид 219.4 сая төгрөг, “Moody’s” компанид жилийн эцэст 169.7 сая, бусад 196.0 сая, нийт 688.4 сая төгрөг төлсөн нь нөлөөлсөн байна.

Олон нийтэд мэдээлэл хүргэх зардал 2011-2015 онд 32.2 саяас 1,248.9 сая төгрөг зарцуулсанаас хамгийн их төлөлт 2014 онд хийгдсэн байна. Тухайн онд “Bloomberg-inside Mongolia”-н сурталчилгаа байршуулах зардал 814.2 сая төгрөг зардлаар бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 52 дугаар “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тогтоолыг үндэслэн Худалдаа хөгжлийн банкны охин компани болох Ти Ди Би Капитал ХХК-иас Худалдаа хөгжлийн банкны Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө 19, нутаг дэвсгэрт байрлах барилгын 11, 12 дугаар давхар, барилгын зоорийн В1 давхрын 10 автомашины 163.1 м.кв талбайтай автозогсоолын зориулалттай барилгыг нийт 28 500 000.00 (Хорин найман тэрбум таван зуун сая төгрөг) төгрөг хүртэлх төсөвт өртөгт багтаан худалдан авч, гэрээ байгуулсан байна. Дээрх тогтоолд “...3294 м.кв талбайтай үл хөдлөх эд хөрөнгийг тус банкны ажлын байрны зориулалтаар үндсэн хөрөнгөдөө ...” гэж заасан ч Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 3 гэрчилгээнд 3403.46 м.кв талбайтай үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлсэн байх ба тогтоолд зааснаас 109.46 м.кв талбайгаар илүү байна.

Үүнийг Монгол Улсын Хөгжлийн банк, Худалдаа хөгжлийн банкны хооронд 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ”-ний 3.1 дэх заалтад “Гэрээний зүйл болох нийт 3240 м.кв талбайтай оффисын зориулалттай 11, 12 давхрын үл хөдлөх эд хөрөнгийн нэг м.кв үнэ 8 278 571.43 (Найман сая хоёр зуун далан найман мянга таван зуун далан нэгэн төгрөг дөчин гурван мөнгө)...” гэж заасантай зөвхөн оффисын зориулалттай талбайн зөрүүг тооцвол 447.0 сая төгрөг, барилгын зоорийн В1 давхрын 10 автомашины автозогсоолын зориулалттай барилгын нэг м.кв-ын үнийг гэрээнд заагаагүй, нийт үнийг 775 510 204.08 (Долоон зуун далан таван сая таван зуун арван мянга хоёр зуун дөрвөн төгрөг найман мөнгө) гэж заасантай тооцон үзвэл НИЙТ гэрээний үнийн дүн 27.6 тэрбум төгрөг нь ТУЗ-ийн тогтоолд зааснаас 900.0 сая төгрөгийн зөрүүтэй болжээ.

Уг байрыг ашиглалтад оруулж хүлээн авснаас хойш байгууллагын урсгал зардал буюу үл хөдлөх эд хөрөнгийн татварт 2015 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 95.8 сая төгрөг, 2016 оны эхний хагас жилд 137.9 сая төгрөг, барилгын элэгдэлд 115.5 сая төгрөг, ашиглалтын зардалд 3.1 сая төгрөг тооцогдсон нь сар тутамд 42.7 сая төгрөг болж байна.

Түрээсийн зардалд 2014 онд 604.6 сая, 2015 онд 788.8 сая, 2016 оны эхний 4 сард 260.2 сая төгрөг зарцуулж 5 сараас Худалдаа хөгжлийн банкны байранд шилжин байршсан байна.

Байр худалдаж авсантай холбоотойгоор үл хөдлөх хөрөнгийн татвар төлж эхэлсэн бөгөөд 2016 оны эхний хагас жилд 160.9 сая төгрөг төлсөнөөр зардалд бүртгэжээ.

Шинээр барилгад нүүж орохоос өмнө байрын түрээс төлдөг байсан. Ажлын байр түрээслэх гэрээг анх 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д.Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Ким Жанг Жин нар байгуулсан бөгөөд түүнээс хойш 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. (2013 оны 07 дугаар сарын 23-ны өдөр, 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдөр, 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдөр)

2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Ким Жанг Жин нарын байгуулсан гэрээнд нэг м.кв-ын нэг сарын үнэ 41 500 төгрөг, нийт түрээслэх талбайн хэмжээ 750 м.кв байв. Сар тутам нийт 31 125 000 (Гучин нэгэн сая нэг зуун хорин таван мянган) төгрөгийг төлдөг. Талбай болон үнийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

	Гэрээ байгуулсан он, сар, өдөр	Гэрээ байгуулсан этгээд	Талбайн хэмжээ (м.кв)	Нэгж талбайн түрээсийн үнэ	Сарын нийт үнэ	Гэрээний дагуу өөрчлөгдсөн үнэ	Шийдвэр гаргаж зөвшөөрсөн эрх зүйн баримт бичиг	Бусад тайлбар
1	2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр	Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Ким Жанг Жин	750.0	41,500.0	31,125,000.0	93,375,000.0		3 сард төлөх
2	2013 оны 07 дугаар сарын 23-ны өдөр	Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны тэргүүн дэд захирал С. Сандагдорж	784.0	41,500.0	32,536,000.0	162,680,000.0		Оны сүүлийн 5 сард төлөх
3	2014 оны 02 дугаар сарын 07-ны өдөр	Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н. Мөнхбат	1,150.0	41,500.0	47,725,000.0	548,837,500.0		Оны сүүлийн 11 сард төлөх
4	2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр	Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.	1,550.0	41,500.0	64,325,000.0	128,650,000.0		Оны сүүлийн 2 сард төлөх

		Мөнхбат						
5	2015 оны 05 дугаар сарын 14-ний өдөр	Макс-Импекс ХХК-ийн Ерөнхий захирал Д. Ганбаатар, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н. Мөнхбат	1,550.0	41,500.0	64,325,000.0	771,900,000.0		

2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар гарсан бичиг хэргийн зардлыг тооцвол нэг ажилтанд (Нийт 126 хүн ажилладаг, үүний 13 нь жолооч, үйлчлэгч тул үлдсэн 113 ажилтан) зарцуулах сарын зардал 32 000 төгрөг байгаа нь төсөвт байгууллагын дунджаас 4-5 дахин өндөр байна.

Байгууллагын төсөв, хөрөнгийг захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэхдээ Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага нь байгууллагад үр ашиггүй нөхцөл, журмыг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулах, урьдчилан амлалт өгч, баталгаажуулсан хэлцэл хийж, өр, авлага үүсгэсэн байна. Тухайлбал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авах төсөв батлах тухай” тогтоол, Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Зардлын төсөв батлах тухай” А-162 дугаар тушаалын дагуу 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 01-2/17 дугаартай 45,000,000.00 (Дөчин таван сая) төгрөгийн “Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г Монгол Улсын Хөгжлийн банкыг төлөөлж Гүйцэтгэх захирал Н. Мөнхбат, “Легал консалтинг”ХХК, “Өмгөөллийн ёс” ХХН-ийн түншлэл, тэдгээрийг төлөөлсөн, “Өмгөөллийн ёс” ХХН-ийн Гүйцэтгэх захирал Р. Мөнхзул, “Легал консалтинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Дэлгэрмаа нар байгуулсан байна.

Энэ гэрээний гүйцэтгэл өнөөг хүртэл гараагүй байгаа учир гэрээний нэг тал болох Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Н. Мөнхбатын гарын үсэгтэй “Гэрээнээс татгалзах тухай” 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 2/843 дугаартай албан тоотыг “Легал консалтинг”ХХК, “Өмгөөллийн ёс” ХХН-д хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. Дээр дурдсан гэрээний дагуу Хөгжлийн банк 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр “Легал консалтинг”ХХК-ийн Төрийн банк дахь 370400000501 тоот дансанд урьдчилгаа төлбөр 30,000,000.00 (Гучин сая) төгрөгийг шилжүүлэн өгсөн. Үйлчилгээний гүйцэтгэл ирүүлээгүй, гэрээний нэг тал татгалзсан тул байгууллагыг нэн даруй хохиролгүй болгож, 30,000,000.00 (Гучин сая) төгрөгийг буцаан төлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Байгууллагын урсгал зардлын үр ашиггүй зарцуулалтыг хүлээн зөвшөөрч, нийтийн эрх ашигт нийцүүлэн ажиллахгүй байгаа удирдлагын үйл ажиллагааг сайжруулах, бүтэц, зохион байгуулалт, тогтсон соёл, ёс зүйг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай байна. Үүнийг хамт олноос гаргуулан авсан асуулгад ажилтнуудын дийлэнх олонхи бичсэн байгаа. Тухайлбал: Олон нийтэд мэдээлэл түгээхтэй холбоотой зардалд 2016 оны эхний хагас жил, 03 дугаар сарын 09-ний өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд 416.4 сая төгрөг зарцуулсан байна.

82
НУУЦ

ИЛ БОЛСОН

Хөгжлийн банкнаас “Анар-Од” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан 2/452 дугаар 80,000,000.00 (Наян сая) төгрөгийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдөр шилжүүлсэн урьдчилгаа 56,000,000.00 (Тавин зургаан сая) төгрөгөөс хийгдсэн ажил гэх 44,000,000.00 (Дөчин дөрвөн сая) төгрөгийг хасаж, үлдэх 12,000,000.00 (Арван хоёр сая) төгрөгийг буцаан төлүүлэх нь зүйтэй.

Мөн Хөгжлийн банкны “Саунд оф монголиа” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан 2/467 дугаар 79,728,000.00 (Далан есөн сая долоон зуун хорин найман мянган) төгрөгийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдөр шилжүүлсэн 70 хувийн урьдчилгаа 55,809,600.00 (Тавин таван сая найман зуун есөн мянга зургаан зуун) төгрөгийг буцаан төлүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Хөгжлийн банкны хамт олноос шалгалтын багийн гаргуулан авсан санал асуулгад байгууллагын Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага өөрсдийн гаргасан шийдвэрээ хэрэгжүүлдэггүй, зөрчдөг, бие биенээ хаацайлдаг, ажлын алдаа, оноогоо шударга хэлэлцдэггүй, хамт олны хурал хийдэггүй, нууцлаг байдлаар ажилладаг, газруудын хоорондын ажлын уялдаа, нэгдмэл байдал хэт алдагдсан талаар дурдаад, жишээ татаж сахилгын шийтгэл оногдуулсан ажилтнуудад урамшуулал олгосон, удирдлагын буруутай үйл ажиллагаа шүүмжлэгдэхгүй байгаа асуудлыг хөндсөн байна. Үүнийг шалгахад дараах зөрчил илрэв. Үүнд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Дотоод аудитын албаны хэсэгчилсэн аудитын тайлан, цаашид авах арга хэмжээг батлах тухай” 07 дугаар тогтоолын 4-т “ТУЗ-өөс өгсөн үүрэг, даалгаврыг хангалтгүй биелүүлсэн Орлогч захирал бөгөөд Актив, пассивын удирдлагын газрын захирал М. Бат-Өлзий, Орлогч захирал бөгөөд Эрсдэлийн удирдлагын газрын захирал Р. Батбаяр нарт сахилгын сануулах шийтгэл ногдуулсугай.” гэж заасан байна. (Тогтоолын хуулбарыг хавсаргав.)

Харин Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” А-33 дугаар тушаалыг үндэслэн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчин 2016 оны нэгдүгээр улиралд Р. Батбаярт 5,800,000.00 (Таван сая найман зуун мянган) төгрөг, М. Бат-Өлзийд 6,000,000.00 (Зургаан сая) төгрөгийн урамшууллыг олгосон байна. Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын 2013 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А-127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын “Арван нэг. Хөдөлмөрийн сахилга, хариуцлага”, 11.5-д “Сахилгын шийтгэл хүлээсэн ажилтанд тухайн улирлын урамшууллыг олгохгүй.” гэж заасныг зөрчсөн тул дээр дурдсан ажилтнуудаас урамшууллын мөнгийн буцаан төлүүлэх нь зүйтэй байна.

-Хөгжлийн банк 2016 оны эхний хагас жилийн байдлаар Сангийн яамнаас авахаар санхүүгийн тайланд тусгасан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хооронд 2012 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан, гурвалсан 77/03/1-35 дугаар “Төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцлийг тохиролцох гэрээ”-ний дагуу төлөх авлага болох 8.2 тэрбум төгрөгийн тооцоо нийлсэн акт байхгүй байна.

Шалгалтын үеийн буюу 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар уг авлага 12.4 тэрбум төгрөг болж өсөөд байна. Дээр дурдсан гэрээг улс орны эдийн засаг, санхүү, төсвийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан 2016 оны 3 дугаар улиралд багтаан шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

-2011-2015 онд нийт 2,893.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсаны 36 хувь буюу 1,031.3 сая төгрөгийг биет бус хөрөнгө, 34 хувь буюу 984.5 сая төгрөгийг тээврийн хэрэгсэл, 20 хувь болох 585.5 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, үлдэх хувийг тавилга, эд хогшлын зардал эзэлж байна.

Тус банкинд нийт 984.5 сая төгрөгийн үнэлгээ бүхий 11 тээврийн хэрэгсэл ашиглагдаж байгаагийн 638.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий 4 ширхэг Тоёота LC-200 маркийн автомашиныг 2014 онд худалдан авсан байна.

-ТУЗ-ын тогтоолоор 2011, 2012 оны ХБ-ны үйл ажиллагааны зардлын, болон үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг худалдан авах төсвийг тус тус баталдаг байна. Гэвч 2011 онд үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг **31,149.1** мянган төгрөгөөр худалдан авахаар төсөвлөсөн байхад **1,053,310.6** мянган төгрөгөөр компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил болон биет бус хөрөнгийг худалдан авч батлагдсан төсвийг **1,022,161.46** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, 2012 онд үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах төсөв батлагдаагүй байхад авто машин **110,025.8** мянган төгрөгөөр худалдан авсан зэрэг зөрчил илэрлээ.

-2011 оны 9 дүгээр 16-ны өдөр ХБанк нь "Грейп Сити" ХХК-тай "Банкны програм хангамжийг бүтээгдэхүүн нийлүүлэх, нэвтрүүлэх ба ашиглалтын дараах засвар үйлчилгээ үзүүлэх" № ЛА-11/33- 4/26 тоот гэрээг байгуулан, 9 сарын 20-өдөр тус байгууллагын ХХБ-ны 453009869 тоот данс руу **838,486,550** төгрөгийг шилжүүлсэн ба энэ нь мөн төсөвлөгдөөгүй гарсан зардал байна. Мөн бүтээгдэхүүний даатгалт үйлчилгээний гэрээг байгуулан жил бүр хураамжийг дараах байдлаар төлсөн байна. Үүнд:

- 2011 он /гэрээ № ЛА-11/33-4/2/ - 36,520,000 төгрөг, /хугацаа 2011-09-16-2012-09-15/
- 2012 он /гэрээ № ГСМ М-13-22/ - 146,080,000.0 төгрөг, /хугацаа 2012-09-16- 2013-09-15/
- 2013 он /гэрээ № ГСМ М-13-22/ - 108,214,431.12 төгрөг - 5%, /хугацаа 2013-09-16 - 2014-09-15/
- 2014 он /гэрээ № ГСМ М-14-21/ - 119,054,320.0 төгрөг - 10%, /хугацаа 2014-09-16 - 2015-09-15/
- 2015 он /гэрээ № М-15-23 гэрээ 3 сарын/ - 29,010,597.0 төгрөг - 5%, /хугацаа 2015-09-16 - 2015-12-31/
- 2016 он /гэрээ № М-16-13 гэрээ/ - 116,042,388.0 төгрөг /хугацаа 2016-01-01 - 2016-12-31/

2012-2016 онуудад нийт системүүдэд 84 удаагийн сайжруулалт хийж, НИЙТ даатгалт үйлчилгээний хөлсөнд гэрээгээр **554,921,736.12** төгрөг зарцуулсан ба нийт даатгалт үйлчилгээний зардлын төсөв 66 %-иар нэмэгдсэн байна.

2012-2015 оны хооронд холбогдох газар хэлтсүүдээс хэрэглэж буй дэд системүүдэд сайжруулалт хийлгэх эсэх талаар санал асуулга авдаггүйгээс болж сайжруулалт хийх шаардлагагүй байсан системүүдэд даатгалт үйлчилгээний хураамж тогтмол төлж байсан байна. Систем бүрээр хэмнэж болох байсан зардлын товъёог харуулав. /мян.төг/

Дэд системийн нэрс	Банкны програм	ДҮН
GrapeBank	Банкны програм	0
GrapeMaster	Ерөнхий дэвтэр	26,689.3
Gramis/	Удирдлагын мэдээллийн систем	0
Grats	Хөрөнгийн удирдлага	35,896.0
GreatHR/	Хүний нөөцийн програм	0
GreatFA	Үндсэн хөрөнгийн	1,176.0
GreatPayroll	Цалин	1,680.0
Авизын интерфейс	онлайн Тусдаа гэрээ байгуулсан байна	323.4
НИЙТ ДҮН		65,764.7

Мөн ТУЗ-ийн 2011 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу банкны програм хангамжийг түрээсээр нийлүүлэх төслийн гэрээгээр 2 удаа /6,7 сард/ нийт 90,761,000 төгрөгийг шилжүүлсэн байна.

- 6 сарын 30-ны өдөр - 58,690,500 төгрөг /түрээс- 32,070,500 төгрөг, нэвтрүүлэх ажлын төлбөрт 26,620,000 төгрөг/
- 7 сарын 21-ний өдөр – түрээсэнд 32,070,500 төгрөг төлсөн байна.

Грейпсити бүтээгдэхүүний даатгалт үйлчилгээний зардал гэрээний дагуу 2015 оны 07 дугаар сараас 12 дугаар сард 58.8 сая төгрөг зарлагддаг. (сар тутам 9.8 сая төгрөг) Нийт биет бус хөрөнгийн буюу программ хангамжийн элэгдэлд сар тутам 8.8 сая төгрөг зарцуулдаг.

Нийт програм хангамжийн зардалд анх худалдан авсан үнийг оролцуулан 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 1,484,169.3 мянган төгрөг зарцуулсан.

Цаашид ч даатгалт үйлчилгээний зардал үргэлжлэн гарах тул програм хангамж ашиглахтай холбоотой зардал /автоматжуулалтын зардал/ нэмэгдэхээр байна.

Иймд мэдээлэл технологийн аудит хийлгүүлэх саналтай байна. Ингэснээр системүүдийн автоматжуулалтын зардлын үр ашиг болон мэдээлэл технологийн эрсдэлийн түвшинг тогтоох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

2011 онд ХБ 20,0 сая төгрөгийн өрийн бичиг арилжаалсан байна. ТУЗ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 19 тоот тогтоолоор “Дунд хугацааны евро өрийн бичгийн хөтөлбөрийг батлах, уг хөтөлбөрийг зохицуулагч, дилер, хуулийн зөвлөх”-ийг томилж 755,636.15 ам долларын зардал гаргасан боловч ТУЗ нь тухайн жилийн төсөвт батлагдаагүй зардлыг гаргасан байна.

Журмын дагуу хийгдсэн худалдан авалтын дүнг нийт гэрээ байгуулсан дүнтэй харьцуулбал дараах байдалтай байна.

№	Он	Журмын дагуу хийсэн худалдан авалтын дүн /төгрөгөөр/	Нийт гэрээ байгуулсан дүн /төгрөгөөр/	Зөрүү /Шууд худалдан авсан гэрээний дүн /
1.	2011	838,486,550.00	1,167,540,546.00	329,053,996
2.	2012	246,154,398	307,766,912.00	61,612,514
3.	2013	233,200,000.00	4,930,284,182.12	4,697,084,182.12 /Блүүмберг ТВ-тэй 2013.10.21-ны өдөр байгуулсан 1,835,200 ам долларын гэрээ ихэнх хувийг эзлэж байна/
4.	2014	362,200,000.00		
5.	2015	30,644,717,970.90		28,500,000,000 /ХХБ-аас худалдан авсан ажлын байрны зардал ихэнх хувийг эзэлж байна.
6.	2016	541,328,208.00	1,365,980,208.00	824,652,000.00

Тав. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд мөрдөж буй зарим эрх зүйн актууд нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх.

5.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР

Хөгжлийн банкныг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, уг тогтоолын хавсралтаар дүрмийг нь баталсан байна. 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль батлагдаж, Засгийн газар уг хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2 дахь заалтуудад заасан Хөгжлийн банкныг үүсгэн байгуулах, түүний дүрмийг батлах, Хөгжлийн банкинд бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн байгуулах Хөгжлийн банкны талаархи бүрэн эрхийнхээ хүрээнд 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 151 дүгээр тогтоол, түүний хавсралтаар урьд мөрдөгдөж

байсан дүрмийг хүчингүйд тооцож Хөгжлийн банкны дүрэм, бүтцийг шинэчлэн баталжээ.

5.1.1. Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтын талаар

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална” гэж заасан.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 15 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасанд нийцсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Дээрхи тогтоолд “Монгол Улсын Их Хурлын шийдвэрт заасан дараахь төсөл, хөтөлбөрийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газар /С.Батболд/-т үүрэг болгосугай.”, 1-т “Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр.”, 2-т “Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого.”, 3-т “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолд заасан “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор.”, 4-т “Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан “Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга, байгууламжийн жагсаалтад орсон төсөл, хөтөлбөр.” гэж заасан.

Уг тогтоолын 1-4 дэх хэсгүүдэд заасан Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн агуулга, хэлбэрээс үзэхэд зөвхөн Улсын Их Хурлын 2008 оны 47 дугаар тогтоол нь тодорхой төсөл, арга хэмжээний жагсаалтыг агуулж байгаа боловч Улсын Их Хурлын 2010 оны 32, 36 дугаар тогтоол, 2010 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөр нь төрөөс тухайн салбарт баримтлах бодлого, хөгжүүлэх ерөнхий чиглэл, зорилтыг тодорхойлсон буюу бодлогын баримт бичгийн шинжтэй, хэрэгжүүлэх тодорхой төсөл, арга хэмжээний нэр заасан жагсаалт агуулаагүй байна.

Түүнчлэн Хөгжлийн банкны зээлээр төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн Улсын Их Хурлын дараахь тогтоолуудыг мөн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт нийцсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Үүнд:

1. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2012 оны 37 дугаар тогтоол:

Идэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хөгжлийн банкнаас олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх/

2. Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2013 оны 63 дугаар тогтоол:

Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголоор хасагдсан, 2014 оны улсын төсөвт тусгагдаагүй болон бусад зам тээвэр, эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах/

3. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014 оны 30 дугаар тогтоол:

Хөгжлийн банкны санхүүжилтээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтыг үндэслэн боловсруулан, тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх/

4. Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай 2015 оны 41 дүгээр тогтоол:

17.4.Цементийн үйлдвэрийн төслүүдэд Хөгжлийн банкнаас санхүүжилт олгох,

10.7.Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх

10.8.Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд Хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгох

10.9.Ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төслүүдэд Хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгох/

5. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015 оны 108 дугаар тогтоол:

Малчдын амьжиргааны түвшинг сайжруулах, махны зах зээл, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд "Мах" хөтөлбөрийг боловсруулан, Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

2016 оны хаврын тариалалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тариалалтад зориулсан зээлийн эх үүсвэрийг холбогдох хуулийн хүрээнд Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах/

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт: "Хөгжлийн банкнаас... санхүүжүүлэх төсөл хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна" гэж, хуулийн 8.1 дэх хэсэгт: "Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан ... томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох

бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг ~~Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална.~~ гэж заасан нь Улсын Их Хурлаас хуулийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийн жагсаалт батлах шаардлагатай гэсэн агуулга юм.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь “Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивийн болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана.” гэсэн заалт нь тодорхой зээлийн эрсдэл болон мөнгөн хөрөнгийн хэмжээг харгалзан төсөл, хөтөлбөр гүйцэтгэгчид банкны зүгээс зээл олгох шийдвэр гаргах эрх бүхий субъектыг заасан заалт байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан, тухайлбал: 10.1.2. “...төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх”, 10.1.3 “...Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх,” 10.1.4 “...зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх”, 10.1.5 “төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэл зээлийн барьцаа хөрөнгөд тооцсон байх” зэрэг шаардлагуудаас үзэхэд Улын Их Хурлаас батлах төсөл, хөтөлбөрийн жагсаалт нь тодорхой нэр бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тоочин бичсэн агуулгатай байх нь гэсэн хуулийн үзэл санаатай байна.

Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоол болон дээр дурьдсан Засгийн газарт чиглэл өгсөн бусад тогтоолууд нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалт гэхээс илүүтэйгээр Улсын Их Хурлаас Үндсэн хууль болон бусад хуульд тогтоомжид заасан эрхийн хүрээнд хууль хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн тодорхой салбаруудыг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газарт чиглэл өгсөн шинжтэй, хэт ерөнхий, нийгмийн бүхий л салбарыг хамарсан зорилго, зорилт, дэвшүүлсэн, өргөн цар хүрээтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх агуулгатай байна.

Хөгжлийн банкны үйл ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдэд хамаарах Засгийн газрын 2011-2016 оны 161 тогтоолыг нягтлан үзэхэд нийтлэг байдлаар Засгийн газрын тогтоолын тэмдэглэх хэсэгт Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолд заасан 4 баримт бичгийн аль холбогдох баримт бичгийн нэрийг дурьдаж, уг баримт бичигт заасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор гэж, тогтоох хэсэгтээ төсөл, хөтөлбөрийн нэр, санхүүжилтийн хэмжээ, зарим тохиолдолд гүйцэтгэгчийг тодорхой дурьдан, санхүүжилт олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан агуулгатай байсан ба Засгийн газар өөрийн үзэмжээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн дурын төсөл, хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолоор баталсан “жагсаалт”-д “хамааруулах”-ад хүргэсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт нь УИХ-д улс орны нийгэм, эдийн засагт онцгой ач холбогдолтой салбаруудыг хөгжүүлэх, эдгээр салбарт ямар төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих, Засгийн газраас өрийн баталгаа гаргаж бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих механизмыг бүрдүүлэх зорилготой байсан боловч хуулийг хэрэгжүүлж байгаа одоогийн практик нь Улсын Их Хурлын дээрх бүрэн эрхэд халдсан, зээлийн

эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэт үрэлгэн, хуульд заасан зорилгод нийцээгүй үйл ажиллагаанд зарцуулах нөхцлийг бүрдүүлжээ.

Иймд цаашид Засгийн газар хуулийн шаардлагад нийцсэн жагсаалтыг Улсын Их Хурлаар батлуулан, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

5.1.2. Төсөл, хөтөлбөрүүдийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх тухай Засгийн газрын тогтоолуудын хууль зүйн үндэслэлийн талаар

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Компанийн тухай хуульд зааснаар Засгийн газар, Засгийн газрын яаманд Хөгжлийн банкинд төвлөрүүлсэн эх үүсвэрийг захиран зарцуулах эрх олгогдоогүй буюу Хөгжлийн банкыг ямар нэгэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх үүрэг өгөх шийдвэр гаргах эрх олгосон заалт байхгүй байна. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу зээл олгох шийдвэрийг Засгийн газар бус Хөгжлийн банкны зээлийн хороо хуульд заасан нэгжүүдийн саналыг үндэслэн гаргахаар заасан.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Хөгжлийн банкны эрх барих дээд байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн хурал байх бөгөөд хувь нийлүүлэгчийн хувьд Засгийн газар нь Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Хөгжлийн банк нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар уг хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд ба үйл ажиллагаандаа мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан хараат бус байх, ашигтай ажиллах, хариуцлагатай байх зарчмыг баримтлахаар хуульчлагджээ.

5.1.3. Хөгжлийн банкны хэрэгцээнд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах эрх зүйн зохицуулалтын талаар

Хөгжлийн банк нь өөрийн дотоод хэрэгцээнд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй." гэснийг баримтлан уг хуулийг мөрдөхгүйгээр Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан "Монгол Улсын Хөгжлийн банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ыг мөрдөж байгааг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр хуульд нэмсэн бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг дагалдаж гарах хууль хэлбэрээр батлагдсан байна. Монгол Улсын Хөгжлийн банкныг улс орны нийгэм, эдийн засагт чухал ач холбогдолтой төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор үүсгэн байгуулсан ба өндөр өртөг бүхий төсөл, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацаа, гүйцэтгэгчийн техникийн болон эдийн засгийн чадавхиас шалтгаалан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах онцгой журам, онцлогтой холбоотойгоор **тус банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт холбогдох бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмаас гадуур зохицуулахаар уг хуулийг баталсан гэх үндэслэлтэй байна.**

Гэвч дээрх зохицуулалтыг Хөгжлийн банк өөрийн дотоод хэрэгцээндээ худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээтэй холбогдох харилцаанд хамааруулан хэрэглэсэн байх тул хуульд холбогдох нарийвчилсан зохицуулалтыг хийх нь зүйтэй байна.

5.1.4. Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын талаар

Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг Засгийн газраас Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж эсхүл зөвлөн, эсхүл тухайн төсөл хөтөлбөрийг хамаарагч төсвийн ерөнхийлөн захирагч, төслийн нэгжүүд сонгон шалгаруулж, ямар журмаар, хэрхэн сонгон шалгаруулсан нь тодорхойгүй гүйцэтгэгчид шууд санхүүжилт олгох байдлаар шийдвэрлэж байна. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй субъектүүд төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгч сонгон шалгаруулалтын журам тогтоон хэрэгжүүлж ирсэн ба тухайлбал, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийт 13 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын ямар журмаар сонгосон нь зээлийн холбогдох материалуудад **тодорхойгүй** байна.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хэрэгжүүлсэн, Гудамж төслийн хүрээнд 95, Орон сууцны хотхон, хорооллын дэд бүтэц төслийн хүрээнд 38, Гэр хорооллын дэд бүтэц төслийн хүрээнд 33 төслийг Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтыг хийсэн гэж үзэн санхүүжилтийг олгосон.

Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-аар төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь /уг журамд төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төрийн захиргааны төв байгууллагыг ойлгоно гэж нэр томъёоны тодорхойлолтод заасан/ төслийн нэгжийг байгуулах, төслийн захирал, ерөнхий нягтлан бодогчийг томилох эрхтэй. Мөн журмын 7.2.1-г “үнэт цаасны хөрөнгөөр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр саналаа ирүүлсэн этгээдүүдээс төслийн захирал дор дурдсан шалгуурыг хангасан 2-оос доошгүй этгээдүүдийг сонгон ТУХ-нд танилцуулж шийдвэрлүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр Хөгжлийн банк, төслийн гүйцэтгэгчтэй гурвалсан гэрээ байгуулан үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, өдөр тутмын хяналт тавих” гэсэн зохицуулалттай байна. Өөрөөр хэлбэл, энэхүү журмаар төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хийх асуудлыг зохицуулаагүй байна.

Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлсэн дийлэнхи төслийн гүйцэтгэгчийг Хөгжлийн банк өөрөө бус тухайн төсөл, хөтөлбөрийг хариуцах салбарыг эрхэлсэн Засгийн газрын яам, орон нутгийн засаг захиргааны нэгж, тэдгээрийн харъяанд байгуулсан төслийн нэгжээс сонгон шалгаруулж гэрээ байгуулан, төслийн санхүүжилтийг олгуулахаар Хөгжлийн банкинд ханддаг байна.

Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан Засгийн газрын яам, орон нутгийн засаг, захиргааны нэгж болон төслийн нэгжүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийг үндэслэн хуулиас гадуур Эдийн засгийн хөгжлийн

сайдын баталсан болон бусад хуулиар тусгайлан эрх олгогдоогүй журмуудыг баримтлан сонгон шалгаруулалт явуулсан байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт: “Хөгжлийн банкнаас **сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн** санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна.” гэж заасан боловч бусад заалтаар сонгон шалгаруулалттай холбоотой зохицуулалт байхгүй байх тул Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг ямар арга замаар, ямар шалгуур үзүүлэлтийг баримтлан, хэн сонгон шалгаруулалт хийх асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

5.1.5. Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа хараат бус, хариуцлагатай байх зарчмын талаар

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:”, мөн зүйлийн 6.1.2-т “хараат бус байх;”, 6.1.5-д “хариуцлагатай байх.” гэж тус тус заасан.

Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн банкны дүрмийн 6.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй төсөл, хөтөлбөрт зээл олгох, баталгаа, батлан даалт зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалтад заасан зээл нь “зөвхөн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэсэн байх” зарчим алдагдаж, мөн хуулийн 10 дугаар зүйлд заасан төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг хангасан эсэхийг Хөгжлийн банк сайтар нягтлан шалгадаггүй, мэргэжлийн шинжилгээ, судалгаагүйгээр зээлийг олгодог, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг ямар шалгуураар сонгон шалгаруулсан нь тодорхойгүй, хуульд заасан шаардлагыг хангаагүй төсөл, хөтөлбөрүүдийг Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн сайд, Аж үйлдвэрийн сайд нарын баталсан шийдвэр, журам, чиглэлийн дагуу санхүүжүүлсэн нь Хөгжлийн банкны хараат бус, хариуцлагатай байх зарчим алдагдсан гэж дүгнэхэд хүргэж байна.

5.1.6. Засгийн газрын гишүүдийн баталсан Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөж буй шийдвэрүүдийн талаар

Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөж байсан гэх Засгийн газрын гишүүдээс баталсан дараахь шийдвэрүүдийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Засгийн газрын 2010 оны “Журам батлах тухай” 119 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу хянан үзлээ. Үүнд:

- Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”;

- Хөдөлмөрийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” А/44 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, түүнд хяналт тавих

журам”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор олгох хөнгөлөлттэй зээлийн журам”;

- Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн “Журам батлах тухай” 64 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох “Төсөл сонгон шалгаруулах хороо болон дэд хороо”-ны журам”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Төслийн иж бүрдэл”, гуравдугаар хавсралтаар баталсан “Төслийн иж бүрдлийн тайлбар”;

- Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” 100 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Төслийн иж бүрдэл”, гуравдугаар хавсралтаар баталсан “Төслийн иж бүрдлийн тайлбар”;

- Сангийн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Ази, Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ази, Европын дээд түвшний уулзалтын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”;

Дээрх шийдвэрүүд нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 1.6.1-т “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр” гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдийн заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн шийдвэрийг;” гэж заасанд буюу Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хамаарах бөгөөд уг журам”-ын 1.3-т “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргана.”, 1.7.2-т “Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заавал дурдсан байх;” гэж заасан шаардлагыг хангахгүй байна.

Түүнчлэн уг журмын 2.5.2-т “Шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ. Энэ шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй;” гэж заасныг зөрчсөн байна.

5.1.7. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалын бусад зөрчлийн талаар

1. Уг тушаал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийн 11¹.1 дэх хэсэг, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль /энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэл болгон баталсан нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 1.3-т “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргана.” гэж заасныг болон 1.7.2-т “Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заавал дурдсан байх;” гэж заасан шаардлагыг хангахгүй байна.

2. Тушаалын хавсралтын 2 дугаар зүйл нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 131 тоот “Аргачлал батлах тухай” тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 3.2-т “хуулиар тусгайлан эрх олгоогүй бол хуулийн нэр томъёоны утга агуулгыг хуулиас доогуур түвшний актаар тодорхойлж болохгүй” гэж заасанд нийцэхгүй байна.

3. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалд хуульд заагаагүй эрх, үүргийг бий болгосон маш олон заалтууд байна. Тухайлбал уг тушаалын хавсралтын 4.1-т “ЭЗХЯам нь дараах эрх, үүрэгтэй”, 6.4-т “Төслийн удирдах хороо нь дараах эрхийг эдлэнэ”, 4.1.5-д “улсын төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн нөхцөл байдлаас хамааран төслийн цаашдын хэрэгжилт оновчгүй, үр дүнгүй болбол өөрийн санаачлагаар төслийн хэрэгжилтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх санал гаргах”, 6.4.5-д “Төслийн санхүүжилт нь Монгол Улсын Хөгжлийн банкаар хийгдэх тул үнэт цаасны хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийнхөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасны дагуу уг хуулиар зохицуулагдахгүй тул гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах асуудлыг төслийн захирлын танилцуулсан саналыг хэлэлцэж шийдвэрлэх.”, 7.2-т “Төслийн нэгж нь дараах эрхтэй.”, 7.2.1-т “Үнэт цаасны хөрөнгөөр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр саналаа ирүүлсэн этгээдүүдээс төслийн захирал дор дурдсан шалгуурыг хангасан 2-оос доошгүй этгээдүүдийг сонгон ТУХ-нд танилцуулж шийдвэрлүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр Хөгжлийн банк, төслийн гүйцэтгэгчтэй гурвалсан гэрээ байгуулах үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, өдөр тутмын хяналт тавих.”, 7.2.1.1-т “тухайн салбарт ажилласан туршлага;”, 7.2.1.2-т “санхүүгийн чадавхи;”, 7.2.1.3-т “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн байх;”, 7.2.1.4-т “Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргаагүй байх.” гэж тус тус заасан.

4. Тушаалын хавсралтын 4.1-т “ЭЗХЯам нь дараах эрх, үүрэгтэй”, 4.1.4-т “төсөл хэрэгжүүлэгч байгууллага (салбарын яам)-аас ирүүлсэн саналыг үндэслэн, эсхүл дангаараа зөвлөх болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлах асуудлыг шийдвэрлэх” гэж заасан ба ямар нөхцөлд гэрээг цуцлах зохицуулалт байхгүй.

5. Тушаалын хавсралтын 6.4-т “Төслийн удирдах хороо нь дараах эрхийг эдлэнэ.”, 6.4.5-д “Төслийн санхүүжилт нь Монгол Улсын Хөгжлийн банкаар хийгдэх тул үнэт цаасны хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасны дагуу уг хуулиар зохицуулагдахгүй тул гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах асуудлыг төслийн захирлын танилцуулсан саналыг хэлэлцэж шийдвэрлэх.” гэж зааж хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар албаны бүрэн эрхээ хэтрүүлж хэм хэмжээ тогтоосон.

6. Тушаалд дурдагдаагүй асуудлыг журмын 1-8 хүртэлх хавсралтаар баталсан. Үүнд журмын хавсралт 1-ээр “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирлын хөлсөөр ажиллах гэрээний загвар”, 2-оор “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний загвар”, 3-аар “Төслийн үйл ажиллагааны зардлын төсвийн маяг”, 4-өөр “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын үндсэн цалингийн жишиг”, 5-аар “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалингийн нэмэгдэл тогтоох

үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд”, 6-аар “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалинг тогтоох үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд”, 7-оор “Дотоод томилолтын зардлын жишиг”, 8-аар “Гадаад томилолтын зардлын жишиг”-ийг баталсан.

5.1.8. Хөгжлийн банкны зээлийн бодлогын эрх зүйн орчины талаар

1. Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Хөгжлийн банкны Зээлийн бодлого”-ыг баталж, дахин шинэчлэн батлаагүй байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “Хөгжлийн банкны зээлийн бодлогыг зээлийн найдвартай эргэн төлөгдөх зарчимд тулгуурлан жил бүр тодорхойлж батлах;” гэж заасныг зөрчиж байна.

2. Монгол Улсын Хөгжлийн банкны Зээлийн бодлогын хоёрт “ ..., Засгийн газраас баталсан хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах ...” гэж заасан нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална.” гэж заасантай нийцэхгүй байна.

3. Монгол Улсын Хөгжлийн банкны Зээлийн бодлогын зургаад “Банкны Зээлийн хороо нь богино болон дунд хугацааны, 5 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийг бие даан шийдвэрлэх бөгөөд 1 жил хүртэлх хугацаагаар үндсэн зээл болон хүүгийн төлбөрөөс чөлөөлөх эрхтэй байна. Бусад тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авна.” гэж заасан нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивийн болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана.” гэж заасантай нийцэхгүй байна.

5.1.9. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар

Хөгжлийн банкнаас төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх шийдвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлаас батлагдсан жагсаалтын дагуу, хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрт Зээлийн хороо шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой болгох

Улсын Их Хурлаас Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг жил бүр хаврын чуулганаараа батлах

Төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтай холбоотой хуулийн хийдлийг арилгах зорилгоор улс, орны нийгэм эдийн засгийн бодлого, хөгжлийн стратегит нийцсэн төсөл, хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулах журмыг хуульчлах, уг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг тодорхой болгох

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад заасан хараат бус байх зарчмыг хэрэгжүүлэх зорилго бүхий зохицуулалтыг хуульд нэмж тусгах.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийн хэрэгжилтийг

тайланд тусгасан утгаар нэг мөр хангах зорилгоор хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хэмжих боломжтой байдлаар өөрчлөлт оруулах болон уг өөрчлөлттэй уялдуулан төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлж, дүгнэх аргачлал, зааврыг тодорхой болгон холбогдох журмыг тогтоосон эрх зүйн актыг батлах эрх бүхий субъектийг хуулиар тогтоох.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлд Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг нарийвчлан тодорхой болгох.

5.2. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.2.1. Бүтэц, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Хөгжлийн Банкны /цаашид "МУХБ" гэх/ бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 151 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Актив-пассивийн удирдлагын, Зээлийн, Эрсдэлийн удирдлагын болон Хяналт, захиргааны гэсэн үндсэн 4 нэгж, туслах 10 дэд нэгжтэйгээр батласнаас хойш бүтэц, зохион байгуулалтад дараахь байдлаар өөрчлөлт хийжээ.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Монгол Улсын Хөгжлийн банкны бүтцийн нэгжүүдийг батлах тухай" 54 дүгээр тогтоолоор бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийн дэд нэгжүүдийн тоог нэмэгдүүлэн нийт 15 дэд нэгжтэй болсон;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн "Барилга захиалагчийн алба байгуулах, Монгол Улсын Хөгжлийн банкны цалингийн сан, орон тооны хязгаарыг нэмэгдүүлэх тухай" 30 дугаар тогтоолоор "Барилга захиалагчийн алба"-ыг шинээр үүсгэн байгуулсан;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Монгол Улсын Хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай" 11 дүгээр тогтоолоор бүтэц, зохион байгуулалтыг дахин шинэчлэн батлахдаа Тэргүүн дэд захирал, дэд захирлын орон тоог хасаж үндсэн нэгжийн захирал нарыг орлогч захирлаар мөн "Хөрөнгө оруулалтын газар"-ыг шинээр үүсгэн байгуулж нийт орон тоог 168 болгожээ.

Дүгнэлт: МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлд МУХБ-ны бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, өөрчлөх эрх хуулиар олгогдоогүй байхад ийнхүү ТУЗ-ийн дээрх тогтоолуудаар Хөгжлийн банкинд бүтцийн өөрчлөлт хийсэн нь МУХБТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2, 20 дугаар зүйлийн 20.1, 22 дугаар зүйлийн 22.1.2, Засгийн газрын 2011 оны 151-р тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "МУХБ-ны бүтэц, зохион байгуулалт"-ыг зөрчсөн шийдвэр болжээ.

Монгол Улсын Үндэсний Аудитын газраас 2014 онд МУХБ-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дээрх зөрчлийг илрүүлэн 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/80 ҮАГ-ГАГ/2014/ГА-6 тоот албан бичгээр шинээр байгуулсан Хөрөнгө

оруулалтын газар болон Барилга захиалагчийн албыг татан буулгах, хэрэгжилтийг 2015 оны 03-р сарын 31-ний дотор хангуулан, биелэлтийг хүргүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Уг шаардлагын дагуу 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Тогтоолд өөрчлөл оруулах тухай” 25-р тогтоолоор Хөрөнгө оруулалтын газрыг “дэмжих нэгж” болгон өөрчилсөн хэдий ч орон тоог хэвээр хадгалан үлдээсэн байна.

Шинэчлэн батлагдсан бүтэц, зохион байгуулалтыг шалгахад МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай судалгаа, шинжилгээг хийлгүйгээр бүтцийн өөрчлөлт хийсэн байх ба газар, нэгжүүдийн бодлого, чиг үүргийг тодорхойлж батлаагүйн улмаас мөрдлөг болгон ажиллах баримт бичиггүй, улмаар зарим нэгжийн чиг үүрэг тодорхойгүй, үндсэн нэгж болон түүнд харьяалагдах хэлтэс хоорондын уялдаа холбоо бага, эсхүл огт хамааралгүй чиг үүрэг хэрэгжүүлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын газрын чиг, үүргийг огт тодорхойлоогүй байх ба түүний харьяанд тус банкны олон нийттэй харилцах алба, бодлого, төлөвлөлтийн судалгааны хэлтэс зэрэг байгаа нь үйл ажиллагааны хувьд уялдаа холбоогүй байна. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийн /цаашид Хөгжлийн банкны дүрэм гэх/ 12.1-д заасан хянан шалгагчийг одоог хүртэл томилж ажиллуулаагүй, шинэчлэн баталсан бүтцэд хянан шалгалт хийх чиг үүрэг бүхий нэгж байхгүй байгаа нь дээрх хуулийн хэрэгжилт хангалтгүй, тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалтын ажиллагаа огт хийгдээгүйд хүргэсэн байна.

Шаардлагатай судалгаа, шинжилгээн дээр үндэслэн байгууллагын бүтцийг батлаагүйн улмаас ажил, үүргийн хуваарилалт тодорхой бус, газар, нэгж хоорондын уялдаа холбоог алдагдаж, давхардал, хийдэл үүсэх нөхцөл бололцоог үүсгэжээ.

Цаашид банкны зохион байгуулалт, бүтцийг хуульд нийцүүлэн өөрчлөх; ингэхдээ нэн тэргүүнд ажил үүргийн шинжилгээг энэхүү Ажлын хэсгийн дүгнэлтэнд үндэслэн хийж, газар, нэгжийн чиг үүргийг боловсруулан батлуулж ажил үүргийн хуваарилалтыг хийх шаардлагатай байна.

5.2.2.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эрх, үүргийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль, дүрэмд заасан эрх үүргийн хэмжээнд зохих түвшинд ажиллан мөрдлөг болгон хэрэгжүүлэх шаардлагатай дараах баримт, бичгийг цаг хугацаанд нь батлуулаагүй, эсхүл огт батлуулаагүй, мөн хуульд заасан холбогдох байгууллагын саналыг аваагүй, хуульд заасан гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн зэрэг асуудлууд байна. Үүнд:

- МУХБ-ны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д Төлөөлөн Удирдах зөвлөл нь “Хөгжлийн банкны стратегийг тодорхойлох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах” гэж заасан боловч тус банкны бизнес төлөвлөгөө оны дунд үед батлагдан гардаг, 2014 оны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг огт батлаагүй байна;

- МУХБ-ны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-д “Хөгжлийн банкны зээлийн бодлогыг зээлийн найдвартай эргэн төлөгдөх зарчимд тулгуурлан жил бүр тодорхойлж батлах” гэсэн хэдий ч Зээлийн бодлогыг 2011 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 13 дугаар тогтоолоор анх батласнаас хойш дахин шинэчлэн батлаагүй;

- МУХБ-ны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5-д заасан “ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох”, Хөгжлийн банкны дүрмийн 10.7-д “багийн гишүүдийн ажиллах журам болон гүйцэтгэх захирлыг томилох журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батлана” гэж заасан ч уг журам одоог хүртэл батлагдаагүй

- МУХБТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д ТУЗ-ийн хэрэгжүүлэх бүрэн эрх, 19 дүгээр зүйлийн 19.4-т Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхой заасан байхад ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хүрээнд батлах шаардлагатай дүрэм, журмыг баталсан байна. Үүнд МУХБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.4.1-д “Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны дотоод дүрэм, журам, заавар, аргачлалыг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 19.4.8-д “Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны боловсон хүчний ...цалингийн сүлжээ, урамшуулал, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох, ...урамшуулах...”, 19.5.1 “Гүйцэтгэх удирдлага нь ХБ-ны актив, пассивын удирдлагын бодлогыг тодорхойлох үүрэг хүлээнэ.” гэж тус тус заасан бүрэн эрхийг ТУЗ хэрэгжүүлж Монгол Улсын Хөгжлийн банкны Актив, Пассивын удирдлагын бодлого, Ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэлийг дүгнэж, урамшуулал олгох журам, Ажилтнуудад зээл олгох журам зэргийг баталсан байна.

Цаашид ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тодорхой зааглан хуульд заасан бүрэн эрхийнх нь хүрээнд ажиллуулах шаардлагатай байна.

МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Хөдөлмөрийн гэрээг нягтлан үзэхэд хөдөлмөрийн гэрээний загвар маягыг зөв ашигласан байгаа хэдий ч Хөгжлийн банкны дүрмийн 10.4-т заасан удирдлагын гэрээнд тусгах ёстой заалтуудаас гүйцэтгэх ажил, хүлээгдэж байгаа үр дүн зэргийг тодорхой тусгаагүй байна. Мөн Орлогч захирал бөгөөд Хөрөнгө орлогын газрын захирал Б.Буянмөнхтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ байхгүй байна.

МУХБ-ны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.8-д тусгасан Төлөөлөн удирдах зөвлөлийн удирдлага дор Гүйцэтгэх Удирдлагаас хараат бус ажиллах Дотоод Хяналтын нэгжийн үйл ажиллагаа тогтворгүй, 2012 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл хугацаанд Дотоод аудитын чиглэлээр ажилтан огт ажиллаагүй, үйл ажиллагаа нь зогссон байна. Тус нэгжийн ажиллах түр дүрмийг 2014 оны 11 дүгээр сард Төлөөлөн удирдах зөвлөлийн 84 дүгээр тогтоолоор батласнаас хойш шинэчлэн батлаагүй байна.

5.2.3. Гүйцэтгэх удирдлагын талаар

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Хөгжлийн банкны дүрмийн 10.2-т тус банкны гүйцэтгэх удирдлагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын дагуу сонгон, томилж, гэрээ байгуулан ажиллана хэмээн заасан хэдий ч гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулалт явуулалгүйгээр шууд томилон ажиллуулжээ. Мөн гүйцэтгэх удирдлагын багийн ажиллах журмыг одоог хүртэл батлаагүй байна.

МУХБ-ны нийт албан хаагчдын дунд дэд ажлын хэсгээс санал асуулга явуулахад санал асуулганд оролцсон 95 ажилтны 53% нь гүйцэтгэх удирдлагын арга барил, үйл ажиллагааны түвшинд муу болон маш муу үнэлгээг, 67% нь удирдлагатай харилцахад хүндрэл, бэрхшээлтэй байдаг гэжээ. Судалгаагаар Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлага мэргэжлийн бус, салбарын хэмжээнд удирдах албан тушаал хашиж байгаагүй, туршлага дутуугаас үйл ажиллагаанд доголдол үүсдэг гэсний дагуу гүйцэтгэх удирдлагын хувийн хэргийг шалгаж үзэхэд гүйцэтгэх удирдлагын багийн зарим гишүүд хуулинд заасан шаардлага болон ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангахгүй байгаа зөрчил илэрлээ.

/Ажлын туршлагыг тодорхойлохдоо Иргэний хуулийн 71-д заасан хугацаа тооцох журмын дагуу хоноогоор тооцов./

Гүйцэтгэх удирдлага				
Д/Д	Нэр, албан тушаал	Томилогдсон он,сар, өдөр	Томилогдох үедээ хуулинд заасан шаардлагыг хангасан байсан эсэх	Томилогдох үедээ ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангасан байсан эсэх
1	Н. Мөнхбат Гүйцэтгэх захирал асан	2013.08.21	Санхүүгийн салбарт 5-с доошгүй жил удирдах албан тушаалд ажиллаагүй.	Банк санхүүгийн салбарт 10-с доошгүй жил, үүний дотор 5-с доошгүй жил удирдах албан тушаал хашсан байх – хангаагүй
2	Б.Буянмөнх, Хөрөнгө оруулалтын газрын захирал	2014.03.31	Санхүүгийн салбарт 5-с доошгүй жил удирдах албан тушаалд ажиллаагүй.	Банк санхүүгийн салбарт 5-с доошгүй жил, үүний дотор 3-с доошгүй жил удирдах албан тушаал хашсан байх - хангаагүй
3	Г.Одонтуул, Зээлийн газрын захирал	2013.10.21 болон 2014.03.31	-	/нийгмийн даатгалын дэвтрийг санхүүд хадгалуулдаггүй өөр дээрээ байлгадаг/
4	Б.Батбилиг Хяналт, Захиргааны газрын захирал	2014.03.31	Санхүүгийн салбарт 5-с доошгүй жил удирдах албан тушаалд ажиллаагүй.	Банк санхүүгийн салбарт 5-с доошгүй жил, үүний дотор 3-с доошгүй жил удирдах албан тушаал хашсан байх - хангаагүй
5	М.Бат-Өлзий Актив, Пассивын удирдлагын газрын захирал	2014.07.23	Санхүүгийн салбарт 5-с доошгүй жил удирдах албан тушаалд ажиллаагүй.	Банк санхүүгийн салбарт 5-с доошгүй жил, үүний дотор 3-с доошгүй жил удирдах албан тушаал хашсан байх - хангаагүй
6	А.Бат-Оргил, Эрсдэлийн удирдлагын газрын захирал	2016.03.09	хангасан	Магистрын зэрэггүй.

Тус банкны гүйцэтгэх захирал байсан Н.Мөнхбат нь Эдийн засгийн хөгжлийн сайдын зөвлөхөөр, Хяналт, захиргааны газрын дарга Б.Батбилэг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга асан, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байсан Б.Шинэбаатарын туслахаар тус тус ажиллаж байгаад томилогдсон байна.

Дүгнэлт, зөвлөмж: МУХБ-ны гүйцэтгэх удирдагын баг нь мэргэшлийн бус, хууль болон ажлын байрны тодорхойлолтонд тавигдсан шаардлага хангаагүй, банк санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлага бага, хүний нөөцийн удирдлагын чадавхи сул байх тул цаашид мэргэжлийн болон туршлагын шаардлагыг хангасан удирдлагын багийг бүрдүүлэх шаардлагатай.

5.2.4. Хүний нөөцийн бодлогын талаар

МУХБ-ны албан хаагчдын Ажлын байрны тодорхойлолтыг хянан үзэхэд Хяналт-захиргааны нэгжээс бусад нэгжийн ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг ажлын байр тус бүрээр гаргалгүй ахлах мэргэжилтэн болон мэргэжилтэн хэмээн ерөнхийлөн батласан байна. Түүнчлэн зарим хэлтсийн захирал, ахлах мэргэжилтэн болон мэргэжилтэн нарын ажлын байрны тодорхойлолтод дараах асуудлууд байгаа нь тухайн ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд хүндрэл, бэрхшээл учруулах боломжийг үүсгэжээ. Тухайлбал:

- Эрсдэлийн удирдлагын газрын санхүүгийн эрсдэлийн хэлтсийн захирал, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт чиг, үүргийн давхардалттай;
- АПУГ-ын Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтсийн чиг үүрэг тодорхойгүй, захирал, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нарын ажлын чиг, үүрэг давхардалтай;
- Хөрөнгө оруулалтын шинжилгээний хэлтсийн захирлын ажлын байрны үндсэн зорилт тодорхойгүй, ерөнхий чиг үүрэгтэй.

“Ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэлийг дүгнэж урамшуулал олгох журам”-ыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4.1-д Гүйцэтгэх удирдлага батлана гэж заасан боловч 2013 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн 11 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөл батласан. Уг журмаар нийт албан хаагчид төдийгүй гүйцэтгэх удирдлагын ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэн урамшуулал олгодог нь МУХБ-ны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5-д Төлөөлөн удирдах зөвлөл нь “Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байгаа юм.

Дээрх журмын хавсралтаар батласан “Ур чадварын шалгуур үзүүлэлт”-ийн хуудсыг нягтлан үзэхэд албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт цөөн, нийт 25 шалгуур үзүүлэлт байгаагаас 1 нь л ажлын гүйцэтгэлтэй холбоотой бусад нь ажлын байранд ерөнхийлөн тавигддаг шаардлагууд болох хариуцлага, ёс зүй, харилцааны чадвар, хувь хүний зохион байгуулалт, төлөвлөлт зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд байгаа нь ажилтны ажлын гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэх шалгуурыг хангахгүй байна.

Албан хаагчдын шууд хамаарах удирдлага хэлтсийн дарга байхад дээрх журмын дагуу газрын захирал албан хаагчыг дүгнэдэг нь тухайн хүний өдөр тутмын

үйл ажиллагаа болон зан байдалтай холбоотой шалгуур үзүүлэлтүүд дээр дүгнэлт тавих нь учир дутагдалтай, үндэслэлгүй өнгө үзэмжээр дүгнэхэд хүргэдэг ба уг үнэлгээний дагуу улирал бүр сарын цалингийн 60%-100% хувьтай тэнцэх хэмжээгээр нийт албан хаагчдад хавтгайруулан урамшуулал олгодог байна.

Хөгжлийн банкны Хүний нөөцийн бодлогын 7.3-т ажлын байран дахь мэргэжлийн мэдлэг, ур чадварыг шалгах, мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг авч шалгалтын үр дүнд үндэслэн ажилтанг албан тушаалын зэрэглэл ахиулах, бууруулах шийдвэрийг Удирдлагын гүйцэтгэх хороо гаргана хэмээн заасан байдаг ч өнөөг болтол “Мэргэжлийн түвшин тогтоох” шалгалтыг нэг ч удаа авч байгаагүй байна.

Одоогийн байдлаар тус банкинд ажилтны ангилал, зэрэглэл болон цалингийн зэргийг нэмэгдүүлэх, бууруулах шалгуур үзүүлэлтийг тогтоосон журам байхгүй. Хөдөлмөрийн дотоор журмын 3.13-т “Ажилтны мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшлийн ур чадвар, туршлагыг харгалзан албан тушаалын зэрэглэлийн дээшлүүлж болно” гэж заасны дагуу ажилтны шууд удирдлагын хүсэлт, саналыг үндэслэн зэрэглэл ахиулж байна.

Дүгнэлт, зөвлөмж: МУХБ-ны Хүний нөөцийн бодлого, байгууллагын ажлын байрны тодорхойлолт болон түүнд заасан ажлын чиг үүргийг ажлын байр тус бүрээр тодорхой болгох шаардлагатай. Ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэлийг шалгах, үнэлэх үзүүлэлт хангалтгүй байх ба уг үнэлгээний дагуу улирал бүр сарын цалингийн 60%-100% хувьтай тэнцэх хэмжээгээр нийт албан хаагчдад хавтгайруулан урамшуулал олгодог нь гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн менежментийг сулруулж, төсвийн сахилга батыг алдагдуулах үндэс болж байна. Цаашид олон улсын түвшинд нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний системийг /KPI/ нэвтрүүлж, албан хаагчийн ангилал, зэрэглэл ахиулах, бууруулах журмыг баталж мөрдүүлэх шаардлагатай.

2.5.Зардлын зарцуулалтын талаар

Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх, Гүйцэтгэх удирдлагын 2011 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх нийт тушаалыг хянан шалгахад тушаалын дийлэнх нь зардал шийдвэрлэсэн асуудал байх ба зардлын зориулалт, зарцуулалт дараах байдалтай байна. /Үүнд дотоод сургалтын зардлыг оруулаагүй болно/

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан зардал

Он	Гадаад томилолт		Гадаад сургалт		Нийт дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2011	-	-	-	-	-	0
2012	-	-	-	-	-	0
2013	6	47,125,100₮	-	-	6	47,125,100₮

НУУЦ

101

ИЛ БОЛСОН

		13,819\$				13,819\$
2014	7	87,469,222₮	-	-	7	87,469,222₮
2015	15	170,091,362₮	3	148,619,075₮	18	318,710,437₮
2016	8	43,818,370₮	-	-	8	43,818,370₮
Нийт дүн: 497,123,129₮						13,819\$

Он	Урамшуулал, шагнал		Гадаад томилолт		Гадаад сургалт		Тэмцээн, уралдаан		Нийт дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2011	-	-	5	10,546,091₮ 4,290 \$	1	1,353,000₮	1	14,960,000₮	7	26,859,091₮ 4,290\$
2012	1	81,675,000 ₮	14	18,363,100 ₮ 10,870 \$ 800 фунт 1082 евро 7600 рубль 3832 юань	7	7,802,700 ₮ 14,320\$	2	1,393,200₮	29	109,234,000₮ 25,190\$ 1082 евро 800 фунт 7600 рубль 3832 юань
2013	6	371,176,600 ₮	13	75,604,522 ₮ 41,041\$ 60 евро	7	50,166,90₮ 13,270\$	4	9,581,243₮	30	506,529,265 54,311\$ 60 евро
2014	6	594,020,000 ₮	12	133,676,330₮	4	16,661,951 ₮	14	136,531,636 ₮	36	880,889,917₮
2015	9	923,240,000 ₮	13	97,784,772₮	-	-	5	13,510,749₮	27	1,034,202,272₮
2016	7	716,720,000 ₮	2	19,156,056₮	-	-	2	3,177,500₮	11	739,053,556₮

Нийт дүн: 3.296.768.101 ₮

83.791 \$

1142 евро

800 фунт

7600 рубль

3832 юань

Гадаад албан томилолтын төсвийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2013 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А-127 тоот тушаалаар батласан “Албан томилолтын журам”-д зааснаас хэт өндрөөр батлан зарцуулах, “Албан томилолтын журмын” 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан “Бусад (виз, бусад хураамж, бэлэг дурсгал, хүлээн авалт г.м)” гэх заалтыг үндэслэн тодорхой тайлбаргүйгээр их хэмжээний мөнгийг төсөвлөн батлуулах зэргээр хэт үрэлгэн зарцуулдаг байсан байна. Тухайлбал,

- МУХБ-ны гүйцэтгэх захирал асан Н.Мөнхбатын гадаад албан томилолтын нислэгийг тогтмол бизнес ангиллаар захиалах;
- Гүйцэтгэх захирал асан Н.Мөнхбатын 2014 онд Санкт-Петербург хотод хийсэн албан томилолтын 3 хоногийн зочид буудлын төлбөрт 11,925,000, нислэгийн тийзэнд 8,985,000 төгрөгийг төсөвлөн баталжээ. Мөн уг айлчлалаар Эдийн Засаг Хөгжлийн Яамны сайд Н.Батбаяр болон Bloomberg телевизийн хөтлөгч, зураглаач нарын буудлын төлбөр болох 1 хүний хоногийн 1,224,300 төгрөг болон замын зардлыг Хөгжлийн банкнаас гаргасан байна. /ТУЗ-ийн 2014.05.20, 30-р тогтоол/
- Гүйцэтгэх захирал асан Н.Мөнхбатын Хонгконг хотод чуулга уулзалтад оролцох 3 хоногийн нийт зардал 8,691,703 төгрөг, нэг хоногийн буудлын төлбөр 786 ам доллараар төсөвлөгдсөн /ТУЗ-ийн 2016.04.04, 29-р тогтоол/
- Гүйцэтгэх захирал асан Н.Мөнхбатыг 2013 онд Ерөнхий сайдын ажлын хэсэгт оролцуулан БНХАУ-ын Бээжин хотод томилолтоор ажиллуулах төсөвт Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр болон дагалдан явах орчуулагчийн Бээжин хотод байрлах зочид буудлын зардлыг тусгасан байсан ба 1 хүний хоногийн зочид буудлын төлбөр 2,908,350 төгрөг, бусад зардалд 5000 ам доллар төсөвлөжээ. / ТУЗ-ийн 2013.10.21 ний 68-р тогтоол/
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр бүхий 4 гишүүн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг 2015 онд Австрали улсын Сидней хотод 4 өдрийн сургалтад хамруулсан нийт зардал 90,857,530 төгрөг болжээ. / ТУЗ 2015.01.28, 6-р тогтоол/

Мөн гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол болон Гүйцэтгэх захирлын тушаал давхардан гарсан тохиолдол байна. Тухайлбал, Орлогч захирал бөгөөд Зээлийн газрын захирал Г.Одонтуул болон хэлтсийн захирал нарыг гадаадад томилолтоор ажиллуулах

тухай Төлөөлөөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Гүйцэтгэх захирлын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А-04, А-05, А-06 тоот тушаалуудыг давхардуулан гаргасан байна.

Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжсэн зарим төслийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаар:

1. Яармаг дахь орон сууцны хорооллын санхүүжилтийг Засгийн газрын тогтоолгүй, УИХ-аар батлуулалгүй гаргасан.

“Шинэ Яармаг” орон сууцны цогцолбор хороолол барих төсөл нь Монгол Улсын Их хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “100 мянган айлын орон сууц” төсөлд хамрагддаг бөгөөд төслийн хэрэгжүүлэгч нь “Юнайтэд Прожект Групп” ХХК. 2015 оны 7 дугаар сарын 20-ны өдөр ТОСК ТӨҮГ-тэй “Шинэ Яармаг” орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилт хийж хамтран ажиллах гэрээ байгуулан, төслийн гүйцэтгэгчээр нь Юнайтэд Прожект Групп ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болох Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-ийг ажиллуулахаар тохирсон.

Нью Яармаг Хаусинг Прожект ХХК нь LOT I, II, III гэсэн 3 үе шаттай нийт 230 сая ам.долларын төсөвт өртөгтэй орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлсэн, нийт санхүүжүүлэлтийн 85 хувийг Хятад улсын Экспорт Импорт банкнаас зээл авч санхүүжүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын дээрх зээлд Хөгжлийн банкаар дамжуулан баталгаа гаргуулж, төслийн санхүүжилтийн үлдсэн 15 хувьд Хөгжлийн банкаар дамжуулан 50 сая ам.долларын зээл олгосон байна.

Засгийн газрын баталгаа

Засгийн Газар 2011 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 246 дугаар тогтоолоор Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-ийн Хятадын ЕХИМбанкнаас авч буй зээлд 300 тэрбум төгрөгтэй тэнцэх дүн бүхий 12 жилийн хугацаатай баталгаа гаргахыг Хөгжлийн банкинд үүрэг болгосон. Дээрх тогтоолыг үндэслэн Хөгжлийн банкны зээлийн хороо 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр нийт санхүүжилтийн 85 хувьтай тэнцэх 195.8 сая долларыг 12 жилийн хугацаатай баталгаа гаргахаар шийдвэр гарган, ТУЗ уг шийдвэрийг үндэслэн 300 тэрбум төгрөгийн баталгааг гаргах шийдвэрлэн 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 2/261 дугаартай албан бичгээр Хятад улсын ЕХИМбекинд 195.8 сая долларын баталгааг гаргасан. Гэтэл Хятадын ЕХИМбанк болон Шинэ Яармаг Хаусинг Прожект ХХК-ийн хооронд байгуулсан зээлийн гэрээ нь 2012 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн он сартай буюу баталгаа гарснаас хойш зурагдсан байна.

Хөгжлийн банкны ТУЗ-ын 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаар тогтоолоор дээрх баталгааг хүчингүй болгох шийдвэр гарган тус банкинд 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/305 тоот албан бичгээр мэдэгдсэн.

Үүний дараа Хөгжлийн банкны дээрх баталгааны асуудлыг дахин хэлэлцэж 2012 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 023 тоот Зээлийн хорооны хурлаар Шинэ Яармаг төслийн LOT I-ийн санхүүжилт болох 83.8 сая ам.долларын зээлд 6 жилийн хугацаатай баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Үүнийг ТУЗ хэлэлцэж 2012 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 43 тоот тушаалаар шийдвэрлэн 2012 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 1/488 албан бичгээр 83,881,157.75 ам.долларын баталгааг хүргүүлсэн.

Гэтэл үүнээс хойш уг баталгаа нь хэрэгжээгүй бөгөөд Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1/169 дугаар албан бичгээр Зээлдэгч банк нь Голомт банкаар дамжуулан зээлийг олгох тухай мэдэгджээ. Энэ нь Хөгжлийн банкны гаргасан баталгааны нөхцлийг буюу Зээлдэгчийг өөрчилж байгаа тул Хөгжлийн банк 2016 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 6/867 дугаар албан бичгээр баталгааны нөхцөлд гарсан өөрчлөлттэй холбоотой судалгаа шинжилгээ хийх шаардлагатай байгааг мэдэгдэн хариу хүргүүлсэн байна. Өөрөөр хэлбэл Хөгжлийн банк Хятад улсын Экспорт Импорт банкинд гаргасан баталгаагаа Голомт банкинд гаргах нөхцөл үүссэн нь Засгийн Газрын холбогдох тогтоолд нийцэхгүй байна.

Хөгжлийн Банкнаас олгосон зээл

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 117 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн банкны ТУЗ 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 33 дугаар тогтоолоор ТОСК ТӨҮГ-аар дамжуулан Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-д 50 сая ам.долларын зээл олгосон.

Хөгжлийн банкны 2015 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн ТУЗ-ийн 33 дугаар тогтоолоор Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-ийн төслийн 85 хувийн Зээлдэгч Хятад улсын Экспорт Импорт банкны шаардлагын дагуу Хөгжлийн банк олгосон 50 сая ам.долларын зээлийг 2 хуваан арилжааны банкуудын хадгаламжийн дансанд байршуулах шийдвэр гарган, шимтгэлийн хөлсөнд зээлийн 0.3 хувийг суутган, 25.0 сая, 24.850 сая ам.долларыг Голомт болон ХХБ-нд байршуулжээ.

Ингэж байршуулахдаа Хөгжлийн банк нь зээлдэгч ТОСК ТӨҮГ, түүний дамжуулан зээлдэгч Нью Яармаг Хаусинг Прожект ХХК болон Голомт банктай 2015 оны 6 дугаар сарын 09-ны өдөр 4 талт гэрээ хийн 25 сая ам.долларыг байршуулан зарцуулах эрхийг битүүмжилсэн. Түүнчлэн 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Худалдаа Хөгжлийн банктай 4 талт гэрээ байгуулан 24.8 сая ам.долларыг байршуулан мөн зарцуулах эрхийг битүүмжилсэн.

Хөгжлийн банкны 2015 оны 9 дугаар сарын 22-ны өдрийн ТУЗ-ийн 79 дүгээр тогтоолоор ХХБ-нд байршуулсан дээрх хөрөнгөөс 18.1 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг хадгаламж барьцаалсан зээл байдлаар Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-д ашиглахыг зөвшөөрсөн бөгөөд 2015 оны 9 дугаар сарын 28 өдөр ХХБ-нд мэдэгдэл хүргүүлэн 10 дугаар сарын 06-ны өдөр 3 талт гэрээ байгуулан дээрх зээлийг олгожээ.

Арилжааны банкуудад байршуулсан нэг жилийн хадгаламжийн хугацаа дууссан тул Хөгжлийн банкны 2015 оны 11 дугаар сарын 28-ны өдрийн ТУЗ-ийн 99 дүгээр тогтоолоор хадгаламжийн хугацааг сунган 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл дээрх олон талт гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хөгжлийн банкны 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн 04 дүгээр тогтоолоор ХХБ-нд байршуулсан 24.850 сая ам.доллартай тэнцэх зээлийг Нью Яармаг Хаусинг Прожект ХХК-д олгох эрхийг Зээлийн хороонд өгсөн бөгөөд Зээлийн хороо энэ эрхийнхээ хүрээнд 2016 оны 02 дүгээр сарын 05-ны өдөр 8.2 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг, 2016 оны 5 дугаар сарын 03-ны өдөр нэмж 5.450 сая ам.долларын зээлийг олгохыг зөвшөөрсөн шийдвэрийг гарган тухай бүрт ХХБ-нд мэдэгдэл хүргүүлж, нийт 18.3 сая ам.долларын зээлийг тус банкин дах хадгаламжийг барьцаалан олгохыг зөвшөөрчээ. Дээрх зээлүүдийн эргэн төлөгдөх хугацаа 2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр бөгөөд зээл эргэн төлөгдөөгүй нөхцөлд Хөгжлийн банкны байршуулсан 24.8 сая ам.долларын хадгаламжаас суутгагдана. Иймээс Хөгжлийн банкны олгосон 50 сая ам.долларын зээлийн 18.3 сая ам.доллар нь эрсдэлд орж болзошгүй байна.

Хөгжлийн банк арилжааны банкуудад битүүмжлэн байршуулсан 49.8 сая ам.долларын хадгаламжийн хүүг авахгүй байгаа бөгөөд хадгаламжийн хүүгийн тухай арилжааны банкуудтай байгуулсан 4 талт гэрээнүүдэд тусгаагүй. Гэтэл хадгаламжийн хүүг авсан бол ТОСК ТӨҮГ-т олгосон 50 сая ам.долларын зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх боломжтой байсан.

Хөгжлийн банкны олгосон 50 сая ам.долларын зээл нь Хятадын ЕХИМбанкны санхүүжилт орж ирэх хүртэл олгогдох зорилготой байсан боловч уг зээл олгогдохгүй хэвээр байсаар байна. Одоогоор Хятадын ЕХИМбанкны зээл олгох нөхцөл нь өөрчлөгдөн Хөгжлийн банкны 85 хувьд нь гаргах баталгаанаас хамааралтай болсон бөгөөд уг баталгааг Голомт банкинд гаргасан нөхцөлд зээлийг олгох боломжтой. Гэтэл энэ хооронд ХХБ-ны хадгаламжийг барьцаалан тус банкаар дамжуулан олгосон 18.3 сая ам.долларын зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2016 оны 9 сарын 26-ны өдөр дуусах бөгөөд энэ өдрийн дотор Хятадын ЕХИМбанкны зээл олгогдох магадлал маш бага бөгөөд энэ нь ХХБ-наас 18.3 сая долларын хадгаламж барьцаалсан зээлийн төлбөрт төлөгдөх эрсдэлтэй байна.

Тус зээлийн барьцаанд 20 ширхэг баригдаж буй барилгын гэрчилгээ байгаа бөгөөд үүний 7 нь 90-95 хувийн гүйцэтгэлтэй, 13 нь 70-80 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 69.8 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна.

Одоогоор тус зээлийн үндсэн төлбөрийн хугацаа эхлээгүй бөгөөд хүүгийн төлбөр 261 хоногийн хоцролттой, 4.3 тэрбум төгрөгийн хуримтлагдсан хүүгийн төлбөртэй нийт 54.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд активын чанарын хувьд "Муу" ангилалд шилжих нөхцөл бүрдсэн байна.

2. Зайрмагийн үйлдвэрийн төсөл

"Зайрмагны үйлдвэр" гэх төсөл нь Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн хүрээнд Хаан банкаар дамжуулан "Мон Эс Энд ЭС" ХХК-д олгосон 1.4

тэрбум төгрөгийн зээл юм. УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор хөтөлбөрт зориулан үнэт цаас гаргахыг Засгийн газарт зөвшөөрсөн. ЗГ-ын 2014 оны 176 дугаар тогтоолоор Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрийн 2 тэрбум төгрөгөөс илүүгүй санхүүжилт хүссэн төслийн эх үүсвэрт шаардагдах 100.0 (нэг зуун) тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд байршуулан олгохыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсөн байна.

Хөдөлмөрийн яамны ЖДҮХСангаас Мон Эс Энд Эс ХХК-д төсөл нь 1435.5 сая төгрөгөөр дэмжигдлээ гэсэн албан тоот ирсэн /№722/. ХААН банкнаас 2014.05.08-нд зээл олгох шийдвэр гарсан. Хугацаа 60 сар. Төслийн нэр: Үйлдвэрийн хүчин чадал, өрсөлдөх чадварыг сайжруулах бизнес төсөл. Хэмжээ 1.4 тэрбум төгрөг.

Зээлийн зориулалт нь зайрмагны үйлдвэрийн 2 шугам нэмэх, агуулахын 1500 мкв талбайг хөлдөөгчтэй агуулах болгох, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх байсан. Зээлийн зориулалтыг шалгах үед зайрмагны 2 шугам угсарсан байсан боловч 1 шугамыг үйлдвэртээ ашиглаж байсан. Эдийн засгийн хямралаас шалтгаалан борлуулалтын орлого буурсан тул нөгөө шугамаа ашиглахгүй байсан. Агуулахын 1500 мкв талбай бүхий хөлдөөгч ашиглалтад орсон байсан. Мөн бүтээгдэхүүн нийлүүлэгч дэлгүүрүүдэд зориулан бага оврын зайрмагны 50 орчим хөлдөөгчийг авсан байсан /. 2016 оны 8 дугаар сарын 29-ны байдлаар зээлийн эргэн төлөлт хэвийн, зээлийн ангилал хэвийн байна. Явцын тайлангаас дүгнэхэд зээлийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

- 3. Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор 200 сая ам.долларыг Чингис бондоос 2012 онд багтааж “Эрдэнэс таван толгой” ХХК-д хууль бусаар олгосон. Нэмж 2014 онд 50 сая ам.доллар олгосон.**

3-ТЗ-Б-2012-144 дугаартай гэрээний талаар:

2012.03.27-ны өдрийн “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 93 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий шинээр барьсан болон барихаар төлөвлөсөн төмөр замын суурь бүтцийг эзэмших төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийг хууль тогтоомжийн дагуу байгуулахаар тогтож мөн тогтоолын 4 дүгээр хэсэгт зааснаар төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төмөр замын төслийг санхүүжүүлэхэд эхний ээлжинд шаардагдах 399.0 тэрбум төгрөгийн зээлийг дээрхи компанид олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл зөвшөөрсөн байна.

Уг тогтоол гарсанаас 1,5 сарын дараа буюу 2012.05.09-ний өдрийн 161 дүгээр тогтоолын 4 дүгээр хэсэгт зааснаар 2012.03.27-ны өдрийн 93 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт өөрчлөлт оруулж, мөн тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан буюу шинээр үүсгэн байгуулагдах компанийг “Эрдэнэс-Тавантолгой” гэж өөрчилсөн.

Засгийн газрын дээрх тогтоолууд гарсныг үндэслэн “Эрдэнэс-Тавантолгой” \Цаашид –“ЭТТ” гэх\ ХК-ийн ТУЗ-ийн 2012.06.04-ний өдрийн 17 дугаар тогтоолоор “Стратегийн ач холбогдолтой Таван толгой төслийн дэд бүтцийн бүтээн

байгуулалтын хүрээнд **Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төсөлд** оролцох болон бусад дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болгох зорилгоор МУХБ-наас 399 тэрбум төгрөгийн зээл авахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн байна. Уг зөвшөөрлийг үндэслэн ЭТТ ХК-ийн гүйцэтгэх захирал **2012.06.04**-ний өдрийн 1\459 дугаартай албан бичгээр МУХБ-нд 399 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлжээ.

2012.06.07 –ны өдөр МУХБ холбогдох мэдээллийг гаргуулахаар ЭТТ ХК-нд албан бичиг хүргүүлж ЭТТ ХК-ийн уг төсөлд ямар хэлбэрээр, ямар эрх, үүрэгтэй оролцох болон зээлийн зориулалт, зарцуулалт болон эргэн төлөлтийн төлөвлөгөө, барьцаа хөрөнгийн талаархи мэдээлэл, төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, ТЭЗҮ, оролцох төсөл хөтөлбөртэй холбоотой төсөв, ТЭЗҮ-г ирүүлэхийг хүссэн байна. Уг албан бичгийн хариуг ЭТТ ХК-иас өдөрт нь буюу **2012.06.07**-ны өдөр 479 дугаартай албан бичиг, түүний хавсралтаар ирүүлсэн. Уг хавсралтад компанийн цэвэр мөнгөн гүйлгээний хураангуйг ирээдүйн 10 жилээр тооцож гаргасан байх ба уг тооцооллын дагуу МУХБ-аас санхүүжилтээр авах мөнгийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх боломжтой гэж үзэж байгаагаар илэрхийлсэн байна. Түүнчлэн уг албан бичигт өөрийн хувьцаагаа Монгол Улсын болон олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргаж арилжаалан хөрөнгө босгох тухай дурьдсан боловч энэ талаар болон дээр дурьдсан мэдээлэлтэй холбоотой ямар нэгэн тооцоо, судалгаа, баримт материал ирүүлээгүй байна.

Мөн өдрийн өөр нэг албан бичгээр зээлийн гэрээний хөрөнгийн баталгаа болон ТЭЗҮ-тэй холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн байх бөгөөд уг тайлбарт Засгийн газрын тогтоолд сангийн сайдад баталгаа гаргах талаар үүрэг хүлээлгэсэн тул уг заалт нь зохих баталгаа болох талаар дурьдаж, төмөр замын суурь бүтцийн нэг хэсэг болох Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн замын ТЭЗҮ хийгдсэн, Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замд ЭТТ ХК төрийн хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилт хийж оролцохоор төлөвлөж байна, Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г гүйцэтгэгч ойрын хугацаанд хийнэ, ЭТТ ХК дэмжлэг үзүүлэн оролцоно гэжээ. Уг албан бичгээс харахад мөн мэдээллийн чанартай бөгөөд албан бичигт дурьдсан мэдээлэлд холбогдох тооцоо судалгаа, баталгаа болох бусад баримт материал хавсаргаагүй байна.

2012.06.08-ны өдөр ЭТТ ХК-аас МУХБ-дирүүлсэн албан бичигт шинээр барьсан болон барихаар төлөвлөсөн төмөр замын суурь бүтцийг эзэмших хувьцаат компанийг өөрийн охин компани хэлбэрээр байгуулна гэсэн байна. Мөн энд дурьдсан компанийн дүрмийг батлах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон төслийн ТЭЗҮ боловсруулах, эдийн засгийн тооцоо судалгааны ажлыг нарийвчлан хийх зэрэг ажлуудыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хийхээр бэлтгэж байгаа бөгөөд төслийн компани байгуулагдмагц төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл авна гэжээ. Зээлийн хувийн хэрэгт авагдсан материалаас харахад үүнийг батлах ямар нэгэн баримт, материалууд авагдаагүй байна.

2012.06.07 гэх огноотой зээлийн хороонд оруулахаар бэлтгэсэн зээлийн маягтад \application for credit approval\зээлийн зориулалтын талаар ЭТТ ХК-иас ирүүлсэн тайлбарын дагуу 100 тэрбум төгрөгийг “Ухаахудаг-Гашуунсухайт” төсөлд төрийн хяналт, оролцоог хангах зорилгоор, 25 тэрбум төгрөгийг “Тавантолгой-Сайншанд” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ бэлтгэх, үлдсэн 274 тэрбум төгрөгийг төмөр замын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулна гэж заасан байна. Уг тооцооллыг батлах ямар нэгэн баримт бичиг зээлийн хувийн хэрэгт авагдаагүй байна. Уг мэдээллийн эх сурвалжийг судлахад зээлийн хувийн хэрэгт авагдсан **2012.06.11** гэх огноотой 494 дугаартай ЭТТ ХК-иас ирүүлсэн албан бичигт дурьдсан мэдээллийг

хуулбарласан байх бөгөөд үүнтэй холбогдох өөр ямар нэгэн баримт бичиг байхгүй байна. Энэ талаар зээлийн маягтад тодорхой дурьдсан бөгөөд зээлийг ашиглах зориулалтыг баталгаажуулсан ямар нэгэн баримт материал ирүүлээгүй, зээлийн эргэн төлөлтийг өөрийн борлуулалтын орлогоос төлнө гэжээ.

Уг маягтын 5 дахь хуудсанд МУХБ-ны Зээлийн газрын санал авагдсан байх ба уг саналд: **“зээлийн зориулалт болон зээлийг ашиглах төлөвлөгөө тодорхойгүй..., энэ талаар тодруулах зорилгоор хүсэлт илгээсэн боловч анализ хийх, дүгнэлт гаргахад хангалттай мэдээлэл ирүүлээгүй. Түүнчлэн зээлийн анализ хийхийн тулд бизнесийн үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай”** гэжээ.

МУХБ-ны Зээлийн хороо үүнээс нэг өдрийн дараа буюу **2012.06.08**-ны өдөр хуралдаж 13 дугаартай шийдвэрээр ЭТТ ХК-д 5 жилийн хугацаатай 7.25 хувийн хүүтэй **300 сая ам.долларын** зээл олгохоор шийдвэрлэж ТУЗ-д танилцуулахаар тогтсон байна. Зээлийн хорооны мөн хуралдааны тэмдэглэлээс харахад Зээлийн хорооны гишүүдийн диилэнхи олонхийн саналаар зээл олгохыг дэмжсэн байх бөгөөд **ЭТТ ХК-ийн** төмөр замын төсөл дахь үүрэг, зээлийг хэрхэн ашиглах, буцаан төлөх хуваарь, төлөвлөгөө, төслийн нийт үнэ, төслийн ТЭЗҮ зэрэг зүйлийг шаардах тодорхой болгох талаар санал гарсан байна.

МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Эрсдлийн удирдлагын газраас **2012.06.08**-ны өдөр уг зээлд холбогдох дүгнэлтийг хүргүүлсэн байна. Уг дүгнэлтэд: **“энэ төсөл нь хэдийгээр МУХБ-ны тухай хуулийн 10.1.4-т заасан заалтыг зөрчөөгүй боловч уг заалтад заасан шаардлагуудыг бүрэн хангахгүй байна.... тодорхой зээлийн зарцуулалтын төлөвлөгөөгүйгээр “зээл авах үндэслэл” нь санхүүгийн хувьд хангалттай биш байна.... ЭТТ ХК-ийн зүгээс оролцох үүрэг нь одоогоор тодорхой биш байна. ЭТТ ХК-ийн энэхүү төсөлд оролцох үүрэг, зээлийн зарцуулалтын төлөвлөгөө нь одоог хүртэл ирээгүй байна... Зээлийн зарцуулалтын төлөвлөгөө, барьцаа хөрөнгөтэй холбоотой шаардлагуудыг хангагдсан тохиолдолд зээлийг олгох нь зүйтэй”** гэжээ.

Мөн **2012.06.12**-ны өдөр банкны АПУГ-аас уг зээл нь МУХБ-ны тухай хууль, УИХ болон Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бөгөөд ХБ-ны зээлийн бодлогод заасан нөхцөлүүдийг хангаж байгаа гэж үзэж байгаа тохиолдолд АПУГ-ын зүгээс татгалзах зүйлгүй гэсэн дүгнэлтийг Зээлийн газарт ирүүлсэн байна. **АПУГ-аас ирүүлсэн дүгнэлтгүйгээр асуудлыг Зээлийн хорооны хурлаар оруулсан шийдвэрлэсэн нь МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.**

2012.06.11-ний өдрийн МУХБ-ний хууль зүйн дүгнэлтэд зээлийн баталгаа болон ЭТТ ХК нь ямар чиглэлийн, хэдэн км төмөр замыг барих зөвшөөрөл авсаныг нягтлан үзэх шаардлагатай гэжээ.

МУХБ-ны ТУЗ-ийн **2012.06.14**-ний өдрийн 29 дүгээр тогтоолоос харахад ЭТТ ХК-д олгох зээлийн талаар хэлэлцээд дараах нөхцөлүүдийг хангуулж МУХБ-ны ТУЗ-д танилцуулсны дараа ЭТТ ХК-тай зээлийн гэрээ байгуулахыг гүйцэтгэх захиралд даалгасан байна. Үүнд:

- Аудитын дэд хороогоор хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах
- Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шаардлагатай зээлийн материалуудын жагсаалтыг гаргаж, түүний дагуу зээлийн материалын иж бүрдлийг хангасан байх
- Зээлийн зарцуулалтын төлөвлөгөөг Зээлдэгчээс гаргуулан авч судлан үзэсэний үндсэн дээр зээлийн хөрөнгийг УИХ, ЗГ-аас батлан гаргасан

шийдвэрийн дагуу зориулалтаар нь ашиглах талаар зээлийн гэрээний төсөлд тусгасан байх

- Зээлийг ямар үе шаттай олгох талаар Гүйцэтгэх удирдлага саналаа боловсруулсан байх
- ЭТТ ХК-ийн ТУЗ-д МУХБ-наас төлөөлөл оруулах шаардлагыг хасах
- Зээлийн гэрээнд МУХБ-ны олгох зээлийн санхүүжилтээр ХБ-ны шаардлагыг хангасан зээл зарцуулалтын төлөвлөгөөг харгалзах
- МУХБ-ны хуульчийн дүгнэлтийг харгалзан үзэх
- Дээрх материалыг бүрдүүлсний үндсэн дээр зээл олгох зэрэг байна.

Зээлийн хувийн хэргээс харахад төсөл, хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Хөгжлийн банкны ТУЗ-ийн дээр дурьдсан тогтоолд заасан шаардлагыг хангаагүй байхад **2012.09.03**-ны өдрийн МУХБ-ны ТУЗ-ийн 41 дүгээр тогтоолоор гүйцэтгэх захиралд ЭТТ ХК-д 5 жилийн хугацаатай **100 сая ам долларын** зээлийг төмөр зам барих бэлтгэл ажлыг хангах ажилд зориулж зээл олгохоор шийдвэрлэж **2012.10.04**-ний өдөр **З-ТЗ-Б-2012-144** дугаартай гэрээг байгуулж **2012.10.05**-ны өдөр 100 сая ам.долларыг ЭТТ ХК-ийн МУХБ дахь харилцах дансанд шилжүүлсэн байна. Гэрээний хугацаа **2017.01.05**-нд дуусна. Уг гэрээний баталгааг **2012.08.30**-ны өдөр Сангийн сайд албажуулж ирүүлсэн байна. Зээлийн хувийн хэргээс харахад **2012.09.03**-ны өдрийн байдлаар мөн оны ТУЗ-ийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагууд хангагдаагүй, мөн уг төсөл, хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн гэх үндэслэлгүй байна. Зээлийн хувийн хэрэгт зээлийн гэрээнд заасны дагуу зээлийн хөрөнгө нь зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхт хяналт тавьж байсан гэх баримт материал авагдаагүй байна.

З-ЭТ-ХО 2012-162 дугаартай зээлийн гэрээний талаар

2012.11.03-ны өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 121 дүгээр тогтоол гарч уг тогтоолоор Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий төмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоортөмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгож урьд гаргасан 2012 оны 93, 161 дүгээр тогтоолуудыг хүчингүй болгосон.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын “Хөгжлийн банкны зээлийн тухай” **2012.12.01**-ний өдрийн 148 дугаар тогтоол гарч, Төмөр замын төслийг санхүүжүүлэхээр Хөгжлийн банкнаас олгосон 399.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл болох 200 сая ам.долларыг **Тавантолгой төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд** “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д зохих журмын дагуу олгох арга хэмжээ авахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл-д зөвшөөрч, холбогдох зээлийн баталгааг зохих журмын дагуу гаргахыг Сангийн сайдад үүрэг болгосон байна.

2012.12.25-ны өдөр ЭТТ ХК-ийн ТУЗ-ийн 36 дугаартай тогтоолоор “Тавантолгой төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд” МУХБ-наас 200 сая ам.долларын зээл авах гэрээнд гарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх захиралд даалгасны дагуу мөн өдөр ЭТТ ХК-иас МУХБ-д Засгийн газрын 148 дугаар тогтоолын дагуу **200 сая ам.доллартай** тэнцэх хэмжээний зээл авах хүсэлт ирүүлсэн байна.

Засгийн газрын дээрх 148 дугаартай тогтоолыг үндэслэн МУХБ-ны ТУЗ **2012.12.28**-ны өдрийн 58 дугаар тогтоолоор 1 жилийн хугацаатай 100 сая

ам.долларын төмнөх олгосон 100 сая ам.доллар дээр нэмж нийт 200 сая ам.доллар зээл олгох шийдвэр гаргасан байна.

Мөн өдрийн буюу **2012.12.28**-ны өдрийн 36 дугаартай Зээлийн хорооны шийдвэрээр Засгийн газрын 2012 оны 148 дугаар тогтоолд заасан зориулалтын дагуу уг тогтоолд заасныг үндэслэн 100 сая ам.долларыг зээлийг ЭТТ ХК-д олгохоор шийдвэрлэжээ. Мөн өдрийн МУХБ-ны Зээлийн газраас тус банкны зээлийн хороонд хүргүүлсэн танилцуулгад **уг зээлийн зориулалт нь МУХБ-ны тухай хуульд заасантай нийцэхгүй** байгааг болон ЭТТ ХК нь тухайн үеийн байдлаар арилжааны банкуудад **131 сая ам.доллартай** тэнцэх хэмжээний өр төлбөртэй байгаа талаар дурьдаж зээлийг **хэрхэн төлөх нь тодорхойгүй** байгааг тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч тус банкны ТУЗ-ийн шийдвэрийн дагуу **2012.12.28** –ны өдөр ЭТТ ХК болон МУХБ хооронд **3-ЭТ-ХО 2012-162** дугаартай 100 сая ам.долларын зээл олгох тухай гэрээ байгуулагдаж, уг зээлд Монгол Улсын засгийн газраас **2013.01.30**-ны өдөр баталгаа гаргаж 100 сая ам.доллар ЭТТ ХК-ийн МУХБ дахь харилцах дансанд мөн өдөр шилжсэн байна.

Зээлийн гэрээний зориулалтад: “Засгийн газрын 2012 оны 148 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасны дагуу” гэж заасан байх бөгөөд зээлийн **зориулалт нь тодорхойгүй** байна. Уг зээлтэй холбоотой ЭТТ ХК-иас ирүүлсэн зээлийн хүсэлтийг судалсан ямар нэгэн баримт материалууд зээлийн хувийн хэрэгт авагдаагүй байх бөгөөд уг зээлээр ямар төсөл хөтөлбөр санхүүжүүлэх нь **тодорхойгүй байх тул санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн гэх үндэслэлгүй** байна. Зээлийн хувийн хэрэгт зээлийн гэрээнд заасны дагуу зээлийн хөрөнгө нь зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхт хяналт тавьж байсан гэх баримт материал авагдаагүй байна.

Зээлийн хувийн хэрэгт авагдсан ЭТТ ХК-ийн бизнесийн үйл ажиллагааны талаархи танилцуулга, баримт материал, тайлангууд болон санхүүгийн чадавхийг тодорхойлсон баримтууд нь дээр дурьдан 200 сая ам.долларын зээл олгогдсоны дараа буюу 2014 оны сүүлээс эхлэн зээлийн хувийн хэрэгт авагдсан нь материал ирүүлсэн болон материал хүссэн албан бичгүүдээр нотлогдож байна.

МУХБ-ны **2015.07.09**-ний өдрийн Зээлийн хяналтын тайлангийн 4 дэх хэсэгт “Төслийн явц төлөвлөгөөний дагуу явагдаж буй эсэх\ажлын болон санхүүжилтийн талаар дэлгэрэнгүйгээр” гэх хэсэгт **“Төслийн зээл биш”** гэж, **2015.09.30**-ны өдрийн Зээлийн хяналтын тайлангийн мөн хэсэгт: **“төслийн зээл биш ба “Тавантолгой” төслийн хүрээнд үйл ажиллагааг сайжруулах, эргэлтийн хөрөнгийн зээл авсан”** гэсэн нь ЭТТ ХК-д олгосон санхүүжилт нь МУХБ-ны тухай хуульд заасантай нийцэхгүй байна гэж дүгнэхээр байна.

Засгийн газрын **2013.09.10**-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор МУХБ-аас ЭТТ ХК-д олгосон 200 сая ам доллартай тэнцэх зээлийн хугацааг сунган, дагалдах бусад нөхцөлүүдийн хамт компанийн давуу эрхтэй хувьцаагаар сольж, Хөгжлийн банк, ЭТТ ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг тус тус 200 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр нэмэгдүүлэх, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах, давуу эрхийн хувьцааг зохих хууль тогтоомжийн дагуу бүртгэх арга хэмжээ авахыг холбогдох яамдын сайд нарт болон ТУЗ-д даалгасан боловч зээлийг давуу эрхийн хувьцаанд шилжүүлэх ажил зогсонги байдалд орсоноор уг Засгийн газрын тогтоол хэрэгжээгүй тул дээрх зээлүүд нь хаагдаагүй байна.

Эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийг төлөх боломжгүй тул ЭТТ ХК-ийн хүсэлтийн дагуу тухай бүр зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ

байгуулан эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Чалко компаниас 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөр авч, Хүний хөгжил санд шилжүүлснээр компанийн санхүүгийн байдал хүндэрсэн байна.

2015.12.17-ны өдрийн зээлийн хорооны шийдвэр, **2015.12.30**-ны өдрийн ТУЗ-ын шийдвэрийг үндэслэн ЭТ-ХО 2012-162 дугаартай зээлийн гэрээний хүрээнд олгосон зээлийн хугацааг **2017.01.30**-ны өдөр хүртэл сунгасан.

3-ТЗ-Б-2012-144 болон **ЭТ-ХО 2012-162** дугаартай Зээлийн гэрээний хүрээнд үүссэн 4,039,763 ам.долларын зөрчилтэй хүүгийн болон нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг **8,052,541,758** төгрөгийн татварын урьдчилгаагаар хаахаар Засгийн газрын үнэт цаасны гэрээ, Гэрээ дүгнэсэн акт, өр авлага барагдуулах тооцоо нийлсэн актыг үйлдэж, **2015.12.30**-ны өдөр зээлийн төлөлтийн гүйлгээг хийсэн байна.

2016.06.30-ны байдлаар **200 сая ам.долларын** зээлийн үлдэгдэлтэй байна. Дээр дурьдсан хоёр зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулан хугацааг тухай бүр сунгасан байна. Тухайн өдрийн байдлаар хуримтлагдсан хүүний дүн: **31,741,465** ам.доллар байна.

3-ЭТ-Э 2014-210 дугаартай гэрээний дагуу олгосон **50 сая ам.долларын зээлийн талаар**

Засгийн газрын **2014.06.04**-ний өдрийн “Эрдэнэс Тавантолгой ХК-д зээл олгох тухай” 177 дугаар тогтоолийн 1 дүгээр хэсэгт зааснаар **Эрдэнэс Тавантолгой ХК-ийн үйл ажиллагааг дэмжих**, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 100 сая хүртэлх ам. доллартай тэнцэх төгрөгийн богино хугацаатай зээл олгохыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны ТУЗ-д зөвшөөрсөн байна.

ЭТТ ХК-иас **2014.09.26**-ны өдрийн 01\1406 албан бичиг, **2014.10.02**-ны өдрийн 01\1428 дугаартай албан бичгээр компанийн үйл ажиллагааг дэмжих, арилжааны банкуудын өндөр хүүтэй зээлүүд төлж барагдуулах зорилгоор 100 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн зээл авах хүсэлтийг ирүүлсэн байна.

МУХБ-ны ТУЗ-ийн **2014.11.13**-ны өдрийн 77 дугаар тогтоолоор Самурай бондын эх үүсвэрээс 50 сая ам.долларын зээлийг ЭТТ ХК-д олгохоор шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2014 оны 177 дугаар тогтоолд зээлийн зорилгыг **ЭТТ ХК-ийн үйл ажиллагааг дэмжих**, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх гэж тодорхойлсон байна. МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар МУХБ нь УИХ-ын жил бүрийн хаврын чуулганаар батлагдсан жагсаалтад багтсан мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан **төсөл, хөтөлбөрүүдийг** санхүүжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна. УИХ-аас МУХБ-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд баталсан гэх 2011 оны 15 дугаар тогтоолд заасан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт: “бүсийн тулгуур төвүүдэд уул уурхай, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх иж бүрэн арга хэмжээ авах” гэж заасан бөгөөд Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль тогтоомжийн хүрээнд Тавантолгой нүүрсний орж газар нь “Бүсийн тулгуур төв” –д хамаарахгүй тул ЭТТ ХК-ийн үйл ажиллагааг УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолд заасан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт хамруулан **санхүүжүүлэх үндэслэлгүй байна.**

2014.12.30-ны өдрийн 3-ЭТ-Э 2014-210 дугаартай гэрээний “Зээлийн нөхцөл” хэсэгт зааснаар зээлийн зориулалт нь Зээлдэгчийн үйл ажиллагааг дэмжих,

нүүрсний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Голомт, Хас, Худалдаа Хөгжлийн Банк зэрэг арилжааны банкуудын зээлийг дахин санхүүлэх байна. Иймд уг зээл нь УИХ-аас батлагдсан жагсаалтад заасан **төсөл, хөтөлбөрийг** санхүүлэх зориулалтад нийцэхгүй байна.

Түүнчлэн МУХБ-ны тухай хуулийн 9.3 дахь хэсэгт МУХБ-ны ТУЗ нь өөрийн татан төвлөрүүлсэн, Засгийн газрын баталгаа гаргаснаас бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг батлаж болохоор заасан боловч уг 50 сая ам.долларын зээлийн эх үүсвэр нь Самурай бонд байх бөгөөд уг бонд нь Засгийн газрын баталгаа гаргасан эх үүсвэр тул МУХБ-ны ТУЗ уг хэсэгт заасан **эрхийн хүрээнд уг зээлийг олгох эрхгүй байна.**

МУХБ-ны зүгээс уг зээлийн талаар гаргасан хууль зүйн дүгнэлтэд уг арга хэмжээ нь УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөрт, мөн УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хамрах тул уг зээлийг олгох боломжтой гэжээ. 2010 оны 36 дугаар зүйлд заасан “Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр”-т ямар нэгэн компанийн үйл ажиллагааг дэмжих, өр төлбөрийг барагдуулах ямар нэгэн зорилт, зорилго тусгагдаагүй байна. Хууль зүйн дүгнэлт нь тус хөтөлбөрийн ерөнхий үндэслэл хэсэгт заасан нийтлэг заалт буюу “хөтөлбөрийн зорилго” хэсэгт уг хөтөлбөрийг хамааруулсан үндэслэлгүй бөгөөд санхүүжүүлэх шийдвэр нь тодорхой үр дүн бүхий, хянах шалгах, үнэлэх боломж бүхий тодорхой шинж чанар, агуулгатай төсөл, хөтөлбөр байж МУХБ-ны тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж байх шаардлагатай, хэрэв зөвхөн хөтөлбөрийн зорилгод хамаарна гэсэн үндэслэлээр санхүүжилт олгох бол МУХБ-ны тухай хуулийн 8.1 дэх хэсэг утга, агуулгаа алдах, цаашлаад МУХБ нь бүхий л төсөл, арга хэмжээнд зээл олгох боломжтой болж хуулийг буруу ойлгох, хэрэглэх явдал газар авна гэх үндэслэлтэй байна. Түүнчлэн Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтад хамаарахгүйг анхаарах нь зүйтэй.

2015.12.21-ний өдөр Төрийн өмчит аж ахуйн нэгжийн авлагыг барагдуулах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 515 дугаар тогтоол гарч, уг тогтоолын 1 дүгээр хэсгээр ЭТТ ХК-ийн хүний хөгжил санд төвлөрүүлсэн урьдчилгаа төлбөрийн үлдэгдлээс 50,302,414 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн өглөгийг хасч, Сангийн яам, Хөгжлийн банк хооронд байгуулсан Батлан даалтын гэрээнд заасан нөхцлийн дагуу Засгийн газрын үнэт цаасанд шилжүүлэн Хөгжлийн банкинд эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн **2012.12.25**-ны өдрийн Төрийн өмчит аж ахуйн нэгжийн авлагыг барагдуулах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 520 дугаар тогтоолоор дээр дурьдсан 515 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан мөнгөн дүнгээс Хөгжлийн банкинд Засгийн газрын үнэт цаас эзэмшүүлэх болон тус банкны татварын урьдчилгаанд суутган тооцох замаар ЭТТ ХК-иас Хөгжлийн банкинд төлөх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайдад даалгасан байна.

Дээрх тогтоолуудын дагуу **2015.12.31**-ний өдрийн байдлаар 3-ЭТ-Э 2014-210 тоот зээлийн гэрээний дагуу **46,262,651 ам.долларын** үүргийн гүйцэтгэл зөрчилтэй байсан тул Сангийн яамнаас 10 тэрбум төгрөгийн үнэт цаас болон **82.2 тэрбум** төгрөгийн Хөгжлийн банкны татварын урьдчилгаагаар зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг хаахаар шийдвэрлэсэн байна.

Гэрээний дагуу олгосон 200 сая ам.долларын зээлийн зориулалт, зарцуулалтын талаар

Зээлийн хувийн хэрэгт авагдсан баримт материалуудаас харахад 2012, 2013, 2014 оны байдлаар МУХБ-ны зүгээс уг зээлийн зарцуулалтад ямар нэгэн хяналт тавьж ажиллаагүй байна. **2016.09.01**-ний өдөр ЭТТ ХК-иас МУХБ-д ирүүлсэн цахим шуудангаар ЭТТ ХК-ийн 200 сая ам.долларын зээлийн зарцуулалтын талаар мэдээлэл ирүүлсэн бөгөөд уг мэдээлэлд дээрх 200 сая доллараас **178.14 тэрбум ам.долларыг –ЭТТ ХК-ийн төлбөр болон хүний хөгжил санд** төвлөрүүлсэн, үлдэгдэл **21.86 тэрбум ам.долларыг** ЭТТ ХК-ийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулсан гэжээ.

Зээлийн хувийн дээр дурьдсан 200 сая ам.долларыг УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэрт заасан зориулалтын дагуу буюу шинэ төмөр замын дэд бүтцийн ажилд зарцуулсан гэх ямар нэгэн баримт материал авагдаагүй байна. МУХБ-ны зээлийн газрын ажилтнуудтай уулзаж дээрх 2 гэрээний биелэлтийн талаар ярилцлага хийхэд, МУХБ-ны зүгээс уг өр төлбөрийг барагдуулахаар 2014 оноос эхлэн идэвхитэй ажиллаж, ЭТТ ХК-ийн санхүүгийн байдал, төлбөрийн чадавхид мониторинг хийж байна, гэвч ЭТТ ХК-ийн зүгээс уг зээлийг барагдуулах төлөвлөгөөгүй, учир нь Засгийн газар Хүний хөгжил сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор ЭТТ ХК иар зээл авхуулж иргэдэд тараасан тул эдгээр өр төлбөрийг компанийн өмнөөс Засгийн газар барагдуулах үүрэгтэй гэж мэдэгдсэн гэжээ. ЭТТ ХК-ийн уг мэдэгдлийн дагуу МУХБ-наас Сангийн яаманд хандаж дээр дурьдсан 200 сая ам.долларын зээлийн баталгааг идэвхжүүлэх талаар хандсан боловч ЭТТ ХК болон МУХБ хооронд байгуулсан зээлийн гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж зээлийн хугацааг сунгах талаар албан бичиг ирүүлсэн, одоогийн байдлаар зээлийг эргэн төлөх талаар ямар нэгэн идэвхитэй арга хэмжээ аваагүй гэсэн байна.

4. Хөрөнгийн биржид 1.49 сая ам.долларын зээл олгосон.

Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоолын тогтоох хэсгийн 3-т “Лондонгийн хөрөнгийн бирж группт төлөх нэн даруй шаардлагатай 1.5 (нэг сая таван зуун мянга) сая ам.долларын хөрөнгийг төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны санхүүжилтээр шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасан байна.

Зээл олгосон болон зээл хаасан талаар

Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоолд заасны дагуу Хөгжлийн банкны Зээлийн хороо “Төрийн өмчийн хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Лондонгийн хөрөнгийн бирж групп хооронд байгуулсан “Ажлын мастер гэрээ”-ний дагуу 2012 оны төлбөрийн үлдэгдэл 1,494,100 ам.долларын санхүүжилт олгох тухай” асуудлыг хэлэлцээд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Зээлийн хорооны шийдвэрээр Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д 1,494,100 ам.долларын санхүүжилтийг барьцаа хөрөнгө улсын төсвөөс эргэн төлөгдөх зэрэг тодорхой нөхцөлтэйгээр олгохоор шийдвэрлэсэн байна.

Сангийн яамны Зээл, зээлийн хүүгийн төлбөр төлөх тухай 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 8-1/162 тоот албан бичигт “Тус “Гурван талт гэрээ”-ний 1-р бүлгийн 2-р зүйлд “Зээлдэгч нь (гэрээнд заасны дагуу Монголын хөрөнгийн бирж

ТӨХК) зээлийг зориулалтын дагуу ашиглаж, Сангийн яамтай хамтран улсын төсөвт тусгуулан, гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, түүний хүүг буцаан төлөх гэж заасан боловч 2015 оны төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас төлөх боломжгүй болсон. Иймд танай банкинд төлөх ёстой үндсэн зээл болон зээлийн хүүгийн төлбөр болох нийт 1,500,491.42 ам.долларын төлбөрийг Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон Хөгжлийн банкны хооронд байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний дагуу Хөгжлийн банкинд байршуулсан Чингис бондын (эх үүсвэрийн) хүүгийн авлагаас суутган тооцно уу” гэж заасны дагуу Хөгжлийн банк нь зээл болон зээлийн хүүгийн төлбөр болох 1,500,491.42 ам.долларын төлбөрийг Хөгжлийн банкинд байршуулсан Чингис бондын хүүгийн авлагаас суутган, зээлийг бүрэн хаасан байна.

Хууль зүйн үндэслэл, шаардлагын талаар

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д олгосон зээл нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална.” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан жагсаалтад дурдагсан төсөл, хөтөлбөрт хамрагдахгүй байна.

Мөн зээлийн хувийн хэрэгт Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх материал хавсаргагдаагүй нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Хөгжлийн банкнаас сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна.” гэж заасан шаардлагыг хангаагүй санхүүжилтийг хийсэн байна.

5. Таван толгойн цахилгаан станц төслийн талаар

Эрх зүйн үндэслэл

Засгийн газрын дараах тогтоолууд гарч “Тавантолгойн цахилгаан станц төсөл”-ийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх үндэслэл, шаардлагыг бий болгожээ.

1.ЗГ-ын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний орд газарт 300МВт цахилгаан станц барих төслийн нэгжийг байгуулж, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээ /төслийн объектийн ажлын зураг төсөл, ТЭЗҮ-ийг захиалж боловсруулах, санхүү эдийн засгийн тооцоо хийлгэх, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ боловсруулах/ авч ажиллахыг ЭЗХС, тухайн төсөл хэрэгжиж байгаа салбарын сайд нарт даалгасан.

2.ЗГ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 80 дугаар тогтоолоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 50 сая хүртэлх ам.доллартай тэнцэх төгрөгийг ЗГ-ын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс ХБ-аар дамжуулан 2013 онд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг ЭЗХС-дад даалгаж, ХБТУЗ-д зөвшөөрсөн.

3.ЗГ-ын 2013 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих цахилгаан станцын хүчин чадлыг 450 МВт байхаар тооцож, төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанийг гадаад, дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоотойгоор үүсгэн

байгуулах арга хэмжээ авахыг ЭХС-дад даалган, Тусгай зориулалтын компанид төрийн эзэмших хувьцаа 34 хувь байхаар тогтоож, Тусгай зориулалтын компанид эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийг зохих журмын дагуу олгохыг ЭХС, эрчим хүчний барилга байгууламж барихад шаардлагатай газрын асуудлыг шийдвэрлэхийг Өмнөговь аймгийн ЗД-д, ус ашиглах зөвшөөрөл болон холбогдох дүгнэлт гаргах арга хэмжээ авахыг БОНХС нарт тус тус даалгажээ.

4.ЗГ-ын 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 261 дүгээр тогтоолоор дор дурдсан арга хэмжээг авсан байна.

“1.Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төсөлд төрөөс олгох санхүүжилтийг давуу эрхийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй мезанин зээл хэлбэрээр олгохыг ХБТУЗ-д зөвшөөрсүгэй.

2.Хөрвөх давуу эрхийн хувьцаа нь компанийн нийт гаргасан хувьцааны 1/3 /гуравны нэгээс/ хэтрэхгүй байхаар тогтоосугай.

3.ЗГ-ын 2013 оны 80 дугаар тогтоолын 1 дэх заалтаар олгохоор шийдвэрлэсэн төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 50 сая ам.доллар болон цаашид төрөөс олгох санхүүжилтийг энэхүү тогтоолын 1-д заасан мезанин зээлийн хэлбэрээр төслийн нэгж, төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанид олгох, холбогдох гэрээг байгуулахыг ЭХС, ХБТУЗ-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолын 1-д заасан зээлийг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлд төрийг төлөөлөн давуу эрхийн хувьцааны өмчлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхийг ЭХС-д зөвшөөрсүгэй.” гэжээ.

Түүнчлэн энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ЗГ-ын 2013 оны 129 дүгээр тогтоолын тусгай зориулалтын компанид төрийн эзэмших хувьцаа 34 хувь байх тухай заалтыг хүчингүй болгосон байна.

5.ЗГ-ын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 375 дугаар тогтоолоор Эгийн голын усан цахилгаан станцыг барих төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг “Төсөл санхүүжүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 80 дугаар тогтоолоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөлд зарцуулахаар шийдвэрлэсэн 50.0 (тавин) сая ам.долларын эх үүсвэрийн үлдэгдлээс ижил нөхцөлийн дагуу санхүүжүүлэхийг ЭЗХС-д даалгаж, ХБТУЗ-д зөвшөөрсөн байна. Үүнтэй холбогдуулан ЗГ-ын 2013 оны 80 дугаар тогтоолын “50.0 сая” гэснийг “хүртэлх” гэж нэмсэн.

ЗГ-ын 2013 оны 71 дүгээр тогтоолын дагуу Эрчим хүчний сайдын 2013 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 36 дугаар тушаалаар Төслийн нэгжийг байгуулсан байна.

Зээл олгох шийдвэр

Дээрх ЗГ-ын тогтоолыг үндэслэн ХБ-ны ТУЗ, Зээлийн хорооны хурлаас дараах шийдвэрүүдийг гаргажээ.

1.ЗГ-ын 2013 оны 80 дугаар тогтоол, ХБ-ны Зээлийн хорооны хурлын 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ЗГ-ын 2013 оны 80 дугаар тогтоолд заасан 50 сая ам.долларын эх үүсвэрээс “Таван толгой цахилгаан станц” төслийн нэгжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх ажлын хүрээнд 1,900,000 ам.долларын зээл олгох З-ДЦ-Б 2013-20 дугаартай “Төсөл санхүүжүүлэх гэрээ”-г

2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ЭЗХЯ, ЭХЯ, ХБ-ны хооронд байгуулсан байх ба уг гэрээний дагуу 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр төслийн нэгжид 1.9 ам.долларыг шилжүүлсэн байна.

2.ЗГ-ын 2013 оны 80, 261 дүгээр тогтоол, ХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоол, ХБ-ны Зээлийн хорооны хурлын 2014 оны 01 дүгээр сарын 29-ний шийдвэрийг үндэслэн “Таван толгой цахилгаан станц” төслийн нэгжид 15,980,000 /арван таван сая есөн зуун наян мянган/ ам.долларын зээл олгох З-ДЦ-Б 2014-09 дугаартай “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-г 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ЭЗХЯ, ЭХЯ, ХБ-ны хооронд байгуулжээ.

Түүнчлэн Засгийн газрын 2013 оны 261 дүгээр тогтоолд “Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөлд төрөөс олгох санхүүжилтийг давуу эрхийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй мезанин зээл хэлбэрээр олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй” гэсний дагуу 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан дээрх “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ний Гуравдугаар бүлэг, заалтад дараах нөхцлүүдийг тусгаж өгсөн байна. Үүнд:

1.Төслийн бэлтгэл хангагдаж, төсөл хэрэгжих нөхцөл бүрдсэн тохиолдолд Засгийн газрын 2013 оны 261 тогтоолын хэрэгжилтийн хүрээнд зээлийг давуу эрхтэй хувьцаанд хөрвөх мезанин зээлийн нөхцөлд шилжүүлэн мезанин зээлийн гэрээ байгуулна. Зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт уг гэрээнд заасан нөхцөлөөр эргэн төлнө.

2.Хэрэв төсөл амжилтгүй болж мезанин зээлийн гэрээ хийгдээгүй тохиолдолд зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт Зээлдэгч болон ЭЗХЯ нь улсын төсөвт тусгуулан Банкинд эргэн төлнө.

3.Дээрх хоёр нөхцөл биелээгүй тохиолдолд Хөгжлийн банк нь ЭЗХЯ, СЯ, МУХБ-ны хооронд 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Санхүүгийн зуучлалын гэрээний дагуу Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг Хөгжлийн банкнаас Засгийн газарт эргүүлэн төлөх дүнгээс Зээлийн гэрээний дагуу төлөгдөх зээл, хүүгийн дүнг хасч бууруулан төлнө. /Санхүүгийн зуучлалын гэрээ нь материалд байхгүй байв./

Зээл олголт, зарцуулалт, төлөлтийн талаар.

ЗГ-ын 2013 оны 375 дугаар тогтоолоор 50 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг Тавантолгойн цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станц гэсэн 2 төсөлд хэрхэн хуваарилах нь тодорхойгүй байсан байх ба ЭХС-ын 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн а/100 тоот албан бичгээр Тавантолгойн цахилгаан станцын төсөлд 16 сая ам.доллар, Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд 34 сая ам.долларыг тус тус зарцуулах тухай мэдэгдсэн байна.

Түүнчлэн МУ-ын Ерөнхий сайдын 2015.03.10-ны өдрийн “Тавантолгойн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 70 дугаар захирамжинд уг төслийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг МУ-ын сай М.Энхсайханд хариуцуулсан байх ба МУ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ЗГ-3/107 тоот албан бичгээр төслийн нэгжийн 2015 оны санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд олгож өгөхийг хүссэн.

ЭЗХЯ, ЭХЯ, ХБ-ны хооронд байгуулсан 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээний дагуу Таван толгой төслийн нэгжид 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр 14,8 сая ам.долларыг олгосон

байх ба тус дүнгээс өмнөх 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан "Төсөл санхүүжүүлэх гэрээ"-ний 1,9 сая ам.долларыг хуримтлагдсан хүүгийн хамтаар суутган авч, тус зээлийг төлүүлсэн байна.

Тус олголтыг Хөгжлийн банкин дахь Тавантолгой цахилгаан станц төслийн нэгжийн харилцах дансанд байршуулан, Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээний хавсралтад тусгагдсан 2013-2015 оны үйл ажиллагааны зардлын дагуу Төслийн нэгжээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүчний яам хянан баталгаажуулж, банкинд ирүүлснээр санхүүжилтийг хэсэгчлэн шилжүүлжээ.

Төсвийн тухай 2015, 2016 оны хуульд үлдэгдэл 1,163,749.00 ам.доллар санхүүжилт тусгагдаагүй тул тус олголтыг Төслийн нэгжид олгоогүй байна.

Мөн Төслийн нэгжийн 2016 оны зардлын төлөвлөгөө нь Сангийн яамнаас батлагдан ирээгүй байгаа тул Төслийн нэгжийн харилцах данснаас 2016 онд санхүүжилтийн гүйлгээ хийгдээгүй байна.

Төслийн нэгжийн Хөгжлийн банкин дахь харилцах данс нь 7.1 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

Зарцуулалт

Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээний дагуу 2013-2015 оны хооронд Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 5,378,889,239.0 төгрөг, Төслийн бэлтгэл ажлын зардал буюу зөвлөх, судалгаа, холбогдох зөвшөөрлүүд авах зэрэг ажилд 22,303,421,905.0 төгрөг буюу нийтдээ 27,682,311,144.0 төгрөгийн зарцуулалт хийхээс 2013-2015 онд Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 3,720,587,728.03 төгрөг, Төслийн бэлтгэл ажилд 11,437,406,678.23 төгрөг буюу нийтдээ 15,157,994,406.26 төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс зөвлөх үйлчилгээний зардалд дараах байдлаар Хөгжлийн банкнаас санхүүжилт хийсэн байна.

1.Техникийн зөвлөх үйлчилгээ

Техникийн зөвлөх үйлчилгээний төлбөрт 2013-2015 онд "Уорли Парсонс" ХХК-д нийт 935,932.98 ам.долларыг Хөгжлийн банкнаас шилжүүлсэн байна. Тус зөвлөхийн ажлын хүрээнд ТЭЗҮ, Нүүрсхүчлийн хийн судалгаа болон бусад зөвлөх үйлчилгээнүүд хийгдсэн байна. Үүнээс ТЭЗҮ хийх ажилд 96,777.62 ам долларыг санхүүжүүлсэн байна.

2.Санхүүгийн зөвлөх үйлчилгээний төлбөрт 2013-2015 онд "SMBC" ХХК-д нийт 729,971.92 ам.долларыг Хөгжлийн банкнаас шилжүүлсэн байна.

3.Хуулийн зөвлөх үйлчилгээний төлбөрт 2013-2015 онд "Шеармэн энд Стийрлинг" ХХК-д нийт 1,414,474.07 ам.долларыг Хөгжлийн банкнаас шилжүүлсэн байна.

Зээлийн эргэн төлөлт

Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээний дагуу үндсэн төлбөр 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр төлөгдөх хуваарьтай байх ба олгогдсон 14,816,251.00 сая ам.долларын зээлийн 2015 онд төлөгдөх хүүгийн төлбөрт 1,484,242.44 ам.долларыг 2015 оны улсын төсвөөс төлсөн. 2016 онд төлөгдөх хүүгийн төлбөр болох 922,620.30 ам.доллар 2016 оны төсөвт тусгагдсан боловч одоогийн байдлаар төлбөр хийгдээгүй байна. Төсөл санхүүжүүлэх, эргэн

төлөлтийг зохицуулах тухай гэрээний дагуу төсөл амжилттай хэрэгжин, мезанин зээлийн гэрээ хийгдэх хүртэл хүүгийн төлбөрийг улсын төсөвт суутгах байдлаар төлүүлж байна гэж тайлбарласан болно.

Дүгнэлт

1.Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төслийг ХБ-аас санхүүжүүлэхтэй холбоотой ЗГ-ын тогтоол, ТУЗ-ийн тогтоолууд нь УИХ-ын тогтоолыг үндэслээгүй, зээлийн хувийн хэрэгт энэ талаар холбогдох танилцуулга, мэдээлэл байхгүй байна .

Түүнчлэн хяналтын явцад уг төслийг УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолоор баталсан ХБ-аас санхүүжүүлэхээр тусгасан 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийн 4.1.2.1-д тусгасан "Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, орон нутагт эрчим хүчний төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрийг бий болгох;" гэсэн зорилтын хүрээнд хамааруулж ойлгож болохоор байна гэж үзсэн хэдий ч УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоол нь өөрөө хуулийн 8.1-д заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтын агуулга, хэлбэрийн шаардлага ханган баталсан хэлбэр биш гэж ажлын хэсгээс дүгнэж байгаа тул уг төсөл нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан "Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална." гэсэнтэй нийцэхгүй байна.

2.ХБ-ны ТУЗ-ийн 2014 оны 07 дугаар тогтоол нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан "Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивын болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана." гэсэнтэй нийцэхгүй байна.

3.Зээлийн хувийн хэрэгт уг төсөл нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар материал хавсаргагдаагүй нь хуулийн дээрх хэсэгт заасан төсөл хөтөлбөрт тавих шаардлагыг хангаагүй санхүүжилтийг хийсэн гэж үзэж байна.

4.Зээлийн хорооны шийдвэрүүдэд Актив-пассивын удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэсэн эсэх талаар тодорхойгүй, энэ талаар зээлийн хувийн хэрэгт хавсаргаагүй, мөн ХБ-ны ЭУГ-ын 2014.01.28-ны өдрийн 1/14/415 дугаар дүгнэлтээр Таван толгойн цахилгаан станц төсөлд 15.98 сая ам.долларын санхүүжилтийг олгох нь эрсдэлтэй талаар дүгнэлт гарсан байх ба энэхүү эрсдлийн дүгнэлтэд дурдсан санал, дүгнэлтийн талаар хэрхсэн нь тодорхойгүй /хүлээн авсан эсэх нь материалаас тодорхойгүй//байхад Зээлийн хороо зээл олгох шийдвэр гаргасан зэрэг нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Зээл олгох шийдвэрийг ХБ-ны актив-пассивын болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана." гэж заасантай нийцэхгүй байна.

Түүнчлэн зээл нь мөн хуулийн 8.3.2-т заасан зөвхөн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэсэн байх гэсэн зээлд тавих шаардлагыг хангасан талаар материал байхгүй байх тул энэхүү шаардлага мөн хангагдаагүй байна гэж үзэв.

5.ЗГ-ын зарим тогтоолууд хуульд нийцээгүй, тухайлбал ЗГ-ын 2013 оны 71 дүгээр тогтоолоор бүтээн байгуулалтын төсөл, объектийн зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийг захиалж боловсруулах арга хэмжээ авахыг холбогдох сайдад даалгасан нь МУХБТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан "ХБ-аас санхүүжүүлэх

төсөл, хөтөлбөр нь төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх;" гэсэн шаардлагыг зөрчиж, улмаар ХБ-аас уг төслийн ТЭЗҮ боловсруулах арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Төсөлтэй холбогдуулан ХБ-ны хуулийн хэлтсээс 2013.11.20-ны өдрийн 2013/37 дугаартай "Таван толгойн цахилгаан станцын барилгын ажлын эхний санхүүжилтийн асуудал"-д гаргасан дүгнэлт, 2014.01.22-ны өдрийн 2014/03 дугаартай "Таван толгойн цахилгаан станцын барилгын ажлын эхний санхүүжилтийн тухай" дүгнэлт, 2014.03.14-ний өдрийн 2014/19 дугаартай "Мезанин зээлийн тухай" дүгнэлт, 2015.04.09-ний өдрийн 2015/30 дугаартай "Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2015 оны үйл ажиллагааны зардлын төсвийн хүрээнд Төслийн нэгжид олгосон 14.8 сая ам.долларын санхүүжилтийн үлдэгдлээс Төслийн нэгжийн 2015 оны үйл ажиллагааны зардал, зөвлөх үйлчилгээ, судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг олгох үндэслэлтэй эсэх." дүгнэлт зэрэг хууль зүйн дүгнэлтүүдийг гаргасан байх ба эдгээр санал, дүгнэлтийг хүлээн авсан эсэх талаар зээлийн хувийн хэргээс харагдахгүй байна. Хууль зүйн дүгнэлтүүдийг хавсаргав. Тухайлбал, ЗГ-ын 2013 оны 261 дүгээр тогтоолд дурдсан мезанин зээлийн гэрээг одоог хүртэл байгуулаагүй, мөн Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд ХБ-ны эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад уг төсөл багтаагүй, ЭЗХЯ татан буугдсантай холбогдуулан "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ"-г Сангийн яамтай шинэчлэн байгуулж, МУХБТХ-ийн 8.3.5-д заасан барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн бусад арга хэрэгслээр хангагдсаны дараа санхүүжилтийг олгох талаар гаргасан хууль зүйн дүгнэлтийг хүлээн авсан нь тодорхойгүй.

Дэд бүтэц-Эрчим хүч төслийн 2013 оны зөвлөх үйлчилгээ болон техникийн хяналт тавих арга хэмжээнд 717.3 сая төгрөг батлуулан, үүнээс 628.0 сая төгрөг гаргуулж авсан.

Барилга, хот байгуулалтын яамны "Дэд бүтэц", "Дэд бүтэц-Эрчим хүч" төслийн талаар:

"Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоол, Эдийн Засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаал, Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 92 дугаар тушаал, Эрчим хүчний сайдын 2013 оны 62 дугаар тушаал, Төслийн удирдах хорооны 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн, дараах бүрэлдэхүүнтэй Төслийн удирдах хороо 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 48 дугаар "Техникийн хяналтын ажил гүйцэтгэх эрх олгох тухай", мөн өдрийн 49 дүгээр "Зөвлөх үйлчилгээ, техникийн хяналтын ажил гүйцэтгэх эрх олгох тухай", мөн өдрийн 50 дугаар "Зөвлөх үйлчилгээ, техникийн хяналтын ажил гүйцэтгэх эрх олгох тухай" тогтоол гаргаж, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ-д 200.0 (Хоёр зуун) сая төгрөгийн, РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ ХХК-д 108.2 (Нэг зуун найман сая хоёр зуун мянган) төгрөгийн, ГАНГАНЖИР КОНСАЛТИНГ ХХК-д 409.1 (Дөрвөн зуун есөн сая нэг зуун мянган) төгрөгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрхийг олгосон байна.

Уг тогтоолд Төслийн удирдах хорооны дарга, гишүүд гарын үсэг зурсан нь:

ТУХ-НЫ ДАРГА: Р. ЭРДЭНЭБҮРЭН /БХБЯ-НЫ ТНБДарга/,

- ГИШҮҮД:
- Д. ДЭЛГЭРЦОГТ /ЭХЯ-НЫ ТНБДарга/,
 - Г. МЭРГЭНБАЯР /БХБЯ-НЫ СБТГ-ЫН дарга/,
 - П. ТОВУУДОРЖ /ЭХЯ-НЫ СБТГ-ЫН дарга/,
 - Г. БАТХҮРЭЛ /ЭЗХЯ-НЫ ХБСТГ-ЫН дарга/,
 - Р. БААСАНЖАВ /ЭЗХЯ-НЫ ХШУДАГ-ЫН дарга/,
 - С. ОЧИРБАТ /Нийслэлийн Засаг Даргын Орлогч/,
 - Н. ГАНТӨМӨР /Нийслэлийн Засаг Даргын Орлогч/,
 - Б. БАДРАЛ /Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд
ЗААлбаны дарга/,
 - Ч. БАТБААТАР /ШӨХТГ-ын ХЭХХ-ийн дарга/,

АСУУДАЛ: Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулахдаа 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдөр буюу Төслийн удирдах хорооны энэхүү тогтоолыг гаргахаас 3 сарын өмнө байгуулсан. 2013 оны 10 сарын 04-ний өдөр уг тогтоолыг нөхөж гаргасан болохыг “Дэд бүтэц-Эрчим хүч” төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал П.Ганбат шалгалтын явцад уулзагдаа мэдэгдсэн. Иймд шалгалтын үеэр холбогдох бүх материалыг татан үзэхээр хүсэлт гаргасан боловч ЭХЯ, БХБЯ-ны архивт хадгалагдаж байгаа, эсхүл Эрчим хүчний хөгжлийн төвийн архивт хадгалагдаж байгаа гээд ирүүлсэнгүй.

Мөн “Дэд бүтэц-Эрчим хүч” төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2013 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 2013/09/30 дугаартай хурлын протоколтой танилцахад “Зөвлөх үйлчилгээний зарлал” гэж 2013 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудад зөвлөх үйлчилгээ авахаар зарласан гэх боловч баримт бичгээр нотлогдоогүй болно.

Монгол Улсын Хөгжлийн банк нь “Дэд бүтэц-Эрчим хүч” төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажилласан баримт бичиг мөн байхгүй байна.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ: “Дэд бүтэц-Эрчим хүч” төслийн үйл ажиллагааг бүхэлд нь тусгайлсан хяналт, шалгалт хийж шалгах нь зүйтэй байна. Ялангуяа зөвхөн зөвлөх үйлчилгээ, техник хяналтын ажил гэж хуваалгүй үндсэн хийгдсэн ажлын гүйцэтгэлийг нягтлан шалгах шаардлагатай. Эрчим хүчний салбарын мэргэжлийн инженер, зөвлөхүүд, мөн дулааны инженер, техникийн ажилтнууд, санхүүгийн ажилтнуудын хамтарсан ажлын багийг ажиллуулах саналтай байна.

- 6. Гудамж төслийн хүрээнд баригдах замын ажлуудын зураг төсөл боловсруулах шатнаас зам барилгын угсралтын ажлыг бүрэн дуустал хяналт зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан “Си ти ай инженеринг интернейшнл” ХХК-тай хийсэн гэрээ, гүйцэтгэл болон санхүүжилт**

Засгийн газрын 2013 оны 46, 81 тогтоолын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг Гудамж төслийн нэгжээс санал болгон ТУХ-аар баталгаажуулан сонгон шалгаруулсан байна. Төслийн удирдах хорооны 2013 оны 04 сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоол гарсан байна. Гэрээнд нэмэлт өөрчлөлт орохтой холбоотой ТУХ-ны 2015 оны 10 сарын 05-ны 05 дугаар тогтоол гарсан байна.

2014 оны 06 сарын 01-ний өдөр гэрээг байгуулж нийт гүйцэтгэх ажлыг 7,931,380.00 ам доллар байхаар гэрээнд тусгасан байна.

Сангийн яамны эрх нээний дагуу нийт 1,208,000,000.00 төгрөг авсан байна.

Гэрээний дүн 7,931,380.00 ам доллар байснаас 5,425,439.00 ам доллар болж буурсан байна. Энэ нь гэрээний хугацаанд гэрээнд тусгагдсан ажил үйлчилгээ цуцлагдсан тул дүн буурчээ.

7. “Шин Жиан Шин Фа” ХХК-ийн 2014 онд хийж гүйцэтгэсэн 3.2 км хатуу хучилттай авто замын ажлын гэрээ, гүйцэтгэл, санхүүжилттэй холбогдох материалууд

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Гудамж төсөл”-ийг батлах тухай, 81 дүгээр “Гудамж төслийн санхүүжилтийн тухай” тогтоолын дагуу “Гудамж” (Улаанбаатар хотын авто замын 33 уулзварыг дөрвөн замын уулзвар болгон шинэчлэх болон Туул, Сэлбэ голын даланг дагуулан хурдны зам барих) төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 200 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлэхийг даалгасан байна.

Гудамж төслийн нэгжийн Төслийн удирдах хорооны 2014 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Увс аймгийн төвд хийх бүтээн байгуулалтын авто замын ажлын гүйцэтгэгчээр төсөл хэрэгжүүлэх нэгжээс сонгон шалгаруулсан “Шин Жиан Шин Фа” ХХК-г сонгохыг зөвшөөрсөн байна.

Гудамж төслийн нэгжээс 2015 оны 4 дүгээр сарын 27-нд Хөгжлийн банкинд гэрээг байгуулах зөвшөөрөл хүсэх тухай албан бичгээр “Шин Жиан Шин Фа” ХХК-ын ажлын төсөвт өртөг 10,095,628,170.98 төгрөг болох талаар холбогдох баримт бичигийг ирүүлсэн байна.

МУХБ-ны 2015 оны 4 дүгээр сарын 28-ны 2015/48 дугаар Зээлийн хорооны хурлын шийдвэр, 2015/40 дугаартай Хууль зүйн дүгнэлт, Барилгын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах тухай инженерийн санал, дүгнэлт, Эрсдлийн удирдлагын дүгнэлтээр ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй гэж дүгнэсэн байсныг тус тус үндэслэн 2015 оны 5 дугаар сарын 28-ны ТУЗ-ын 34 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар батлагдсан Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх нийт 241 төслийн 794,655,600,000.00 төгрөгийн санхүүжилтийн гэрээг зохих журмын дагуу Сангийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр байгуулж, гэрээний дагуу санхүүжилт олгохыг даалгасан байна.

2015 оны төсвийн тухай хуулийн 3-р хавсралтад “Увс аймгийн авто замын барилгын ажил” төсөл арга хэмжээнд 7,455,600,000.00 төгрөгөөр батлагдсан.

МУХБ-ны 2015 оны 11 дүгээр сарын 24-ний зээлийн гүйлгээ хийх шийдвэрээр Гүйцэтгэгчийн капитал банк 2000021679 дансанд 6,935,464,116.57 төгрөг, Норм нормативын сан төрийн сан, СЯ-900028410 дансанд 11,958,727.68 төгрөг, барьцааны суутгал ХБ-3600000252 дансанд 372,647,241.91 төгрөг нийт 7,320,070,086.16 төгрөгийн зээл олгосон байна.

ЗТЯ-аас МУХБ руу Санхүүжилт шийдвэрлүүлэх тухай 2015 оны 9 дүгээр сарын 23-ны 03/4090 албан тоот-Зам тээврийн сайдын 2015 оны 129 дүгээр тушаалын 3 дугаар заалтад дээрх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргад үүрэг болгосон. Уг тушаалын дагуу Гудамж төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Увс аймгийн төвд хийх бүтээн байгуулалтын уулзвар, авто зам 3.2 км-ын барилгын ажил гүйцэтгэгч Шин Жиан Шин Фа ХХК-ын ажлын гүйцэтгэл 1-ын санхүүжилтийн хүсэлтийг хяналтын зөвлөх үйлчилгээний "Си Ти Ай инженеринг интернэшнл" ХХК-иар баталгаажуулж ирүүлснийг хянан хүргүүлсэн байна.

Шинжаан шинфа ХХК-ын МУХБ-нд ажлын гүйцэтгэл санхүүжүүлж өгнө үү гэсэн 2015 оны 11 дүгээр сарын 23-ны 323 тоот албан бичиг.

8. Атар өргөөгийн уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1 км авто замын барилгын ажлын 440.0 сая төгрөгийн С-ГТ-Б 2013-159 тоот гэрээ /үнийн дүнг өөрчлөн хийсэн/, гүйцэтгэлийн санхүүжилт

Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 46 дугаар тогтоолоор "Гудамж төсөл"-ийг баталсан байна. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 4 сарын 5-ны өдрийн 29 тоот тушаалаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг үндэслэн Гудамж төслийн нэгжийг байгуулсан байна.

Гудамж төслийн нэгжийн төслийн удирдах хорооны 2013 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 69 тоот тогтоолоор "Монроуд" ХХК-ийг тус ажлыг гүйцэтгэхээр сонгож баталсан байна.

Хөгжлийн банкны ТУЗ-ын хурлаар 5.0 тэрбум төгрөгөөс дээш зээлийн асуудлыг оруулдаг тул уг төсөл нь заасан хэмжээнээс бага байсан тул хурлаар оруулаагүй байна. Гэвч Хөгжлийн банкны тухай хуулийн 8.2-д "Зээл олгох шийдвэрийг актив пассивын болон эрсдлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана" гэж заасан боловч уг заалтыг дагаж мөрдөөгүй Зээлийн хороо шууд шийдвэр гарган зээл олгосон байна.

Хөгжлийн банкны Зээлийн хорооны 2013 оны 9 дугаар сарын 20-ний өдрийн хурлаар "Монроуд" ХХК-тай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г Гудамж төслийн ирүүлсэн дүнгийн 80 хувиар тооцож 440,000,000 төгрөг байгуулахаар зөвшөөрсөн байна.

Мөн Хөгжлийн банкны Зээлийн хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн хурлаар "Гудамж" төслийн авто замын 2, уулзварын 3 төсөлд нэмэлт гэрээг 8,215,273,787 төгрөгөөр байгуулахаар зөвшөөрөл өгсөн байна. Үүнд "Монроуд" ХХК-тай 1,895,550,885 төгрөгийн нэмэлт гэрээ байгуулахаар заажээ.

"Гудамж" төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Б.Батболдоос ХБанк руу гэрээ байгуулах зөвшөөрөл болон урьдчилгаа санхүүжилт хүссэн тухай 2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 572 тоотоор хүргүүлсний дагуу "Гудамж" төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Б.Батболд (Захиалагч), МУ-ын ХБанкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбат (Санхүүжүүлэгч), "Монроуд" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Тэнгис (Гүйцэтгэгч) нар хамтран "Дулааны 3-р цахилгаан станцын урд уулзвараас

Яармагийн гүүр хүртэлх 1 км замыг өргөтгөн шинэчлэх зам барилгын ажил гүйцэтгэхээр 2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр С-ГТ-Б 2013-159 тоот гэрээг 440,000,000.0 төгрөгөөр байгуулсан байна.

Мөн оны 12 дугаар сарын 13-ны өдөр тус гэрээнд өөрчлөлт орж С-ГТ-Б 2013-159-1 тоот нэмэлт гэрээ байгуулан гэрээний дүнг 1,895,550,885 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Гэвч гэрээг нэмэгдүүлэх болсон шалтгаан, тооцоолол зэрэг байхгүй байна.

Гудамж төслийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дуусаагүй барилгад 1,840,908,959.11 төгрөгөөр бүртгэлтэй байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх бүх гэрээнд барьцаалбар байхгүй байна.

Монроуд ХХК нь нийт 3 удаа 1,743,161,710.32 төгрөгийн санхүүжилтийг ХХБанкны 499214956 тоот дансаар авсан байна.

Хөгжлийн банк болон "Монроуд" ХХК нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Хоорондын тооцоо нийлсэн акт үйлдсэн байна. Нийт гэрээний дүн, олгосон санхүүжилтийг харьцуулахад 11,341,203.12 төгрөгийг "Монроуд" ХХК-д дутуу төлсөн байна. Төлбөр тооцоо дууссан тул дахин төлбөр гарахгүй.

Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасны дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт дараах шаардлага тавигддаг байна. Үүнд:

№	Тавигдах шаардлага	Хангасан эсэх
1	Засгийн газрын баталсан МУ-ын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамрагдах	Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 46 дугаар тогтоолоор "Гудамж төсөл"-ийг баталсан байна. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 4 сарын 5-ны өдрийн 29 тоот тушаалаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг үндэслэн Гудамж төслийн нэгж байгуулагдсан байна.
2	Төсөл хөтөлбөрийн зураг, төсөв, техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх	Уг гэрээг байгуулахаас өмнө төсөл хөтөлбөрийн зураг, төсөв, техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх ёстой байдаг. Гэвч ажлын зургийг нь өөр байгууллагын зурагтай хамт нийлүүлэн хийсэн байсан. Гэрээнд ажлын зураг хавсрагдаагүй гүйцэтгэгч байгууллагад байгаа гэсэн тайлбар өгсөн. Мөн техник эдийн засгийн үнэлгээ хийдэг байсан тухай баримт бичиг байхгүй байна.
3	Эдийн засгийн өсөлтийг	Эдийн засгийн өсөлтийг дэмжих, эсхүл

	дэмжих, эсхүл олон улсын болон европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортынг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх	олон улсын болон европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортынг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн бүтээгдэхүүнд зориулагдаагүй байна.
4	Зээлийн эрсдлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх	Зээлийн эрсдлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуур зэргийг тооцсон тухай баримт байхгүй байна. Мөн нэмэлт гэрээ хийж гэрээний дүн өөрчилсөн нь ямар ч шалтгаан болон эдийн засгийн тооцоололгүйгээр нэмэгдүүлсэн байна. Гудамж төслийн удирдах хорооны тогтоолоор зам барилгын ажил гүйцэтгүүлэхээр "Монроуд" ХХК-ийг шууд сонгон баталсан байна.
5	Төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэл зээлийн барьцаа хөрөнгөд тооцсон байх	Гудамж төслийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дуусаагүй барилгад 1,840,908,959.11 төгрөгөөр бүртгэлтэй байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх бүх гэрээнд барьцаалбар байхгүй байна.

9. Гудамж төслийн хүрээнд замын ажил гүйцэтгэсэн "Пабликроуд" ХХК-ийн ажил гүйцэтгэх гэрээ, санхүүжилт , гүйцэтгэлийн холбогдох материал

**Хэрэгжсэн төслийн нэр: 3, 4-р хорооллын эцсийн уулзварын өргөтгөл шинэчлэл
Гүйцэтгэгч:Пабликроуд ХХК**

Хугацаа: 2013-2014

Дээрх төслийн материалд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үзлээ. Үүнд: 2013 оны гарсан ЗГ-ын 46,81 тогтоолын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг Гудамж төслийн нэгжээс санал болгон ТУХ-аар баталгаажуулан сонгон шалгаруулсан байна.

Төслийн удирдах хорооны 2013 оны 07 сарын 31-ний өдрийн 56 дугаар тогтоол гарсан байна.

125
НУУЦ

ИЛ БОЛСОН

Зээлийн хорооны шийдвэр нь 2013.08.23-ны өдөр урьдчилсан байдлаар 300.000.000.00/гурван зуун сая/ төгрөгийг зураг төсөв гараагүй байхад гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр шийдсэн байна. Хорооны шийдвэр дээр Зураг төсөл гүйцэтгэж дууссаны дараа төсөвт өртөгийг баталгаажуулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна гэж шийдвэрлэсэн байна. Төсвийн тухай хуулийн 29.416 болон Барилгын тухай хуулийн 13.217, 13.518-д заасныг зөрчиж магадлал хийлгээгүй зураг төслөөр авто зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлж гэрээ байгуулсан байна.

Анхны санхүүжүүлэлтийг 2013 оны 8 сарын 27-нд гэрээ байгуулагдаад 4 хоноод урьдчилгаа байдлаар авсан байна.

Гэрээнд 2013 оны 10 сарын 21-нд нэмэлт өөрчлөлт орж зураг төсөв магадлалаар баталгаажиж, Гэрээний төсөвт өртөг **1,356,847,700.00/ нэг тэрбум гурван зуун тавин зургаан сая найман зуун дөчин долоо мянга долоон зуу/** байхаар тусжээ.

Хоёр дах удаагийн санхүүжилтийг 2013 оны 10 сарын 24-нд Гүйцэтгэлийн бичилт 2013.05-2013.08 гэж **622,996,764.00** төгрөг авсан байна.

Гудамж төслийн ирүүлсэн сонгон шалгаруулалтын мэдээгээр **2013.07.23 нд сонгон шалгаруулалтад оролцохоор:**

- 1) Паблицроуд ХХК,
- 2) Саруул Жим ХХК,
- 3) Өвөр залаат ХХК,
- 4) Монгол асфальт ХХК,
- 5) Уулын зам ХХК,
- 6) Мэжистрал ХХК,
- 7) Хушингарын навч ХХК,
- 8) Өргөн говь ХХК гэсэн 8 компани ирүүлжээ.

Гэтэл дээрх гүйцэтгэлийн бичилтээр сонгон шалгаруулалт хийхээс өмнө **Паблицроуд ХХК** ажлыг эхлүүлсэн байна.

Санхүүжилт-3 2013.12.27 нд **351,262,200.00 төгрөг** эцсийн санхүүжилтээр авсан байна.

Улсын комиссын акт 2013 оны 12 сарын 26-нд хүлээн авсан. Улсын комиссын актад захиалагч байгууллагын мэдэгдэл ирүүлсэн он сар, ашиглалтад оруулахыг хүлээн зөвшөөрсөн огноо байхгүй байна.

Хэрэгжсэн Төслийн нэр: Өргөө кино театрын урд уулзварын шинэчлэлийн ажил

Гүйцэтгэгч: Паблицроуд ХХК

Хугацаа: 2013-2014

Дээрх төслийн материалд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үзлээ. Үүнд:

2013 оны гарсан ЗГ-ын 46,81 тогтоолын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг Гудамж төслийн нэгжээс санал болгон ТУХ-аар баталгаажуулан сонгон шалгаруулсан байна.

Төслийн удирдах хорооны 2013 оны 05.15-ны өдрийн 13 дугаар тогтоол гарсан байна.

- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт 2013.05.15
 - 1) Юнайтедроуд интернэйшнл ХХК,
 - 2) Мөнх тэнгэрийн харгуй ХХК,
 - 3) Баткубик ХХК,
 - 4) Пабликроуд ХХК
 - 5) КТК ХХК-ний түншлэл
- Зээлийн хорооны шийдвэр нь 2013.05.27-ны өдөр **1,590,537,381.38** төгрөгийг гэрээнд тусгасан байна. Магадлалын дүгнэлт:
 - 2013.04.04-Ус зайлуулах суваг, түүний техникийн нөхцөл
 - 2013.04.09-Усан хангамжийн техникийн нөхцөл

Анхны санхүүжүүлэлтийг 2013.05.31-нд гэрээ байгуулагдаад 4 хоноод 2013.05-2013.06 сарын Ажлын Гүйцэтгэлд гэж 292,645,000.078 авсан байна.

Нийт 1,496,176,000.32 олгосон, банкны баталгаа болох 5%-ийг 2016.04.18нд Чингис Хаан банкны ГЗ/173 тоот албан бичгээр ирүүлсэн баталаагаар чөлөөлсөн байна.

Хэрэгжсэн Төслийн нэр: 100 айлын уулзвар

Гүйцэтгэгч:Пабликроуд ХХК

Хугацаа: 2014

Дээрх төслийн материалд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үзлээ. Үүнд:

2013 оны гарсан ЗГ-ын 46,81 тогтоолын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг Гудамж төслийн нэгжээс санал болгон ТУХ-аар баталгаажуулан сонгон шалгаруулсан байна. Төслийн удирдах хорооны 2014 оны 05.08-ны өдрийн 27 дугаар тогтоол гарсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт 2014.04.23

- 1) Пабликроуд ХХК,
- 2) Готикголд ХХК,
- 3) Мегастракчер ХХК

Зээлийн хорооны шийдвэр нь 2014.05.23-ны өдөр шийдвэр гарч. 2014 оны 06 сарын 01-ний өдөр гэрээг байгуулж **1,209,299,000.00** төгрөгийг гэрээнд тусгасан байна. Магадлалын дүгнэлт:

- 2013.07.04-Дулааны хангамж
- 2013.07.03-Гадны цахилгаан хангамж,
- 2013.07.03-Гадна холбоо тохиолол

Улсын комиссын акт гарч 2014 оны 11 сарын 20-нд хүлээн авсан байна. Улсын комиссын актад захиалагч байгууллагын мэдэгдэл 2014 оны 10 сарын 21-нд ирүүлж, 2014 оны 10 сарын 30-нд ашиглалтад оруулахыг хүлээн зөвшөөрсөн байна.

Нийт 1,108,589,805.01 төгрөг олгосон, банкны баталгаа болох 5%-ийг 2016.04.18нд Чингис Хаан банкны ГЗ/174 тоот албан бичгээр ирүүлсэн баталагаагаар **60,464,950.00 төгрөг** чөлөөлсөн байна.

10. Яармагийн гүүр орчмын орон сууцны хорооллын бохир ус, дулаан, цахилгаан шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг хийхээр гэрээ байгуулсан “Пума” ХХК-тай байгуулсан гэрээ, санхүүжилт, гүйцэтгэлийн материал

Төслийн сонгон шалгаруулалтын хувьд: Засгийн газрын 2011 оны 149 дүгээр тогтоолд төслийн гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулна гэж заажээ. Энэхүү төслийг “Пума” ХХК нь өөрийн хөрөнгөөр хийсэн бөгөөд Засгийн газрын 118 дугаар тогтоолоор нийт 21,769,400,000 төгрөгөөр санхүүжүүлт хийх бөгөөд 2013 онд 10,769,000,000 төгрөг, 2014 онд 11,000,000,000 төгрөгөөр олгохоор батлагдсан.

Зээл олгосон шийдвэрүүдийн талаар: Төслийн удирдах хорооны 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 29 дугаар тогтоол гарсан байна. Хөгжлийн банкны Зээлийн хорооны шийдвэр нь 2013.08.19-ны өдөр гарсан бөгөөд гадна бохирын ажилд зориулж 3,802,000,000 төгрөгийг санхүүжүүлэхээр шийдсэн байна. Уг санхүүжилтийн дүн 5 тэрбум хүрээгүй учраас ТУЗ-ын шийдвэр гараагүй.

Хоёр дахь зээлийн хорооны шийдвэр нь 2013 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр гарсан бөгөөд Төрийн өмчийн хорооноос “Пума” ХХК-ийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлыг бүртгэн авч ашиглалтыг хариуцах тухай тогтоол гарсны дараагаар 6,967,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгохыг дэмжиж ТУЗ-д танилцуулан холбогдох зөвшөөрлийг авахаар шийдвэрлэсэн байна.

ТУЗ-аас 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 56 тоот тогтоол гарч “Пума” ХХК-д 6,967,000,000 төгрөгийг олгохыг зөвшөөрсөн байна.

2014 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Зээлийн хороо дулааны ажлын үлдэгдэл санхүүжилт болох 1,900,000,000 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна.

Төсөл санхүүжүүлэх гэрээг тухайн бүр Хөгжлийн банк, Эдийн засгийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, “Пума” ХХК-ны хооронд байгуулж байсан байна. Үүнд:

- Гэрээ-1: 2013 оны 08 дугаар сарын 21-ны өдөр 3,802,000,000 төгрөгийг санхүүжүүлэх гэрээ байгуулсан
- Гэрээ -2: 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 6,967,000,000 төгрөгийг санхүүжүүлэх гэрээ байгуулсан.
- Гэрээ -3: 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 42-2/253 тоот С-ДБ-Б2013/БХБЯ-280 дугаартай төсөл санхүүжүүлэх гэрээнд өөрчлөлт оруулах тухай 1,900,000,000 төгрөгийн гэрээ хийсэн байна.

Энэ төслийн санхүүжилтийн нийт 3 гэрээ байгуулсан бөгөөд баталгаа, барьцаалбар байхгүй байна.

Аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт авсан дансны хуулга болон мемориалын баримт

Аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт авсан дансны хуулгыг тулгаж үзэхэд дараах байдлаар санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Санхүүжилт -1: 2013 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 3,802,000,000 төгрөгийг олгосон.
- Санхүүжилт -2: 2013 оны 10 дугаар сарын 09-ны өдөр 6,967,000,000 төгрөгийг олгосон.

Нийт: 2013 онд 10,769 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

- Санхүүжилт -1: 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдөр 1,900,000,000 төгрөгийг олгосон.

Үүнээс хойш ямар нэгэн санхүүжилт хийгдээгүй байгаа бөгөөд дансны үлдэгдэлийн тулгалт хийгдээгүй буюу үлдэгдэл санхүүжилт болох 9.1 тэрбум төгрөгийг баталгаажуулаагүй байна.

“Пума” ХХК-ийн хийсэн ажлын гүйцэтгэл болох 3 боть материал 3 боть ажлын төсөв өгсөн байна.

Ажлын гүйцэтгэлийг тооцсон ажлын хэсгийн акт дүгнэлтүүдийн хувьд:

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байгуулсан ажлын хэсэг 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдөр ХУД-ийн Яармагийн гүүрний хажуу талд “Пума констракшн” ХХК-ийн барьж буй орон сууцны хорооллын дулаан хангамж, ариутгах татуурга, цахилгааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулалт, угсралтын ажлын явц, түүний нийт төсөвт өртөг, санхүүжилтийн талаарх ажлын хэсгийн 01/2012 дугаартай дүгнэлт гарсан байна. “Пума” ХХК-ийн уг төслийг гүйцэтгэсэн нийт төсөвт өртөг 27,202,656,954 гэж байсныг энэ ажлын хэсгийн дүгнэлтээр 21,769,400,000 төгрөг байна гэж тогтоосон.

Дээрх ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн 2012 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Яармагийн гүүрний хажуу талд “Пума констракшн” ХХК-ийн барьж буй орон сууцны хорооллын дулаан хангамж, ариутгах татуурга, цахилгааны шугам сүлжээний ажлыг Хөгжлийн банкаар дамжуулан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 337 дугаар тогтоолд шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр өөрчлөн мөнгөн хөрөнгийн асуудлыг Улсын төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх гэсэн дүгнэлт гаргасан байна.

Цахилгаан, дулаан, ариутгал татуургын ажлуудыг “Пума” ХХК нь 2012 онд барьж дуусган Улсын коммист хүлээлгэн өгсөн байна. Энэхүү ажлуудад 2013 оны 07 дугаар сарны 06-ны өдөр инженерийн санал дүгнэлт гаргасан байна. Үүнд:

Гадна дулааны шугамын төсөвт өртөгт ажлын тоо хэмжээг шалган дараах дүгнэлтийг хийжээ.

№	Хийгдэх ажлын	Төсөвөөр	Зургаар	Илүү
---	---------------	----------	---------	------

	нэр			тооцсон
1	гулсах тулгуур	868 ш	234 ш	634 ш
2	Бетон дэр	1185 ш	234 ш	951 ш
3	Бөмбөлгөн хаалт	64 ш	33 ш	31 ш
4	Сувгийн тэвш	2178 ш	603 ш	1575 ш
5	Бетон суурийн арматурчлал	189 тн	116 тн	73 тн

Дүүжин гүүрний угсралтын төсөвт өртөгт ажлын тоо хэмжээг шалган гаргасан дүгнэлт

№	Хийгдэх ажлын нэр	Төсөвөөр	Зургаар	Илүү тооцсон
1	Ган багана	268.4 тн	3.7 тн	264.7 тн
	Дам нуруу	145.6 тн	14.6 тн	131 тн
	Ган татлага холбоос	5.8 тн	2.04 тн	3.76 тн
	Бетон дэвсгэр үеийн арматурчлал	10.86 тн	2 тн	8.86 тн
	Баганын бетон зугалт	156 м3	60 м3	96 м3

Дээрх зүйлийг дүгнэхдээ: ажлын тоо хэмжээний ихээхэн зөрүүг харахад төсөвт өртгийг илүү тооцсон байна. Иймд орон сууцны хорооллын Дулаан, Ариутгах татуурга, Цахилгаан хангамжийн шугам сүлжээ, Дүүжин гүүр тус бүрийн ажлын гүйцэтгэлийн төсвийг гарган экспертизийн нарийн мэргэжлийн багаар хянуулан бодит төсвийг баталгаажуулах шаардлагатай.

Засгийн газрын 118 дугаар тогтоолоор нийт 21,769,400,000 төгрөгөөр санхүүжилтийг 2013 онд 10,769,000,000 төгрөг, 2014 онд 11,000,000,000 төгрөгөөр олгохоор баталагдсан. Эхний санхүүжилтийн 10,769,000,000 төгрөгийг санхүүжүүлэх боломжтой ба 2014 оны санхүүжилт хийхээс өмнө дээрх 4 төсвийг улсын экспертизээр хянаж баталгаажуулсан дүнгээс хамаарч үлдэгдэл төлбөрийг хийх хэрэгтэй гэсэн дүгнэлтийг 2013 оны 07 сарын 08-ны өдөр Инженер Д. Мөнхмандал гаргажээ.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан 21,7 тэрбум төгрөг нь ажлын жишиг үнэ тул хувийн хөрөнгө оруулалтын бодит хэмжээг шалган тогтоож, санхүүжилтийн дүнг тодорхойлон 2013-2014 онд олгох боломжтой гэсэн Хууль зүйн дүгнэлтийг 2013 оны 07 дугаар сарын 09-ны өдөр хуульч Б.Чинзориг гаргасан байна.

Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Чинзориг зээлийн эрсдэлийн дүгнэлтийг 2013 оны 07 сарын 16-ны өдөр гаргасан байна. Үүнд: Эргэн төлөлтийн эх үүсвэр нь улсын төсөв бөгөөд төслийн ажил 100% гүйцэтгэгдсэн тул улсын комисс хүлээн авсан байна. Иймд энэхүү зээлд эрсдэл байхгүй байна гэж дүгнэжээ.

Энэхүү төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ тус банк нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд Хөгжлийн банкны санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг харгалзан үзээгүй байгаа нь уг хуулийг зөрчсөн байна.

Түүнчлэн энэхүү төслийн үлдэгдэл санхүүжилтийг олгохын өмнө дээрх дүгнэлтийн 3-т дурдсан инженерийн дүгнэлтийг харгалзан үзэж тухайн барилга байууламжийн зураг, төсвийг нарийн мэргэжлийн экспертүүдээр хянуулж бодит өртөгийг тогтоох шаардлагтай гэж үзэж байна.

АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Шалгалтаар Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зөвхөн хугацааны ангилал хийхэд /чанарын болон харгалзах хүчин зүйлийн ангилал хийгээгүй/ **зээлийн эрсдэлийн санг 352.4 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах, хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлагыг 146.3 тэрбум төгрөгөөр бууруулж, хүүгийн орлогоос буцаах тохируулгууд хийгдэж, энэ нь шалгах өдрийн байдлаарх тухайн жилийн ашгийг 498.7 тэрбум төгрөгөөр бууруулснаар тус банкны өөрийн хөрөнгө -319.6 тэрбум төгрөг болж, эзэмшигчийн өмч алдагдаж байна.** Энэ нь зээлийн чанар муудсантай холбоотой байна.

Банкны ашигт ажиллагаа маш хангалтгүй, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд эрс муудсан бөгөөд банкны тухайн жилийн алдагдал банкны гаргасан шалгах өдрийн тайлангаар 116.9 тэрбум төгрөг, шалгалтаар хийсэн тохируулгын дараа 615.7 тэрбум төгрөгт хүрч, энэ дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулсан нь банкны тогтвортой үйл ажиллагаанд шууд нөлөөлөхөөр байна.

Шалгах өдрийн байдлаарх Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2,991.3 тэрбум төгрөгийн зээлийн 34.7 хувь буюу 1,037.2 тэрбум төгрөгийн зээл /93 зээл/-ийн хугацааг сунгасан байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээлүүдийн зээлийн хүүгийн төлбөр 2016 оны эхнээс огт төлөгдөхгүй байгаа бөгөөд энэ төрлийн зээлийн хугацаа сунгалт цаашдаа ч үргэлжлэхээр байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрүүдийн болон төслүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг харьцуулж үзэхэд ойрын 3 жилийн хугацаанд эх үүсвэрүүдийн эргэн төлөлт нийт 3,732.4 тэрбум төгрөг байхад зээлийн эргэн төлөлт

нийт 2,248.3 тэрбум төгрөг байгаа нь эх үүсвэрүүдийн эргэн төлөлтийг хийхэд саад учруулахаар байна.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүдийн үндсэн төлбөр 2016 оны үлдсэн саруудад 42.5 тэрбум төгрөгөөр, 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 706.3 тэрбум төгрөгөөр төлөгдөх хуваарьтай байна. Мөн Хөгжлийн банк шууд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн чанаргүйд ангилагдсан зээлүүдийн үндсэн төлбөр 2016 оны үлдсэн саруудад 368.5 тэрбум төгрөгөөр, 2017 оны эхний улиралд 42.9 тэрбум төгрөгөөр төлөгдөх хуваарьтай байна. **Шалгах өдрөөс буюу 2016 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс 2017 оны эхний улирлыг дуустал хугацаанд эргэн төлөгдөх ёстой дээрх 1,160.2 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт төлөгдөхгүй байх магадлал маш өндөр байна. Гэтэл Хөгжлийн банк 2017 оны 3 дугаар сард 580.0 сая ам.долларын ДХЕӨБ /Дунд хугацааны евро өрийн бичиг/-ийг бүрэн төлөх ёстой. Өөрөөр хэлбэл, зээл эргэн төлөгдөхгүй эрсдэлд орсон нь ДХЕӨБ-ийг төлж чадахгүйд хүргэхээр байна.**

Чингис бондын эх үүсвэрээр олгогдсон Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл төлөгдөхгүй тохиолдолд үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг эргэн төлөх үүргээс эдгээр зээлийн үндсэн болон зээлийн хүүгийн төлбөрийн нийт хэмжээгээр чөлөөлөгдөж, банкинд эрсдэл үүсэхгүй байхаар Сангийн яамтай байгуулсан "Санхүүгийн зуучлалын гэрээ"-нд зохицуулагдсан байна. **Харин Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 123.1 сая ам.долларын зээлийн эргэн төлөлт Улсын төсөвт суухгүй /төсөл хэрэгжээгүй, төслийн хэрэгжилт хангалтгүй гэх мэт шалтгаанаар/ бол эрсдэл үүсэхээр байгааг анхааруулж байна.**

Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2016 оны 09 дүгээр тогтоолоор арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн доод хэмжээг **500.0 тэрбум төгрөг болон түүнтэй тэнцэх валютаар тогтоосон боловч 2016 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар банкууд дахь мөнгөн хадгаламж нийт 534.8 тэрбум төгрөг байна.** Тус банкнаас шалгалтын ажлын хэсэгт гаргаж өгсөн тайлан мэдээнээс үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банк хадгаламж татах нэмэлт зөвшөөрөлгүй Чингис хаан банкинд **8.8 тэрбум төгрөг, 2.5 сая ам.доллар, 1.0 сая евро, Богд банкинд 2.0 сая еврогийн хадгаламж тус тус байршуулсан нь Монгол Улсын Хөгжлийн банкны эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж байна гэж үзлээ.** Мөн "Арилжааны банкны санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, мөнгөн хадгаламж байршуулах хэмжээ тогтоох аргачлал"-ын дагуу тооцон гаргасан банкуудад байршуулах боломжит хадгаламжийн хязгаарлалтын хэмжээг Улаанбаатар хотын банк, Худалдаа Хөгжлийн банк, Чингис хаан банкинд хэтрүүлэн байршуулсан нь банкны эрсдлийн түвшинг нэмэгдүүлж байна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассивын ханшийн тэгшитгэлээр нийт 155.3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Үүний 132.1 тэрбум төгрөгийн алдагдал иений ханшаас шалтгаалсан байна. **Гадаад валютын тэнцлээс харахад төгрөгийн ханш цаашид сулравал ханшийн тэгшитгэлээр алдагдал хүлээсээр байхаар байна.**

Банк нь зах зээлийн эрсдэл буюу хүү болон ханшийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих тогтолцоог тодорхой хэмжээнд бүрдүүлсэн боловч түүнийгээ үйл ажиллагаандаа үр ашигтайгаар ашиглах боломж нь бага, зах зээлийн эрсдэл нь өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөлөл өндөр, шалгах өдрийн байдлаар ханшийн

тэгшитгэлээр алдагдалтай ажилласан, банкны нэгдсэн эрсдэлийн бодлогыг шинэчлэн боловсруулж батлуулах шаардлагатай, эрсдэлийн удирдлагын хувьд шаардлагатай хүний нөөц, эх үүсвэрийг бүрдүүлэх, удирдлагын мэдээллийн системийг бий болгох, дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэл үүссэний дараа бус эрт илрүүлэх эрсдэлд чиглэсэн аудитын үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатай байна.

Шалгалт хамрах хугацаанд Хөгжлийн банкны эрсдэлийн түвшинд тавих тогтмол хяналт орхигдсоор иржээ. Хөгжлийн банк нь Банкны тухай хуульд заасан үйл ажиллагааг арилжааны банкны нэгэн адил эрхлэж байгаа, Хөгжлийн банкны тухай хууль нь Банкны тухай хуульд бүрэн агуулагдаж байгаа учир Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Монголбанк хэрэгжүүлэх нь зохимжтой харагдаж байна.

Тус банкны Дотоод аудитын алба, Эрсдэлийн удирдлагын хороо, Зээлийн хороо нь зээлийн эрсдэлийг үнэлэх, илрүүлэх, бууруулах, зээлийг үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр маш хангалтгүй ажиллаж иржээ.

Монгол Улсын Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн зарим эх үүсвэрүүд гадаадын зах зээлд гаргасан Монгол улсын Засгийн газрын бондын хүүгээс 50 хувиар өндөр байна. Хэдийгээр тус эх үүсвэрүүдийн нэрлэсэн хүү бага харагдаж байгаа боловч эх үүсвэрийг татахтай холбоотой гарсан зардлууд нь өндөр байгаа нь эх үүсвэрийн өртгийг өсгөж байна. Мөн тухайн эх үүсвэрүүдийг дотоодын банкуудад байршуулахдаа бага хүүгээр өгч байгаа нь банкыг хүүгийн томоохон эрсдэлд оруулж байна. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн болоод хөрөнгө оруулалтын хооронд валют тус бүрийн зохистой харьцаа алдагдсан байгаа нь эх үүсвэрийн эргэн төлөгдөх цаг хугацааны бүхий л эрсдэлүүд тус банкинд бий болсон байна.

МУХБ нь Засгийн газрын 299 дугаар тогтоолын дагуу хөрөнгийн чөлөөт үлдэгдлээр ЗГ-ын үнэт цаасыг худалдан авч байгаа хэдий ч, хөрөнгийн чөлөөт эх үүсвэрийг 2014 оны ЗГ-ын шинээр гаргаж байсан өндөр өгөөжтэй үнэт цаасыг худалдан авалгүй, өмнөх онуудад гаргасан, бага хүүтэй үнэт цаасыг УБ хотын банкнаас худалдан авсан байна.

Худалдан авах ажиллагааны журамд сүүлийн 2 жилд 3 удаа өөрчлөлт оруулан баталсан байна. Тухайлбал: журмын 28 дугаар зүйл буюу харьцуулалтын арга хэсэгт Зээлжих зэрэглэл тогтоолгох, хууль зүйн туслалцаа авах, банкны үйл ажиллагаанд олон улсын стандарт шаардлага хангахтай холбоотой үйлчилгээ авах зэрэгт үнийн санал ирүүлэхийг мэдэгдэнэ гэсэн байдлаар журамд өөрчлөлт оруулсан.

Мөн 2016 оны 6 сард журмын 29.1.6 буюу тендер шалгаруулалтыг шууд гэрээ байгуулах аргаар явуулах гэсэн хэсэгт "Хувьцаа эзэмшигчээс өгсөн хугацаатай үүрэг даалгаварыг биелүүлэх зорилгоор ажил, үйлчилгээг нээлттэй эсхүл хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол" гэсэн заалтыг нэмсэн байна. Энэ заалтыг үндэслэн ганц сарын дотор тус банкны Олон нийттэй харилцах албанаас зохион байгуулсан сурталчилгаатай холбоотой нийт 1,1 тэрбум төгрөгийн шууд гэрээ хийсэн байна.

Энэ нь тухайн байгууллагын гүйцэтгэх удирдлага журамд хэзээ ч өөрчлөлт оруулан баталж, хэдэн ч тэрбумын гэрээ хийж болохыг харуулж байх бөгөөд төрийн өмчит бусад байгууллагуудын адил хууль мөрддөг болох зайлшгүй шаардлагатай байна.

Шалгалтын явцад холбогдох баримт бичиг, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэртэй нарийвчлан танилцахад бүхэлдээ хууль эрх зүйн шаардлага, улс орны нийтлэг эрх ашигт нийцэхгүй байна гэж үзэж байна.

Монгол Улсын Хөгжлийн Банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тус банкны бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, өөрчлөх эрх хуулиар олгогдоогүй байхад Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолуудаар Хөгжлийн банкинд бүтцийн өөрчлөлт хийсэн нь Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 20 дугаар зүйлийн 20.1, 22 дугаар зүйлийн 22.1.2, Засгийн газрын 2011 оны 151-р тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "МУХБ-ны бүтэц, зохион байгуулалт"-ыг зөрчсөн шийдвэр болжээ.

Ийнхүү шийдвэр гаргахдаа шаардлагатай судалгаа, шинжилгээн дээр үндэслэн бүтэц, зохион байгуулалтыг батлаагүйн улмаас ажил, үүргийн хуваарилалт тодорхой бус, шинэчилсэн бүтцийн дагуу хуваагдан ажилладаг ч Засгийн газрын 151 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан бүтцэд заасан чиг үүргийн дагуу ажиллах шаардлагатай тулгарах зэргээр тодорхой бус байдлыг үүсгэж байгаа юм. Энэ нь газар, нэгж хоорондын уялдаа холбоог алдагдуулах, ажил үүргийн давхардал, хийдэл үүсэх нөхцөл бололцоог үүсгэж байна. Мөн шинэчлэн баталсан бүтцэд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийн 12.1-д заасан хянан шалгагчийг томилоогүй байгаа нь тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийх ажиллагаа огт хийгдээгүйд хүргэсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Төлөөлөн удирдах зөвлөлийн хэрэгжүүлэх бүрэн эрх, 19 дүгээр зүйлийн 19.4-т Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхой заасан байхад Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хүрээнд батлах шаардлагатай дүрэм, журмыг баталсан нь хуульд нийцэхгүй байгаа юм.

Түүнчлэн гүйцэтгэх удирдлагын баг нь мэргэжлийн бус, банк санхүүгийн салбарт ажиллаж байсан мэдлэг, туршлага багатайгаас өөрийн удирдлага доорхи ажилтнуудыг шаардлагатай мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж чадахгүй байна. Үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай банкны бизнес, стратегийн төлөвлөгөөг цаг тухайд нь батлуулдаггүй, зээлийн болон эрсдэлийн бодлогыг шинэчлэн жил бүр батлуулдаггүй, хянан шалгагчийг томилж ажиллах журам болон гүйцэтгэх удирдлагын багийн ажиллах журмыг өнөөг хүртэл батлаагүй нь Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулах, хариуцлагатай байх зарчмууд алдагдахад нөлөөлсөн гэж үзэж байна.

ЦААШИД ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ АСУУДАЛ

Монгол Улсын Засгийн газарт:

- Засгийн газар гадаад зах зээлээс валютаар босгосон бонд, зээлийн эх үүсвэрийн байршуулалт, зарцуулалтыг хийхдээ ханшийн эрсдлийг тооцож байх.

-Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүдийг сайжруулахын тулд Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга замыг авч хэрэгжүүлэх.

-Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгохдоо Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллах.

-Хөгжлийн банк нь төрийн өмчит компаний хувьд төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хийхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрддөг байхаар холбогдох хуулиадад өөрчлөлт оруулах

-Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлүүдийн хүүгийн болон үндсэн төлбөрийг хэрхэн төлөх талаар тодорхой ажил зохион байгуулах

-Зээл, үнэт цаас төлөгдөх, авлага барагдахад болон хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлснээр учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг оновчтой тодорхойлохуйц "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг боловсруулан, Сангийн ямаар хянуулсаны үндсэн дээр Хөгжлийн банкны ТУЗ-өөр батлуулах.

-“Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Дансны жагсаалт”, “Санхүүгийн тайлангийн маягт, загвар”, “Санхүүгийн тайлан, тодруулга бэлдэх аргачлал” зэргийг боловсруулан Сангийн ямаар хянуулсаны үндсэн дээр Хөгжлийн банкны ТУЗ-өөр батлуулах.

-“Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, хяналт тавих чиг үүрэг бүхий субъектээр батлуулах /банкны эрсдэлийг илэрхийлэх журмуудыг Гүйцэтгэх захирлаар бус хяналт тавих чиг үүрэг бүхий субъектээр батлуулж байх/;

Хууль эрхзүйн хүрээнд:

-МУХБ-ны тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу УИХ-аас батлах төсөл, хөтөлбөрийн жагсаалт мөн хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх, санхүүжүүлэлт олгох шийдвэрийг мэргэжлийн дүгнэлт, судалгаа, шинжилгээнд үндэслэн зөвхөн Зээлийн хороо шийдвэрлэх тухай зохицуулалтыг тодорхой болгох

-УИХ-аас МУХБ-ны тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг жил бүр хаврын чуулганаараа батлах

-Улсын нийгэм эдийн засгийн бодлого, хөгжлийн стратегит нийцсэн төсөл, хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулах журмыг хуульчлах, уг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг тодорхой болгох

-МУХБ-ны тухай хуулийн 6.1.2 дахь заалтад заасан Хөгжлийн банкны хараат бус байх зарчмыг хэрэгжүүлэх зорилго бүхий зохицуулалтыг хуульд нэмж тусгах.

-ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.6 дахь хэсгийн хэрэгжилтийг тайланд тусгасан утгаар нэг мөр хангах зорилгоор хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

-МУХБ-ны тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хэмжих, үнэлэх боломжтой байдлаар өөрчлөлт оруулах.

-Төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлж, дүгнэх аргачлал, зааврыг тодорхой болгон холбогдох журмыг тогтоосон эрх зүйн актыг батлах эрх бүхий субъектийг хуулиар тогтоох.

-МУХБ-ны тухай хуулийн 18 дугаар зүйлд ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг нарийвчлан тодорхой болгох.

Хөгжлийн банкинд:

-МУБХ-ны зохистой харьцааны үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн бууралтаас хамаарч зарим эх үүсвэрүүдийг эргүүлэн татах нөхцөлтэй тул гэрээний үүргийг ханган ажиллах/банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах/;

-Банкны эх үүсвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа болон зээлийн эргэн төлөлтийн хугацааг нэгтгэн удирдаж, өдөр тутмын мэдээ, тайлан гаргах;

- Банкны чөлөөт эх үүсвэрийг байршуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг баримтлах, эрсдлийн тогтоосон хязгаарлалтын хүрээнд арилжааны банкуудад харилцах, хадгаламжаа байршуулах;

-Банкны эх үүсвэрийн чөлөөт эх үүсвэрийг байршуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг баримтлах, эрсдлийн тогтоосон хязгаарлалтын хүрээнд арилжааны банкуудад харилцах, хадгаламжаа байршуулах, Эрсдлийн удирдлагын газар болон Актив, пассивын удирдлагын газруудын ажлын уялдаа холбоог хангуулан ажиллах.

-Зээлийн үнэ цэнийн бууралтыг хэрхэн тооцож, бүртгэхийг “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар” боловсруулахдаа дэлгэрэнгүй оруулж өгөх, тухайн зээлд зээлийн эрсдэлийн сан байгуулахдаа зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцсон зээлийн эрсдэлийн сан, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцсон зээлийн эрсдэлийн сан хоёрын аль ихээр нь байгуулахаар журамлах

-Дотоод аудитын алба болон зээлийн үйл ажиллагаатай холбоотой газар, нэгж, хороодын үйл ажиллагааг эрс сайжруулах.

- Банкны зохион байгуулалт бүтцийг хуульд нийцүүлэн өөрчлөх, ингэхдээ нэн тэргүүнд ажил үүргийн шинжилгээг хийж газар, нэгжийн чиг үүргийг боловсруулан батлуулж, ажил үүргийн хувиарлалтыг хийхийн хамт хянан шалгагчийг томилж, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах

-МУХБ-ны зохистой харьцааны үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн бууралтаас хамаарч зарим эх үүсвэрүүдийг эргүүлэн татах нөхцөлтэй тул гэрээний үүргийг ханган ажиллах, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байна.

-МУХБ, Худалдаа Хөгжлийн банк, “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн хооронд векселээр хийх төлбөр тооцооны харилцааг зохицуулах тухай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах (Эрдэнэс МГЛ компаний үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хүү болон үндсэн төлбөрийн тодорхой хувийг жил бүр төлж байхаар эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах,) Векселийн алданги болох 1.9 тэрбум төгрөгийг анх векселээр санхүүжүүлэх шийдвэр гаргасан этгээдээр хариуцуулах.

-Арилжааны банкны санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, мөнгөн хадгаламж байршуулах, хэмжээ тогтоох аргачлалын 2.4 дэх "Арилжааны банкинд байршуулах хугацаат мөнгөн хадгаламжийн нийт хэмжээг тухайн банкны актив хөрөнгийн хэмжээнээс хамааран Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан интервалын хувиас хэтрүүлэхгүй байхаар чиглэл өгнө" гэснийг өөрчлөн найруулах, интервалын хувийг тогтоох гүйцэтгэх захирлын тушаалыг хүчингүй болгох;

-МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр "арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршиж буй чөлөөт мөнгөн хөрөнгийн доод хэмжээг 500 тэрбум төгрөг хүртэл" гэснийг хүчингүй болгож, Хөгжлийн банкны түргэн борлогдох чадвартай чөлөөт мөнгөн хөрөнгийн доод хэмжээг 500 тэрбум төгрөг хүртэл гэж өөрчлөх;

-“Чанаргүй зээл болон тэнцлийн гадуур бүртгэлтэй зээлийн хүүгийн авлагыг төлүүлэх төлөвлөгөө”, “Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт, ашигт ажиллагааг сайжруулах төлөвлөгөө” боловсруулан ТУЗ-өөр батлуулж, хэрэгжүүлэх;

-Зээл, үнэт цаас төлөгдөх, авлага барагдахад болон хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлснээр учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг оновчтой тодорхойлохуйц “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг боловсруулан, Сангийн ямаар хянуулж, эрх бүхий этгээдээр батлуулах;

-“Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Дансны жагсаалт”, “Санхүүгийн тайлангийн маягт, загвар”, “Санхүүгийн тайлан, тодруулга бэлдэх аргачлал” зэргийг боловсруулан Сангийн ямаар хянуулж, батлуулах;

-“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам” зэрэг банкны эрсдэлийг илэрхийлэх журмуудыг Гүйцэтгэх захирлаар бус хяналт тавих чиг үүрэг бүхий субъектээр батлуулж байх;

-Монголбанкны “Урт хугацаат своп хэлцлийн журам” нь банкуудын 5-аас дээш жилийн хугацаатай гадаадаас татсан эх үүсвэрт своп хэлцэл хийж, ханшийн эрсдэлээс сэргийлэхэд зориулагдсан. Уг журмыг судалж, гаднаас татсан эх үүсвэрийн алдагдалыг бууруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна.

-Улсын төсвөөс төлөгдөх нөхцөлтэй зээлийн хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага, Чингис бондын эх үүсвэрийн хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн тооцоог Сангийн яамтай даруй нийлж, төлөлтийг хангуулах;

-“Зээлийн үйл ажиллагааны журам”-ын 5.3 дахь хэсэгт заасан “Зээлийн үндсэн хүүг тооцох аргачлал”-аа Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-236 тоот тушаалаар баталсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.2 дахь заалттай нийцүүлэх;

-Монгол Улсын Хөгжлийн Банкны хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгож ажлын байрны тодорхойлолт болон түүнд заасан ажлын чиг үүргийг ажлын байр тус бүрээр тодорхой болгох шаардлагатай. Мөн тус банкны албан тушаал ахиулах, бууруулах, цалингийн зэрэглэлийг тогтоох асуудлыг зохицуулдаг дүрэм, журам одоогоор байхгүй ажилтны шууд удирдлагын хүсэлт, саналыг үндэслэдэг нь учир дутагдалтай тул журмыг даруй боловсруулан батлуулах нь зүйтэй.

-Төрийн аудитын хуулийн "18.5.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Ийнхүү гүйцэтгэсэн аудитын тайлангийн чанарыг төрийн аудитын байгууллага баталгаажуулна" гэж заасан байгааг тодорхой болгож чиг үүргээ аудитын бусад байгууллагаар хэрэгжүүлэхээр заасныг аудитын Санхүүгийн үйл ажиллагаа болон нийцлийн аудитыг заавал хийлгэхээр зааж өгөх, мөн 3 болон түүнээс дээш чиг үүргийг болж өгвөл шилжүүлэхгүй байх зайлшгүй шаардлагатай байна.

-Тус банкны "Ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-д заасан шалгуур үзүүлэлт нь ажлын гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэх боломжгүй, удирдлагын үзэмжээр дүгнэх магадлал өндөртэй ба уг шалгуур үзүүлэлтийн үр дүнд үндэслэн улирал бүр сарын цалингийн 60%-100% хувьтай тэнцэх хэмжээгээр нийт албан хаагчдад хавтгайруулан урамшуулал олгодог нь байгууллагын төсвийг хэт үрэлгэнээр баталж, зарцуулж байгаа олон жишээгийн нэг юм. Иймд цаашид олон улсын түвшинд нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний системийг /KPI гэх мэт/ судлан нэвтрүүлэх шаардлагатай.

-Монгол Улсын Хөгжлийн банкны удирдлага нь гадаад албан томилолт, сургалт зэрэгт "Албан томилолтын журам"-д заасан зохих дүнгээс хэт өндөр төсвийг батлан зарцуулдаг тул цаашид журмын дагуу ажиллах нь зүйтэй. Мөн тус банкны олон нийттэй харилцах ажлын хүрээнд байгуулсан гэрээнд зарцуулсан мөнгө сүүлийн хоёр жилийн хугацаанд огцом нэмэгдсэн байх ба уг чиглэлээр хийгдсэн ажил нь байгууллагад үр ашиг багатай, үр дүнг хүлээлцсэн акт, баримт дутуу зэрэг дутагдал илэрсэн тул цаашид анхаарах нь зүйтэй.

-Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломж нь Санхүүгийн зуучлалын гэрээний дагуу Сангийн яамнаас авсан Чингис бондын өр төлбөрийг Өөрийн хөрөнгөд хөрвүүлэх боломжтой Хоёрдогч өглөг болгон хөрвүүлэх замаар Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой байна. Тиймээс тус өр, төлбөрийг өөрийн хөрөнгөд СТОУС-ын дагуу хэрхэн хөрвүүлэх боломжтой эсэх талаар судалж, хуулийн дагуу өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар хувьцаа эзэмшигчдээр шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

-Тус банкны худалдан авах ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, хариуцлагатай болгохын тулд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам зааврыг үйл ажиллагаандаа мөрддөг болгох шаардлагатай байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3,6 дахь заалтыг хүчингүй болгох нь зүйтэй юм.

-Монгол Улсын Хөгжлийн банкны хороодын үйл ажиллагааны үндсэн чиглэлд холбогдох дүрэм, журмын дагуу дараах чиглэл баримтлан ажиллах, Үүнд:

Актив, пассивын удирдлагын хорооны хурлаар:

1. Банкны орлого, зарлагыг дүгнэх;
2. Банкны активын өсөлт болон өөрийн хөрөнгийн өсөлтийг дүгнэх;
3. Банкны актив, пассивын хугацаа болон хүүгийн зөрүүг хэлэлцэх;

4. Банкны түргэн борлогдох актив хөрөнгийн хэмжээг тодорхойлох;
5. Эрсдлийн удирдлагын газраас гаргасан хүү, шимтгэл, санхүүгийн үйлчилгээний талаарх тогтоосон хязгаарлалт дүрэм журмыг баримтлан ажилласан талаар хэлэлцэх;
6. Банкны эх үүсвэрүүдийн хүү, хугацааг хэлэлцэж, ирэх сард олгох зээлийн хэмжээ, зээлийн суурь хүү, зээлийн эргэн төлөлтийн хугацааг эх үүсвэр болон валют тус бүрээр тогтоож уг шийдвэрийг баримтлан ажиллах;
7. Зээлийн хороогоор танилцуулагдаж буй төсөл нь АПУХ-оос баталсан шийдвэртэй зөрчилдөж байгаа тохиолдолд тус төслийг тусгайлан судалж АПУХ-ны ээлжит бус хурлаар дахин хэлэлцэх;
8. Арилжааны банкуудад мөнгөн хадгаламж байршуулах хэмжээг хорооны хурлаар хэлэлцэж АПУХороо, газрын захирал, хэлтсийн захирлын эрхийн хязгаарлалтыг тогтоох шаардлагатай байна.
9. -АПУХ нь АПУБодлогын 4.2.4.1-д дурдсан 7 төрлийн тайланг нэгдсэн байдлаар холбогдох газруудаас гаргуулж улирал бүр ТУЗ-д гаргаж өгөх;
10. -Нарийн бичгийн даргыг томилохдоо өмнөх нарийн бичгийн даргыг чөлөөлж байх;
11. -Хорооны нарийн бичгийн дарга нь хороогоор оруулсан материалыг зохих журмын дагуу архивын нэгж болгон товъёолж, дугаарлан, үдэж, хавтаслуулан архивт хадгалуулах

Зээлийн хорооны хурлаар:

1. АПУХ-оор шийдвэрлэсэн тухайн сард гарахаар төлөвлөж буй зээлд олгох эх үүсвэрийн хэмжээ, зээлийн суурь хүү болон зээлийн хугацааг мөрдлөг болгох
2. Зээлийн хороогоор танилцуулагдаж буй төсөл нь АПУХ-оос баталсан шийдвэртэй зөрчилдөж байгаа тохиолдолд АПУГ-аас тусгайлан судлуулах, дахин танилцуулах

Эрдэлийн удирдлагын хорооны хурлаар:

1. Банкны чөлөөт мөнгөн хөрөнгийн байршуулалтын хүү, шимтгэл, санхүүгийн үйлчилгээний талаарх тогтоосон хязгаарлалт, дүрэм, журмыг баталж дараа сард баримталж ажиллахыг үүрэг болгох
2. Банкны гадаад валютын эрсдэлийг тооцоолж, гадаад валют тус бүрийн стоп лосс ханшийг тогтоох
3. Банкны гадаад валютын арилжааны хязгаарлалтыг тогтоож, дараа сарын валют арилжааны дүнгийн хязгаарлалтыг тогтоох
4. Банкны санхүүгийн зохистой харьцаа, үр ашгийг танилцуулах
5. Банкнаас шинээр байршуулахаар шийдвэрлэсэн мөнгөн хадгаламжийн дүн, валют хугацааг тодорхойлж, арилжааны банкуудаас хүүгийн саналыг нэгдсэн байдлаар авах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.
6. -Эрсдэлийн удирдлагын бодлого, үйл ажиллагааны журмыг олон улсын стандарт ISO31000-тэй нийцүүлэн боловсруулж нийцүүлэх;
7. -ЭУХ-ны ээлжит хурлыг улиралд 2-оос доошгүй удаа хуралдуулах;

8. -Хороогоор хэлэлцүүлсэн асуудлын хэрэгжилтийг эргэн хэлэлцэж үр дүнг гүйцэтгэх удирдлагад танилцуулах, мөн хэрэгжилтийн үнэлгээг үйл ажилгааны үнэлгээнд оруулах;
9. -Хорооны гишүүдийг албан тушаалаар нь тодорхой болгох;
10. -Нарийн бичгийн даргыг томилохдоо өмнөх нарийн бичгийн даргыг чөлөөлж байх;

-Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлуулж үр дүнгийн үнэлгээтэй уялдуулах;

-ТУЗ-ын хурлын шийдвэр түүнийг баталгаажуулахдаа хуралд оролцсон эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулсны үндсэн дээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байх;

“Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хуралд оролцогчдын саналын баримт бичгийн баталгаажуулсан хувийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хувь нийлүүлэгчид хүргүүлж, хурлын тэмдэглэлийг албажуулан цаг тухайд нь архивлаж байх;

- “Нууцыг хамгаалах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, журмын 2.6-г өөрчилж Нууцын төслийг гараар бичиж нууцын ажилтнаар хэвлэмэл машинаар гаргуулж гараар бичсэнийг усгана гэж оруулах;

-Гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааны журам буюу гүйцэтгэх удирдлагын ажлын харилцан уялдаа холбоо, чиг үүрэг, хариуцлага харилцааг зохицуулсан журам батлуулах;

-Монгол Улсын Хөгжлийн банкыг татвар төлөгч болохын тухайд татварын хяналт, шалгалт хийгдээгүй байна. Татварын хяналт шалгалтыг яаралтай хийлгэх

Хуулийн байгууллагад :

-Чингис бондын эх үүсвэрийг Хөгжлийн банкинд ам.доллараар байршуулаагүйгээс Чингис бондын эргэн төлөлтийг хийхэд хүүгийн зөрүүгээр Засгийн газар 694.5 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээхээр байна.

-Хөрөнгө оруулалтын зардлаа тухайн санхүүжүүлсэн төслийн орлогоос нөхөх байтал Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчид уг төслөөр бий болсон дэд бүтийг худалдан авсан буюу төсөл хэрэгжүүлсэн компанид бий болсон эрсдэлийг төр худалдан авах замаар өөрт шилжүүлэн авсан байна.

Тухайлбал, Засгийн газрын 2013 оны 239, 299 дүгээр тогтоолуудаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд "Говийн зам" ХХК-ийн барьсан авто замыг "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн мэдэлд шилжүүлэхээр шийдвэрлэж "Эрдэнэс Монгол" ХХК болон МУХБ-ны хооронд 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 3-ЭМГЛ-ХО-2014-05 дугаартай зээлийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан байна.

Векселийн хугацаа дуусах үед Монголбанкнаас МУХБ-нд векселийн төлбөрийг хугацаандаа төлөх, хугацаа хэтэрвэл хуулийн дагуу алданги төлөхийг удаа дараа албан бичгээр анхааруулсан боловч төлөлт хийхгүй явсаар 1.9 тэрбум төгрөгийн алданги хүлээж, банкийг хохироосон.

-2016 онд худалдан авсан нийт гэрээний үнийн дүнгээс 1,186,308,250 төгрөгийн гэрээ нь банкыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажилд зориулан 6 дугаар сард буюу УИХ-ын сонгуулийн өмнө байгуулсан гэрээнүүд ихэнх хувийг эзэлж байна.

-Төсвөөс эргэн төлөгдөх “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн үйл ажиллагааны зардлыг хэтрүүлсэн байдал баримтаар харагдаж байна. Зөвхөн цалингийн зардлын хувьд 1,484,800.0 мянган төгрөгийг (2016 оныг оруулбал 2,217,600.0 мянган төгрөг) давхар тооцон санхүүжүүлсэн байна.

-“Шинэ төмөр зам” төслийн ажлын төсөв, гүйцэтгэлийг Зам тээврийн яам дээр шалгах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, төслийн захиалагчаас банкинд ирүүлсэн зарим баримт бичгээс харахад хуулийн зөвлөх үйлчилгээнд 3.2 сая ам доллар, техникийн зөвлөх үйлчилгээнд 3.0 сая, санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 1.6 сая, ХААН банкны зээл, хүүгийн төлбөрт 6.5 сая ам доллар, “Монголын төмөр зам” ТӨХК-ний энэ төслийн нэгжийн санхүүжилт сард дунджаар 120 сая төгрөг, зээлийн зориулалтад нийцэхгүй Хятад улсад оюутан сургасан 112.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

-Тавантолгойн цахилгаан станц төслийн техникийн зөвлөх үйлчилгээнд 935,932.98 ам.доллар, санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 729,971.92 ам.доллар, хуулийн зөвлөх үйлчилгээнд 1,414,474.07 ам.доллар гэх зэргээр өндөр дүнтэй, 2013-2015 оны үйл ажиллагаанд төлөвлөсөн төсвөөс хэт өндөр зардал гаргасан.

-Японы иений эх үүсвэрээр бүрдүүлж тухайн эх үүсвэрийг ханшийн судалгаагүйгээр өөр валютад хөрөнгө оруулан, ханшийн эрсдэлээс хамгаалах ямар ч оролдлого хийгээгүй байгаа нь банкыг алдагдалд оруулах ноцтой үйл ажиллагаа болсон.

-Эрдэнэс Тавантолгой ХК-д хуульд заасан шаардлага зөрчиж нийт 3 удаа гэрээ байгуулан 250 сая ам. долларын зээл олгосон. Үүнээс 50 сая ам.долларын зээлийг Засгийн газрын үнэт цаас гарган Хөгжлийн банкинд эзэмшүүлэх замаар төлж барагдуулсан боловч 200 сая ам. долларын зээлийн үлдэгдэлтэй. Эрдэнэс Тавантолгой ХК-аас ирүүлсэн баримтаас үзэхэд дээрх зээлийн хөрөнгийг Хүний хөгжил санд төвлөрүүлсэн байна.

-Амгалан дулааны цахилгаан станцын төсөлд Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох хүртэлх хугацаанд 3 удаагийн гэрээгээр 45,54 сая ам. долларын зээлийн санхүүжилтийг олгосон.

-Гудамж төслийн хүрээнд хийгдсэн 3, 4-р хорооллын эцсийн уулзвар, Цэцэг төвийн урд уулзвар, Ахуйн үйлчилгээний зам барилгын ажил, Архангай аймгийн төв дэх 1.51 км авто замын барилгын ажил, Архангай аймгийн төв дэх 3.63 км авто замын барилгын ажил, Архангай аймгийн төв дэх 6,25 км авто замын барилгын ажил зэрэг ажлууд авто замын барилгын ажлын зураг төсөл хийгдэж дууссаны дараа барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн дүгнэлтийг аваагүй буюу төсөвт өртгийг баталгаажуулаагүйгээр гүйцэтгэх ажлыг эхлүүлсэн. Төсөвт өртөг үндэслэлгүйгээр өссөн.

-Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны

хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ын дагуу сонгон шалгаруулалтыг хийсэн гэж үзэн санхүүжилтийг олгосон хууль зөрчсөн.

-“Шинэ Яармаг” орон сууцны хорооллын санхүүжилтийг Засгийн газар, Улсын Их Хурлын тогтоолгүй гаргасан.

-“Блүүмберг ТВ”-тэй 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан 1,835,200 ам доллар буюу тухайн үеийн ханшаар хөрвүүлвэл 3,115,252,000 төгрөгийн зар сурталчилгээ байршуулах гэрээ байгуулсан.

-ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авах төсөв батлах тухай” тогтоол, Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Зардлын төсөв батлах тухай” А-162 дугаар тушаалын дагуу 45,000,000.00 төгрөгийн “Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г “Легал консалтинг” ХХК, “Өмгөөллийн ёс” ХХН-ийн туншлэлтэй байна.

-Мөн Хөгжлийн банкны “Саунд оф монголиа” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 79,728,000.00 төгрөгийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан.

-2011 онд ХБ 20,0 сая төгрөгийн өрийн бичиг арилжаалсан байна. ТУЗ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 19 тоот тогтоолоор “Дунд хугацааны евро өрийн бичгийн хөтөлбөрийг батлах, уг хөтөлбөрийг зохицуулагч, дилер, хуулийн зөвлөх”-ийг томилж 755,636.15 ам долларын зардал гаргасан нь тухайн жилийн төсөвт батлагдаагүй зардлыг гаргасан.

-Гадаад албан томилолтын төсвийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан МУХБ-ны Гүйцэтгэх захирлын тушаалаар батласан “Албан томилолтын журам”-д зааснаас хэт өндрөөр батлан зарцуулах, “Албан томилолтын журмын” 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан “Бусад (виз, бусад хураамж, бэлэг дурсгал, хүлээн авалт г.м)” гэх заалтыг үндэслэн тодорхой тайлбаргүйгээр их хэмжээний мөнгийг төсөвлөн батлуулах зэргээр хэт үрэлгэн зарцуулдаг.

-Хөгжлийн банк арилжааны банкуудад битүүмжлэн байршуулсан 49.8 сая ам.долларын хадгаламжийн хүүг авахгүй байгаа бөгөөд хадгаламжийн хүүгийн тухай арилжааны банкуудтай байгуулсан 4 талт гэрээнүүдэд тусгаагүй. Гэтэл хадгаламжийн хүүг авсан бол ТОСК ТӨҮГ-т олгосон 50 сая ам.долларын зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх боломжтой байсан.

-Дэд бүтэц-Эрчим хүч төслийн 2013 оны зөвлөх үйлчилгээ болон техникийн хяналт тавих арга хэмжээнд 717.3 сая төгрөг батлуулан, үүнээс 628.0 сая төгрөг гаргуулж авсан.

Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулахдаа 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдөр буюу Төслийн удирдах хорооны энэхүү тогтоолыг гаргахаас 3 сарын өмнө байгуулсан. 2013 оны 10 сарын 04-ний өдөр уг тогтоолыг нөхөж гаргасан.

-Хөгжлийн банкны Зээлийн хорооны 2013 оны 9 дугаар сарын 20-ний өдрийн хурлаар “Монроуд” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г Гудамж төслийн ирүүлсэн дүнгийн 80 хувиар тооцож 440,000,000 төгрөг байгуулахаар зөвшөөрч мөн өдөр С-ГТ-Б 2013-159 тоот гэрээг 440,000,000.0 төгрөгөөр байгуулсан боловч өөрчөл орж С-ГТ-Б 2013-159-1 тоот нэмэлт гэрээ байгуулан гэрээний дүнг 1,895,550,885 төг болгон

нэмэгдүүлсэн байна. Гэвч гэрээг нэмэгдүүлэх болсон шалтгаан, тооцоолол байхгүй.

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

Ажлын хэсгийн ахлагч:

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд

Б.Энхбаяр

Гишүүд:

Сангийн дэд сайд	Х.Булгантуяа
Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД	Ж.Бат-Эрдэнэ
Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	Б.Нямаа
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТЗУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Махвал
Монголбанкны Хяналт шалгалтын газрын Захирал	Н.Батсайхан
Монголбанкны Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч	М.Адилбиш
Монголбанкны Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч	Ш.Хандсүрэн
Монголбанкны Хяналт шалгалтын газрын хянан шалгагч	Ж.Солонго
Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга	Б.Мөнхбат
Нарийн бичгийн дарга:	
Монгол Улсын Хөгжлийн банкны Хуулийн хэлтсийн захирал	М.Золжаргал

Ажлын дэд хэсгийн гишүүд:

Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга	Ж.Цогтбаяр
Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн	Т.Мөнхгэрэл
Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн	П.Цэрэнлхам
Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн	М.Цолмончимэг
Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн	Б.Сансармаа
Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэн	Н.Дэлгэрбат
Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн	Л.Амгалан
Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн	Ш.Цолмон
Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн	Я.Жавхлан
Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны	


193
НУУЦ

ИЛ БОЛСОН


хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн
Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй,
хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн
Монголбанкны Хяналт шалгалтын газрын
хянан шалгагч
Монголбанкны Хяналт шалгалтын газрын
хянан шалгагч
Монголбанкны Хяналт шалгалтын газрын
хянан шалгагч
Монголбанкны Хяналт шалгалтын газрын
хянан шалгагч

Н.Наранцогт

 Г.Сарнай

 Ш.Хандсүрэн

 Б.Буян

 М.Мөнх-Өлзий

 Б.Халиунаа